



Хөдөлмөр.
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ
ҮНДЭСНИЙ ХОРОО

ХҮҮХДИЙН ЭРХ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ДҮРЭМ, ЖУРАМ, СТАНДАРТЫН ХЭРЭГЖИЛТЭД НЭЭЛТТЭЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар хот
2023 он

**ХҮҮХДИЙН ЭРХ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН ХЭРЭГЖИЛТЭД
НЭЭЛТТЭЙ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТАЙЛАН,
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын даргын хамтарсан 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн “Нээлттэй хяналт-шалгалт хийх тухай” А/34,12 дугаар тушаал, хоёрдугаар хавсралтаар удирдамж баталж, мэдээлэл цуглуулах ажлыг 2023 оны 3 дугаар сарын 27-оос 4 дүгээр сарын 25-ны хугацаанд зохион байгууллаа.

Нээлттэй хяналт-шалгалтын ажлын хэсгийн хурал 2 удаа, өргөтгөсөн цахим хурал 1 удаа зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүд болон аймаг, дүүргийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Хүний эрхийн үндэсний комиссын ажилтнуудад үүрэг чиглэл өгч, мэдээлэл цуглуулах заавар боловсруулж, арга зүйгээр ханган хамтран ажилласан.

- Ажлын хэсгийн гишүүд 4 багт хуваагдаж ажиллаж, дэд багуудын төрийн бус байгууллагаас ажлын хэсэгт ажилласан гишүүд ахалж ажиллалаа.
- Дэд багууд баталсан удирдамжийн дагуу мэдээлэл цуглуулалтыг хийж, нэгдсэн үр дүнг боловсруулсан.
- 21 аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсүүд 2023 оны 04 дүгээр сарын 11-14-ний өдрүүдэд орон нутаг дахь хүүхдийн эрхийн хэрэгжилтэд баталсан удирдамж, хяналт-шалгалт явуулах зааврын дагуу нээлттэй хяналт-шалгалтын ажлыг гүйцэтгэж тайлан ирүүлсэн.
- Хүний эрхийн үндэсний комиссын орон нутаг хариуцсан ажилтнуудаар дамжуулан мэдээлэл цуглуулалтыг гүйцэтгүүллээ.

ХОЁР.НЭЭЛТТЭЙ ХЯНАЛТ-ШАЛГАЛТ ХИЙСЭН АРГА, ХЭЛБЭР

Ажлын хэсгийн үндсэн зарчим нь харилцан мэдээлэл солилцох, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хянаж, шалгах, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэгдсэн.

- Баримт бичиг, судалгаа, шинжилгээний тайлан, хувийн хэргийн бүрдэл, статистик мэдээлэл цуглуулах;
- Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зардлын төлөвлөлт, зарцуулалтын шилэн дансны мэдээлэлтэй танилцах,
- Холбогдох төрийн байгууллага, олон улсын байгууллагаас хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, статистик мэдээлэл;
- Байгууллагын удирдлага, албан хаагчид, үйлчлүүлэгчтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах;
- Нээлттэй хяналт-шалгалтын явц, үр дүнг фото зураг, дүрс бичлэг, холбогдох ажилтан, иргэний ярилцлага, тэмдэглэл.

**ГУРАВ. НЭЭЛТТЭЙ ХЯНАЛТ-ШАЛГАЛТЫН ХҮРЭЭ, ШАЛГАЛТАД ХАМРАГДСАН
БАЙГУУЛЛАГА, ОБЪЕКТ**

3.1.Ажлын хэсгийн гишүүд дараах байгууллага, объектыг түүвэрлэн авч хяналт-шалгалт хийсэн.

Ажлын хэсгийн зарчим нь мэдээлэл солилцох, дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг 2017-2022 оны байдлаар хянаж, шалган үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэгдсэн бөгөөд удирдамж, зааварт дурдагдсан байгууллага, объектод ажиллаж, удирдлага, албан хаагчидтай уулзаж, ярилцах, бичиг баримт, тоон мэдээг үзэх, баталгаажуулах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн сан, программуудтай танилцах зэрэг аргачлалаар явууллаа.

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар;
2. Нийслэлийн Баянзүрх, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс;
3. Монголын Хүүхдийн ордон;
4. Хүүхдийн урлан бүтээх төв;
5. Хүүхдийн төрөлжсөн асрамж халамжийн төвүүд болох “Өнөр бүл” хүүхдийн төв, Нийслэлийн сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор, “Вербист” асрамж, халамжийн төв, ЭМЯ-ны харьяа Хүүхдийн төв сувилал;
6. Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах 1111 төв;
7. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв;
8. Мэдээлэл, шуурхай удирдлагын төв (101, 102, 103, 105 тусгай дугаарын утас);
9. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын утас 107
10. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төв;
11. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр;
12. Налайх дүүргийн Голомт цогцолбор сургуульд хүүхэд хордсон гэх мэдээллийн мөрөөр дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс, Эрүүл мэндийн төв, Боловсролын хэлтэс.

3.2. Аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, шинжлэх ухааны газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар зэрэг байгууллагуудын хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг үнэлэв.

3.3. Аймаг, дүүргийн Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагаа, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан багийн үйл ажиллагаа, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, цагдаагийн хүүхдийн байцаагч, Хүүхдийн элчийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилт, гарсан үр дүнд нээлттэй хяналт-шалгалт хийсэн.

ДӨРӨВ. ХҮҮХДИЙН ЭРХ, ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ, АВАХ АРГА ХЭМЖЭЭ

Нээлттэй хяналт-шалгалтын хүрээнд Улсын Их хурлаас 2016 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон холбогдох бусад дүрэм, журам, стандарт, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан, статистик, Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан зэрэгт баримт бичгийн шинжилгээ хийлээ.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчлэл нь хүүхдийн эрхийг хамгаалахад төрийн бүх шатны байгууллагын үүрэг, оролцоо, хамтын ажиллагаа болон хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүргийг хуулиар тогтоосон байна. Мөн тус хуульд хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий хүүхдийн эрхийн ажилтан /байцаагч/-тай байх эрх зүйн зохицуулалттай болсон хэдий ч хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх, үүрэг, эрх зүйн байдлыг хуулиар бүрэн тогтоогоогүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

- 2016 оноос бүрдэж эхэлсэн хүүхэд хамгааллын тогтолцоо холбогдох хуулиудыг хэрэгжүүлэх шатандаа, дагалдан гарах дүрэм журам, стандартуудыг батлах, санхүүжилтийн механизмаа тодорхойлж турших шатандаа явж байна.
- Хүүхэд хамгааллын хүүхдийн эрхэд суурилсан цогц арга хэмжээ авах, хүчирхийллийг арилгах зохицуулалтын иж бүрэн хүрээ байхгүй, салангид, хэсэгчилсэн, идэвхтэй хариу үйлдэл үзүүлдэггүй тогтолцоо.

- Хүүхдийн эрхэд суурилсан, хүүхдийн дээд ашиг сонирхолд нийцсэн байх ёстой боловч нийгмийн халамж хамгаалал суурьтай, хүүхдийг төвд байрлуулж хамгаалах тогтолцоог өрж байна.
 - Хувь хүүхдэд тулгарч болох бүх нөхцөлийг тооцож зурагдаагүй, эмзэг бүлгийн хүүхдүүд хамгаалалгүй үлддэг, хөтөлбөр үйлчилгээнүүд хүүхдийн ялгаатай эрэлт хэрэгцээ, эрхийг эдлүүлэхэд чиглэсэн биш тогтолцоо болсон.
 - Хүүхдийг хүчирхийлэлд өртсөн хойно хүрч очих тогтолцоо, урьдчилан сэргийлэх тогтолцоо маш сул.
- Хүүхдийг хамгаалах, эрсдэлд орсон хойно туслах, гэр бүлд үзүүлэх дэмжлэг үйлчилгээ бүрэн бүрдээгүй, хуульчлагдаагүй.
- Боловсролын салбарт хүүхэд хамгааллын төсөв байхгүй, дотуур байранд байгаа хүүхдийг хэрхэн хамгаалах зэргээр салбар дундын зохицуулалт муу байна.

ЕРӨНХИЙ САНАЛ

- Цогц, үр дүнтэй хүүхэд хамгааллын (дэмжлэгийн) тогтолцоог бэхжүүлэх зорилготой байх;
- Хүүхдийг тогтолцооны төвд гэр бүлийн хамт тавих;
- НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг бүрэн удирдлага болгох;
- Боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хуулийн, иргэний нийгмийн, орон нутгийн байгууллагууд, гэр бүл хамтаараа хүүхдийн эсрэг хүчирхийлэл, мөлжлөг, үл хайхрал, болон бусад хэлбэрийн хүчирхийллийн эсрэг хүчээ нэгтгэн ажиллах, дээрх нөхцөлд байгаа хүүхдийг хамгаалах, туслахад хууль тогтоомж чиглэх;
- Үндэсний төлөвлөлтийн үйл явцад хүүхэд хамгааллын асуудал туссан байх;
- Нийгмийн хамгааллын тогтолцооны нэг хэсэг ба түүний хүрээ хязгаараас давсан тогтолцоо байх;
- Төрийн байгууллагуудын хариуцлага, үйлчилгээг орон нутгийн байгууллагууд, ТББ-ууд, орон нутгийн бүлгүүд үзүүлнэ, салбар ба түвшний хооронд зохицуулалт хийх ялангуяа холбон зуучлах тогтолцоог багтаасан байх;
- Бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалах, урьдчилан сэргийлэх эрх зүйн, захиргааны, нийгмийн, боловсролын арга хэмжээ авах.

ТАЙЛАН

Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад хуулиуд нь хэрэгжилтийнхээ эхний шатанд байна.

Хүүхэд хамгааллын тухай хууль (ХХТХ) нь Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцооны хууль эрх зүйн хүрээг анх удаа үндэсний, орон нутгийн, анхан шатны түвшинд тогтоож өгсөн гэж судлаачид үзсэн ба хүүхэд хамгааллын тогтолцооны үр дүнтэй үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэдгийг оролцогч талууд хүлээн зөвшөөрсөн тул тус хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээг голлон барьж, хууль тогтоомжийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг тодорхойлов.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2016 оноос хойш хүүхэд, гэр бүлийн салбарт мөрдөгдөх 50 гаруй дүрэм, журам, стандартыг хуулийг хэрэгжүүлэх үүднээс баталж, хэрэгжилтийг хангахад анхааран ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын асуудал нь ялгаатай хэд хэдэн суурь хуулиуд, мөн олон журам, дүрэм, заавар бүхий эрх зүйн хоёрдогч баримт бичгүүдэд тусгагдсан байдаг. Энэ нь хүүхдэд хамгааллын үйлчилгээг ямар шат дарааллаар, хэрхэн хүргэх талаар үүрэг хүлээгчид тодорхой ойлголт, мэдээлэлтэй байхад хүндрэл үүсгэж байна гэж судлаачид үзсэн байгааг анхаарах шаардлагатай.


Хуульд нарийвчилсан заалтууд байхгүй, хүүхэд хамгааллын кейс менежменттэй холбоотой тодорхойлолт дутагдалтай, мөн хамгаалагдах хэрэгцээтэй хүүхдэд үзүүлэх

үйлчилгээг бүрэн тусгаагүй, үзүүлэх дэмжлэгийн түвшнийг тодорхойлж заагаагүй, хяналт мониторинг хийх тухай заалтууд байхгүй байгаагаас бүрэн хэрэгжихгүй байна гэж дүгнэсэн.

НҮБ-ын Хүүхдийн сангийн “Хүүхэд хамгаалалтай холбоотой эрсдэлд урьдчилан сэргийлэх ба хариу үйлдэл үзүүлэх зорилготой нийгмийн халамж, боловсрол, эрүүл мэнд, аюулгүй байдал, хуулийн зэрэг нийгмийн салбаруудыг хамарсан-дамнасан хууль, бодлого, дүрэм, журам ба үйлчилгээний багц” гэсэн хүүхэд хамгааллын тогтолцооны тодорхойлолтыг энэхүү тайланг бичихэд ашиглав.

Нөхцөл байдал:

Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн (2020) дүнгээс үзвэл судалгаанд оролцсон хүүхдүүдийн 42 хувь нь хамгаалуулах эрх зөрчигддөг, 29 хувь нь хөгжих эрх, 24 хувь нь эсэн мэнд амьдрах эрх, 5 хувь нь оролцох эрх зөрчигддөг гэж хариулжээ.



эрхийн зөрчил байна. Хөгжих эрхийн хувьд сургуульд сурах, амарч тоглох, сувилалд явах зэрэгтэй холбоотой эрхүүд, хамгаалуулах эрхийн хувьд хүчирхийлэл, үл хайхрах байдлаас ангид байх эрх нь, оролцох эрхийн хувьд өмчлөх, ажил үйлчилгээний хөлс урамшуулал авах эрхүүд илүүтэй нэрлэгдсэн байна.

Зөвлөмж-1:

(1) Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай хуулийг төрийн захиргааны болон бусад байгууллагын бүрэн эрх, үүргийг заасан, уламжлалт бичлэгтэй биш хүүхэд хамгааллын үйлчилгээг хэрхэн хүргэх процедурын хууль болгож боловсруулах;

(2) Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулахдаа хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэх гол зохицуулалттай ба салбар дамнасан байх хандлага, тогтолцооны хандлага баримтлах;

(3) Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиас хүүхэд хамгаалалтай холбоотой заалтуудыг Хүүхэд хамгааллын тухай хуульд нэгтгэх, дүрэм, журмуудад байгаа зарим заалтуудыг Хүүхэд хамгааллын тухай хуульд тусгах байдлаар хүүхэд хамгааллын тогтолцооны бүрэн бүтэн байдлыг хангах;

(4) Хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэхэд оролцогч бүх талуудын үүрэг, ажил үйлчилгээний хялбар, уялдаа холбоог бүрэн тодорхойлсон нийтлэг зураглалыг хамтран боловсруулсны үндсэн дээр хуулийн төслийг бичих;

(5) Монгол Улсын Эрүүгийн хуулиар 18 насанд хүрээгүй хүүхдэд бэлгийн дарамт учруулах, бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг хориглодог. Мөн 18 насанд хүрээгүй хүүхдийг цахим болон цахим бус хэлбэрээр садар самууны бичлэгт хүч хэрэглэн ашиглах, арилжаа, худалдааны зорилгоор бэлгийн хүчирхийлэл үйлдэхийг хориглодог. Цаашилбал, цахим төхөөрөмж, ухаалаг утас ашиглан насанд хүрээгүй хүүхдэд бэлгийн дарамт үзүүлэхийг хориглох талаар хууль, тогтоомжид бүрэн тусгах.

1. Хүүхэд хамгааллын талаарх мэдлэг ойлголт, хандлагын өөрчлөлт

Төрийн албан хаагчид, холбогдох салбарын анхан шатанд нийтийн/төрийн үйлчилгээ үзүүлдэг ажилтнууд, олон нийтийн дунд хүүхэд хамгааллын асуудлыг хүлээн зөвшөөрөх, эн

тэргүүнд анхаарах байдал нэмэгдсэн. Хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн ойлголт, хандлага сайжирч, хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг таньж мэдэх, мэдээлэх явдал ихэссэн.

Нөхцөл байдал:

2021 оны байдлаар нийт хүн амын 37,3 хувийг 18 хүртэл насныхан эзэлж байна. Нийт хүүхдийн дунд хагас өнчин 36,135 буюу 2.7 хувь бүтэн өнчин 2990 буюу 0.2 хувь, хөгжлийн бэрхшээлтэй 11,835 хүүхэд буюу 0.9 хувь, хүнсний эрхийн бичигт хамрагдсан 84071¹ хүүхэд буюу 9.3 хувь, нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа 457038² хүүхэд буюу 36.7 хувь байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 111,776 дуудлага мэдээлэл хүлээн авсан нь өмнөх онтой харьцуулахад 17 хувиар өссөн. Хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлт 79 хувьтай байгаа нь 2021 онтой харьцуулахад 2,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

2022 онд эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 14,207 хүүхэд, хүүхдийн асрамж, халамжийн төвд асран хамгаалуулж байгаа 974 хүүхэд, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлж, аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 3,226 хүүхэд байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон 2014 хүүхэд, хүүхэд оролцсон гэмт хэрэг 1258, гэмт хэрэгт холбогдсон 1540 хүүхэд, гэмт хэргийн улмаас хохирч амь насаа алдсан 92, бэлгийн хүчирхийллийн хохирогч 369 хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 117 хүүхэд³, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор үйлчлүүлсэн 1491 хүүхэд, хамтарсан багийн үйлчилгээ авсан 3853 хүүхэд байна.

Улсын хэмжээнд бүртгэлтэй 48 зуслан байгаагаас тогтмол үйл ажиллагаа явуулсан 38 зуслан байна. 2022 онд 59,378 хүүхэд зусланд хамрагдсан.

Улсын хэмжээнд 15 хүүхдийн хөгжлийн ордон, 6 хөгжлийн төв, 4 хүүхдийн театр, үйл ажиллагаа явуулж, 13 аймаг, 3 дүүрэгт 4-25 төрлийн дугуйлан хичээллэж, 2022 онд хөгжлийн үйлчилгээнд 61050 хүүхэд, оролцооны чиглэлээр 244 арга хэмжээнд 78,003 хүүхэд оролцсон.

Хүснэгт 1. Салбарын тоон мэдээлэл. 2018-2022 он

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	Тайлбар
1.	Хүүхдийн тусламжийн 108 утасны тоон мэдээлэл	174,818	134,877	118,662	92,762	111,776	ХТУ-108 программын мэдээлэл
2.	Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд	19,058	13,468	22,756	20,724	14207	ГБХЗХГ-ын мэдээллийн сан
3.	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ авсан хүүхэд	897	902	852	603	1491	ГБХЗХГ-ын тоон мэдээлэл
4.	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд	310	253	213	345	369	ГБХЗХГ-ын тоон мэдээлэл
5.	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хөдөлмөр эрхэлдэг хүүхэд	495	960	723	144	533	ГБХЗХГ-ын тоон мэдээлэл
6.	Хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хараа хяналтгүй хүүхэд	57	84	97	151	112	ГБХЗХГ-ын тоон мэдээлэл
7.	Асрамж, халамжийн төвд амьдарч байгаа хүүхэд	1054	1067	1069	1031	974	ГБХЗХГ-ын тоон мэдээлэл

¹ ХХҮЕГ-ын Өрхийн мэдээллийн сан 2021 он

² ХХҮЕГ-ын Өрхийн мэдээллийн сан 2021 он

³ Цагдаагийн ерөнхий газрын мэдээллийн сан 2022 он

Монгол Улсад хүчин төгөлдөр хэрэгжиж буй хууль, тогтоомжид боловсролын байгууллага, эрүүл мэндийн төв, олон нийтийн хөгжлийн төв, асрамж, халамжийн газарт хүчирхийллийн талаар мэдээлэх хүүхдэд ээлтэй арга замыг тусгаагүй.

“Гэр бүлийн дотоод асуудал” гэж зарим орон нутагт хүүхэд хамгааллын үйлчилгээ авахад нь туслахыг хүсэхгүй байх тохиолдлууд гарсан, хүүхэд хамгааллын кейс маш цөөхөн бүртгэгдсэн, эсвэл огт гараагүй гэсэн орон нутгуудад гүнзгийрүүлсэн хяналт-шалгалт хийж шалтгааныг тогтоох шаардлагатай. Хүүхэд хамгааллын асуудлыг барууны, Америкийн тогтолцоо, Монголын хөрсөнд нийцэхгүй, хүүхдийн эрх нь дэндэж байна, үүрэг хариуцлагыг нэмэх хэрэгтэй гэсэн хандлагууд түгээмэл байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таньж мэдэхээс татгалзах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл байхгүй, эсхүл түүнтэй холбоотой ийм муу зүйл гардаггүй гэх ташаа тогтсон хандлага үүнд хувь нэмэр оруулж байна. Мөн орон нутгийн удирдлагын зүгээс “гэмт хэрэг байхгүй” гэж нэр хүндээ хамгаалахыг шаардаж шахалт үзүүлдэг болох нь үнэлгээний явцад илэрсэн. Энэ нь хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг мэдээлэх шугам, сувгийн зохицуулалтын үр дүн муу байгаатай холбоотой байж болох юм.

Засгийн газар нь иргэддээ хүүхдийн эсрэг хүчирхийллийн асуудлуудын талаар мэдээллийг шат дараатай өгөх ёстой.

Зөвлөмж-2:

(1) Хүүхэд хамгааллын талаарх олон нийтийн ойлголт, хандлагыг өөрчлөхөд гол хэрэгсэл болж буй Байгууллагын хүүхэд хамгааллын загвар бодлого, Эцэг эхийн зөвлөлийн удирдамжийг иргэний нийгмийн байгууллага болон бусад талуудтай хамтран тууштай хэрэгжүүлэх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, үр дүнг үнэлэх;

(2) Хамтарсан багт ажиллаж буй төрийн албан хаагчийн ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн гэрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг тусгаж үнэлэх;

(3) Хүчирхийллийн кейсийг дарсан, нуусан тохиолдолд хариуцлага тооцох механизмыг хуулийн төсөлд тусгах;

(4) Бүх хуулиудад хүүхдийн эрхийн зарчмаар үнэлгээ хийх ажлыг үе шаттай эхлүүлэх;

(5) Зөвхөн мэдлэг ойлголт нэмэгдүүлэх сургалт хангалтгүй, хандлага, үнэт зүйл, зан үйлийг өөрчлөх сургалтуудыг төлөвлөж зохион байгуулах.

2. Хүүхэд хамгааллын нөхцөл байдалд дорвитой өөрчлөлт гарахгүй байгаа нь Хүүхэд хамгааллын тухай хуулиас хамтарсан багийн тухай заалтыг авч, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд шилжүүлсэнтэй холбоотой байна.

2017 онд Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулан хамтарсан багийн зохион байгуулалт, үүрэгтэй холбоотой заалтуудыг тус хуулиас авч, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд шилжүүлсэн. Хамтарсан багийг удирдах үүрэг хариуцлагыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (ХНХЯ)-наас Хууль зүй, дотоод хэргийн яам (ХЗДХГ)-д шилжүүлсэн. Ингэж өөрчилснөөр хүүхэд хамгааллын хариу арга хэмжээтэй холбоотой манлайлал, удирдлага зохион байгуулалтын дэмжлэгийг бууруулж, хүүхэд хамгаалал дахь нийгмийн ажлын үйлчилгээнд зориулах санхүүгийн хуваарилалт, хариуцлагыг хоёрдуулан, улмаар хамтарсан баг нь гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, тохиолдолд илүү их анхаарах ёстой гэсэн хандлагыг бий болгох зэргээр Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийг сулруулсан.

Нөхцөл байдал:

Хамтарсан баг нь үйлчилгээний түвшинд салбар дундын зохицуулалтыг хангах механизм юм. Тухайн баг нь засаг захиргааны анхан шатны нэгж дээр гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, түүний гэр бүлийг гишүүнд эмнэлгийн тусламж, сэтгэл зүй, нийгмийн халамж, хүүхэд хамгаалал, холбон зуучлах үйлчилгээг хамтран үзүүлдэг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4-т хамтарсан багийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тусалцаа, дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, чиглэл өгөх үүргийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд үүрэгжүүлэн хуульчилсан.

2017 оноос хамтарсан багийн гишүүдийг хүүхдийн эрх, хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн асуудлаар сургаж, чадавхжуулах ажлыг ХНХЯ, ГБХЗХГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллаж байна. 2018 оноос эхлэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас сум, хорооны хамтарсан багуудад хүүхэд хамгааллын кейсийн зардлыг олгож эхэлсэн байна.

2021 онд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хамтарсан багийн үйлчилгээний мэдээллийн санг цахимжуулж, nats.gov.mn программыг хөгжүүлж, 728 хамтарсан багийн нийгмийн ажилтанд таблет олгож, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг ХНХЯ, ХЗДХЯ, ГБХЗХГ болон аймаг, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас тогтмол зохион байгуулж байна.

Хүснэгт 2. Хамтарсан багаас хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан хүүхдийн тоо

№	Үзүүлэлт	2018	2019	2020	2021	2022	Тайлбар
		ОН	ОН	ОН	ОН	ОН	
1	ХБ-ийн тоо	609	676	684	731	765	ГБХЗХГ-ын мэдээлэл
2	Хамтарсан багийн шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейсийн тоо	2866	3189	4697	6946	7309	
3	Хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээ авсан хүүхэд			17679	21566	15968	
4	Хүүхэд хамгааллын кейст олгосон зардал /мян.төг/	597.1	338.5	218.2	226.1	415.3	

Зохицуулалт болон хамтарсан багийн үйлчилгээнд шаардагдах зардлыг тодорхой болгох, хүний нөөцийн тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг хангах шаардлагатай байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн **18.1.2-т** “Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх”, хуулийн **18.1.5-д** “сум, хороонд хамтарсан баг байгуулах, үйл ажиллагаанд нь хяналт тавих” чиг үүргийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд үүрэгжүүлэн хуульчилсан.

Бүх шатны Засаг дарга нарт тус хуулийн **19.1.2-т** “хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх” гэж **19.1.5-д** “хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах”-ыг үүрэгжүүлэн хуульчилсан боловч өнөөдрийг хүртэл уг асуудлыг шийдвэрлээгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

ХНХЯ-аас 2020 онд хийсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ХНХЯ, ХЗДХЯ-аас 2021 онд “Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журам”-ын хэрэгжилтэд хийсэн үнэлгээгээр аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, бүх шатны Засаг дарга нар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй, хамтарсан багийн үйл ажиллагаа хангалтгүй, хүний нөөц тогтворгүй, санхүүжилт хангалтгүй гэсэн дүгнэлт гарсан.

Зөвлөмж-3:

(1) Хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэх ажлыг хариуцах төрийн захиргааны төв байгууллагыг тодорхой болгох (ХНХЯ эсхүл ХЗДХЯ)

(2) Хүүхдэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийн механизмыг зөвхөн бүтэц, чиг үүргийн хувьд гэр бүл, залуучуудын хөгжлийн асуудлаар өргөжүүлсэн өнөөгийн бүтцийг шинэчлэн хүүхдийн асуудал хариуцсан байгууллага болгохоор хянаж үзэх. Ингэхдээ хуульд заасан үйлчилгээг ялангуяа хүүхэд, гэр бүлд үзүүлэгч талуудын оролцоо, үйл ажиллагааг зохицуулах, хянах эрх хэмжээг нэмэгдүүлэх;

(3) ХНХЯ, ГБХЗХГ, орон нутгийн ГБХЗХХ-үүд Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлэх стратеги, төсөвтэй төлөвлөгөө боловсруулах;

-Яамны түвшинд Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийг тайлагнах, хариу үйлчилгээ хүргэх байгууллагыг сонгох, сургалтын хөтөлбөр батлах, хүүхэд хамгааллын судалгаа хийх, Засгийн газрын бүх түвшинд хамтын ажиллагаа, оролцоог дэмжих зэрэг үйл ажиллагааг хуульчлах,

-Харин орон нутгийн түвшинд хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж буй оролцогч талуудад заавар, чиглэл өгөх, одоо болон ирээдүйд хийх үйл ажиллагаа, арга хэмжээний чиглэлийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх зэрэг үүргүүдийг тусгах;

(4) Шинэчлэн найруулах хуулийн төсөлд практикт бий болсон салбар дундын хамтын ажиллагааг зохицуулах.

3. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдол илрүүлэхэд авах хариу арга хэмжээ, үйлчилгээ нь ихэвчлэн хязгаарлагдмал

Монгол Улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль нь цогцоороо хүүхдийн эсрэг хүчирхийллийн кейст хариу үйлчилгээ үзүүлэхэд чиглэдэг. Кейс менежмент нь ялгаатай олон байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулахад тусалдаг бөгөөд кейс менежментийг үр дүнтэй хийхэд сайн манлайлал хэрэгтэй. Боломжтой бүх нөхцөлд, кейс хариуцсан нийгмийн ажилтан нь бусад ямар нэг ажилд сатаарахгүйгээр зөвхөн хүлээлгэн өгсөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг хариуцан кейс менежментийн үйлчилгээндээ анхаарах ёстой.

Хариу арга хэмжээнд хүчирхийлэгчийг тусгаарлах, хохирогчийг аюулгүй газар байрлуулах (бусад асран хамгаалах үйлчилгээ), хүчирхийлэлд өртсөн тохиолдолд түргэн тусламж, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, урт хугацааны эрүүл мэндийн болон сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ, сэтгэлзүйн зөвлөгөө, нөхөн сэргээх эмчилгээ, хууль эрх зүйн дэмжлэг/туслалцаа, хуулийн хамгаалалт, гэрчийн хамгаалалт үзүүлэх болон гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага, шийтгэл хүлээлгэх үйл ажиллагаа орно. Эдгээр хуулийн дагуу Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон эрүүл мэнд, сум/хороо, цагдаагийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн олон талт хамтын үйл ажиллагаатай хамтарсан баг үйлчилгээ үзүүлнэ.

Нөхцөл байдал:

Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2021 онд Улсын Их Хурлаар батлагдсан. Хуулийн нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилтийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг батлан мөрдүүлж, төсвийн зарцуулалт, үр ашигт байдал, хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих механизмыг илүү боловсронгуй болгоход анхаарч байна.

- ✓ *Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журмаар хүүхэд хамгааллын үйлчилгээг “шуурхай тусламж, үйлчилгээ”, “хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ”, “урьдчилан сэргийлэх үйлчилгээ” гэх 3 түвшинд авч үзэж байна.*
- ✓ *Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын шинэчлэлээр хүүхэд хамгааллын шуурхай тусламж үйлчилгээнд 6%, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд нийт зардлын 54%, хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 40%-ийг төлөвлөн хуваарилах зохицуулалттай болсон байна.*

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, төрийн үйлчилгээний бүтэц болгож, программын 3 дугаар шатны шинэчлэлийг хийж, утас, чат, мессежээр дуудлага, мэдээлэл хүлээн авч байна.

2017 оноос хүчирхийллийн хохирогчид аюулгүй байдлын хамгаалалт, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгжийг 5 дахин нэмэгдүүлж, 17 түр хамгаалах байр, 17 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ үргэлжлэх хугацаа харилцан ялгаатай. Хүүхдэд гарч буй ахиц, эрсдэл буурсан эсэх, хэргийн шийдвэрлэлттэй нягт уялдана. Хүүхэд хамгааллын кейс шийдвэрлэлт 2022 онд 71.7 хувьтай байгаа нь 2021 онтой харьцуулахад 2.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хамтарсан багийн гишүүд үндэсний хэмжээнд хуулийг хэрэгжүүлэхээр дагалдан гарсан журам, зааврыг ихэнхдээ дагаж мөрддөггүй.

Кейс менежментийн хариу үйлчилгээ практик дээр бараг байхгүй, нийгмийн ажилтнууд энгийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, эсхүл үйлчилгээ үзүүлэх өөр байгууллага руу кейсийг холбон зуучлах эсхүл хаах зэргээр л хариу үйлчилгээ хязгаарлагдаж байна.

Хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил, үйлчилгээний шинэчлэлийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Хамтарсан багийн гишүүд болон гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан албан хаагчдын ажил, үүргийн уялдаа холбоог сайжруулах, хамтарч асуудлыг шийдвэрлэх чадвар дээшлүүлэх зорилготой “Хүүхэд, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажил, үйлчилгээний арга зүй, кейс менежмент” сэдэвт сургалтыг зохион байгуулж, нийслэлийн хамтарсан багийн нийгмийн ажилтан, орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулжээ.

- ✓ *Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалт, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл”-ийн хэрэгжилтийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/110 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар”, А/111 дүгээр тушаалаар “Салбарын хүүхэд хамгааллын бодлого”-ыг баталсан.*
- ✓ *Байгууллага, аж ахуйн нэгжүүд хүүхдийн эрх ба бизнесийн зарчимд суурилсан хүүхдэд ээлтэй “хүүхэд хамгааллын бодлого” батлан хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлснээр салбарууд Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгээ батлан мөрдөж, үндэсний хэмжээнд 1904 байгууллага хүүхэд хамгааллын бодлого мөрдөж, 5363 байгууллага, аж ахуй нэгжийн дэргэд эцэг эхийн зөвлөл ажиллан, 522 байгууллага хүүхдийн өрөө, 68 байгууллага хүүхдийн цэцэрлэг байгуулан хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлээд байна.*
- ✓ *2022 онд “Эцэг эхийн зөвлөл”-ийн Үндэсний зөвлөгөөнийг цахимаар, 16 аймаг, 7 дүүрэг орон нутагтаа “Эцэг эхийн зөвлөл”-ийн зөвлөгөөн зохион байгуулж, арга зүйн дэмжлэг үзүүлэн, сайн туршлагыг хуваалцаж, эцэг эхийн зөвлөлийн 4381 дарга гишүүдийг хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр арга зүйгээр хангаж, 85,385 албан хаагчдыг гэр бүлийн боловсрол, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хүмүүжлийн эерэг арга зүй, хөгжлийн үйл ажиллагаанд хамруулсан байна.*

Урьдчилан сэргийлэх, чадавхжуулах сургалт, нөлөөллийн ажлын үр дүнд:

- ✓ Салбарын болон бусад салбарын албан хаагчдыг сургаж чадавхжуулах ажлыг үе шаттай зохион байгуулж ажилласны үр дүнд хууль, цагдаа, эмнэлэг, боловсролын салбарт “хүүхдэд ээлтэй арга барил”-ыг ойлгож, нэвтрүүлж эхэлсэн.
- ✓ Иргэд, олон нийт, ажлаа хийж яваа төрийн албан хаагч хүүхдийн эсрэг хүчирхийллийг мэдээлдэг, холбон зуучилдаг болсон.
- ✓ Бусад салбарын оролцоо, хамтын ажиллагаа сайжирч, хамтарсан хяналт, шалгалт хийх, сургалт, нөлөөлөл, аян зохион байгуулах ажлаа уялдуулж эхэлсэн. ТББ, хувийн хэвшлийн оролцоо, санаачилга нэмэгдсэн.

Хүндрэл бэрхшээл:

- *Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэр бүлийн орчин дахь архидалт, гэр бүлийн хүчирхийлэл бодитой буурахгүй байна.*
- *Иргэд, олон нийтийн мэргэжлийн байгууллагаас сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ авах хандлага, ойлголт сул байна.*
- *Цахим орчны сөрөг нөлөөлөл ихэсч байна.*

- Хүүхдийн хөгжлийг дэмжих орчин, үйлчилгээний хүртээмж сул байна.
- Салбар бүрд мэргэшсэн хүний нөөцийн хомсдол үүсэж байна.
- Анхан шатанд сум, хорооны Хамтарсан багийн нийгмийн ажилтан солигдсон, программ ашиглаж чадахгүйгээс кейсийн мэдээллээ бүрэн оруулж, хааж, дүгнэж чаддаггүй, ажлаас гарсан, шилжсэн нийгмийн ажилтан дараагийн хүндээ нэвтрэх эрхээ шилжүүлж, программ хэрхэн ашиглах талаар зааж зөвлөдөггүй, кейс хүлээлцэхгүй байгаа зэрэг бэрхшээл байна.

Зөвлөмж:

- (1) Хаана ажиллаж байгаагаас үл хамааран нийгмийн ажилтан, хамтарсан багийн гишүүд хүүхэд хамгаалах тохиолдол бүрд адил үүрэг гүйцэтгэх;
- (2) Хүүхэд хамгааллын кейс бүрд тодорхой нэг 'кейс менежер'-ийг томилж, кейс менежментийн үйл явцыг хянаж, удирдах ажлыг хариуцуулах заалтыг хуульд тусгах;
- (3) Хүчин төгөлдөр байгаа журмуудыг сайжруулахдаа хүүхэд хамгааллын үйлчилгээ механизмтай холбоотой хуулиудад үндэслэн хүүхдэд үзүүлэх үйлчилгээг зааглан, хамаарах субъектийн онцлог хэрэгцээ, нөхцөл байдалтай уялдуулан үйлчилгээг төрөлжүүлэх, шаардлагатай үйлчилгээний талаарх журмуудын уялдааг хангахад анхаарах;
- (4) Хуулиуд батлагдмагц боловсруулагдан тодорхой хугацаанд хэрэгжсэн, туршиж шалгасан журмуудад үнэлгээ хийх, тасралтгүй сайжруулах;
- (5) Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг олон нийтийн оролцоо, гэр бүл, мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагад суурилсан байдлаар хөгжүүлэх;
- (6) Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмыг өөрчлөх, Хүүхдийн хувийн хэргийн маягтыг товч болгох, бусад зүйлтэй холбоотой кейст хөтлөх маягтыг зөвхөн хүчирхийллийн асуудлаар зориулсан тул бусад унаач зэрэг олон төрлийн кейст тохирохоор өөрчлөх; кейс менежментийн онлайн системийг нэвтрүүлэх зэрэг олон өөрчлөлтийг хийх.

4. Хүүхэд, гэр бүлд чиглэсэн чанартай үйлчилгээ, ялангуяа хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үйлчилгээ хангалтгүй, хүртээмжгүй байна.

Хүүхэд хамгааллын хуулийг бүрэн хэрэгжүүлэхэд халамжийн хувилбарт үйлчилгээнээс гадна урьдчилан сэргийлэх үйлчилгээг хөгжүүлэх хэрэгтэй. Үүнд: хорт зуршлын эрсдэлт хүчин зүйлсэд туштай нөлөөлөх хөтөлбөр, гэр бүл салалтаас сэргийлэх гэр бүлийн дэмжлэгийн бүлэг, эцэг эхэд зориулсан хөтөлбөр зэрэг багтана.

Үйлчилгээг бэхжүүлэх, ялангуяа зорилтот урьдчилан сэргийлэх (эцэг, эхийн хөтөлбөр гэх мэт) үйлчилгээ, нийгмийн ажлын кейс менежмент, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө, сэтгэл зүйн дэмжлэг, гэр бүлд суурилсан халамжийн хувилбарт үйлчилгээ гэх мэт шинэ хэлбэрүүдийг хөгжүүлснээр хүүхэд хамгааллын эрдлийг бууруулах, хүчирхийлэл үйлдэгдэхээс өмнө асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй байх болно.

Хүүхэд хамгааллын тухай хууль нь хүүхдэд зориулсан яаралтай үед түр байрлуулж хамгаалах, мөн удаан хугацаанд байршуулан халамжлах зэрэг хамгаалах байр дээр түшиглэсэн үйлчилгээг нэмэгдүүлэхэд хүргэжээ. Үнэлгээний дүнгээс харахад Монгол Улсын хүүхэд хамгааллын тогтолцоо нь хүүхдийг аюултай нөхцөл байдлаас холдуулж, түр хамгаалах байранд байрлуулан хамгаалахаар хязгаарлагдсан байна.

Нөхцөл байдал:

ХНХ-ын сайдын А/209 тушаалаар батлагдсан “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам”-ын хэрэгжилтийн хүрээнд 2022 оны байдлаар улсын хэмжээнд хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн төвд амьдардаг хүүхдийн тоо буураагүй, 21 байгууллагын 30 төвд 1033 хүүхэд амьдарч, эдгээрийн 59 хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэжээ.

2022 онд асрамж халамжийн төвд амьдарч байгаа хүүхдийн тоо өмнөх онтой харьцуулахад 57 хүүхэд буюу 5,5 хувиар буурсан ч гэр бүлтэй хүүхдийн тоо 2021 онтой харьцуулахад 28 хүүхэд буюу 6,7 хувиар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 10 хүүхэд буюу 13,2 хувиар тус тус өссөн. Гэр бүлд эргэн нэгдсэн болон үрчлэгдсэн хүүхдүүдийн эцэг, эх, асран хамгаалагчид хүүхдийн нас болон сэтгэл зүйн онцлогийг мэддэггүй. Өөрөөр хэлбэл, хүүхдийнхээ зан үйл, сэтгэл хөдлөлийн онцлогийн талаар ойлголтгүй; хүүхэдтэй

ажиллах арга барилаа олдоггүй, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх болон хүмүүжлийн эерэг арга барилуудаас мэддэггүй болох нь судалгаагаар гарчээ.

Хүүхдийг асрамж халамжийн төвд түр байрлуулсан ч гэр бүлд эргэн нэгтгэхэд бэлтгэх үйлчилгээ хөгжөөгүй, ялангуяа асралт гэр бүлтэй адил удаан хугацаанд гэр бүлд тулгуурлан үзүүлэх халамжийн хувилбарт үйлчилгээний шийдэл, (үрчлэл, дэмжлэгт садан төрлийн асрамжийг нэмэгдүүлэх) мөн үр дүнтэй кейс менежментийг багтаасан гэр бүлийн орчинд нь дэмжих үйлчилгээ зэрэг дутагдалтай байна.

Хэдийгээр хариу үйлчилгээнд хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх, асрамж халамжид хүлээлгэн өгсний дараа хяналт, дэмжлэгээ үзүүлнэ гэсэн боловч энэ үйлчилгээ хангалтгүй байна.

Хөдөө орон нутгийн хүн ам цөөн, бие биеэ таньдаг, жижиг орон нутгийн хувьд хүүхэд дахин эрсдэлд орсныг мэдэхэд хялбар байдаг бол Улаанбаатар хотын хүн ам ихтэй хороодын хувьд кейс хаагдсанаар тухайн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ зогсдог байна. Мөн хүүхэд хамгааллын нэгдсэн системгүйгээс хүүхэд нэг дүүргээс нөгөө дүүрэг рүү эсвэл аймаг хооронд шилжихэд тухайн хүүхэд өмнө нь ямар үйлчилгээ авч байсныг мэдэх боломжгүй байна.

Хууль зөрчсөн хүүхэд, тэдний гэр бүл, эцэг эх, асран хамгаалагчтай хамтран гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг ул суурьтайгаар тодорхойлон, шалтгаан нөхцөлийг арилгах үйлчилгээг олон салбарын хамтын ажиллагаагаар гэр бүлд хүргэх үйлчилгээ байхгүйгээс хүүхэд дахин хууль зөрчих, гэр бүл, нийгэмд гадуурхагдах эрсдэл өндөр хэвээр байна.

Эрүүгийн хэрэг хянан, шийдвэрлэх тогтолцоо нь хууль зөрчсөн хүүхдэд ял, шийтгэл оноох, засан хүмүүжүүлэхэд чиглэсэн тул тэднийг ирээдүйд нийгмийн идэвхтэй, хариуцлагатай, бүтээлч иргэн болоход дэмжих, хөгжүүлэхэд зорьсон үйлчилгээ үгүйлэгдэж байна.

Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдэд үзүүлж буй өнөөгийн үйлчилгээ нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай гэрээт нэг төрийн бус байгууллагын тодорхой орон нутгийн харьяа хүүхдүүдэд үзүүлж байгаа үйлчилгээгээр хязгаарлагдаж байна. Эдгээр хүүхдэд зориулсан нөхөн сэргээх, гэр бүл, нийгэмд эргэн нэгтгэх үйлчилгээ дутмагаас суллагдсан хойноо Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагын ажилтнуудтай холбогдон үйлчилгээ авахыг хүсдэг ч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дагуу ажилтан албан хаагчид суллагдсан хүүхэдтэй хувийн харилцаатай байх нь хориотой байдаг байна.

2021 оны 12 сард зохион байгуулагдсан Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний чуулганы төлөөлөгч хүүхдүүд гэр бүлийн орчинтой холбоотой зарим гэр бүл, гэр бүлийн амьдралд хүүхдэд тохиромжгүй нөхцөл байдал их байгаа, гэр бүлд хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, оролцох бүлгийн эрхүүд бүгд ялангуяа хамгаалуулах эрх илүү зөрчигддөг, зайлшгүй хэрэгцээт зүйлсээр дутагдах, бие махбод, сэтгэл санааны хувьд хүчирхийлэгдэх, үл хайхрагдах, үзэл бодлоо илэрхийлэх боломжгүй байх, хүсэл сонирхлыг үл сонсох, аюул, эрсдэл их байдаг тухай ярьж хэлэлцсэн. Гэр бүлд хүчирхийлэх, доромжлох, хэрцгий харьцах, үл хайхрах, аашилж загнах, үзэх ядах, санаа бодлыг сонсохгүй байх зэрэг хүчирхийллийн харилцаа ааваас ээжид, ээжээс хүүхдэд, хүүхдээс бусад талуудад дамжин үргэлжилдэг гэж хүүхдүүд үзэж байна.

ХНХЯ нь Стандартчилал хэмжил зүйн газартай хамтарч “Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021 стандарт”-ыг хэрэглэх чадамжийг олгох сургалтыг Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүүхдийн сантай хамтран 3 удаа зохион байгуулж, 21 аймаг 9 дүүргийн мэргэжлийн ангийн 300 хүнийг хамруулав. Гэвч гамшиг онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал хангалтгүй байгааг Улаанбаатар хотын Налайх дүүрэгт Голомт цогцолбор сургуулийн сурагчид хордсон асуудалд хийсэн нээлттэй хяналт-шалгалтын дүн харуулав. Хүүхдийн эрх, хамгааллын асуудал эрхэлсэн бүх шатны байгууллага Хүүхдийн эрхийн хуулийн, мөн Хүүхэд хамгааллын хуулийн заалтаар хүлээсэн үүргээ туйлын хангалтгүй биелүүлсэн байв. ХХТХ-д заасны дагуу хордлогод орсон хүүхдүүдэд⁴ Налайх дүүргийн

⁴ 4.1.1."эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд" гэж эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгчгүй, эсхүл гамшиг, онцгой байдлын нөхцөлд байгаа хүүхдийг хэлнэ.

ГБХЗХХ хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ⁵ үзүүлээгүй бөгөөд бусад төрийн байгууллага хамтран ажиллаагүй. ГБХЗХГ, НГБХЗХГ зэрэг хүүхэд хамгааллын асуудал эрхэлсэн эрхэлсэн байгууллагууд орон нутгийн хэлтсийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаагүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, түүний үр дүнг үнэлж дүгнээгүй байв.

ЗӨВЛӨМЖ:

(1) Эцэг эх, асран хамгаалагчид зориулах эцэг эхийн хөтөлбөр, эхэд чиглэсэн менторын хөтөлбөр, дэмжих бүлэг зэрэг үйлчилгээ, үйл ажиллагааг багтаасан зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээг хөгжүүлэх стратегийг хамтран боловсруулах (ГБХЗХГ, НҮБХС, ба (ОУ)-ын ТББ-ууд);

(2) Гэр бүлд суурилсан хувилбарт халамжийн үйлчилгээг тухайлбал гэртээ үлдэх боломжгүй хүүхдэд зориулсан удаан хугацаанд асарч халамжлах асралт гэр бүл, үрчлэлт, албан ёсны садан төрлийн асрамжид өгөх зэрэг үйлчилгээг хөгжүүлэх (ГБХЗХГ, НҮБХС and (ОУ)ТББ-ууд);

(3) Гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгохдоо гэр бүлийн гишүүд болон донтох эмгэгт хамаарал бүхий этгээдэд үзүүлэх үйлчилгээний төрөл, нөхцөлийг нарийвчлан тодорхойлох;

(4) Хүүхэд хамгааллын тухай хуульд сургуулиуд хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх тодорхой журмыг тусгах, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрт нийгэм дэх бэлгийн дарамт болон цахим бэлгийн дарамт зэрэг бусад түгээмэл хүчирхийллийн асуудлыг тусгаж оруулах ба жендэрийн хэвшмэл ойлголтын талаар тусгах;

(5) Хүүхэд хүчирхийлэлд өртөх эрсдэл өндөртэй дотуур байр, асрамж халамжийн төвүүд зэрэг газраар айлчлах орон нутгийн хөтөлбөрийг санхүүжүүлэх, хэрэгжүүлэх;

(6) Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээнд байгаа хүүхдийн гэр бүл, асран хамгаалагчдад эрсдэлийг арилгах зорилгоор гэр бүлд чиглэсэн цогц үйлчилгээг хүүхдийн үйлчилгээтэй зэрэгцүүлэн үзүүлэх. Эдгээр үйлчилгээнд нийгмийн халамж; хөдөлмөр эрхлэлт; ажлын байранд зуучлах; мэргэжил олгох; санхүүгийн тэтгэлэг; гэр бүлийн харилцаа; хүмүүжлийн эерэг арга; сэтгэл зүйн зөвлөгөө; донтох эмгэгийн нөхөн сэргээх болон эрүүл мэндийн бусад үйлчилгээг байгууллага, салбар бүр чиг үүргийн хүрээндээ харилцан уялдаатай, цогц төлөвлөж бүрэн хэрэгжүүлэх;

(7) Гамшиг, онцгой байдлын үед хүүхэд хамгааллын байгууллага ажиллах эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

5. ИЛРҮҮЛЭЛТ ТОГТВОРТОЙ БИШ

Хүүхэд хамгааллын үйл ажиллагаатай холбоотой хуулиудыг дагаж гарсан журмууд нь хүчирхийллийн хохирогч, гэрч хүүхдийг хамгаалахад голлон анхаарснаас хөдөлмөр эрхэлдэг, ялгаварлан гадуурхагдсан зэрэг хүүхдэд шаардлагатай үйлчилгээгээ авч чадаж буй нь эргэлзээтэй байна.

Зөрчил, дуудлага цагдаагийн байгууллага эсвэл Хүүхдийн тусламжийн утсаар хүлээн авч бүртгэсэн дуудлага, мэдээллээр үйлчилгээний бүртгэл хязгаарлагдаж байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар жендэрийн мэдрэмжтэй, хүүхдэд ээлтэйгээр хүчирхийллийн тухай мэдээллийг хүлээн авч шаардлагатай нийгмийн үйлчилгээнд холбон зуучлах чиглэлээр сургалтад хамрагдсан цагдаагийн албан хаагч аймаг, дүүргийн цагдаагийн хэлтэс дээр хэргийг бүртгэж авахыг тусгасан.

Энэхүү журмыг дагаж мөрдөх сургалтад хамрагдсан цагдаагийн албан хаагчид нь орон нутгийн түвшинд хүрэлцэхгүй байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулахгүй бөгөөд хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрт биш зөвхөн жендэрт суурилсан хүчирхийлэлд хариу арга хэмжээ авах үүрэг хүлээж байна.

Зөвхөн хүн/хүүхэд мэдээлснээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлж байгаа нь хангалтгүй. Идэвхгүй аргаас өөрсдөө байнгын хяналт хийж, гэрээр/ эрсдэл өндөр холбогдох байгууллагаар явж илрүүлэх зохицуулалт байхгүй байна. Тухайлбал, үрчлүүлсэн хүүхэд, дотуур байр, асрамж, халамжийн газрууд, хүүхэд шавилан сууж буй сүм хийд, өдөр өнжүүлэх

⁵ эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, аюулгүй байдлыг хангах, дэмжих, холбон зуучлах, нийгмийн харилцаанд дасган зохицуулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх үе шат бүхий үйл ажиллагаа

төв зэрэг эрсдэл өндөр газруудаар гэнэтийн айлчлал хийж, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх шаардлагатай байна.

Гудамж талбай, олон нийтийн газар хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрх, аюулгүй байдлыг хангах зорилготой “Хүүхэд хамгаалагч” төслийг үргэлжлүүлж цагдаагийн байгууллагуудаас “Хүүхэд хамгаалагч”-аар ажиллах хүсэлт гаргасан иргэнийг сонгон шалгаруулж дөрвөлсөн гэрээ байгуулан, аймаг, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн даргын тушаалаар томилж, энэ оны 10 дугаар сараас эхлэн нийслэлийн 9 дүүргийн хороодод 153, 21 аймагт 45 нийт 198 иргэн хүүхэд хамгаалагчаар үүрэг гүйцэтгэсэн.

“Хүүхэд хамгаалагч” эргүүл 2022 онд ажлын өдрүүдэд давхардсан тоогоор 1130 чиглэлд ажиллаж, 132500 хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, төөрсөн 74, хараа хяналтгүй явсан бага насны 45 хүүхдийг гэрт нь хүргэж, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй, эрсдэлт нөхцөлд байгаа 52 хүүхдийг илрүүлж бүртгэлд оруулан харьяа газрын хамтарсан баг болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт мэдээгдэж ажилласан.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, илрүүлэх гарын авлагыг ашиглах удирдамжийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/57 дугаар тушаалаар батлуулсан. Удирдамжийг ашиглах чиглэлээр нийгмийн ажилтнуудад зориулсан сургалтыг Хүйсийн тэгш эрх төв ТББ-тай хамтран зохион байгуулжээ.

Нөхцөл байдал:

Зарим хамтарсан баг хүүхдийн эсрэг хүчирхийллийн ямар ч тохиолдол гараагүй эсхүл маш цөөн тохиолдол гарсан гэж мэдээлж байв.

Улсын дүнгээр 282 өдөр өнжүүлэх төв үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 227, орон нутгийн 14 аймагт 55 өдөр өнжүүлэх төв тус тус ажиллаж байна. Эдгээр төвүүдэд нийт 5314 хүүхэд хамрагдаж байгаагийн 85 хувь буюу 4480 хүүхэд Улаанбаатар хотод, 15 хувь буюу 834 нь орон нутагт хамрагддаг ба нэг өдөр өнжүүлэхэд дунджаар 18 хүүхэд хамрагдаж байна. Өдөр өнжүүлэх төвүүдийн 88 хувь нь 10-15 цагаар ажилладаг бол 10 хувь нь 6-9 цаг ажиллаж, хүүхдүүд хичээлээс гадуур ихэнх цагаа өнгөрүүлж байна.

Өдөр өнжүүлэх төвүүдийн 15 хувь нь хүүхэд хамгааллын бодлогын дүрэмтэй бөгөөд тэдний 80 хувь нь ажилтнуудад хүүхэд хамгааллын дүрмийг мөрдөж ажиллах гарын үсэг зуруулж, байгууллагын самбарт ил байрлуулсан байна. Мөн эцэг эх, багш нарын хүүхдийн өмнө хүлээх үүрэг хариуцлагыг албан ёсоор баталгаажуулах байдал хангалтгүй байгаа бөгөөд хоёр өдөр өнжүүлэх тутмын нэг нь хүүхдийн анкетын мэдээлэл, эцэг эхтэй байгуулсан гэрээ, гурван өдөр өнжүүлэх тутмын нэг нь үйл ажиллагааны дотоод журам, ажилчдын гэрээ огт байхгүй байна.

Түүнчлэн хоёр өдөр өнжүүлэх тутмын нэг нь агааржуулалтын систем, ариун цэврийн булан, ариутгалын бодисын хэрэглээ хадгалалт, сав суулга ариун цэврийн халдваргүйжүүлэлт байхгүй, 75 хувь нь галын дүгнэлт, галын булан, аюулгүй ажиллагааны дүрэм, хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичиг байхгүй байна.

Улсын хэмжээнд шашны үйл ажиллагаанд хүүхэд хамруулдаг 127 сүм хийдийг хамруулснаас 73 хувь нь буюу 92 сүм хийд орон нутагт, 27 хувь буюу 35 сүм хийд нийслэл Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна.

Улсын хэмжээнд Будда, Христ, Исламын шашны үйл ажиллагаанд 2837 хүүхэд хамрагдаж байгаагийн 84 хувь буюу 2341 хүүхэд Улаанбаатар хотод, 14 хувь буюу 476 хүүхэд орон нутагт хамрагдаж байна. Үүнээс тогтмол шавилан суудаг 564 хүүхэд байгаа бол 2238 хүүхэд сүм хийдийн үйл ажиллагаанд тогтмол хамрагдаж байв.

Сүм хийдэд шавилан суугаа хүүхдийн боловсрол эзэмших эрхийн асуудал төрийн холбогдох байгууллагын анхаарлын гадна үлдсэн хийгээд сүм хийдэд шавилан суугаад суурь боловсрол давхар эзэмших боломжгүй нь нэгэнт тодорхой байгаа учраас шашны сургалттай ерөнхий боловсролын сургуулийг үндэсний хэмжээнд бүсчлэн байгуулах эсхүл суурь боловсрол эзэмшсэний дараа насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд оролцуулах, шашны боловсрол олгох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай байгааг дахин сануулах нь зүйтэй.

ЖСХ-ийн бэлэн байдлыг хангахад орхигдож буй асуудлуудыг тодотгож харахад үнэлгээнд хамрагдсан эрүүл мэндийн байгууллагуудад ЖСХ-ийн хохирогчийг олон улсын

удирдамжид заасан нийтлэг арга барилаар илрүүлэх зохистой тогтолцоо хараахан бүрдээгүйн улмаас ГССҮТ-ээс бусад байгууллагуудад илрүүлэг ховор хийгддэг байна. Иймээс хохирогч нуугдмал хэвээр үлдэж, өвөрмөц дэмжлэг авч чадахгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

(1) Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх тохиолдолд мэдээлж, холбон зуучлах нэгдсэн тогтолцоотой болох;

(2) Хүүхдийн эрхийн улсын байцаагчийг дагнасан байдлаар ажиллуулах, квот тогтоон орон тоог нэмэгдүүлэх. Тухайн байцаагч нь харьяа орон нутгийн гэр бүл, эцэг эх/асран хамгаалагч, өмчийн бүх хэлбэрийн байгууллагатай хамтран хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх ажлыг хэрэгжүүлэх;

(3) Хүүхдийг үрчлүүлэх буюу гэр бүлд эргэн нэгтгэхээс өмнө урьдчилан хүүхдийн амьдрах орчны судалгааг маш сайн хийх, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн хөгжил, хүмүүжил төлөвшлийн талаар ойлголт мэдлэг олгох, сургалт хийх, зөвлөгөө өгөх, тогтмол харилцаатай байх, гэр бүлд үнэлгээ хийх, хүүхэдтэй тусгайлан уулзах, зөвлөгөө дэмжлэгээр хангах;

(4) Хүүхэд хамгааллын байгууллагын зүгээс хүүхэд үрчилсэн гэр бүлтэй тогтмол эргэх холбоотой байх, хаяг, холбоо барих мэдээлэл өөрчлөгдсөн, хүүхэд гэрээсээ явсан, цэрэгт явсан зэрэг мэдээллийг бүртгэх, хөтлөх сан үүсгэх, тодорхой хариуцсан мэргэжилтэн томилох, эцэг эх, асран хамгаалагчид мөн хариуцлага тооцох тогтолцоог бий болгох;

(5) Өдөр өнжүүлэх төвийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хүүхэд хамгааллын асуудлаарх хууль эрх зүй, тэдгээртэй холбогдох дүрэм, журмыг гаргах, гдөр өнжүүлэх төвүүдийн хөтөлбөрийг арга зүйн нэг стандарттай болгох;

(6) Насанд хүрээгүй хүүхдийг шашны үйл ажиллагаанд оролцуулах, шашны боловсрол олгох асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулах, эцэг, эхийнхээ хараа хяналтад амьдарч чадахгүй байгаа сүм хийдэд шавилан суудаг хүүхдүүдтэй ажилладаг хүмүүст чиглэсэн хүүхдийн эрхийн сургалт, ойлголт нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах, гомдол мэдээллээ өгөх үр дүнтэй арга хэрэгсэл, хүүхэд хамгааллын тогтолцоог хүртээмжтэй болгох замаар эдгээр хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах.

6. НИЙГМИЙН АЖЛЫН ЧАДАВХ СУЛ

Хүүхэд хамгааллын кейс менежмент нь чадварлаг, туршлагатай, хангалттай тооны хүний нөөц шаардах, шуурхай эрчимтэй хүргэх үйлчилгээ. Боломжтой бүх нөхцөлд, кейс хариуцсан нийгмийн ажилтан нь бусад ямар нэг ажилд сатаарахгүйгээр зөвхөн хүлээлгэн өгсөн хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдлыг хариуцан кейс менежментийн үйлчилгээндээ анхаарах ёстой.

Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021 стандартыг мөрдүүлэх, салбарын хүний нөөцийг сургаж, чадавхжуулах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулжээ. Тухайлбал:

- 21 аймаг, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын удирдлагууд болон 100 гаруй нийгмийн ажилтанд Нийгмийн ажлын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраар дамжуулан түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хамтарсан багийн нийгмийн ажилтан 570 гаруй хүнд сургалт зохион байгуулсан.

- Нийгмийн ажлын үйлчилгээний стандартыг 2500 хувь хэвлүүлж, Боловсролын ерөнхий газар болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраар дамжуулан нийгмийн ажилтнуудад түгээсэн.

Нөхцөл байдал:

Цөөн нийгмийн ажилтантай, ур чадвар, мэргэжлийн удирдлага ба менежментийн дэмжлэг хангалтгүй; хүүхэд, гэр бүлийн гишүүдтэй уулзах тусгай өрөө тасалгаа байдаггүй. Хангалттай боловсон хүчин дутагдаж байгаа нь үйлчилгээний чанар алдагдахад хүргэж байна.

Төрийн анхан шатны байгууллагын харьяа нийгмийн ажилтнуудыг орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын харьяанд шилжүүлэх тухай МУ-ын Гэр бүлийн тухай хуулийн төсөлд тусгагдсан.

ЗӨВЛӨМЖ:

(1) Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тохиолдол дээр ажиллаж буй бүх нийгмийн ажилтан нь нийгмийн ажлын боловсролтой, хүүхэд хамгааллын сургалтад хамрагдсан байхыг шаардах;

(2) Орон нутгийн ГБХЗХХ-ээс сум, хорооны нийгмийн ажилтныг мэргэжлийн удирдлагаар хангах тодорхой бүтцийг бий (Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18–р зүйлийг дагуу) болгох;

(3) ГБХЗХГ нь зохих сургалт, заавраар хангах, хянах тухай хуулийн заалтыг хэрэгжүүлэх.

7. Сум, хорооны түвшинд ажилладаг хамтарсан багт хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт маш бага хуваарилагддаг.

Хүүхэд хамгааллын тухай хууль хэрэгжсэний дүнд МУ-ын ЗГ-аас хүүхэд хамгааллын ажилд зарцуулах төсөв, хөрөнгө нэмэгдсэн.

НҮБ-ын Хүүхдийн сан, Засгийн газрын захиалгаар хийсэн “Монгол Улсын Хүүхэд хамгааллын үйлчилгээний өртөг ба төсвийн дүн шинжилгээ” судалгаанд дурдсанаар хуулийн хэрэгжилтийг хангахад 11.5 тэрбум төгрөг шаардлагатай гэж үзсэн.

Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдэхэд УИХ, Засгийн газраас онцгойлон анхаарч ажиллаж байна. Тодруулбал,

- 2017 онд 1.2 тэрбум төгрөг;
- 2018 онд 6.4 тэрбум төгрөг;
- 2019 онд 7.6 тэрбум төгрөг;
- 2020 онд 8.0 тэрбум төгрөг;
- 2021 онд 8.0 тэрбум төгрөг;
- 2022 онд 8.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган баталсан.

2021 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны “Аргачлал, зардлын норматив батлах тухай” А/23, 27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг батлан мөрдүүлж байна.

Орон нутгийн хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт ноцтой хэмжээнд дутагдалтай хэвээр байгаа, үүний улмаас хуульд заагдсан хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд саад бэрхшээл ихээхэн тулгарч байгаа тухай үнэлгээний дүн илтгэлээ.

Үнэлгээнд оролцсон бараг бүх оролцогчид санхүүжилтийн хязгаарлагдмал байдал нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилт, ялангуяа хамтарсан багийн үйл ажиллагаанд саад бэрхшээл болж байгааг цохон тэмдэглэж байв.

Санхүүжилттэй холбоотой хууль эрх зүйн орчин хангалтгүй байна. Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг санхүүжүүлэх тухай ерөнхий заалт байгаа боловч Цаашлаад хүүхэд хамгааллын санхүүжилтийн нарийн төлөвлөлт, зарцуулалтын зориулалт, ангилал болон ил тод байдал зэрэг нарийвчилсан эрх зүйн баримт бичиг байхгүй байна.

Нөхцөл байдал:

Монгол Улсын төсвөөс 2023 оны төсвийн жилд хүүхэд харах үйлчилгээний зардалд 1,510,475,100 төгрөгийг зарцуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад батлуулсан.

Засгийн газрын 2022 оны 97 дугаар тогтоолоор Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам"-ыг батлуулж, "Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам"-ыг ХНХС-ын 2022 оны А/180 дугаар тушаалаар баталж мөрдүүлэн ажиллаж байна.

ГБХТТ хуулиар ЖСХ-тэй тэмцэх үйл ажиллагааг улсын төсвөөс санхүүжүүлэх үүргийг холбогдох эрх бүхий байгууллагууд хүлээсэн хэдий ч ЭМЯ-ны түвшинд ч, байгууллагуудын түвшинд ч энэ үйл ажиллагаанд зориулсан төсөв хуваарилагддаггүй. Эмнэлэгт суурилсан ЖСХ-ийн НЦҮТ-ийн тогтвортой санхүүжилт шийдэгдээгүй хэвээр байна.

8. Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдийн оролцоотой шууд холбоотой заалт байхгүй байна.

Хүүхдийн эрхийн тухай конвенцод хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүний үндсэн эрхийн нэг бөгөөд энэхүү эрхийг нийгмийн бүхий л орчинд хангах нь хүүхэд өсвөр үеийнхний чадавхад, нийгмийн хөгжилд ч эергээр нөлөөлдөг. Төрийн дөрвөн шатлалт үүрэг бол хүний эрхийг хангах, хамгаалах, хүндэтгэх, хүний эрхэд ахиц гаргах бөгөөд хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавьж үзэх, хүүхдийн амьдралын бүхий л талбарт утга учиртай оролцоог хангахад төрийн үүрэг оролцоо нэн чухал юм.

Хүүхдийн эрхийн тухай хуульд хүүхдийн үзэл бодол, саналыг хүндэтгэн үзэх тухай зааж, хүүхэд нь үзэл бодлоо шууд илэрхийлэх, эсхүл ямар нэг эвсэл холбоогоор дамжуулан илэрхийлэх, мэдээлэл хайх ба хүлээн авах эрхтэй гэж заасан байдаг.

Нөхцөл байдал:

Хүүхэд хамгааллын тухай хуульд хүүхдийн оролцоотой шууд холбоотой заалт байхгүй байна. Гадуурхагдсан, эмзэг бүлгийн хүүхдүүд хүүхэд залуучуудын байгууллагад нэгдэх, үйл ажиллагаанд оролцох оролцоо нь бусад хүүхдүүдтэй харьцуулахад мэдэгдэхүйц бага байна.

Нийгмийн аль ч түвшинд хүүхэд өөрт хамааралтай асуудлаар шийдвэр гаргахад оролцох боломж, нөхцөл бүрдээгүй.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэхдээ насанд хүрэгчид өмнөөс нь шийдвэр гаргадаг.

Гэмт хэрэгт сэжиглэгдсэн, ял шийтгэл хүлээсэн хүүхдэд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхгүй хэмээн ханддаг.

Харилцааны зөөлөн ур чадвар, даван туулах чадварт суралцах боломж нөхцөл хангалтгүй. (Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал, ДЗОУБ, 2021)

ЗӨВЛӨМЖ:

(1) Хүүхэд хамгааллын тогтолцооны бүх хүрээнд хүүхдийн оролцоог хангаж ажиллах дүрэм, журмыг боловсруулж, хэрэгжүүлэх арга зүйд оролцогч бүх талуудыг сургах;

(2) Гэр бүл, сургууль, орон нутаг, үндэсний хэмжээнд, шүүхийн тогтолцоонд хүүхдийн оролцох үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахад чиглэсэн хууль эрх зүйн орчныг сайжруулах, Тухайлбал: шинэ бие даасан бодлогын баримт бичиг боловсруулах, одоо хэрэгжиж байгаа бодлого эрх зүйн баримт бичгүүдийн хэрэгжилтийг сайжруулах, тэдгээрт нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулах, ялангуяа сургуулийн дүрэм журам, бүтэц, үйл ажиллагааны төлөвлөлт, хяналт болон төсвийн төлөвлөлтөд сурагчдын оролцоог хангах асуудлыг дүрэм журмаар зохицуулах гэх мэт;

(3) Хүүхдийн оролцооны тухай ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, энэ хүрээнд хүүхдийн үзэл бодлыг сонсох үүрэг бүхий хүмүүс эцэг эх, шүүх захиргааны ажилтан, багш боловсролын байгууллагын ажилтан,

эрүүл мэндийн ажилтан зэрэг хүмүүст хүлээсэн үүрэг эрхэлж буй ажилтай нь холбоотойгоор хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар тохирсон сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулах, эерэг хандлага уламжлалыг бий болгох; хүүхдүүдэд мөн энэ чиглэлээр тохирсон сургалт хөтөлбөр бий болгох хэрэгжүүлэх;

9. Салбар хоорондын хамтын ажиллагаа сул, хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллахгүй байсан ч тодорхой хариуцлага хүлээдэггүй

Хүүхэд хамгааллын тухай хууль нь гэр бүл, боловсрол, эрүүл мэндийн салбар, хэвлэл мэдээлэл, дижитал орчин болон олон нийтийн орчинд үүрэг хүлээгчдийн хүлээх чиг үүрэг, хариуцлагыг тодорхойлсон.

Хүүхдийн эрхийн тухай хуулиар Хүүхдийн төлөө зөвлөл үндэсний болон орон нутгийн зөвлөл нь хүүхдийн эрхийг хангахад нийгмийн нөөц баялгийг дайчлах; салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах шаардлагатай арга хэмжээ авах; холбогдох төрийн байгууллагад чиглэл, хуулийн этгээдэд зөвлөмж өгөх үүрэгтэй. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн гишүүнд бүх яамдын Төрийн нарийн бичгийн дарга нар, ХЭҮК, ОУБ болон ТББ-ын төлөөлөл ордог бол орон нутгийн түвшинд Засаг дарга, нийгмийн ажилтан буюу нийгмийн бодлогын түшмэл, боловсролын газар, эрүүл мэндийн газар, цагдаагийн газар, хөдөлмөр, нийгмийн халамжийн газар зэрэг орон нутгийн түвшний нийгмийн үйлчилгээ үзүүлэгч нар багтдаг.

Нөхцөл байдал:

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны өнөөгийн хэлбэрээр салбар дундын зохицуулалтыг хангах боломжгүй. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл нь жилд нэгээс хоёр удаа хуралдаж тухайн жилийн ажлын төлөвлөгөөг баталж, өнгөрсөн онд хийсэн ажилтай танилцах зарчмаар ажиллаж байгаа нь тус зөвлөл салбар дундын зохицуулалт хийж ажиллах үүргээ биелүүлэхгүй, бэлэг тэмдэг төдий ажиллаж байгаагийн илрэл юм. Тиймээс Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлөөс шийдвэр гарган хүүхдийн талаар шийдсэн салбар дундын хамтын ажиллагааг бэхжүүлсэн тохиолдлууд хуруу дарам цөөн байна.

Орон нутаг, анхан шатны ХТЗ-ийн үйл ажиллагаа нь харилцан адилгүй, Засаг даргын мэдлэг, хандлагаас бүрэн хамааралтай. (Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал,

ЗӨВЛӨМЖ:

(1) Үндэсний болон орон нутгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн чиг үүргийг тодорхой болгох төлөвлөгөө боловсруулах (яамдын хооронд болон хүүхэд хамгаалалд оролцдог салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих, хүүхэд хамгааллын тогтолцооны үйл ажиллагааг хянах, ХНХЯ ба ГБХЗХГ-д “шүүмжлэлтэй ханддаг найз” болох гэх мэт).

(2) Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих Ажлын хэсэг, Хүүхдийн төлөө зөвлөл зэрэгт иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг нэмэгдүүлэх замаар оролцоо, ил тод байдал, хариуцлага, хяналт, нөлөөллийг нэмэгдүүлэх;

(3) Салбар дундын хамтын ажиллагааг зохицуулахын тулд салбар бүрийн оролцоог нарийн тодорхойлж холбогдох хууль, журамд тусгах, салбар бүрд хүүхэд хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллуулах, салбарын хүүхэд хамгааллын чадавхыг бэхжүүлэх, сургалтыг одоо байгаа сургалтын системд суулгах, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээнд шаардлагатай төсөв, хөрөнгийг жил бүр салбарын төсөвт суулгах.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ:

ЖСХ-тэй тэмцэхэд эрүүл мэндийн салбар тодорхой үүрэгтэйгээр оролцох эрхзүйн дэмжлэгт орчин байгаа хэдий ч ЖСХ-тэй тэмцэх асуудал эрүүл мэндийн бодлогын баримт бичгүүдэд хангалттай тусгагдаагүй байгаа нь харагдлаа. Тухайлбал, эрүүл мэндийн салбарт жендерийн тэгш байдлыг хангах стратеги төлөвлөгөө болон нөхөн үржихүй, эх, хүүхдийн эрүүл мэнд үндэсний төлөвлөгөө зэрэг цөөн баримт бичигт ЖСХ-тэй тэмцэх хариу арга

хэмжээний зарим үйл ажиллагаа орсон хэдий ч эрүүл мэндийн салбарын стратеги төлөвлөгөө, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц үйл ажиллагааны стандартууд гэх мэт гол бодлогын баримт бичгүүдэд уг асуудал тусгагдаагүй байна. Энэ нь эрүүл мэндийн байгууллагуудад ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээний хэрэгжилт сул байхад нөлөөлж байна.

ЖСХ-ийн эсрэг хариу арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, хянах талаар эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжлийн зааварчилгаа хангалттай бус байлаа. Одоогоор Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага (ДЭМБ)-ын удирдамжийн дагуу боловсруулсан ЖСХ-ийн талаарх үндэсний удирдамж/протокол байхгүй байна; хүчирхийлэлд өртсөний дараа үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт гараагүй байна; ЖСХ-ийн сургалтын нэгдсэн хөтөлбөр буюу гарын авлага алга.

ЭМЯ-наас хүчирхийллийн хохирогчид эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх болон сэтгэлзүйн зөвлөгөө өгөх тухай журмуудыг батлан гаргасан байгаа. Гэхдээ эдгээр журмууд нь Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ), ДЭМБ-аас гаргасан хүчирхийлэлд өртсөн охид, эмэгтэйчүүдэд зайлшгүй шаардлагатай тусламж үйлчилгээний багц (ЗШТҮБ) орсон эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цогцоор нь авч үзээгүй, тухайлбал, хохирогч эмэгтэйд ээлтэй дэмжлэг, хүчингийн дараах цогц тусламжийг хангалттай тусгаагүй байна.

Эрүүл мэндийн ажилтан ЖСХ-ийг цагдаад болон холбогдох байгууллагад мэдээлэх үүрэг хүлээдэг ч ГССҮТ-өөс бусад байгууллагын ажилтнууд маш цөөн тохиолдлыг мэдээлдэг байна.

ЗӨВЛӨМЖ:

- Эрүүл мэндийн яам, хамтрагч талууд ЖСХ-д өртсөн хохирогчид эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ үзүүлэх Үндэсний удирдамжийг батлах, байгууллагын түвшинд уг удирдамжийг хэрэгжүүлэх протоколын хамтаар олон улсын стандартад суурилсан боловсруулж хэрэгжүүлэх;
- Сургалтын нэгдсэн гарын авлагатай болох, холбогдох тусламж үзүүлэгчдийг бүрэн сургах, төгсөлтийн өмнөх ба дараах хөтөлбөрүүдэд ЖСХ-ийн эсрэг эрүүл мэндийн хариу арга хэмжээг оруулах зэргийг багтаасан чадавх бэхжүүлэх стратегитай болох;
- Хууль эрхзүйн болон бодлогын орчныг олон улсын нотолгоонд суурилсан зөвлөмжүүдтэй бүрэн нийцүүлэх, жишээ нь эрүүл мэндийн ажилтан ЖСХ-ийн тохиолдлыг заавал мэдээлэх заалтыг өөрчлөх талаар ухуулга нөлөөллийн ажил хийх. (Хамтарсан үнэлгээний тайлан: Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг эрүүл мэндийн салбарын хариу арга хэмжээний бэлэн байдал Монгол Улсад, ЭМЯ, НҮБХАС, 2023)

Боловсролын салбарт:

Боловсролын орчинд хүүхдэд аливаа шийтгэлийн арга хэрэглэх, ялгаварлан гадуурхах, дарамт, хүчирхийлэлд өртүүлэхийг хориглож, хүчирхийллийн асуудлыг илрүүлэх, мэдээлэх, үйлчилгээг дэмжих, хүүхдэд хүчирхийллийн бус харилцааны мэдлэг, ур чадвар олгох, зан үйлд нөлөөлөх зэрэг сургалт явуулах, хүчирхийллээс ангид орчин бүрдүүлэх үүрэг зохицуулалтыг Боловсролын тухай, Бага дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх тухай зэрэг хуулийн 40 гаруй заалтаар хуульчилжээ.

Боловсрол сургалтын байгууллагад суралцаж байгаа хүүхэд бүрийг тухайн орчинд бие мах бодийн шийтгэл, сэтгэл зүйн болон үе тэнгийнхний дарамт, үл хайхрах байдал, гэмт хэрэг, зөрчил, хорт зуршилд өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор БШУЯ-ны зүгээс 2017-2020 онуудад хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр дараах дүрэм журам, нийтлэг шаардлагуудыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”,
- “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх журам”,

- “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журам”,
- “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт”,
- “Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын дотуур байрын орчин, үйлчилгээний стандарт”,
- “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчны эрүүл ахуйн стандарт”

Нөхцөл байдал:

2021 оны 12 сард зохион байгуулагдсан Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний чуулганы төлөөлөгч хүүхдүүд “Сургуулийн орчинд зарим сургууль дотуур байрны орчинд хүүхдэд ээлтэй бус, үе тэнгийнхний дарамт их, ялгаварлан гадуурхдаг, бие махбод, сэтгэл зүйн хүчирхийлэл гардаг, багш нар зүй бус ханддаг, байрын багш ажилтны хүүхэдтэй харилцах харилцаа муу, ариун цэврийн өрөө хэцүү, үргэлж л хоол мөнгөний асуудалтай байдаг. Цэцэрлэг, өдөр өнжүүлэх, асрах газарт хүүхэд бие махбодын шийтгэл, бага насны хүүхдэд зүй бус харьцах өшиглөх, цохих, алгадах байдал зөндөө, өдөр өнжүүлэх шаардлага хангаагүй газар орчинд хүүхдийг дээрэлхэж, “гарч хүрч” байлгадаг, хүнсний аюулгүй байдал муу, асрах газарт сэтгэл зүйн дарамт их, ганцаардал, сэтгэл гутрал, дээрэлхэл, үл хайхрах байдал их. Хөгжих орчин байхгүй.” гэж үнэлжээ.

Хүүхэд хамгааллын бодлогын хандлага дээрдэж эхэлсэн ч хэрэгжилт тааруухан, 24 цагийн цэцэрлэг, МСҮТ, дотуур байранд хүүхэд хамгаалал сул байна.

Сургуулийн Хүүхэд хамгааллын бодлого батлагдаж хэрэгжээд даруй дөрвөн жил болж байгаа ч тус бодлого мэргэжлийн хяналтад үзүүлдэг олон цаасны нэг болж хэрэгжилт биеллээ олохгүй байна. Багш нарын хувьд хүүхдийн эрх, хамгааллын талаар мэдлэг дутмаг байгаа учир заавал мэдээлэх үүргээ төдийлөн ухамсарлахгүй байна. Сургуулийн орчинд гарч байгаа хүүхэд хамгааллын хамгийн түгээмэл асуудал нь багшийн ёс зүйн зөрчил, үе тэнгийн дээрэлхэлт, ялгаварлан гадуурхалт мөн дотуур байрны сурагчдын асран хамгааллын асуудал юм. ЕБС-ийн хэмжээнд 2019 оны эхний таван сарын байдлаар 395.0 мянган хүүхэд эрсдэлд нөхцөлд байгааг үнэлж тогтоосон байна.

БШУЯ, УИХ-ын байнгын хорооны зөвлөмжөөр дунд сургуульд хүүхэд хамгааллын үйлчилгээнд шаардлагатай төсвийн тооцоог хийж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйлчилгээнд 445.0-485.0, эрсдэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд 162.0-331.0 сая төгрөг нийт 521.0-708.0 сая төгрөг нэг сургуульд дунджаар шаардагдах тооцоолол гаргажээ.

ЗӨВЛӨМЖ:

(1) Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын ажлыг эрчимжүүлэхийн тулд сургууль дээрх мэргэжилтнүүд багаар ажиллах зохицуулалтыг хийх;

(2) Сургууль дээр сэтгэл зүйч ажиллуулах замаар сэтгэл зүйн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэлтийг анхан шатны нэгжид сайжруулах;

(3) Эцэг, эх/ асран хамгаалагчдыг хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг аргад сургах;

(4) Хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажилд хүүхдийг оролцоог хангах;

(5) сургуулийн багш, ажилтнуудын ажил үүргийн хуваарьт хүүхэд хамгааллын ажлыг оруулах;

(6) хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлэх болон урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулахад шаардлагатай төсвийг суулгах;

(7) Сургуулийн нийгмийн ажилтны тоог нэмэгдүүлэх, сургууль бүрд сэтгэл зүйч ажиллуулах.

10. Хангалттай мэдээлэл дутагдах зэрэг асуудлаар сорилт, бэрхшээл тулгарч байна.

Хүүхэд хамгааллын ажлын үр дүнг үнэлэх, хянах, тайлагнах, бодлого, хөтөлбөрийн өөрчлөлт, тохируулгыг хийхэд нотолгоог үндэслэх чухал байдаг.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран 2016 онд батлагдсан Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийж, үр дүнг олон нийтээр хэлэлцүүлж, 2 хуульд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж байна. Мөн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам, Хамтарсан багийн ажиллах, санхүүжүүлэх журам"-д тус тус үнэлгээ хийж, журам шинэчлэх ажлыг зохион байгуулж байна.

Мэдээллийн санг сайжруулах хүрээнд статистик мэдээ авдаг маягтуудын давхцалыг арилгаж, 7 маягтыг 2020 онд шинээр батлуулсан.

Үндэсний статистикийн хорооны даргын 2018 оны А/136, А/153, 2016 оны А/331 тоот тушаалаар дараах маягтууд батлагдсан:

- "Гэр бүлийн статистикийн нэгдсэн үзүүлэлтийг тооцох аргачлал"-ын хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиргааны мэдээллээс гарах 13 үзүүлэлтийн 4 маягт;
- "Залуучуудын статистикийн нэгдсэн үзүүлэлт, түүнийг тооцох аргачлал"-ын хүрээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын захиргааны мэдээллээс гарах 16 үзүүлэлтийн 5 маягт;
- Хүүхдийн төлөө үндэсний газрын даргын 2016 оны 03 сарын 04-ний өдрийн А/28 тоот тушаал "Хүүхэд хамгааллын статистик үзүүлэлт";
- ГХБЗХГ-ын даргын 2018 оны 10 сарын 18-ны өдрийн А/208 тоот тушаал "Хүүхэд хөгжил, хамгааллын үйлчилгээний мэдээ авах, нэгтгэх маягт;
- ГБХЗХГ-ын даргын 2017 оны А/34 тоот тушаал "Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дуудлага мэдээллийн маягт.

Нөхцөл байдал:

Өмнө дурдсанчлан Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой тоон мэдээлэл олох боломж их хязгаарлагдмал байна.

Монгол Улсын өнцөг булан бүрд тохиолдсон хүүхэд хамгааллын тохиолдлуудын тухай стандартчлагдсан захиргааны мэдээллийг цуглуулах өргөн хүрээтэй хүүхэд хамгааллын мэдээллийн баазыг бий болгож чадаагүй байгаа нь тод харагдлаа.

Хүүхдийн тусламжийн утасны мэдээлэл нь дуудлага бүрийн шалтгааныг бүртгэдэг ерөнхий мэдээллийг баазыг агуулдаг хэдий ч дуудлага бүрийн цаана байгаа хүүхдийн нас, хүйс, эсхүл хөгжлийн бэрхшээлийн тухай нарийвчлан задалсан мэдээлэл байхгүй, мөн тухайн дуудлагын тохиолдол бүрд чиглэсэн хариу арга хэмжээний тухай мэдээлэл агуулаагүй байна.

ЖСХ-ийн асуудал эрүүл мэндийн салбарын мэдээллийн удирдлагын тогтолцоонд шууд утгаар ороогүй учраас ЖСХ-ийн тохиолдлыг болон тусламжийг тусгайд нь бүртгэх, мэдээлэх ажиллагаа байгууллагуудад хийгдэхгүй байсан.

Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан хүүхдэд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос ямар төрлийн үйлчилгээ үзүүлж байгаа талаар мэдээлэл байхгүй.

ЗӨВЛӨМЖ:

(1) Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийг багтаасан хүүхэд хамгааллын дижитал мэдээллийн удирдлагын системийг байгуулж, ажиллуулж эхлэх

(2) Хүүхэд хамгааллын үйлчилгээний явц, үр дүнг шинжлэх, мэдээллийг үүрэг хүлээгч, үйлчилгээ үзүүлэгч талуудад шуурхай хуваалцах, хариу арга хэмжээний уялдааг хангах

мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлэх. Тус системийг бусад салбарын мэдээллийн сантай харилцан мэдээлэл солилцох механизм болгох;

11. Хүүхэд хамгааллын үйлчилгээний эрх тэгш байдал

Хамгаалал хэрэгтэй хүүхэд бүр адил тэгш хамгаалагдах ёстой. Хамгааллын үйлчилгээ нь зөвхөн амьдарч буй орон нутгийн харьяаллаас хамаарахгүй, малчин өрх, дотоодын шилжилт хөдөлгөөн хийсэн өрхийн хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдийн амьдралын хэв маягт тохирсон илүү уян хатан байх явдал их чухал.

Дараах эмзэг бүлгүүд хүүхэд хамгааллын үйлчилгээ авч чадахгүй тогтолцооны гадна “орхигдож” байна:

Хүснэгт 3.

Бүлгүүд	Шалтгаан	Шийдэл
1 Малчин өрхийн хүүхэд	Хүүхэд хамгааллын тухай хууль нь голлон төвлөрсөн суурин газрын засаг дарга болон орон нутгийн төрийн байгууллагаар дамжиж хэрэгжиж байна. Хөдөө орон нутгийн нүүдэлчин өрхийн хүүхдийг хамгаалахад хамгааллын тогтолцоо нь сайн тохирохгүй байна.	Хуулийн шинэчлэлд хүүхэд хамгааллын мэргэжлийн удирдлага, кейс менежментийг тодорхойлж, хүүхэд хамгааллын үйлчилгээний журамд үйлчилгээний хэлбэр, алхмуудыг тодорхой зааж өгөх.
2 Хууль зөрчсөн хүүхэд	Хууль зүйн хорооны үйл ажиллагаа сайн биш. Хууль зөрчсөн хүүхдэд чиглэсэн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ муу байна.	Ажлын албаны үйл ажиллагааны чиглэл, чадавхыг сайжруулах.
3 Дотуур байрны хүүхэд	Үе тэнгийн дээрэлхэл	Дотуур байрны талаарх салбарын хууль эрх зүйн орчинд зохицуулалт байхгүй. 2019 онд батлагдсан дотуур байрын стандартаас өөр барих баримт бичиг байхгүй.
4 Шилжин ирсэн бүртгэлгүй иргэдийн хүүхэд	Дотоодын шилжилт хийсэн иргэдийн хүүхдүүдийн хувьд оршин суух бүртгэлийн шаардлагатай холбоотой тэдэнд хүүхэд хамгааллын үйлчилгээ улмаар нийгмийн болон халамжийн үйлчилгээ авахад нь хаалт, бэрхшээл тулгарч байна. Дотоодын шилжин ирсэн өрхийн хүүхдийн хамгаалал сул.	Бүх хүүхдэд хууль адил тэгш үйлчилнэ.
5 Баян-Өлгий дэх тува, казах хүүхдийн хамгааллын асуудал	Төрөлх (казак, тува) хэл дээрх зөвлөгөө, мэдээлэл,	Үндэстний цөөнхөд хүртээмжтэй байдлаар хүүхэд хамгааллын урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээг үзүүлэх.
6 Өнөр бүл төвийн хүүхдүүд	174 хүүхдээс 63 хүүхэд (39,4%) нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 20 буюу (16,7%) нь эмгэг сэтгэцтэй, 15 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, 5 хүүхэд группт байдаг. Мэргэжлийн хяналтын Ерөнхий газрын Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагчийн хяналт шалгалтын танилцуулгаас, 2022	Олон хүүхэд оюуны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд хамрагддаг
7 Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхэд	УИХ-аас 2021 онд баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн суурь зарчимд “хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах” цоо шинэ зохицуулалт тусгаж, -Тус хуульд 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын нөхцөл, - 15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд	-Үндэсний их баяр наадмаас бусад уралдаан, сунгаа үсэргээний үед хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчин шаардлагатай. -ЗГ-ын 2019 оны 57 дугаар тогтоолоор жил бүрийн 10 дугаар сарын 01-05 дугаар сарын 01 хүртэл уралдаан сунгаа үсэргээг хориглосон.

		<p>оролцуулах бүрд хүүхдийн эрхийн байцаагчаас зөвшөөрөл авах, - насанд хүрээгүй хүнийг ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллуулах, уртын ээлжээр ажиллуулахыг хориглосон хүүхдэд ээлтэй эрх зүйн зохицуулалттай болсон. ХНХ-ын сайд холбогдох жагсаалтуудыг баталсан байна. -Үндэсний их баяр наадмын тухай хуулиар хурдан морины уралдаанч хүүхдийн насыг 8 болгож, үндэсний их баяр наадмын үед хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг сайжруулсан.</p>	
8	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	Хөгжлийн бэрхшээлтэй 11435 хүүхэд байна.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах эрх, эсэн мэнд амьдрах, хөгжих эрх хангагдахгүй байна.
9	Бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй/ өртсөн охид	<p>Хэдийгээр охид, хөвгүүдийн аль аль нь бэлгийн хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй ч охид илүү их бэлгийн хүчирхийллийн хохирогч болж байгаа тухай мэдээлэл их байна. Бэлгийн хүчирхийллийн тохиолдол цөөн мэдээлэгдэж байгаагийн нэг шалтгаан нь авах боломжтой үйлчилгээнүүд дутагдалтай байгаатай холбоотой байж болох юм.</p>	Баг, сумын түвшинд мэдээлэх, тусламж хүсэх, эмчилгээтэй холбоотой дараагийн бэрхшээл нь тусламж авахаар хандан очиж байгаа хүний мэдээллийн нууцыг хадгалах чадвар, ёс зүйтэй холбоотой асуудал.
10	Хөвгүүд	<p>Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шүүхээр шийтгүүлсэн хүүхдүүдийн дийлэнх нь нь хөвгүүд байгаа ба хуулийн дагуу авах ёстой үйлчилгээгээ хүүхэд авч чадахгүй байна. Одоогийн тогтолцоонд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн хүүхдийг эргэн нийгэмд ороход туслах дэмжлэг байхгүй байна</p>	Хүүхэд хамгааллын тухай хуулийг хэрэгжүүлэхгүй, хүүхдийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг хэвийн явуулахгүй байгаа нь хөвгүүдэд шударга бус хандах, хөвгүүдийг гадуурхагдсан эрсдэлтэй бүлэгт хэвээр үлдээх үр дагавартай байна.

12. Хүүхэд хамгааллын тухай хууль нь иргэний харьяалалгүй хүүхдэд хамаарахгүй юм шиг харагдаж байна.

Зөвлөмж: Иргэншлээс үл хамааран "Монгол улсад амьдарч байгаа бүх хүүхдэд энэ хууль хамаарна" гэж (ХЭК-тэй нийцүүлэн) Хүүхэд хамгааллын тухай хуульд өөрчлөлт оруулах

13. ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛАЛ

Интернэт болон цахим технологийн эрин үед хүүхдийн сурах, хөгжих, тоглох, бие биетэйгээ харилцах хэлбэр үндсээрээ өөрчлөгдөж тэдэнд өөрийгөө илэрхийлэх, мэдлэг боловсрол эзэмших, авьяас чадвараа хөгжүүлэх маш өргөн боломжууд нээгдэж байна. Гэвч нөгөө талаас интернэт болон цахим орчинд хүүхдүүд өөрсдийн насанд тохироогүй зохисгүй контент буюу мэдээлэл, зураг, бичлэг зэргийг олж үзэх, садар самуун, хүчирхийллийн шинж чанартай контентыг бусдаас хүлээж авах, хүчирхийлэл, бусад гэмт хэргийн хохирогч болох явдал нэмэгдэж байна.

Нөхцөл байдал:

Хүүхдийн эрхийн хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль болон бусад хууль, түүнийг даган гарсан журам дүрэм боловсруулж, эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч цахим орчинд

хүүхдийн хамгаалагдах эрх зөрчигдсөөр байгааг статистикийн тоо баримтууд харуулсаар байна. Монгол Улсад цахим орчинд хүүхдийг хүчирхийллээс хамгаалах тухай хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудад ч зохицуулалт хангалтгүй байна.

2015-2019 онд цахим орчинд 43 хүүхэд хохирсон. Гэмт хэргийн төрлөөр нь авч үзвэл, залилах гэмт хэрэгт 6, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах гэмт хэрэгт 7, хүчиндэх гэмт хэрэгт 1, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэгт 1 хүнийг яллагдагчаар татжээ.

Судалгаанд оролцсон хүүхдийн 50 хувь нь цахим дарамтад өртөж, тэдний 15 хувь нь энэ талаар эцэг, эхдээ хэлсэн байна.

2021 оны 12 сард зохион байгуулагдсан Хүүхдийн оролцооны байгууллагуудын үндэсний чуулганы төлөөлөгч хүүхдүүд “хэвлэл мэдээлэл, цахим орчин нь хүүхдүүд хамгийн их харьцдаг мэдээллийн орчин. Энэ орчны мэдээлэл болон харилцааны хандлага, хэлбэр хүүхдэд сөрөг нөлөө их байна. Хүүхдүүдийн эсрэг ашиглах хэлбэр, байдал нь илүү гэмт хэргийн шинжтэй болж байгааг” илэрхийлжээ.

Эрүүгийн хуулийн 16.8 болон 16.9-д хүүхдийг садар самуунд уруу татах, ашиглахыг хориглосон заалт байдаг ч садар самуун явдал гэсэн ойлголтыг нарийвчлан тодорхойлоогүйн дээр цахим орчинд хүүхдийг садар самуунд оролцуулах, уруу татах, ашиглах болон бодит хүүхдийг оролцуулаагүй ч хүүхдийн дүрсийг дуурайлгасан зохиомол дүрийг садар самуунд талаар тусгайлсан заалт оруулаагүй байна. Түүнчлэн, цахим орчинд хүүхэд уруу татах, холбоо тогтоох, урхидах, цахим орчинд хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдэхээр дарамтлах гэх зэрэг бусад нарийн асуудлуудыг хуульчилж, зохицуулаагүй байна.

Зөрчлийн тухай хуульд хүүхдийн эрхийн зөрчилд оногдуулах зөрчлийг тодорхойлон заасан ч цахим орчин дахь хүүхдийн эрхийн зөрчил, хүүхдийн эсрэг бэлгийн дарамт, хүчирхийлэл, бэлгийн мөлжлөгийн шинжтэй зохицуулалтуудыг нарийвчлан заагаагүй байна.

Тус хуулийн 8 дугаар зүйлд “хэвлэл мэдээлэл, цахим орчинд хүүхдийг түүний хөгжил, эрүүл мэнд хүмүүжил, төлөвшилд, сөрөг нөлөө үзүүлэхүйц тоглоом, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгаа, цахим сүлжээнээс хамгаална” гэж гэр бүл, сургууль, болон хуулиар үүрэг хүлээсэн бусад этгээдүүд хүүхдийг хэрхэн хамгаалах үүрэгтэйг хуульчлан зохицуулсан байдаг. Ингэхдээ хүүхдэд зориулсан цахим агуулга контент нь хүүхдийн хөгжил, эрүүл мэнд, хүмүүжил, төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зааж, хэрэв тус хуулийн заалт зөрчигдсөн тохиолдолд авах арга хэмжээ, хариуцлагыг ерөнхийлөн заасан боловч процедурын шинжтэй нарийвчлан оруулаагүй байна. (Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам, 2021)

ЗӨВЛӨМЖ:

- (1) Нэгдэн орох шаардлагатай олон улсын гэрээг судалж, бүс нутгийн хэмжээнд цахим гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ, мэдээллийн системд элсэж, сайн туршлагыг нэвтрүүлэх, үр дүнг тогтмол үнэлэх механизмтай болж улмаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх стратеги бодлогодоо тусгах;
- (2) Цахим орчин дахь хүүхэд хамгаалал, хүүхдийн эсрэг бэлгийн мөлжлөг болон бэлгийн бурангуй үйлдлээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх салбар дундын зохицуулалтыг хангасан тусгайлсан хуультай болох эсвэл холбогдох эрх зүйн баримтыг шинэчлэх;
- (3) Зохисгүй агуулга, хууль бус контентын албан ёсны тодорхойлолтыг холбогдох эрх зүйн баримт бичигт тусгаж оруулах;
- (4) Иргэдээс ирсэн гомдол хүсэлтийн дагуу хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллийг тодорхойлдог бие даасан зөвлөл байгуулан ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- (5) Хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээний стандарт гаргах, сөрөг нөлөөтэй мэдээллийг насны ангилалд тохируулан ялгамжтай, оновчтой тодорхойлох;
- (6) Хүүхдийн эсрэг чиглэсэн аливаа төрлийн хүчирхийлэл, хүүхдийн эрүүл мэнд, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшилд сөрөг нөлөө бүхий мэдээллийг зориуд түгээхтэй холбоотой хууль бус үйлдлийг шуурхай таслан зогсоох, шалган шийдвэрлэх, буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлэх.

14. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо зохих ёсоор ажиллахгүй байна.

Орон нутгийн түвшинд ГБХЗХГ-ын зэрэгцээ аймаг, дүүргийн Засаг дарга тус бүр тухайн орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай зөвшилцөн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, байгуулах шаардлагатай байдаг. Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны сөрөг үр дагаврыг хамгийн бага байлгах, хүүхдийг нийгэмшүүлэх, сэргээн засах үйлчилгээ үзүүлэх ерөнхий зорилгоор гэмт хэрэг, зөрчил үйлдсэний улмаас шийтгэл хүлээсэн, хариуцлага тооцуулсан хүүхдүүдтэй харилцдаг үүрэгтэй юм.

Нөхцөл байдал:

Гэмт хэрэг, зөрчилд холбогдон шүүхээр шийтгүүлсэн хүүхдүүдийн дийлэнх нь нь хөвгүүд байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлд гэмт хэрэг, зөрчилд холбогдсон эсхүл шүүхээр шийтгүүлсэн хүүхдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээний тухай заасан. Энэ үйлчилгээ нь хүүхэд хамгааллын тогтолцооны нэг хэсэг бөгөөд энэ үйлчилгээнд боловсролын хөтөлбөр, зөвлөгөө, уулзалт, нөхөн сэргээх үйлчилгээ, мэргэжлийн боловсрол, сургуультай эргэн нэгтгэх зэрэг үйлчилгээ хамаарна. Энэ үйлчилгээг хамтарсан багаар биш Хүүхэд хамгааллын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хүүхдийн эрхийн хууль зүйн хороогоор дамжуулан хүргэнэ.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо нь мөн хохирогч, гэрч хүүхдэд тусламж үзүүлэх үүрэгтэй. Гэвч тус үнэлгээгээр энэ хороо нь амьдралд дээр ажилладаггүй болох нь илэрсэн.

Хуульд төсөв, тодорхой зохицуулалт, хэрэгжүүлэх механизмыг тодорхой зааж тусгаагүй учраас хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны шаардлагатай хамрах хүрээ, гишүүнчлэл, ажиллах журам нь орхигдон дутагдаж, хуулийн дагуу авах ёстой үйлчилгээгээ хүүхэд авч чадахгүйд хүргэж байна. Одоогийн тогтолцоонд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн хүүхдийг эргэн нийгэмд ороход туслах дэмжлэг байхгүй байна. Гэмт хэрэг үйлдсэн шалтгаанд чиглэсэн нарийн мэргэжлийн үйлчилгээ байхгүй үед хүүхдийн гэр бүлийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан, мансууруулах бодисын хамааралтай болсон, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай эсхүл оюуны хөгжлийн бэрхшээлтэй зэрэг асуудалтай хүүхэд богино хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэх магадлалыг ихэсгэх талтай.

Монгол Улсын нэгдэн олон улсын гэрээ конвенцод нийцүүлэн Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос үйл ажиллагааг бий болгосон хэдий ч хууль зөрчсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ (i) хүүхэд болон тэдний асран хамгаалагчийн үзэл бодлыг тусгах, үр дүнтэй байдлаар оролцох боломжийг хангах; (ii) эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийг гишүүдийн хууль зөрчсөн хүүхдийн өмнө хүлээсэн үүргийг таниулах, үүргээ биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх; (iii) сайн дурын ажилтан, сайн дурын байгууллага, олон нийтийн байгууллага болон олон нийтийн оролцоог хангах; (iv) олон нийт, гэр бүл, найз нөхдийн зүгээс хууль зөрчсөн хүүхдийг ялгаварлан гадуурхахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрх зүйн орчин, үйлчилгээ үзүүлэх механизмд тусгаагүй байна.

Хэдийгээр Монгол Улс нь олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргийн дагуу Сургалт, хүмүүжлийн тусгай байгууллагыг хорих ялаар шийтгэгдсэн хүүхэд, өсвөр насны хүний эрхийг хангах зорилгоор бий болгосон ч тус байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгодог Хорих ангийн дотоод журам, Нийгмийн ажлын аргачилсан заавар, Сэтгэл зүйн ажлын заавар, Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр зэрэг нь насанд хүрэгчдийн хорих ангитай ижил.

Нийтэд тустай ажил хийх ялыг хууль зөрчсөн хүүхдээр хэрхэн гүйцэтгүүлэх талаар тусгайлан заасан журам байхгүй учир насанд хүрэгчидтэй хамт энэ ялыг эдэлж байна. Энэ төрлийн ялаар шийтгэгдсэн хүүхэд ихэвчлэн гудамж талбай цэвэрлэх, мод тарих, зүлэг

ногоо арчлах ажил хийдэг нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдал, ёс суртахуунд хор нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхдийн сургалтын төлөвлөгөөг тухайн орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хариуцсан ажилтан хүүхдийн оролцоог хангалгүй, хүсэл сонирхол, хэрэгцээг судлан үзэлгүйгээр хүүхэд бүрд нийтлэг байдлаар гарган, дотоод нөөц бололцоогоороо хэрэгжүүлж байна. Хүмүүжлийн чанартай арга хэмжээг хэрэгжүүлснээр хүүхдэд гарсан өөрчлөлтийг хэмжих, үйлчилгээний үр дүнг хэмжих үнэлгээ, мониторингийг оролцогч талуудын аль ч хийхгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Гэрч, хохирогч, хууль зөрчсөн хүүхдийн эрхийн хангах талаар

- (1) Хүүхэд холбогдсон болон хохирогч болсон эрүүгийн болон зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийг Улаанбаатар хотод бий болгох;
- (2) Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны үе шат бүрд хүүхдийн эрхийг хамгаалах талаар зайлшгүй оруулах;
- (3) Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/ үйлдсэн насанд хүрсэн этгээдэд тэнсэн харгалзах ял өгдөг атлаа энэ төрлийн хэрэгт холбогдсон хүүхдүүдэд бүгдэд нь хорих ял оногдуулах; шийдвэр гаргаж байгааг өөрчлөх, хүүхдэд хорихоос өөр төрлийн хариуцлага оногдуулах эрх зүйн орчныг бий болгох;
- (4) ЦЕГ, УЕП болон ШЕЗ-ийн тоон мэдээллийг харьцуулж гаргадаг байх;
- (5) Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүүхэд бие даан нэхэмжлэл гаргасан тохиолдолд бүртгэх боломжтой байх;
- (6) Гэр бүл цуцлах хэрэг маргааны үед хэдэн хүүхдийн хууль ёсны эрх ашиг хөндөгдөж, хэрхэн шийдвэрлэгдэж байгаа талаар мэдээллийг шүүхийн программд тусгах (программд нь энэ төрлийн бүртгэлийг хийх цонх байхгүй);
- (7) Хүүхдийн санал асуух ажиллагааг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар нарийвчлан зохицуулах;
- (8) Гэр бүл цуцалснаас хойш хүүхдийн эрх хэрхэн хамгаалагдаж байгаад хяналт тавьдаг механизмыг бий болгох;
- (9) Гэмт хэргийн талаар гомдол мэдээлэл хүлээн авах, шалгах ажиллагаанд сэжиглэгдэж байгаа хүн нь хүүхэд байх тохиолдолд хэрхэн шалгах талаар зохицуулалтыг бий болгох;
- (10) Мөрдөн байцаалтын ажиллагаа эхлэхээс өмнө буюу сэжигтнээр тооцогдохоос өмнө хийгдэх хэрэг бүртгэлт, мөрдөн шалгах ажиллагаанд хүүхдийг хэрхэн оролцуулах, хувийн байдлыг тогтоох ажиллагааны явцад насанд хүрээгүй хүүхдийг хэрхэн хамгаалах талаар зохицуулалтыг бий болгох;
- (11) Хүүхдээс “гэрч” гэж мэдүүлэг авдаг байдлыг таслан зогсоох;
- (12) Эрүүгийн хэрэгт холбогдсон хүүхдийн хэрэг хянан шийдвэрлэх зарим ажиллагаанд зөвхөн “хууль ёсны төлөөлөгч”-өөр дамжуулан оролцохоор байгааг өөрчлөх, хүүхэдтэй ашиг сонирхлын зөрчилтэй, хүүхдийг хамгаалах боломжгүй хууль ёсны төлөөлөгчийн оронд хүүхдийн эрх ашгийг хамгаалах боломжтой бусад субъект оролцох бололцоог бий болгох;
- (13) Хохирогч, холбогдогч эмэгтэй болон эрэгтэй хүүхдээс (ялангуяа хүчингийн гэмт хэргийн үе) мэдүүлэг авах ажиллагааг зайлшгүй ижил хүйсийн алба хаагчаар гүйцэтгүүлэх, энэ чиглэлийн хүний нөөцийг бэлтгэх;
- (14) Хохирогч хүүхдийн “хууль ёсны төлөөлөгч”-өөр зөвхөн эцэх эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг томилохоос гадна хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж чадах сурган хүмүүжүүлэгч эсвэл хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын алба хаагчийг томилох боломжийг хуулиар бий болгох;
- (15) Хохирогч хүүхдийг зайлшгүй хууль зүйн туслалцаагаар хангаж, өмгөөлөгчтэй мэдүүлэг өгдөг байх талаар хуульд тусгайлан заах;

- (16) Хохирогч хүүхдийг хамгаалах тогтолцоог зөвхөн “түр хамгаалах байр” гэдгээр хязгаарлах бус хүүхдийн тав тухтай, айдасгүй байх бүхий л бололцоог хангаж, гэмт хэрэгт холбогдсон этгээдийг тусгаарлах арга хэмжээ авдаг байх эрх зүйн орчныг бий болгох;
- (17) Хорихоос бусад төрлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дахь хүүхэд хамгааллын тогтолцоог бий болгох. Тухайлбал, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны этгээдэд хэрхэн хяналт тавих, сургууль, боловсрол эзэмших эрхийг нь хэрхэн хангах, хүүхэд хамгааллын бусад байгууллагатай хэрхэн хамтран ажиллах талаар зохицуулаагүй байна. (Хүүхэд хамгааллын тогтолцооны зураглал, ДЗОУБ, 2021)

II ХЭСЭГ.

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 6 ДУГААР БҮЛГИЙН 6.20 ДУГААР ЗҮЙЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Хүүхдийн эрхийн байцаагчид нь хүүхдийн эрхийн 16 төрлийн зөрчлийг шалган шийдвэрлэх, хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүрэгтэй ажиллаж, 2022 онд 110 зөрчлийг шалган шийдвэрлэж, 32,9 сая төгрөгийн торгууль оногдуулсан байна.

Хүснэгт 4.Хүүхдийн эрхийн зөрчил шалган шийдвэрлэсэн тоон мэдээлэл

№	Үзүүлэлт	2018 ОН	2019 ОН	2020 ОН	2021 ОН	2022 ОН
1	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо	87	171	125	91	110
2	Хяналт, шалгалтын тоо	174	833	1113	93	667

-Мөн Хүүхдийн эрхийн улсын байцаагч нар Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/122, А/123 тоот тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт” болон “13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын төрөл, хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл”-д хяналт тавьж, мөрдүүлэх, дүгнэлт гаргах чиг үүргийг гүйцэтгэж байна.

-УИХ-аас 2022 онд баталсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хурдан морины уралдаанд оролцох хүүхдийн насны доод хязгаарыг 8 нас болгож, уралдаанч хүүхэд нь үндэсний хурдан морины уралдааны үед болон морины сунгаа, бэлтгэлийн үеийг хамруулсан нэг жилийн ослын даатгалд даатгуулсан байх, бүх шатны Засаг дарга “Үндэсний их баяр наадмын үндэсний хурдан морины уралдаан болон бусад сунгаа, бэлтгэлийн үед хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор уг нөхцөлийг үүсгэж байгаа үйл ажиллагааг хязгаарлах, хориглох арга хэмжээг авах, хяналт тавих.” зэрэг хуулийн зохицуулалттай болсон.

-Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолоор “жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хурдан морины үсэргээ, сунгаа, уралдаан зохион байгуулахыг хориглож”, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022-2023 онд энэ төрлийн зөрчил гараагүй.

-2022 оны 6 дугаар сарын 01-ээс хойш зохион байгуулагдсан 259 хурдан морины уралдаан зохион байгуулагдаж, 7596 хүүхэд хурдан морь унасан.

Нөхцөл байдал

Хүүхдийн эрхийн ажилтан-улсын байцаагч аймагт 1-2 хүн, зарим аймаг, дүүрэгт улсын байцаагч байхгүй, суманд огт байхгүй. Дүүрэгт ганц нэгээс хэтрэхгүй, СХД-т байхгүй байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн дагуу торгууль тавихаас өөр эрх мэдэлгүй байна.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн байдал салбарын хуулиар тодорхой зохицуулагдаагүй, мөн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, багш мэргэжилтэй албан хаагч улсын байцаагчийн эрх авч ажиллаж байгааг дахин нягталж үзэх, хууль хэрэглэх, зөрчил шалгах ажиллагаа маш муу байна. Хүүхдийн эрхийн улсын байцаагч нь эрх зүйч мэргэжилтэй байх нь хуулийг хэрэглэх, зөрчлийг хуулийн хүрээнд шалгахад илүү үр дүнтэйг анхаарч өөрчлөлт хийх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

- (1) Хүүхдийн эрхийн тухай хуулиар хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, ГБХЗХГ-ын нийгмийн ажилтан, Орон нутгийн ГБХЗХГ-ын нийгмийн ажилтан, Хүүхдийн эрхийн ажилтан- улсын байцаагч гэсэн албан тушаалын чиг үүргийг эргэн нягтлахын зэрэгцээ хүүхдийн эрхийг хангахад мэргэжлийн ажил үйлчилгээтэй нь уялдуулах.
- (2) Нэр томъёог нэг мөр ойлгомжтой болгох, аливаа зөрчилд хүрч ажиллаж чаддаг байх нөхцөлийг бий болгон уг албан тушаал, ажил үйлчилгээ нь сум, баг, хороонд байх нөхцөлийг хангахаар шинээр зохицуулах
- (3) Хүүхдийн эрхийн ажилтныг анхан шатны нэгжид ажиллуулж, төсөв хуваарилах;
- (4) Хүүхдийн эрхийн улсын байцаагчийг ажил үүрэг давхар гүйцэтгэх нөхцөлийг өөрчлөх, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- (5) Эрх зүйч мэргэжлийн хүнийг Хүүхдийн эрхийн улсын байцаагчаар сургаж, эрх олгох, хуульд өөрчлөлт оруулах;
- (6) Хүүхэд хамгааллын асуудлыг давхар хариуцаж байгаа бүтцийн зураглалыг дахин судалж, өөрчлөх.

III ХЭСЭГ.

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 14 ДҮГЭЭР БҮЛГИЙН 14.1 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХ ЗААЛТАД ДУРДСАН ЯМАРВАА НЭГЭН ШИНЖЭЭР ЯЛГАВАРЛАН ГАДУУРХСАН ҮЙЛДЭЛ

Монгол Улс Үндсэн хуулиараа иргэдийнхээ үндсэн эрх, эрх чөлөөг баталгаажуулсны нэг нь ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх юм.

Эрүүгийн хуулийн Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт хүнийг ялгаварлан гадуурхаж, хувийн эрх, эрх чөлөөг нь хязгаарласан үйлдлийг бүхэлд нь “ялгаварлан гадуурхах” гэмт хэрэгт тооцсон.

Нөхцөл байдал:

Нээлттэй нийгэм форум ба Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн 2021 онд хийсэн “Шинэ төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийн байдал” судалгааны тайланд дараах дүн шинжилгээг хийсэн байна.

Ялгаварлан гадуурхах гэмт хэрэг нь цагдаагийн байгууллагын албан ёсны статистик мэдээний маягтад 14.1 дүгээр зүйлээрээ тусгагдаагүй байна.

Монгол Улсын шүүхийн 2019 оны 3 дугаар улирлын шүүн таслах ажиллагааны тайлангийн “Хянан шийдвэрлэсэн зарим хэргийн харьцуулалт” гэсэн 2.2 дахь хүснэгтэд Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг (14-р бүлэг) гэсэн багана оруулсан байх боловч хянан шийдвэрлэсэн гэмт хэргийн тоон мэдээлэл тусгагдаагүй байна.

ЦЕГ-ын Статистик мэдээллийн хэлтсээс авсан судалгаагаар улсын хэмжээнд Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан 5 хэрэг бүртгэгдсэнээс 2018 онд 2, 2019 онд 1, 2020 онд 1, 2022 онд 1 хэрэг тус тус бүртгэгджээ.

Хэргийг ангилж үзвэл үндэс угсаа, нийгмийн гарал үүслээр нь ялгаварлан гадуурхсан 3, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхсан 1, бэлгийн чиг баримжаагаар нь ялгаварлан гадуурхсан 1 тохиолдол байна.

Цагдаагийн байгууллага “гэмт хэргийн шинжгүй” гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгох саналтайгаар 3, яллах дүгнэлт үйлдүүлэх саналтайгаар 1 хэргийг прокурорын байгууллагад шилжүүлжээ. 2020 онд шүүхээр шийдэгдсэн “ялгаварлан гадуурхах” хэргийн тухайд Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2020 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 2020/ШЦТ/868 дугаартай шийтгэх тогтоол гарчээ.

Уг шийтгэх тогтоолд хохирогчийн эрх, эрх чөлөөг нь хязгаарласан буюу төрөлхийн болон жам ёсны, түүнчлэн бусад эрхийг нь хориглосон, хязгаарласан шинж байхгүй тул ялгаварлан гадуурхах гэмт хэргийн шинжийг хангахгүй байна гэж дүгнэн хэрэгсэхгүй болгожээ. Эндээс хэдийгээр холбогдогчийн зүгээс хохирогчийг ялгаварлан гадуурхсан үйлдэл нь тогтоогдсон ч хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан шинжгүй л бол гэмт хэрэгт тооцох боломжгүй байгаа Эрүүгийн хуулийн зохицуулалт хэргийн шийдвэрлэлтийн байдалд сөргөөр нөлөөлж, хохирогч хохирсон хэвээр үлдэхэд хүргэжээ.

Хүнийг ялгаварлан гадуурхах үзэгдэл нийгэмд газар авсан ч хуулиар шийдэгдэх явдал хангалтгүй байна. Зөвхөн сурч боловсрох эрхийн хувьд авч үзэхэд хүүхдүүд нийгэм-эдийн засгийн статус, хөгжлийн бэрхшээл, үндэс угсаа, хэл соёл, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, шилжин суурьшсан байдал, өсвөр насандаа жирэмсэлсэн, хүүхэд төрүүлсэн зэргээрээ ялгаварлан гадуурхагддаг гэдэг нь “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслээс хийсэн боловсролоос гадуурхагддаг бүлгийн хүүхдүүдийн талаарх хэд хэдэн судалгаанаас тод харагддаг.

Эрүүгийн хуульд зохицуулагдаагүй үлдсэн болон засан сайжруулах шаардлагатай зарим асуудал байх тул ялгаварлан гадуурхахтай тэмцэх эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзэх боломжгүй байна.

Шүүхийн практик болон цагдаагийн байгууллагад шалгагдсан гэмт хэргийн хувьд хэдийгээр холбогдогчийн зүгээс хохирогчийг ялгаварлан гадуурхсан үйлдэл нь тогтоогдсон ч хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан шинжгүй л бол гэмт хэрэгт тооцох боломжгүй байна. Хохирогчийн эрх, эрх чөлөөг хязгаарласан байх нь Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлд заасан “ялгаварлан гадуурхах” гэмт хэргийн объектив талын заавал байх шинж учраас энэ шинжийг хангаагүй тохиолдолд хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэрэг үүссэн ч шүүхийн шатанд хэрэгсэхгүй болох гол шалтгаан болж байна.

ЗӨВЛӨМЖ

- (1) Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй 30 гаруй хуулиар ялгаварлан гадуурхалтыг хориглосон боловч түүнийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг орхигдуулжээ. Иймд бусад хуулийг зөрчиж хүнийг ялгаварлан гадуурхсан үйлдэл бүрд тохирох хариуцлагын төрөл, хэмжээг хуульчлах нь хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх заалтыг хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлэх болно.
- (2) Хууль сахиулах, прокурор болон шүүхийн ажилтнуудын ялгаварлах гадуурхах гэмт хэргийн асуудлаар ажиллах мэргэжлийн чадавхыг бэхжүүлэх,
- (3) Монгол улсын нэгдэн орсон Хүүхдийн эрхийн, Боловсролын талаар алагчлахтай тэмцэх, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэг олон улсын гэрээ конвенцыг шүүхийн практикт хэрэглэх явдлыг дэмжих,
- (4) Ялгаварлах гадуурхах гэмт хэргийн талаар статистик цуглуулах, нийтэд мэдээлэх, олон нийтэд хандан буруушаах, тамлан зогсоохыг уриалах.

IV ХЭСЭГ.

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТ

Хүний эрхийн үндэсний комисс шинэ бүрэлдэхүүнээр ажиллаж эхэлснээс хойш хугацаанд буюу 2020 оны 10 сараас 2022 оныг дуусталх хугацаанд хүүхдийн эрхийн

хэрэгжилттэй холбоотой нийт 17 зөвлөмжийг холбогдох төрийн байгууллагуудад өгсөн байна.

2020 оны 10 сараас 2021 он дуустал 8 зөвлөмж, 2022 онд 9 зөвлөмж өгснөөс 7 зөвлөмж бүрэн (100%), 7 зөвлөмжийг хэрэгжих шатанд (70%), 3 зөвлөмжид хариу ирүүлээгүй тул хэрэгжээгүй гэж үзэж байна.

Хүснэгт 5.

Боловсролын салбар	Хөдөлмөр нийгмийн хамгааллын салбар	Эрүүл мэндийн салбар	Хурдан морины уралдаан
10	3	1	3

Боловсролын салбарт хамгийн олон зөвлөмж өгсөн бөгөөд багш нарын зүгээс үзүүлэх бие махбодын шийтгэл, хүүхдийг сургуулиас хөөх шийтгэл үзүүлж байгааг зогсоох, хувийн сургууль хүүхдийг ялгаварлан гадуурхсан, эрхийг зөрчсөн байдлыг засаж залруулах, зохицуулах, 2-3 настай хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, хүүхдэд үзүүлж байгаа тусламж үйлчилгээний чанар, эмийн хяналт, дотуур байрны нөхцөлийг сайжруулах, дотуур байрны хүүхдийн хоолны чанар, ариун цэврийн ерөөний үйлчилгээний хэвийн үйл ажиллагаа, хүйсийн ялгаатай болгох, дотуур байрны төсөв санхүүжилт, цалин хөлсийг бүрэн олгох, сургууль дээрх хүүхэд хамгааллыг сайжруулах, дотуур байр ашиглалтад оруулах, багш ажилчдын ажлын байрны бэлгийн дарамт, ажлын байрны дарамт, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсоох, хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэх, Хөдөлмөрийн хуульд нийцүүлэх, хөдөлмөрийн гэрээг хуулийн дагуу байгуулах, бичиг хэргийн бүртгэл, өргөдлийн хариу өгөх зэрэг зөвлөмжүүдийг өгчээ.

Нийгмийн хамгааллын салбарт Хамтарсан багийн арга зүйг удирдамжаар хангаж ажиллах, ТАХ-ын ёс зүйн хариуцлагыг сайжруулах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зөвлөмжийг өгсөн байна.

Хүүхэд хамгааллын салбар ба орон нутгийн удирдлагуудад өвөл хаврын морин уралдаан зохион байгуулахгүй байх, унаач хүүхдийн эрхийг хамгаалах, Унаач хүүхдийн хамгааллыг сайжруулах, хүүхэд гэмтэж бэртсэн тохиолдолд бүртгэж мэдэгдэх, буруутай этгээдэд хариуцлага тооцох зөвлөмж өгчээ.

Эрүүл мэндийн салбарт 2-3 настай хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, 2 сайдын хамтарсан тушаалын зүйл заалтыг өөрчлөх зөвлөмж өгсөн.

ЗӨВЛӨМЖ

- (1) ХЭҮК-оос хүүхдийн эрхийн хэрэгжилттэй холбоотой холбогдох төрийн байгууллагуудад өгсөн зөвлөмжийг нийтэд ил тод мэдээлэх;
- (2) ХЭҮК-оос хүүхдийн эрхийн хэрэгжилттэй холбоотой холбогдох төрийн байгууллагуудад өгсөн зөвлөмжийн биелэлтийг жил тутам УИХ-д тайлагнах.

ТАВ. ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧЛИЙН ХАРИУ АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хамгаалал, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх үйлчилгээ, бусад харилцааг зохицуулсан 50 гаруй журам, дүрэм, стандарт, эрх зүйн баримт бичиг мөрдөгдөж байна.

Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгаагаар нийт хүн амын тоо 3.4 саяд хүрч, үүнээс 37.3 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна.

2021 онд 39.1 мянган өнчин хүүхэд байгаагийн 2.9 мянга (7.6 хувь) нь бүтэн өнчин хүүхэд, 36.1 мянга (92.4%) нь хагас өнчин хүүхэд, хүнсний эрхийн бичигт хамрагддаг хүүхэд

84,071 (6.6 %), нийгмийн халамжийн зайлшгүй дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхөд амьдарч байгаа 457,038 (36.7%) хүүхэд байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхэд 14207, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр үйлчлүүлсэн хүүхэд 3226, хүүхдийн асрамж, халамжийн 21 байгууллагын 30 төвд 1031 хүүхэд, 2023 оны 1 дүгээр улиралд 974 хүүхэд амьдарч байна.

5.1. ТУСГАЙ ДУГААРЫН УТАСНЫ ТӨВД БҮРТГЭГДСЭН ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЗӨРЧИЙН ДУУДЛАГА МЭДЭЭЛЭЛ, ШИЙДВЭРЛЭЛТ

5.1.1 Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв

Тус төв нь 2012 оны 10 дугаар сараас үйл ажиллагаагаа эхэлсэн ч дуудлага мэдээллийн дата сангийн бүрдүүлэлт, программын үйл ажиллагаа 2020 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэлсэн.

Нийт 13 орон тоотой, түүний 10 нь дуудлагын оператор. 17:30 цагаас хойш иргэд гомдол, саналаа цахим хуудсаар дамжуулан өгдөг. Дуудлага, мэдээллийн ачааллын оргил өдөр 1000 гаруй дуудлага иргэд, олон нийтээс ирдэг бөгөөд нэг иргэн дунджаар 3-30 минутын хугацаанд гомдол, саналаа хэлдэг байна.

2020 оноос хойш тус төв нь 423,745 дуудлага мэдээлэл хүлээн авч, 75,755 дуудлага мэдээллийг шийдвэрлэж ажилласан байна. Нийт дуудлага мэдээллийн 135,894 нь лавлагаа мэдээлэл, 46,332 нь гомдол, 13,376 санал, 7,094 хүсэлт, 5,412 талархал, 7,118 тасарсан дуудлага, 575 дугаар андуурсан, 330 шүүмжлэл байна.

2020 оноос хойш хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр нийслэлийн хэмжээнд 51 дуудлага мэдээлэл, 21 аймгийн хэмжээнд 70 дуудлага мэдээлэл нийт 121 хүлээн авч, холбогдох байгууллагад холбон зуучилж, шийдвэрлэлтийн мэдээллийг авсан байна.

Ажлын өдрүүдэд 08:30-17:30 цагийн хооронд иргэд, олон нийтээс ирсэн талархал, хүсэлт, гомдол, санал, шүүмжлэлийн талаарх дуудлага мэдээллийг хүлээн авдаг.

Ажлын хэсэг 13:30-16:00 цагийн хооронд ажиллахад төрийн үйлчилгээний цахим мэдээллийн сан E-mongolia.mn-д холбогдсон системийг салгах болсон шалтгаанаар системд доголдол үүссэн, нэг ч дуудлага аваагүй.

Иргэд, олон нийтэд үйлчилж буй тус төвийн удирдлага, ажилтнуудын харилцаа, хандлага дутагдалтай, нээлттэй хяналт-шалгалт явуулах тухай удирдамжид тусгасан хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангалтгүй, хүүхдэд ээлгүй, ажлын хэсгээс шаардсан мэдээ тайлан, тайлбарыг хангалтгүй ирүүлсэн зэрэг зөрчил дутагдалтай байсан.

ДҮГНЭЛТ:

- Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв нь Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах газрын бүтцэд байдаг, бие даасан байгууллага биш тул Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсэг, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй, байгууллагын хүүхэд хамгааллын бодлого"-оо баталж мөрдөөгүй, байгууллагын эцэг, эхийн зөвлөл байгуулагдаагүй, хүүхдийн өрөө байхгүй;
- Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн 2018-2022 оны нийт хүлээн авсан дуудлагын мэдээлэл гарах боломжгүй. Түүн дотор хүүхдийн эрх, хүчирхийлэл, бусад төрлийн хүүхэдтэй холбоотой санал, гомдол, дуудлагын төрлөөр ангилсан мэдээлэл байхгүй;
- Өмнөх жилүүдийн нийт дуудлага болон хүүхэдтэй холбоотой дуудлага мэдээлэл, гомдол, саналын талаар бэлэн тайлан мэдээ байхгүй /Зөвхөн дата санд байдаг. Тайлан мэдээ авах шаардлагатай бол Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дата санд хүсэлт өгөх, Засгийн хэрэг эрхлэх газрын даргаас зөвшөөрөл авч өгөх тайлбар тавьсан/;
- Ажилтан, алба хаагчид, үйлчлүүлж буй иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх гэнэтийн нөхцөл байдал үүссэн тохиолдолд анхны тусламжийн хайрцаг байхгүй;
- Галын аюулгүй байдал хангаагүй. Галын хорын хугацаа дууссан байв.

ЗӨВЛӨМЖ:

- Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд 2020-2022 оны хооронд ирсэн нийт дуудлага мэдээллийн судалгаа, түүн дотор хүүхэдтэй холбоотой зөрчил, гомдол, саналыг төрлөөр нь ангилсан байх, холбогдох хуультай нийцүүлж, дүрэм, журамдаа өөрчлөлт оруулах;
- Удирдлага, ажилтнуудын харилцаа, хандлагыг сайжруулах;
- Хүний эрх, хүүхдийн эрхийн талаар мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах;
- Хүүхэд хамгааллын бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
- Хүүхдийн өрөө, хүүхдэд ээлтэй орчин /нярай хүүхэдтэй үйлчлүүлэгчид живх солих, түр амрах булан/ бүрдүүлэх.

5.1.2. Мэдээлэл, шуурхай удирдлагын төв (101, 102, 103, 105 тусгай дугаарын утас)

Монгол Улсын Шадар сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2010 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 42/123/246 хамтарсан тушаалаар байгуулагдаж, төрөл мэргэжлийн албадын үйл ажиллагааг уялдуулан холбож, шуурхай удирдлагаар хангах үүрэгтэйгээр Шуурхай удирдлагын хэлтэс 101, 105, Шуурхай удирдлагын хэлтэс 102, Шуурхай удирдлагын хэлтэс 103, Захиргаа удирдлагын хэлтэс, Техник ашиглалтын хэлтэс гэсэн 5 хэлтэс, 161 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд 2022 онд гал түймэр, гамшиг осол, гэмт хэрэг, зөрчил, эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн 861,234 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн байна. Үүнд:

- Гал түймэр, гамшиг ослын дуудлага, мэдээлэл хүлээн авч дамжуулдаг тусгай дугаарын 101,105 утсанд 4275 дуудлага, мэдээлэл хүлээн авсан нь нийт дуудлагын 0,5 хувийг;
- Гэмт хэрэг, зөрчлийн дуудлага, мэдээлэл хүлээн авч дамжуулдаг тусгай дугаарын 102 утсанд 536,512 дуудлага мэдээлэл буюу нийт дуудлагын 62,3 хувийг;
- 102 тусгай дугаарын утсанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 38,948 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс хүүхдийн эрх зөрчигдсэн гэх 9,833 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн нь нийт дуудлага мэдээллийн 25,2 хувийг;
- Эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн дуудлага мэдээлэл, хүлээн авч, дамжуулдаг тусгай дугаарын 103 утсанд 320,447 дуудлага мэдээлэл буюу нийт дуудлагын 37,2 хувийг тус тус хүлээн авч харьяа байгууллагуудад дамжуулж ажилласан байна.

2023 оны 1-р улирлын байдлаар нийт 210,040 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн байна.

- 101, 105 дугаарын утсанд 827 дуудлага мэдээлэл ирсэн нь нийт дуудлагын 0.4 хувийг,
- 102 дугаарын утсанд 126,069 дуудлага мэдээлэл хүлээн авсан нь нийт дуудлага мэдээллийн 60 хувийг,
- Мөн 102 утсанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 5,260 дуудлага мэдээлэл бүртгэгдсэнээс хүүхдийн эрх зөрчигдсэн гэх 1,466 дуудлага мэдээлэл бүртгэгдсэн нь нийт дуудлагын 27,9 хувийг тус тус эзэлж байна.
- 103 тусгай дугаарын утсанд 83,144 дуудлага мэдээлэл хүлээн авсан нь нийт дуудлагын 39,6 хувийг эзэлж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс 102, 101, 105, 103 тусгай дугаарын утсанд хүүхдийн хүчирхийлэл, осол гэмтэл, өвчлөлийн талаарх мэдээллийг тогтмол дамжуулж ажилладаг байна. Үүнд:

- 2022 онд 102 дугаарын утсанд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 1606 дуудлага дамжуулснаас хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийн дуудлага 1186,
- 2023 оны 1-р улиралд хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 376 дуудлага дамжуулснаас хүүхдийн эсрэг хүчирхийлэл, зөрчлийн дуудлага 278 байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс 2022 онд 103 тусгай дугаарын утсанд 15 дуудлага, 2023 оны 1-р улиралд 5 дуудлага, 101, 105 дугаарын утсанд 2022 онд 8, 2023 оны 1-р улиралд 3 дуудлага мэдээллийг тус тус дамжуулсан байна.

Мэдээлэл, шуурхай удирдлагын төв нь дуудлагыг зөвхөн дамжуулах үүрэг гүйцэтгэж байна. Операторууд зөвхөн дуудлага өгөгчийн нэр, хаяг, байршлыг асууж тодруулаад тухайн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага руу шилжүүлдэг.

Үйл ажиллагааны нэгдсэн стандарт, дүрэм журам байхгүй (Хүүхэд дуудлага өгөхөд яаж харьцах нь ойлгомжгүй, ярианы стандарт, зураглал байхгүй.)

Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажил хангалтгүй байгаагаас зорилтот бус дуудлага дийлэнх хувийг эзэлж байна.

ДҮГНЭЛТ:

- Мэдээлэл, шуурхай удирдлагын төв нь 2010 онд байгуулагдсан бөгөөд тухайн үеэс хойш нийслэлийн хүн ам эрс нэмэгдсэнтэй холбоотойгоор дуудлагын ачаалал ихэссэн учраас төвийн үйл ажиллагааг өргөтгөх хэрэгцээ шаардлага үүссэн байна.
- Хүн амын өсөлт, дуудлага мэдээллийн ачаалал нэмэгдэж байгаатай холбоотойгоор тус төвийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн нэгдсэн дугаарлалт (112)-д шилжүүлэх шаардлагатай байна. Гэмт хэрэг, хүчирхийлэл, эрүүл мэнд, гамшиг онцгой байдлын бүх дуудлагыг нэг цэгт хүлээн авах 112 тусгай дугаарын утсыг ашиглалтад оруулахад шаардлагатай, 4.5 тэрбум төгрөгийн асуудлыг шийдвэрлүүлэх асуудал тулгараад байна.
- Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст үйлчилгээ хүртээмжгүй байна. Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан дүрст дуудлагын үйлчилгээг өргөтгөх, дохионы хэлмэрчдийн цалин, орон тооны асуудлыг шийдвэрлэх бодит хэрэгцээ үүссэн.
- Бусад байгууллага, салбаруудтай (ГБХЗХГазар, ХТУ-108 болон хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ зэрэг) хамтран ажиллах, хүүхэдтэй холбоотой дуудлагыг холбон зуучлах явдал хангалтгүй, зөвхөн дамжуулагчийн үүрэг гүйцэтгэж байна.
- Дуудлагын байршлыг тогтоогч байхгүй, сүлжээгээр тодорхойлох боломжгүй. Байршил тогтоогч тоног төхөөрөмж өртөг өндөртэй, төсвийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байна.
- Байгууллагын бодлого, үйл ажиллагааны дүрэм, журмуудад хүний эрх, хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жендерийн эрх тэгш байдлыг хангах зэрэг асуудал тусгагдаагүй байна.
- Хүүхэд хамгааллын бодлого баталж мөрдөөгүй, албан хаагчид нь энэ талаарх ойлголт мэдээлэл дутмаг байна.
- Тус байгууллагын үйлчилгээнд хүүхдийн эрхийг хүндэтгэсэн, хүүхдэд ээлтэй хандлага ажиглагдахгүй байна.
- Дуудлага, мэдээллийн нарийвчилсан статистик гаргадаггүйгээс хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хүний эрх, хүүхдийн эрх, хамгаалал, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жендерийн эрх тэгш байдлыг хангах талаарх холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн байгууллагын бодлого, үйл ажиллагааны дүрэм, журамд өөрчлөлт оруулах;
- Дүрст дуудлагын үйлчилгээг өргөтгөж хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулсан дохионы хэлмэрчтэй холбодог болгох;
- Хүүхэд хамгааллын бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах;
- Үйлчилгээг олон нийтэд сурталчлах.

5.1.3. Гэр бүлийн хүчирхийллийн дуудлагын утас 107

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25.1.2-т заасны дагуу Нийслэлийн цагдаагийн газрын гэр бүлийн хохирогчийг Түр хамгаалах байр нь гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл авч, зөвлөгөө өгөх зорилгоор 2014 он 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн “107” тусгай дугаарын утсыг 24 цагаар ажиллуулж эхэлсэн. Одоогийн байдлаар 1 шугамтай, жижүүрийн сэтгэл зүйч 1, жижүүрийн офицер 1, нийт 2 алба хаагч ээлжлэн 24 цагаар

иргэдээс дуудлага, мэдээлэл хүлээн авч, хууль эрх зүйн болон сэтгэл зүйн зөвлөгөө, мэдээлэл өгдөг.

107 тусгай дугаарын утсанд 2018-2023 оны эхний улирлын байдлаар нийт 58,490 иргэн хандсаны 10,610 иргэнд сэтгэл зүйн болон хууль эрх зүйн зөвлөгөө, 46,984 иргэнд бусад хууль эрх зүйн зөвлөгөөг өгч ажилласан байна. Жилд дунджаар 8,500 орчим иргэдэд зөвлөгөө өгдөг.

2018-2023 оны эхний улирлын байдлаар иргэд, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 2,261 дуудлага мэдээлэл ирснийг Мэдээлэл, шуурхай удирдлагын 102 тусгай дугаарт 1,455, хөдөө орон нутгийн 21 аймгийн цагдаагийн газар хэлтсүүдэд 806 мэдээллийг дамжуулан шийдвэрлэлтийг авч ажилласан байна.

Дээрх хугацаанд 107 тусгай дугаарт Хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой 691 дуудлага мэдээлэл ирсэн байна. Үүнийг жилээр авч үзвэл: 2018 онд 175, 2019 онд 128, 2020 онд 88, 2021 онд 139, 2022 онд 135, 2023 оны эхний улиралд 26 мэдээлэл ирсэн байна.

Тус төвийн үйл ажиллагаа ямар нэгэн доголдолгүй, хэвийн ажиллаж байсан.

107 дугаарт хандсан иргэдээс шаардлагатай тохиолдолд Түр хамгаалах байранд байрлуулах шаардлагатай иргэдийн мэдээллийг харьяа аймаг, дүүргийн цагдаагийн газар хэлтэст дамжуулж, иргэдийг хамгаалалтад авч ажилладаг. Тус байгууллагаас “107” тусгай дугаарын утсыг иргэд, олон нийтэд танилцуулж, сурталчлах ажлуудыг тогтмол зохион байгуулдаг байна.

ДУГНЭЛТ:

- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид зөвлөгөө өгөх, дуудлага хүлээн авах 107 дугаарын төвийн үйл ажиллагаа жигдэрсэн, 24 цагаар, 3 ээлжээр ажилладаг, одоогоор 1 сэтгэл зүйч, 2 нийгмийн ажилтны орон тоо дутуу байна.
- Хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилт хангагдсан байна.

ЗӨВЛӨМЖ:

- Дуудлагыг тухай бүр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн болон Хүүхэд, гэр бүл, хөгжлийн байгууллагад холбон зуучлах, шийдвэрлэлтэд бодитой хяналт тавьж ажиллах, хүүхэд хамгааллын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх.

5.1.4. Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв

Монгол Улсын хувьд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн Төлөө Үндэсний газраас Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг 2005 онд “Найз утас 1979” нэртэйгээр анх нээн ажиллуулж эхэлсэн. 2006 онд Олон улсын Хүүхдийн Тусламжийн утасны сүлжээ /Child Helpline International/-д элсэн орж, 2008 онд гишүүнчлэлийн статустай болсон.

2014 онд “Дотно Утас 1979”-ийн судалгаа, хэрэгцээнд тулгуурлан Хүүхдийн тусламжийн 108 утас нэртэйгээр Монгол Улсын хэмжээнд 24 цагийн турш үнэ төлбөргүй дуудлага мэдээлэл хүлээн авах утасны үйлчилгээ болгон өргөжүүлж, төсөл хэлбэрээр хуучнаар Хүүхдийн төлөө газрын дэргэд ажиллаж эхэлсэн.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “энэ зүйлд заасан мэдээ, мэдээллийг хүлээн авах, илрүүлэх зорилгоор яаралтай тусламжийн 24 цагийн утас ажиллуулж болно” гэснийг үндэслэн Засгийн газрын 2016 оны 55 дугаар тогтоолоор “Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв”-ийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын харьяанд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ажиллуулсугай” гэсэн шийдвэр гарч, төрийн үйлчилгээний бүтэц болон өргөжсөн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/292 тоот тушаалаар журамд өөрчлөлт батлагдсанаар 2017 оны 12 дүгээр сард тус төвийн тээврийн хэрэгсэлд тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэж байгаа нь хүчирхийлэлд өртсөн хүүхдэд “хүүхэд хамгааллын яаралтай тусламж, үйлчилгээ”-г үзүүлэх боломжийг

нэмэгдүүлсэн. Улаанбаатар хот дотор эрсдэл өндөртэй дуудлагад шуурхай тусламж үзүүлж, холбон зуучлах ажлыг хийж байна.

2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн программын гуравдугаар шатны шинэчлэл хийгдэж ашиглалтад орж эхэлсэн, программын шинэчлэлтэй холбоотойгоор зөвхөн утсаар биш чат болон мессежээр дуудлага мэдээлэл хүлээн авах зөвлөгөө тусламж үзүүлэх боломжтой болсон. Ингэснээр 108 утасны программ нь хүүхэд хамгааллын салбарт мэдээлэл технологид суурилсан оновчтой шийдэл болж дата баазын суурь тавигдсан байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар тус төвийн дүрэм, бүтэц, орон тоо баталж, чиг үүрэг, удирдлагаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар хангаж ажилладаг. Нийт батлагдсан бүтэц, орон тоо 23. Одоогоор 8 албан тушаал дээр 26 хүн ажиллаж байна.

- Захирал-1, ТҮ-10,
- Ахлах сэтгэл зүйч-1, ТҮ-7,
- Ахлах ажилтан-4, ТҮ-7,
- Зөвлөгч нийгмийн ажилтан-12, ТҮ6,
- Чат үйлчилгээний гэрээт ажилтан-4, ТҮ-6 (Гэрээт 4 ажилтан хүүхэд хамгааллын зардлаас цалинждаг)
- Нягтлан-1 ТҮ-8
- Жолооч-3 ТҮ-3

Тус төв нь гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй болон эрсдэл өндөртэй дуудлага, мэдээллийг Мэдээлэл шуурхай удирдлагын төв-102, цагдаа, эмнэлгийн байгууллагууд, сум, хороодын Засаг даргаар удирдуулсан хамтарсан баг, аймаг, дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, хэлтэстэй хамтран ажилладаг.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв нь 2014 оны 6 дугаар сараас 2023 оны 3 дугаар сарын 30-ны байдлаар нийт 1,200,000 дуудлага хүлээн авч хүүхэд хамгааллын холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн байна.

Хүснэгт 6.Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн үйлчилгээний тоон мэдээлэл

№	Үзүүлэлт	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
1	Нийт дуудлага	174,818	134,877	118,662	92,762	111,776
2	Зорилтот дуудлага	81104	70,515	71,461	61,799	64,811
3	Зорилтот бус дуудлага	93714	64,362	47,201	30,963	46,965
4	Хүүхэд хамгааллын кейсийн тоо, кейс шийдвэрлэлтийн хувь	4317 (73,1%)	6070 (84,3%)	9192 (69%)	8102 (65,5%)	9294 (79%)
5	Он дамнан ажилласан кейсийн тоо	1161	947	2850	2795	1641
6	Шуурхай тусламж үйлчилгээ үзүүлсэн хүүхдийн тоо	819	1241	1045	906	1279

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар/хэлтэс, сум, хорооны хамтарсан багт шилжүүлсэн кейс шийдвэрлэлт 2018 онд 73.1 хувь 2019 онд 84.3 хувь, 2020 онд 69 хувь, 2021 онд 65,5 хувь, 2022 онд 79 хувь, 2023 оны нэгдүгээр улирлын байдлаар 82.5 хувьтай байна.

Хүүхэд хамгааллын кейс хаагдахгүй байгаа шалтгаан нь хамтарсан багууд тогтворгүй, 7 хоноод ажлаасаа гарч байна, нийгмийн баталгаа, цалин хөлс, нэг хүнд ноогдох хүний тоо, ачааллаас болоод улсын хэмжээнд хамтарсан багуудын бараг тал хувь нь нийгмийн ажилтангүй болсонтой холбоотой байна.

Мөн хамтарсан багийн шинэ нийгмийн ажилтнууд программ ашиглаж чадахгүй, ажлаас гарсан, орсон ажилтнууд ажлаа хоорондоо хүлээлцдэггүй, үйлчлүүлэгчийн хувийн хэргийг (кейс) шилжүүлдэггүй, программд нэвтрэх эрхээ шилжүүлдэггүй, мөн хаалгадаггүй байдал түгээмэл байна.

Тоног төхөөрөмж, техник программын хувьд хэвийн байдалтай.

Хүний нөөц хариуцсан хүн байхгүй, 2022 онд зөвлөгч нарын 50-60 хувь нь шинэчлэгдсэн. Тус төвийн захирлын хувьд хүний нөөцийг халах солих тушаалыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай зөвшилцөж хийдэг.

Цалингийн хувьд илүү цаг гэж авдаг, шугам дутуу байх ёсгүй, заавал нэг хүн нөхөж ажилладаг байна.

Дуудлагын нэг Starex маркын авто машинтай, 2017 оноос хойш ашиглаж байгаа, эвдрэл гэмтэл их гардаг.

ДУГНЭЛТ:

- Ажиллах хүчний цалин хүрэлцээгүй. Илүү цагийн цалинг нийгмийн даатгал дээр өр үүсгэх байдлаар аргацааж ирсэн. Цалингийн сан хүрэлцдэггүй.
- Чат, болон мессеж үйлчилгээ дээр ажиллаж байгаа зөвлөхүүдийн орон тоо, цалин шийдвэрлэгдээгүй, агентлагаас (ГБХЗХГ/ нэмэлт зардал авч цалинжуулдаг.
- Хүний нөөцийн хувьд тогтворгүй, утасны операторууд ойр ойрхон халагдаж солигддог. Дадлагажуулах, сургах хөтөлбөр байхгүй.
- Дуудлагаар ажиллах машин техник дутмаг.
- Ажлын байрны нөхцөл 24 цагаар ажилладаг. Нэг дуудлагын ажилтан өдөрт 110-120 дуудлага хүлээн авдаг. Олон улсын стандартад дүйцүүлэх, мөн журам байдаг ч ингэж ажиллана гэдгийг заасан байхаас норм нормативтай болгох.
- Төвийн захирлын хувьд эрх нь хязгаарлагдмал, хүний нөөц бусад асуудлаар агентлагтай заавал зөвшилцөж, шийдвэрлэж байгаа нь зөв эсэх асуудлыг анхаарч үзэх.
- Хамтарсан багийн нийгмийн ажилтнууд ажлаас гарахдаа Хүүхдийн тусламжийн 108 утасны нэвтрэх эрхээ шилжүүлэхгүй байх тохиолдол цөөнгүй бөгөөд нэгдсэн байдлаар эрх олгох, хаах асуудлыг зохицуулсан дүрэм, журам байхгүй. Эндээс дүгнэхэд Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль болон Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллахгүй байна.
- Шинэ ажилтнуудад зориулсан программ ашиглах заавар, мэдээллийн аюулгүй байдал, нууцын гэрээ байхгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн дүрэм, бүтэц, орон тоог шинэчлэн тогтоох;

- Үйл ажиллагааны стратегийг боловсруулж батлах;
- Шинэ ажилтныг дадлагажуулах, сургах, давтан сургах хөтөлбөртэй болгох;
- Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, программ ашиглаж байгаа анхан, дунд шатны ажилтнуудад олгож байгаа нэвтрэх эрхийн бүртгэл, ашиглалт, шилжүүлэх, хаах асуудлыг холбогдох хуультай нийцүүлэн журамлаж, мөрдүүлэх;
- Аймаг, дүүргийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон хамтарсан багийн нийгмийн ажилтнуудад программ ашиглах заавар болон арга зүйн сургалтыг тогтмол явуулах;
- Хүүхэд хамгааллын кейсийн мэдээллийг /хувийн хэрэг/ танилцуулж, ажил хүлээлцүүлэх;
- Татвар, нийгмийн даатгалын өр үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тодорхойлж шийдвэрлэх;
- Хүүхдийн тусламжийн 108 төвийн захирлын ажлын байрны тодорхойлолтыг эргэж харах, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас шууд хамааралтай холбогдох шийдвэрийг зөвлөлдөж гаргадаг байдлыг эргэж харах;
- Хаагдаагүй олон жил болсон кейсийг хаахтай холбоотой тодорхой шийдвэрийг гаргаж өгөх;
- Дуудлага хүлээн авах ачаалал ихтэй байдаг тул бүтэц, орон тоог нэмэгдүүлэх, төсөв, санхүүжилтийг нэмэгдүүлэх;
- Парк шинэчлэл хийх, нийслэлийн 9 дүүргийн дунд 2 шаардлага хангасан шуурхай дуудлагын машинтай болгох анхаарах;
- Системд хаагдсан дуудлагын чанарт үнэлгээ хийж, чанаржуулахад анхаарах.

5.1.2. ТҮР ХАМГААЛАХ БАЙР, НЭГ ЦЭГИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг хамгаалах чиглэлээр Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын дэргэд 2008 онд 2 түр хамгаалах байр ажиллаж байсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулга мөрдөгдөж эхэлснээс хойш улсын хэмжээнд 17 нэг цэгийн үйлчилгээний төв, 17 түр хамгаалах байр 4 байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулж байна.

Эдгээр 34 хамгаалах байр нь 4 байгууллагын дэргэд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, хэлтсийн дэргэд 13 Түр хамгаалах байр, 9 Нэг цэгийн үйлчилгээний төв байгуулагдсанаас 21 нь тогтвортой үйлчилгээ үзүүлж байна.

Нээлттэй хяналт-шалгалтын хүрээнд нийт 19 Нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байруудаас мэдээлэл ирүүлсэн.

Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/38 дугаар тушаалаар баталсан “Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд хяналт тавих журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/116 дугаар тушаалаар баталсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэх журам”, ХНХ-ын сайдын 2020 оны А/150 дугаар тушаалаар батлагдсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам” болон “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019” стандартыг тус тус мөрдөн ажиллаж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 2021 онд www.E-tuslamj.mn сайт хөгжүүлэлт хийж, ашиглаж эхэлсэн.

5.2.1. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төв

Гэмтэл согог судлалын үндэсний төв /цаашид ГССҮТ гэх/-ийн Нэг цэгийн үйлчилгээ нь 2009 онд байгуулагдсан 14 дэх жилдээ үйл ажиллагаагаа явуулж ирсэн загвар төвөөр шалгарч байсан түүхтэй, орон тооны 5 хүн 8/16 аар ээлжилж ажилладаг.

2022 он гарсаар 142 хүүхэд ирж үйлчлүүлсэн бөгөөд 2023 он гарсаар 64 хүүхэд ирээд байна. Сүүлийн үед сургууль цэцэрлэгийн орчинд ихэвчлэн бие махбод сэтгэл санааны хүчирхийлэл үйлдэгдсэн байна.

Осол, гэмтлийн дуудлагаас хүүхдийн дуудлагыг шүүж үзэхэд 2022 оны 04 сарын 10-ны байдлаар 6 хүүхэд байна. Хүүхдийн дуудлага, мэдээллийг Хүүхдийн тусламжийн 108 утсанд байнга мэдээлдэг. Сургууль цэцэрлэгийн орчинд үе тэнгийн дээрэлхэлт, сэтгэл зүйн дарамт их гардаг учир ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр 1500 багш, сурган хүмүүжүүлэгч нарт сургалт нөлөөллийн ажил явуулж байна.

Статистик тоо мэдээгээ Цагдаагийн программд байнга шивж оруулахаас гадна Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт өдөр бүр мэдээлэл өгдөг учир улсын хэмжээний тоо мэдээлэлд орж явдаг.

Хүүхэд хамгааллын бодлогоо 2019 боловсруулж, Эцэг, эхийн зөвлөл байгуулан ажиллаж байгаа. Үйлчлүүлж байгаа хүүхэд болон ажилтан, албан хаагчдынхаа хүүхдийг хамруулсан хүүхэд хамгааллын бодлогоо боловсруулсан. Байгууллагын барилга байшингийн хүртээмжээс хамаарч Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-т заасан хүүхдийн өрөө болон өөрийн байгууллага дээр цэцэрлэг байхгүй, хүүхдээ хүчирхийлсэн эцэг, эхийн аль нэгнээр сахиур авахгүй байхыг бодлогодоо тусгасан. (3 нас хүртэл хүүхэд сахиуртай байдаг.)

Хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд хүүхдийг хүлээн авах, үзлэг хийх өрөө, эрчимт эмчилгээний өрөө болон эргэлтийн, памперс солих өрөөнүүд тусдаа байхаар зохицуулсан.

ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд зааснаар санхүүжилтийн журам 2017 оны 4 сарын 06-нд батлагдан хэрэгжиж байгаа боловч асуудал байсаар байна. Жилийн төсөв нь 140.0 орчим сая төгрөг гүйцэтгэлээр санхүүжилт авдаг нь одоо үйлчилгээ авч байгаа хүмүүстэйгээ харьцуулахад хүрэлцэхгүй байна.

Салбар хоорондын уялдаа хуульд заасан шигээ хэрэгжихгүй байна.

6-8 настай хүүхдүүдийн өндрөөс унаж ирэх явдал ихэссэн. Эцэг, эхчүүдийн үүрэг, хариуцлага дэндүү сул байна.

Сүүлийн үед насанд хүрсэн хүмүүс болон хүүхдүүд нь сэтгэл зүйн хувьд өөрийнхөө бие махбодыг зүсдэг өвдөлтийг мэдэрч тайвширдаг шинэ гэмээр сэтгэц сэтгэл зүйн өвөрмөц асуудал нэлээдгүй газар авч ирж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утаснаас хүүхдийн хувийн нууцтай холбоотой асуудал их задарч түүнээсээ болоод эмнэлэгт ирэхдээ танайхаас үйлчилгээ авахгүй, миний тухай мэдээллийг багшид хэлсэн, сургуульд мэдэгдсэн гэх мэт зүйлээс шалтгаалж хэвтэн эмчлүүлэхээс татгалзах, мэдээлэл өгөхгүй байх асуудал их гарч байна.

Тус газрын нэг цэгийн үйлчилгээний төв дээр үйлчилгээний стандарт байгаа боловч орчны байрны стандарт гэж байхгүйгээс сул өрөөгөө ашиглах замаар үйлчилгээний ажилтан, хамгаалах байр нэг дор ариун цэврийн өрөө болон бусад бүх зүйл нь нэг дор хамтын хэрэглээтэй ашиглагдаж байна. Иймээс эмнэлгийнхээ эзэмшлийн газрыг ашиглаж “Дэмжих төв”-ийн барилга барихаар ТЭЗҮ гаргаад явж байна.

Сүүлийн үед хүчирхийлэлд өртсөн ахмад хүмүүс их ирж байна. Орон гэргүй 37 хүн ирсэн нь маш их хүндрэл учруулсан. Нэн ялангуяа асрамж, халамжийн төвд амьдарч байгаад 18 нас хүрээд гарч байгаа хүүхдүүдэд анхаарал хандуулах, нийгэмшүүлэх шаардлагатай байна. Шууд гудамжинд гардаг хүмүүсийн ихэнх тохиолдол тэр хүүхдүүд байх магадлал өндөр байгаа учир аж ахуйн нэгж, албан байгууллагад хүлээлгэн өгөх зэрэг эзэнжүүлэх арга хэмжээг бодлогын түвшинд боловсруулж анхаарал хандуулах цаг болсон байна.

Эрүүл мэндийн яамнаас гаргасан статистик тоо, мэдээллийн үзүүлэлтэд хүүхдийн зарим асуудлыг нэмж өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

5.2.2. Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын харьяа гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчлэх Түр хамгаалах байр

Тус хамгаалах байр нь 2014 оны 10 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 35 дугаар зүйлд заасанчлан хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. Бүрэлдэхүүний хувьд орон тооны 23 алба хаагч ажиллахаас түр хамгаалах байрны дарга 1, сэтгэл зүйч 3, нийгмийн ажилтан 2, жижүүрийн офицер, цагдаа тус бүр 4, тогооч 2, нярав, цагдаа жолооч, эмч тус бүр 1 нийт 21 алба хаагч үүрэг гүйцэтгэж, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан тус бүр 1 орон тоо дутуу байна.

2018-2023 онд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 1430 гэр бүлийн 1430 хүнд үйлчилснээс 12 буюу 0,83 хувь нь эрэгтэй, 549 буюу 39 хувь нь эмэгтэй, 869 буюу 61 хувь нь насанд хүрээгүй хүн 869 /эрэгтэй 422, эмэгтэй 447/ байна.

Насанд хүрээгүй хүмүүсийн 470 буюу 54 хувь нь 2-4 нас, 213 буюу 25 хувь нь 5-9 нас, 115 буюу 13 хувь нь 10-14 нас, 71 буюу 8 хувь нь 15-17 насны хүн байна.

Байрлагч хүүхдүүд бие махбодын хүчирхийлэлд байнга өртдөггүй ч эх, эцэг нь байнга хэрүүл маргаан гаргадаг, сэтгэл санаа, эдийн засгийн хүчирхийлэлд өдөр тутам өртөж улмаар гэртээ хэвийн амьдрах нөхцөл бүрдээгүйгээс гэрээсээ дайжих, найз нөхдийндөө олон хоногоор хонох, гудамж, олон нийтийн газраар сэлгүүцэх, сургууль завсардах зэрэг эрсдэлд өртөж байгаа нь судалгаагаар гарсан.

Үйлчлүүлэгч насанд хүрсэн 561 иргэний 2,3 хувь буюу 13 нь ганц бие, 337 буюу 61,0 хувь нь нэгээс хоёр хүүхэдтэй, 163 буюу 29,0 хувь нь гурваас дөрвөн хүүхэдтэй, 27 буюу 5,1 хувь нь 5-аас дээш хүүхэдтэй иргэн байсан.

Хүчирхийлэл үйлдэгч нь 30-34 насны дийлэнх хувийг эзэлж байгаа нь архины хамааралтай, эрхэлсэн тодорхой ажилгүй, тогтвортой ажил хөдөлмөр эрхэлдэггүй, гэр бүлийн амьдрал тогтворгүй, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлтэй холбоотой эрсдэл өндөртэй, сэтгэл санааны, бие махбодын, эдийн засгийн, бэлгийн хүчирхийллийг хавсарсан байдлаар үйлдэгддэг болох нь судалгаагаар тогтоогдсон.

Хүчирхийлэлд өртөгсдийн хамгийн их 378 буюу 69 хувийг хамтран амьдрагч эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн бие махбодын хүчирхийлэлд 378 буюу 29,5 хувь, сэтгэл санааны хүчирхийлэлд 561 буюу 38,3 хувь, бэлгийн хүчирхийлэлд 33 буюу 2,3 хувь, эдийн засгийн хүчирхийлэлд 21 хувийг тус тус эзэлж байна.

Шалгалтад хамрагдсан хугацаанд нийт 775 иргэнд эмнэлгийн, 1162 иргэнд сэтгэл зүйн, 1430 иргэнд нийгмийн халамжийн, 869 насанд хүрээгүй хүн хүүхэд

хамгааллын үйлчилгээнд, 821 хүнд эрх зүйн туслалцаа, 260 хүүхдэд боловсролын үйлчилгээнд тус тус хамруулж, нийт 1430 иргэнд хоол хүнс, ариун цэврийн бүтээгдэхүүн гэх мэт анхан шатны үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Шалгалтын явцад үйлчлүүлэгчдийн өрөөний тохижилт, агааржуулалт муу байсан /албан тушаалтны танилцуулснаар БЗД-ийн 11 дүгээр хороонд шинэ байрны шав тавьсан, барилгын ажил явагдаж байгаа, энэ оны 11 сард ашиглалтад орох тул хуучин байранд нэмэлт засвар үйлчилгээ хийхгүй байгаа гэх/;

Үйлчлүүлэгчийн хоолны цэсийн нэр төрөл сонголт муутай, 3-4 өдөр гоймонтой хоолны цэстэй байсан нь үйлчлүүлэгчийн эрүүл мэндэд муугаар нөлөөлж болзошгүй байсан.

Кейс хөтлөлт бүрдэл муутай, үзүүлсэн үйлчилгээний талаар тусгаагүй зэрэг байдал илэрсэн.

ДУГНЭЛТ:

Түр хамгаалах байрны үйл ажиллагаа, бичиг баримтын бүрдэл, байрны аюулгүй байдал харьцангуй жигдэрсэн, хохирогчид үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар сайн байна.

ЗӨВЛӨМЖ:

- Үйлчлүүлэгчийн хоолны цэсийг 5-аас доошгүй өдрөөр сонголт бүхий цэс гарган, хамгаалах байрны даргаар батлуулж хэвших, хоолны дээжийг өдөр бүр авч, тогтоосон хугацаанд устгалд оруулж байх;
- “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын Хүүхэд хамгааллын бодлого”-ыг түр хамгаалах байрны онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжилтийг хангах;
- Кейс бүрдүүлэлтийн чанарыг сайжруулах;
- Ижил төстэй үйл ажиллагаа бүхий бусад түр хамгаалах байрнаас туршлага судалж хэрэгжүүлэх.

5.2.3. Нийслэлийн Шүүхийн шинжилгээний ерөнхий газрын Шүүхийн анагаах ухааны шинжилгээний газрын дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төв

Шүүхийн шинжилгээний үндэсний төв нь Засгийн газрын 2005 оны 63 дугаар тогтоолоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулагдан ажиллаж эхэлсэн. 250 ажилтантай, 28 эмчтэй.

Нэг цэгийн үйлчилгээний төв нь барилга байгууламжийн нэгдүгээр давхарт, харуулын дэргэд байрладаг, гадна дотор орчин бүрэн камержсан, камерын бичлэг 90 хоног хүртэл хадгалагддаг, гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай, компьютер, хэвлэгч, хувилагч зэрэг тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Хохирогчийг хүлээн авч ярилцах өрөө болон хүүхэд саатуулах тоглоомын хэсэгтэй, хүүхэд хамгааллын бодлоготой. Үйлчлүүлэгчдийн бүртгэлээ E-tuslamj.mn-д шивж оруулдаг боловч гацах, сүлжээ орохгүй байх зэрэг шалтгаанаар бүрэн бүртгэгддэггүй.

Барилга байгууламжийн хувьд 1971 онд 1-р эмнэлгийн шарил хадгалах зориулалтаар баригдсан, хуучирч элэгдсэн, шүүх эмнэлгийн үзлэгээс гадна бусад эмнэлгүүд болон гэртээ нас барсан хүмүүсийн шарилыг хүлээн авч задлан шинжилгээ хийдэг учир дотор агаарын чанар муу байдаг. Ажилтнуудын хувьд формалин зэрэг химийн бодисын харшилтай, тэдэнд зориулсан халуун устай шүршүүр байхгүй учир задлан хийсний дараа усанд орох боломжгүй байдаг, 60-70 хувь нь стрессээс гаралтай өвчлөлтэй, химийн лаборатори байрладаг, хор судлал, эм тариа, хувцасны шинжилгээ хийдэг учир дотор агаарын бохирдол, хордлого ихтэй. Мөн шарил авах гэсэн машинууд эмнэлгийн гадаа дугаарладаг болохоор яг энэ байранд 24 цагийн турш үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төв ажиллуулахад тохиромж муутай.

Нэг цэгийн үйлчилгээний төв нь үйлчлүүлэгчийг 24 цагаар байрлуулдаггүй, өрөөний хүртээмж, нөхцөл байдалтай холбоотойгоор үйлчлүүлэгчид амрах унтлагын өрөө байхгүй, тодорхой төсөвгүй, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанаас 9.0 сая төгрөгийн шаардлагатай зүйл хуваарилсан, мөн нэмж 21.0 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зориулан хуваарилсан, худалдан авалт хийхээр үнэ судалж байгаа.

Хүүхэд хамгааллын зардлаас авч байгаагүй, шүүх эмнэлгийн үзлэг, задлан хийдэг учир байранд хоол цай хийх боломжгүй гэсэн дүгнэлт гарсан, нийгмийн үйлчилгээ, хохирогч хамгааллын чиглэлээр мэргэшсэн хүний нөөцгүй, Нэг цэгийн үйлчилгээний төвийг зөвхөн нэг сэтгэл зүйч ажиллуулдаг.

Тус төвд үйлчлүүлэгч ирэхэд шүдний оо, сойз, саван нэг удаагийн ариун цэврийн хэрэгсэл байдаггүй, худалдаж авах төсөв ч хангалттай биш байгаа.

Хөдөлмөрийн дотоод журамд нь хүүхэд хамгааллын бодлого, мэдээлэх журам тусгагдаагүй, хүүхэд хамгааллын бодлогоо ил байршуулаагүй, Ажлын байрны бэлгийн дарамттай холбоотой гомдлыг хэрхэн шийдвэрлэх асуудлыг тусгаагүй.

Бусад хамгаалах байр, НЦҮТ, хамтарсан баг, 107, 108-тай холбоогүй, Шүүх эмнэлэг ХЗДХЯ-ны харьяанд байгаа нь тогтолцооны хувьд оновчгүй, эрүүл мэндийн яамны сургалтад мэргэжилтнүүд хамрагддаггүй, эмч, ажилтнууд цагдаагийн алба хаагчид хамаардаг учир эрт тэтгэвэрт гардаг, мэргэшиж ажиллах боломж муутай байдаг.

Хүүхдийн хувийн хэрэг товъёгийн дагуу хөтлөгдөөгүй, зөвхөн бүртгэлтэй, хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний ахиц, өөрчлөлтийг үнэлэх, дараагийн үйлчилгээг төлөвлөх явдал хангалтгүй байна.

ДУГНЭЛТ:

- Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн байранд 24 цагийн турш хохирогчийг байрлуулан үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвийг ажиллуулахад орчин нөхцөл, эрүүл ахуйн хувьд тохиромж муутай байна. Харин энд хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд ханддаг, 24 цагийн турш ажилладаг учир хохирогчдыг тайвшруулах, анхан шатны зөвлөгөө, мэдээллээр хангаж, бусад үйлчилгээнд холбон зуучлах төв маягаар ажиллуулах боломжтой байна.
- ШШҮХ-нд зөвлөгөө өгөх НЦҮТ төвийг тогтвортой ажиллуулах нь нэн шаардлагатай тул санхүүжилт, хүний нөөцийн асуудлыг нэг мөр шийдвэрлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хувийн хэргийн /кейс файл/-ийн хөтлөлтийг сайжруулах;
- Хүүхэд, эмэгтэйчүүдийн кейс дээр бусад салбаруудтай хамтран ажиллах, холбон зуучлах үйлчилгээг хөгжүүлэх;
- Санхүүжилт, хүний нөөц, цаашид барилга байгууламжийн шинэчлэлийн асуудлыг шийдвэрлэх.

5.2.4. Чингэлтэй дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төв

2020 оны 06 дугаар сард НҮБ-ын санхүүжилтээр нээгдсэн бөгөөд зохицуулагч-1, Сэтгэл зүйч-1, ээлжийн нийгмийн ажилтан-3, үйлчлэгч-1, жижүүр-3, тогооч-1, жолооч-1 нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх зорилгоор эмчтэй гэрээ байгуулан ажилладаг. 20 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай.

2020 онд 165 хүнд үйлчилгээ үзүүлснээс хүүхэд 160, насанд хүрэгч 5 байна. Эдгээрээс гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 111, бусад түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд рүү шилжүүлсэн 52, асрамж халамжийн төв рүү шилжүүлсэн 2 үйлчлүүлэгч байна.

2021 онд 502 хүнд үйлчилгээ үзүүлснээс хүүхэд 480, насанд хүрэгч 22 байна. Эдгээрээс гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 217, бусад түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд рүү шилжүүлсэн 276 үйлчлүүлэгч байна.

2022 онд 374 хүнд үйлчилгээ үзүүлснээс хүүхэд 349, насанд хүрэгч 25 байна. Эдгээрээс гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн 338, бусад түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд рүү шилжүүлсэн 14, асрамж, халамжийн төв рүү шилжүүлсэн 8 үйлчлүүлэгч байна. 2020 оноос хойш үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд одоогийн байдлаар урсгал засвар хийх шаардлагатай байна.

ДУГНЭЛТ:

- Барилга байгууламжийн дотоод өнгө үзэмж, тохижилтод анхаарч засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлага үүссэн байна.
- Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид холбогдох маягтын дагуу хувийн хэрэг хөтөлж байгаа хэдий ч тусгайлан үзүүлсэн үйлчилгээний бүртгэл тэмдэглэл дутмаг байна.
- Үйлчилгээ авсан хүүхдүүдийн ар гэрт Нөхцөл байдлын үнэлгээг тогтмол хийж, эргэх холбоотой, түргэн шуурхай ажиллах шаардлагатай байна.
- Ажилтнуудын тогтвор суурьшил, нийгмийн баталгаанд анхаарч ажиллах.
- Стресс менежментийн ажлыг байгууллагын сэтгэл зүйч, удирдлага хариуцан тогтмол зохион байгуулах.

ЗӨВЛӨМЖ:

- Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудыг ажлын байран дээр нь чадавхжуулах ажил зохион байгуулах нэн шаардлагатай.
- Мэргэжлийн нийгмийн ажилчид, сэтгэл зүйчдийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл боломжоор хангах
- Ажлын байрны стресс менежментийг тогтмол зохион байгуулж хэвших

5.2.5. БЗД-ийн Цагдаагийн хэлтсийн дэргэдэх Нэг цэгийн үйлчилгээний төв

Тус байгууллага нь 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Баянзүрх дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор бүтэц орон, тоо батлагдаж, НҮБ-ын Хүн амын сангийн дэмжлэгтэйгээр тохижуулсан. Үйл ажиллагааг Гэр бүл, хүүхэд, залуучуудад эрх зүйн үйлчилгээ үзүүлэх “Цагаан шонхор төв” НҮТББ гэрээлэн гүйцэтгэдэг. Одоогийн байр нь өмнө нь БЗД-ийн хорооны Цагдаагийн хэсгийн байр байсан. Үйлчлүүлэгчдээ Цагдаагийн хэлтэс, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс журмын дагуу хүлээн авдаг ба 2020 онд 151 хүнд үйлчилгээ үзүүлснээс 66 нь насанд хүрэгч, 85 нь хүүхэд, 2021 онд 85 хүнд үйлчилгээ үзүүлснээс 32 нь насанд хүрэгч, 53 нь хүүхэд, 2022 онд 110 хүнд үйлчилгээ үзүүлснээс 46 нь насанд хүрэгч, 64 нь хүүхэд байна.

Байршлын хувьд тохиромжтой, нууцлал, аюулгүй байдал хангагдсан. Аюулгүй байдлын хамгаалалт, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ, эрх зүйн туслалцааг нэг дороос авах боломжтой. Дохиоллын систем, камерын хяналттай бөгөөд цагдаагийн 3 хэлтэстэйгээ шууд холбогддог. Тус төв нийт 5 өрөө бүхий нэг давхар байгууламж бөгөөд зай талбайн хувьд бага хэдий ч өрөөний зохион байгуулалт, зай ашиглалт маш сайн байсан. Салбарын болон орон нутгийн захиргааны байгууллагуудтай хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулан ажилладаг. Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийг түшиглэн байгуулагдсан, үйл ажиллагаагаа БЗД-ийн 1,2,3-р хэлтсийн цагдаа нартай хамтран явуулдаг онцлогтой.

Нийт 8 хүний орон тоотой, захирал, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрх зүйч, эмч, ээлжийн 3 ажилтан ажилладаг. Тус төвийн захирал болон ээлжийн ажилтан нар Цагдаагийн байгууллагад Хүүхдийн байцаагч, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах хэлтсүүдэд ажиллаж байгаад гавьяаны амралтаа авсан туршлагатай албан хаагчид ажиллаж байгаа нь хууль эрх зүйн туслалцаа үзүүлэхэд дэмжлэг болж байна. Орон нутгийн төсвөөс санхүүждэг.

Нийт үйлчлүүлсэн хохирогчдын дийлэнх нь дүүргийн Цагдаагийн хэлтсээс холбон зуучилсан хохирогч байна. Баянзүрх дүүргийн Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хамгаалах Нэг цэгийн үйлчилгээний төв нь үйлчилгээнд зориулсан автомашин байхгүй байгаа нь үйлчлүүлэгчийг бусад үйлчилгээнд хамруулах, холбон зуучлахад хүндрэлтэй байна.

Хүний нөөцийн хувьд тогтвор суурьшилгүй байгаа нь үйлчилгээний үр дүнд сөргөөр нөлөөлж байгааг дурдаж байсан. Мөн мэдээллийн сангийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай бөгөөд байгууллага бүр тал бүрийн мэдээллийг өөрийн маягтын дагуу авдаг. Мэдээллийн нэгдсэн сантай болох нь ажлын ачааллыг бууруулах давуу талтайг дурдаж байсан.

Хамтарсан багт хохирогчийн талаарх мэдээллийг албан бичгийн хамт хүргүүлдэг ч хохирогчийн үйлчилгээний талаар хариу ирүүлж мэдээлэл солилцож, хамтран ажилладаггүй байна.

Хохирогч байрлуулах 4 ортой бөгөөд тэднийг нас хүйсээр ангилан байрлуулахад тохиромжгүй байв.

Холбон зуучлах үйлчилгээний эхлэлүүд тавигдсан байгаа ба цаашид хохирогчдод урт хугацааны мэргэжлийн үйлчилгээнд хамрагдах, нийгмийн баталгааг сайжруулахад бодитой дэмжлэг үзүүлэхүйц урт хугацааны хөтөлбөр төлөвлөгөө боловсруулан талуудтай хамтран ажиллах хэрэгцээ байна.

ДҮГНЭЛТ:

- Хохирогчийн хувийн хэрэг бүрдүүлэлт болон холбогдох бусад бичиг баримтын бүрдэл сайн. Орон тооны их эмч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нар ажиллаж, хувийн хэрэгт зохих маягт бүртгэлүүд бүрэн хөтлөгдсөн байна. Хохирогчдод хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх тусгайлан хөтөлбөр боловсруулж, үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийнхээ бүртгэлийг хөтөлж, хувийн хэрэгт хавсаргаж байгаа нь сайшаалтай.
- Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв болон дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтран ажиллах талаар хангалтгүй ажиллаж байна.
- Баянзүрх дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төв нь үйл ажиллагааны хувьд тогтмолжсон тулгамдсан асуудлууд байгаа хэдий ч тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.
- Ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулахад анхаарах, ажилтнуудыг мэргэшүүлэх, стресс менежментийн ажлыг тогтмол зохион байгуулахад анхаарах шаардлагатай байна.
- Үйл ажиллагааны чанар, үйлчилгээг сайжруулах эдийн засгийн хөшүүргээ нэмэгдүүлж, зохих журам шалгуурын дагуу хувьсах зардал авах асуудлыг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.
- Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийг сэтгэл зүйчдийг нарийн мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага байна. Ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах арга зүйд суралцах нэн шаардлагатай.

ЗӨВЛӨМЖ:

- Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төв, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэстэй хамтын ажиллагааг сайжруулах.
- НЦҮТ-үүдийг стандартад нийцүүлэн (бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, эхчүүд хүүхдийн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн г.м) төрөлжүүлэх;
- Ажилтнуудын тогтвор суурьшилтай ажиллах орчин нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, ажилтнуудыг мэргэшүүлэх, стресс менежментийг тогтмол зохион байгуулж, ажлын байрны стрессийг бууруулах

5.2.6. Орон нутгийн түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн үйлчилгээний мэдээлэл

Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдээр 2018 оноос 2022 онд 17,256 хүн үйлчлүүлсний 67,7% нь хүүхэд, 32,3%-ийг насанд хүрэгч эзэлж байна. Эдгээр үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, нөхцөл байдлын үнэлгээ хийсний үндсэн дээр шаардлагатай үйлчилгээнүүдийг хуулийн дагуу үзүүлдэг.

Нийт үйлчилгээ авсан хохирогчийн 67 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлдэг бөгөөд тэдгээрийн 70 хувь нь гэр бүлийн орчинд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс хүчирхийлэлд өртөж хохирсон байна.

Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийн санхүүжилт шийдвэрлэгдээгүй учир, хүний нөөцийн асуудал хангалтгүй, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаагүй, үйлчилгээ нь жигд, хүртээмжтэй биш байна. Тухайлбал, Эмнэлэгт түшиглэсэн НЦҮТ нь өвчтөний хоолноос үйлчлүүлэгчдийн хэрэгцээг хангадаг.

Зарим НЦҮТ-ийн байр нь үйлчлүүлэгчийг байрлуулахад тохиромжгүй, шаардлага хангахааргүй байна.

Нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байрны үйлчилгээний зааг ялгаа тодорхой бус, НЦҮТ-ийн стандарт байхгүй байна.

Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн орчин нөхцөл нь хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настанд хүртээмжгүй байна.

Ихэнх ТХБ, НЦҮТ-ийн камержуулалт, аюулгүйн дохиолол болон хамгаалалт сул, E-tuslamj.mn-руу нэвтэрч чаддаггүй байдалтай байна.

ЗӨВЛӨМЖ:

Бодлогын түвшинд:

- НЦҮТ-ийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг боловсруулж, батлуулан, улсын хэмжээнд мөрдөх,
- Түр хамгаалах байр, НЦҮТ-ийн санхүүжилтийг хэрэгцээ, шаардлагад нь нийцүүлэн тооцоолж, улсын төсөвт тусган баталж, хэрэгжүүлэх,
- Хохирогч түр хамгаалах байранд байх үеийн зардал, уг байрнаас гараад цаашид эрх зүйн, нийгмийн хамгааллын тусламж үргэлжлүүлэн авах хугацааны зардлыг тус тусад нь тооцоолж, зардлын жишгийг тогтоох,
- Одоо байгаа ТХБ, НЦҮТ-үүдийг стандартад нийцүүлэн (бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, эхчүүд хүүхдийн, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн г.м) төрөлжүүлэн хөгжүүлэх;
- ТХБ, НЦҮТ-ийн ажилтнуудыг сургаж дадлагажуулах чиглэлээр сургалтын нэгдсэн хөтөлбөр боловсруулж, гарын авлагаар хангах,
- Гамшиг, нийтийн эрүүл мэндийн бэлэн байдлыг хангах Гамшиг, нийтийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдлыг хангах, эрсдэл хохирлыг бууруулах, хохирлыг богино хугацаанд арилгах талаар төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, үүнд шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах,
- Баримт бичгийн хадгалалт, хамгаалал, хувь хүний мэдээллийг дамжуулах, тухайн хүнд аливаа үйлчилгээг үзүүлэх зуучлахдаа “Байгууллагын нууцын тухай”, “Архивын тухай” болон холбогдох бусад хуулийг хэрэгжүүлэх;
- Цахим мэдээллийн нэгдсэн санг илүү боловсронгуй болгож хөгжүүлэх;
- Хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх.

5.3. Хүүхдийн төрөлжсөн асрамж, халамжийн төвийн үйл ажиллагаа, нөхцөл байдал, зөвлөмж

Монгол Улс асрамж, халамж шаардлагатай хүүхдийг төвлөрсөн асрамжийн газарт биш гэр бүлийн орчинд, төрөл садны болон асралт гэр бүлд өсгөн хүмүүжүүлэх бодлого баримталж, энэ хүрээнд Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартыг шинэчлэн баталсан.

2023 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд 21 байгууллагын 30 асрамж, халамжийн төвд 974 хүүхэд, залуус үйлчилгээ авч байна. Нийт хүүхдээс 23 хүүхэд их дээд сургуульд элсэн орсон, 86 хүүхэд нь хөгжлийн бэрхшээлтэй, 86 нь 18-аас дээш насны залуучууд бөгөөд хүүхдийн асрамж халамж төвөөс үйлчилгээг үргэлжлүүлэн авч байна.

Эдгээр төвүүдээс 3 төв нь улсын төсвөөс, 28 төв олон улсын болон төрийн бус байгууллага, хувь иргэний санхүүгийн эх үүсвэрээр үйл ажиллагаа явуулж байна.

2021 онд ХНХ-ын сайдын А/209 тушаалаар “Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам”-ыг батлан мөрдүүлж байна.

2022 онд ХНХ-ын сайд, Сангийн сайдын 2022 оны А/23, А/27 дугаар тушаалаар батлагдсан “Хүүхдийн хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын дагуу хувийн асрамж халамжийн 10 байгууллагын 17 төвийн 386 хүүхдэд хүүхдийн хоолны хувьсах зардал олгосон.

“Насанд хүрч асрамж, халамжийн төвөөс гарч буй залуучуудын бие даан амьдрах хөтөлбөр”-ийг шинэчлэн баталж, хэрэгжүүлж байна.

Төвлөрсөн асрамж, халамжийн үйлчилгээнээс гэр бүлийн орчинд хүүхдийг хүмүүжүүлэх, хувилбарт үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх зорилгоор асралт гэр бүлийн үйлчилгээг нэвтрүүлж эхлээд байна.

Хүүхдийн асрамжийн төвийн үйл ажиллагааны зардлын нормативыг бодит өртгөөр нь тооцож, шинэчлэн баталж мөрдүүлэх ажлыг зохион байгуулахаар Өнөр бүл хүүхдийн төвийн зардлын тооцооллыг гаргаж төрийн болон хувийн хэвшлийн халамж, асрамжийн төвүүдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж санал авсан. Зардлын нормативыг хүүхдүүдийн хэрэгцээ шаардлага болон зах зээлийн өртгийн дагуу шинэчлэхээр ажиллаж байна.

Асрамж, халамжийн төвүүдэд тулгамдаж байгаа асуудлын нэг нь хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаа шаардлагатай насанд хүрсэн залуусыг холбон зуучлах байгууллага байхгүй байна. Нийт 17 төвд 17 насанд хүрсэн, байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй залуус үйлчлүүлж байна.

Асрамжийн төвөөс үйлчилгээ авч байгаад насанд хүрч, бие даан амьдарч байгаа залууст төрөөс тодорхой дэмжлэг зайлшгүй хэрэгцээтэй байдаг. Эдгээр хүүхдүүд их дээд сургуульд суралцаж мэргэжил эзэмшихэд сургалтын төлбөр, амьжиргааны зардал, амьдрах орон байр зайлшгүй шаардлагатай байдаг.

5.3.1.Өнөр бүл хүүхдийн төв

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагын (MNS 5852:2017) Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хүрээнд үзүүлэх нийгмийн үйлчилгээ хэсэгт байгаа 7.2 Сурч боловсрох, хөгжихөд чиглэсэн үйлчилгээний чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тухайлбал “хүүхэд бүрийг харьяа орон нутгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд бүрэн хамруулна” гэсэн заалтын хэрэгжилтийг хянаж үнэлэв.

Хүүхдийн эрхийн, ялангуяа сурч боловсрох эрхийн зөрчил байдаг эсэх; Хүүхэд хамгааллын нөхцөл байдалд дүгнэлт гаргав.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага-MNS 5852:2017 хэрэгжилтийг хянах үүднээс

- Бичиг баримттай танилцах;
- Ажилтан, албан хаагчдын төлөөлөлтэй уулзах;
- Ажиглалт, тэмдэглэл хийх замаар ажиллах арга барилаа сонгон ажилласан болно.

ДҮГНЭЛТ:

2022 оны 9 сарын 12-15-ны хооронд хийгдсэн Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага стандартын хэрэгжилтэд хийсэн ГБХЗХГ, МХЕГ-ын хамтарсан хяналт шалгалтаар илэрсэн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн талаар шалгалт хийсэн.

Дээрх шалгалтын дүгнэлтэд байгаа “Тус төвд асран халамжлуулж байгаа 174 хүүхдийн 63 нь буюу 39,4% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 20 буюу 16,7% нь эмгэг сэтгэцтэй, 15 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, 5 хүүхэд группт байдаг. Мөн асрамж, халамжийн төвийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүд олноор сургууль завсардаж, сурч боловсрох эрх нь зөрчигдөж байгаа тухай” мэдээлэл, хүүхдүүд олноор оюуны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд хамрагддаг тухай ИНБ-уудаас өгсөн мэдээллийг нягтлан шалгав.

Тус төвийн Ерөнхий захирал М.Өлзийчимэг, Хүүхдийн асрамж, халамж, үйлчилгээний хэлтсийн дарга н.Цагаанжанар болон бусад ажилтнуудтай уулзаж, ярилцлага хийн, мэдээлэл цуглуулсны үндсэн дээр дараах дүгнэлтүүдийг хийж байна.

- Хүүхэд хамгааллын тухай хуулийн төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрхэмлэж, хүүхэд эцэг, эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг, эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх эрхүүд зөрчигдөж байх магадлалтай байна. Тус төвд 162 хүүхэд хамрагдаж байгаагаас 66 хүүхэд нь эцэг, эхтэй, 50 нь хагас өнчин хүүхэд байгаа ба эцэг, эх нь орон гэргүй, архины хамааралтай зэрэг шалтгаанаар эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, хөгжих хэвийн орчин нь алдагдсан гэж үзэн тухайн орон нутгийн Засаг дарга захирамж гарган “эрсдэлт нөхцөл байдалд байгаа хүүхдүүд” гэж тодорхойлон тус төвд шилжүүлдэг байна. 10 аймгаас 18 хүүхэд, бусад нь Улаанбаатар хотын 7 дүүргээс, ялангуяа Баянзүрх дүүргээс 52 хүүхэд байгаа нь анхаарал татаж байна. (Баримт 1. Хүүхдүүдийн харьяаллын судалгаа) Шүүхээр эцэг, эх байх эрхийг хасаагүй, хязгаарлаагүй тохиолдол дийлэнх байна.

- Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх журам (2021 онд батлагдсан)-ын 6.3 дугаар заалт хэрэгжихгүй байна. Хуулийн дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хувилбарт үйлчилгээ үзүүлэх санал, дүгнэлтийг хамтарсан баг гаргаж байгаа ч нөхцөл байдлын үнэлгээ хийгдээгүй, баримт бичгийн бүрдэл хангалтгүй, хүүхдийн нөхцөл байдлыг тодорхойлсон нотолгоогүй хүүхдүүд ирж байна. (Баримт 2. Хан-уул дүүргийн ГБХЗХХ-ийн даргад явуулсан албан бичиг)
- Хүүхдийн эцэг, эхийг тогтоогоогүй, эмчийн үзлэгт оруулаагүй, хүүхдийн мөнгийг нь хэн авдгийг нь тодорхойлоогүй, хувийн хэрэг бичилтгүй, дүнгийн хавтгайгүй ирэх, эсвэл сургууль завсардсан хүүхдүүд ирж байгаа нь төвлөрсөн асрамж, халамжийн үйлчилгээ үзүүлэгчдэд хүндрэл учруулж байна. Тухайлбал, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс сүрьеэгийн халдвартай 3 хүүхэд ирж, бусад хүүхдийн эрүүл мэндийг эрсдэлд оруулсан тохиолдол гарчээ.
- Өнөр бүл төвийн дүрэмд тус төвийн хүлээн авах ёстой хүүхдүүдийг заасан байхад Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний нэг хэсэг болсон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг хувилбарт үйлчилгээнд хамруулж байгаа нь зохимжгүй байна. Бусад хүүхдүүдийн эцэг, эх, гэр бүлийн гишүүд нь ирж уулзаад байхаар өнчин хүүхдүүдэд хүндээр тусдаг, сөрөг зан үйлтэй хүүхэд ирж өнчин хүүхдүүдэд буруугаар нөлөөлдөг. (Баримт 3. Өнөр бүл төвийн дүрэм)
- СЭМҮТ-өөр Хүүхдийн IQ-г толгой дараалан тогтоолгодог ба энэ онош дээр суурилан хүүхдийг Оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд олноор хамруулах нь хүүхдийг бага наснаас шошголон эрхэм чанарт халдаж байгаа гэж үзэхэд хүргэж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн оношилгоо 30,000 төгрөгийн үнэтэй бөгөөд 9-өөс дээш настай хүүхдийг хамруулдаг. Энэ оношилгоог хийснээр 20 хүүхдийг эмгэг сэтгэцтэй хэмээн үзэж судалгаа гаргасан байна. (Баримт 4. Асрамж халамжийн хувилбарт үйлчилгээнд хүүхэд хүлээн авах журам), (Баримт 5. Өнөр бүл хүүхдийн төвийн эмгэг сэтгэцтэй хүүхдүүдийн судалгаа, 2022 оны 8 сар)
- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт сайжирсан байна. Гэвч боловсролын тогтолцоонд тухайн төвийн хүүхдүүд хамрагдахад санхүүгийн болон бусад саад тотгорууд тулж байна. Цэцэрлэгийн насны 8 хүүхэд байдаг. 1 хүүхэд Идэрийн Эрдэм цэцэрлэгт хамрагдаагүй байна. Шалтгаан нь бөөрний хагалгаанд орж байгаа. 50 дугаар цэцэрлэгт 5 хүүхэд, 22 дугаар цэцэрлэгт 2 хүүхэд хамрагдаж байна. Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар "Цэцэрлэгийн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас хичээлийн жилд бэлтгэх сургалтын хэрэглэгдэхүүн, ариун цэврийн хэрэгслийн жагсаалтыг баталсан байдаг. Гэтэл энэхүү бэлтгэлийг хүүхэд нэг бүрээр хангах төсөв төлөвлөгддөггүй. Өөрсдийн хангамжийн бараа материалаас гаргаж өгөхөөр цэцэрлэгүүд чанарыг голдог. Жилд нийт 2.5 сая төгрөг хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүнд төсөвлөдөг нь Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага стандартын хэрэгжилтийг хангахаар төв дотроо зохион байгуулахад зориулагддаг. Мөн 8.7 сая төгрөг хичээл үйлчилгээний зардалд төсөвлөгддөг. (Баримт 6. Бага насны хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний хэсгийн боловсролын үйлчилгээнд хамрагдалтын судалгаа, 2023 оны 4 сар)
- Норм норматив батлахдаа үнэ бодитой биш тул төсөв хүрэлцдэггүй. Тус төвийн төсөвт турсик 800, цээживч 2500 гэх зэргээр үнийн өсөлт, инфляцыг тооцоогүй нормативыг баримталсаар байна. 2021 оны 9 сард СЯ, ХНХЯ хамтран баталсан болон 2021 оны 11 сарын 21-нд ХНХЯ баталсан норм нормативд барааны үнэ өөрчлөлтгүй батлагдсан.
- Сургуульд хамрагдалт сайжирсан ч хүүхдүүдийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтгүйгээр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуульд хамруулсаар байна. Хүүхдийг хувийн сургуульд сургах, сүм хийдэд шавилан сургах зэрэг шийдвэрийг хэрхэн яаж гаргаж байгаа нь тодорхойгүй байна. Хамран сургах тойрог тогтоож өгөөгүй тул сургууль хүүхэд авахдаа дургүй. Засаг даргын захирамжийг үндэслэн ЕБС-д албан бичиг хүргүүлдэг. БЗД-ийн 44, 53, 48, 68 дугаар сургуулиуд хүүхэд элсүүлж авдаг бол 14, 33 дугаар сургуулиуд хүүхдийг элсүүлж авахаас татгалздаг. 1-р ангийн 8 хүүхэд үсэглэлийн баярт оролцоход 100 мянган төгрөгийг монтаж хийх зэрэгт зарцуулахаар хурааж байна. Уг зардал төвийн төсөвт байхгүй тул хүндрэл үүсдэг. Энэ хэлбэрийн төлбөр хураамжийг өгдөггүй тул төвийн хүүхдүүдийг авахаас сургууль, багш нар татгалздаг.

Баримт 7. Өнөр бүл хүүхдийн төвийн боловсролын үйлчилгээний судалгаа, 2023 оны 3 сар) Сурах бичгийн түрээс хүүхэд нэг бүрээр төл гэдэг боловч (15000 төгрөг) төсөвгүй тул хүүхдүүдэд сурах бичиг дутагдалтай. М.Өлзийчимэг 2016 онд захирлаар томилогдон ирэхэд программын хоцрогдолтой, завсардсан олон хүүхэд 55 дугаар сургуульд хамрагддаг байсныг шийдвэрлэж, тоог эрс багасгасан.

Бага насны хүүхдийн асрамж, халамжийн үйлчилгээний хэсэгт 59 хүүхэд харьяалагддаг. 6 хүүхэд 25 дугаар сургуульд, 9 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 55 дугаар сургуульд суралцдаг.

(Баримт 8.Өнөр бүл хүүхдийн төвийн 2-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа, 2022 оны 3 сар) Хөгжлийн бэрхшээлтэй 2-18 насны 23 хүүхэд тус төвд амьдардаг. Үүнээс 4 хүүхэд сургуульд хамрагддаггүй.

-2 хэвтрийн хүүхэд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн СЗХ-ийн төвд эмчлүүлдэг.

-2 хүүхэд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуусын Солонго төвд хамрагддаг.

Тусгай сургуулиас ердийн сургуульд шилжүүлэх бодлого баримталж байна.

2023 онд 5 хүүхэд 55 дугаар сургуулиас 53 дугаар сургууль руу шилжүүлсэн. 2 хүүхэд Баянзүрх дүүргийн АББ-ын төвд сурдаг.

“Хөөрөх тавцан” хувийн сургууль 2020 онд 10 хүүхэд 1-р ангиас авсан, одоо 5 хүүхэд 3 дугаар ангид сурч байна. 3 хүүхэд 48 дугаар сургууль руу шилжин сурч байгаа ба 2 хүүхэд гэр бүлдээ эргэн нэгтгэгдсэн.

Мэргэжлийн үнэмлэхтэй болгох зорилгоор “Хөвгүүд” хувийн 8 хүүхэд сургасан.

Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутагт байрлах Чойрын хийдэд 4 хүүхэд шавилан сууж байна. Тус сумын сургуульд болон НТБ-ын төвд хамрагддаг.

Хүүхдүүд өөрсдөө хүссэн ба эцэг эх, хамаатан садан нь зөвшөөрсөн. Жил бүр төвийн ажилтнууд эргэж очиж, нөхцөл байдлын үнэлгээ хийдэг. 13 хүүхэд коллеж, МСҮТ-д сурдаг.

16 хүүхдэд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын Салбар комиссын дүгнэлт гарсан бусдад нь байхгүй байна. Салбар комисс нь тухайн орон нутгийн харьяалалтай, оршин суугаа хүүхдийн хөгжлийн бэрхшээлтэй эсэхийг тогтоох, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг тодорхойлох, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах талаар шийдвэр гаргах, шаардлагатай гэж үзвэл харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн болон боловсролын үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй. 2020 оны 4 сарын 24-ний өдөр 7 хүүхдийг 55 дугаар сургууль дээр хуралдсан Салбар комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй болохыг тодорхойлсон байна.

- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хийгдээгүй, багш, нийгмийн ажилтнууд эцэг эхийг төлөөлж оролцоогүй.

- Хөгжлийн бэрхшээлтэй насанд хүрэгчид төвд амьдарсаар байна. 20 настай Анхзаяа, Энхдалай нар оюуны хомсдолтой, саажилттай. СЭМҮТ, Ахмадын асрамж авахгүй, “Ачлалтай хүүхдүүд” насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй хүн авдаг ч аваагүй.

Тус төв 2022 оноос хойш хүүхдийн сэтгэцийн эмч Д. Энхтуяаг ажиллуулж, сэтгэцийн тулгамдсан асуудалтай хүүхдүүдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлдэг болсон байна. Сэтгэцийн эмгэгтэй, айдас түгшүүртэй, цочролд орсон хүүхдүүдийн ойлгоц удаан байдаг тул ердийн сургуулиуд (48 сургууль) сурч чадахгүй байна гэж үзээд 55 дугаар тусгай сургуульд эцэг эх, багштай нь яриад шилжүүлсэн. Мэргэжлийн сэтгэл зүйч 3 (бага, дунд, ахлах) ажилладаг. Хүчирхийлэл, өнчрөл, гэмт хэргийн гэрч болж сэтгэцийн цочролд орсон, хоол тэжээлийн дутагдал, үл хайхрал зэргээс үүдэлтэй оюуны хоцрогдол үүссэн тул хүүхдүүдийг тусгай сургуульд хамруулдаг. Үе тэнгийн дээрэлхэлд өртсөн, зан үйлийн өөрчлөлттэй хүүхдүүд ирдэг. 55 дугаар сургуулийн элсэлтийн комисст сэтгэцийн эмч байхгүйгээс түр зуурын оюуны сааталтай хүүхдийг сэтгэцийн эмгэгтэй гэж оношлоод элсүүлэх тохиолдол гарч хүүхэд хохироох явдал байна гэдгийг эмч дурдав.

Хүүхэд хөгжлийн төсвийг хассан ба багш ажиллуулахгүй гэсэн шийдвэрээ эргэж харах шаардлагатай байна. Хүүхдийн хөгжилд анхаарч 10 дугуйлан ажиллуулдаг байсан.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээг байгуулж, бүтэц өөрчлөгдөж, 33 орон тоо хасагдсан тул 4 дугуйлантай болсон. Төсөвт байхгүй тул хандив тусламжаар санхүүжүүлдэг /НҮБХС дэмжлэг үзүүлдэг.

Багш ажиллуулахгүй нийгмийн ажилтан байх шаардлагатай гэж байгаа нь амьдралд нийцдэггүй, хүүхдүүдийн гэрийн даалгавар хийлгэх, хичээл давтуулахад багш хэрэгтэй болдог.

Хичээлийн хоцрогдолтой хүүхдүүдэд Шинэ эрин, 18-р сургууль, MIU сургуулиудаас багш нар ирж хичээл заадаг.

Охид, хөвгүүд нэг байранд давхраар ялгаатай амьдардаг нь хүүхэд хамгааллын хувьд эрсдэлтэй гэж үзэж байна.

Төвд хүний нөөцийн асуудал тулгамдаж байна. Хүүхдүүдийн эцэг эхийг орлодог тул төвд тогтвор суурьшилтай ажиллах ёстой. Гэтэл 24 цаг тасралтгүй ажилладаг, баяраар амардаггүй, янз бүрийн нөхцөл байдалтай хүүхдүүдтэй ажиллах болдог тул залуучууд халширдаг. Хөдөлмөрийн хүнд нөхцөл тул цалин хөлс өндөр байх үнэлэмжийг өндөрсгөх хэрэгтэй. Хүүхэдтэй ажиллах, эмзэг бүлгийн хүүхдүүдтэй ажиллах хүнд өндөр шалгуур тавих хэрэгтэй болдог гэтэл шаардлага нь цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлтэйгөө таардаггүй тул хүний нөөц дутагдаж байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хууль, дагалдан гарсан дүрэм, журмуудын зөрүү, хийдлийг арилгах;
- Өнөр бүл төвийн дүрэмд заасан хүүхдийг авдаг болгох;
- Хүүхдэд үзүүлж байгаа эрүүл мэндийн үйлчилгээнээс IQ тогтоох, СЭМҮТ-ээр оношлуулах байдлыг зогсоох;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд тэгш хамуулан сургах;
- Хүүхдүүдийг сурах арга барилд дадуулах, сурлагын хоцрогдол гаргахаас сэргийлэх зорилгоор багш ажиллуулах;
- Хүүхдийг олноор Засаг даргын захирамж гарган тус төвд ирүүлж байгааг судлан үзэж, зохицуулалтыг нарийвчлах;
- Тус төвийн баримталдаг төсөв зохих норм нормативыг шинэчлэх, төсөвт хүүхдийн сургууль, цэцэрлэгт хамрагдахтай холбогдон гардаг зардлуудыг тусгах;
- Хүүхэд хамгааллын эрсдэлүүдийг үнэлэн үзэж, холбогдох шийдвэрүүдийг гаргах;
- Хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт хамрагдах асуудлыг Боловсролын ерөнхий газартай харилцан тохирч шийдвэр гаргуулах.

5.3.2. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хүүхэд, залуучуудын сургалт, хүмүүжлийн тусгай цогцолбор

Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборт Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ нийтлэг шаардлага MNS5852:2017 стандартын хэрэгжилтэд хяналт шалгалт хийж, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлагын (2017) Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний хүрээнд үзүүлэх нийгмийн үйлчилгээ хэсэгт байгаа 7.2 Сурч боловсрох, хөгжихөд чиглэсэн үйлчилгээний чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тухайлбал “хүүхэд бүрийг харьяа орон нутгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд бүрэн хамруулна” гэсэн заалтын хэрэгжилтийг хянаж үнэлэв.

Хүүхдийн эрхийн ялангуяа сурч боловсрох эрхийн зөрчил байдаг эсэх; Хүүхэд хамгааллын нөхцөл байдалд дүгнэлт гаргав.

Нөхцөл байдал:

“Тус төвд асран халамжлуулж байгаа 174 хүүхдийн 63 нь буюу 39,4 хувь нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай, 20 буюу 16,7 хувь нь сэтгэц, эмгэгтэй, 15 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй, 5 хүүхэд группт байдаг. Мөн асрамж халамжийн төвийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүд олноор сургууль завсардаж, сурч боловсрох эрх нь зөрчигдөж байгаа тухай” мэдээлэл, хүүхдүүд олноор оюуны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуульд хамрагддаг тухай иргэний нийгмийн байгууллагуудаас өгсөн мэдээллийг нягтлан шалгав.

Тус төвийн Ерөнхий захирал С.Амгалан, ХЗСХТЦ-ын Залуучуудын төвийн эрхлэгч О.Халиунаа болон бусад ажилтнуудтай уулзаж, ярилцлага хийн, мэдээлэл цуглуулсны үндсэн дээр дараах дүгнэлтүүдийг хийж байна:

Дүгнэлт 1. Сурч боловсрох эрхийг хангахыг чармайдаг боловч хамран сургах тойргийн сургуулиуд элсүүлэн сургах дургүй, хүүхдийг ялгаварлан харьцдаг тохиолдол гарч байна.

Нийт 174 хүүхэд тус төвд асрамжлуулдаг. 2 тусдаа төвтэй: 4-17 насны хүүхдийн үйлчилгээг Төгсжаргал, 18-21 настай залуусын төвийн (25 залуус) үйлчилгээг Халиунаа нар хариуцдаг. 70 ажилтан албан хаагчидтай.

Дүүргийн Засаг Даргын захирамж, хамтарсан багийн үнэлгээнд үндэслэн хүүхдүүд ирдэг. (Баримт 1. СБД-ийн Засаг даргын захирамж, 2023)

Сургуулийн өмнөх боловсролын хувьд 32 дугаар цэцэрлэгт хамрагддаг.

ГБХЗХ-ийн Хэлтэс нь хүүхдийн бага, дунд боловсролын асуудлыг шийдвэрлэхдээ тус төв байрлаж байгаа хорооны хамран сургах тойргийн сургуулиудад хандаж шийдвэрлэдэг. Амгалан цогцолборт 44 хүүхэд, 92 сургууль, 55, 40, 97, УБ Эмпати, БЗД-ийн НТБ-ын төвд голлон сурч байна. (Баримт 2. ХЗСХТЦ-ын Хүүхдийн төвөөс Амгалан цогцолбор сургуульд сурч байгаа хүүхдүүдийн судалгаа, 2023)

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд боловсрол тасралтгүй олгох журмын дагуу сургуульд хамруулдаг. (Баримт 3. Бусад сургуульд сурч байгаа хүүхдийн судалгаа, 2023)

Сургуулиуд хэцүү хүлээж авдаг. Хүүхдүүдийг ад үзнэ, хүүхэдтэй ажиллах боломжгүй гэж буцаана. Сургалтын үйл ажиллагааны явцын дунд ямар сургуульд шилжүүлэн сургах талаар хамтран шийдвэр гаргах тохиолдол байдаг.

Байгууллагын дүрмийг Нийслэлийн Засаг дарга баталсан. (Баримт 4. Нийслэлийн Засаг даргын захирамж, 2013 он) Дүрмээр дараах бүлгийн хүүхдүүдийг хамруулдаг:

-Эцэг эхийн хараа хяналтаас гарсан

-Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүд

-Хагас болон бүтэн өнчин

Цэцэрлэгийн насны 8 хүүхдийн 7 нь цэцэрлэгт хамрагдаж байна.

Амьжиргааны түвшин доогуур хүүхэд дунд сургуулийг амжилттай төгсөөд (800 оноо авахад) Их, дээд сургуульд сургалтын төлбөр хөнгөлдөггүй. Төсөвт төлбөрийн зардал тусдаггүй.

Тус төв салбартаа манлайлах зорилго тавьсан бөгөөд асрамж халамжийн салбарт өөрчлөлт хийх, нөлөөлөх, нийгмийн ажилтны ур чадварын уралдаан, нэгдсэн шинэ жилийн баяр тэмдэглэх, ном солилцох өдөрлөг, Улаанбаатар, БЗД -ийн номын сантай хамтран ажиллах зэргээр идэвхтэй ажиллаж байгаа нь талархууштай.

Дүгнэлт 2. Хүүхдийг тусгай сургуульд хамруулах, сэтгэцийн оношилгоо хийлгэх байдал байсаар байна.

Тус төвд 5 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд асруулдаг. (Баримт 5. Хүүхдийн төвийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгаа, 2023)

БЗД-ийн 55 сургуульд 3 хүүхэд суралцаж байна.

Хүснэгт 8.

№	Нөхцөл байдал
1.	“А.Э” нь ХБХЭМБНХ-ын салбар комиссын шийдвэрээр сонсголын бууралт гэсэн оноштойгоор 55 дугаар сургуульд сурч байна. <ul style="list-style-type: none">❖ БЗД-ийн ХБХЭМБНХ-ын салбар комиссын бүрэлдэхүүнд 55 дугаар сургуулийн захирал Ч.Ганбилэг ажилладаг тул хүүхдийг 29 дүгээр сургуульд биш 55 сургуульд элсүүлсэн байх магадлалтай.❖ Сонсголын аппарат зүүлгэсэн тул ердийн сургуульд хамруулах бүрэн боломжтой байсан. (Баримт 6. ХБХЭМБНХ-ын салбар комиссын шийдвэр)

2.	“С.А” нь СЭМҮТ-ийн хэт хөдөлгөөнтөх гэдэг оноштойгоор 55 дугаар сургуульд сурч байна. ХБХЭМБНХ-ын салбар комиссын шийдвэргүй. (Баримт 7. СЭМҮТ Сэтгэл зүйн оношилгоо)
3.	“Э.Э” нь БЗД-ийн ХБХЭМБНХ-ын салбар комиссын шийдвэрээр мэдрэл оюуны хөгжлийн бэрхшээлийн төрөл хэсэгчилсэн таталт оногтойгоор 55 дугаар сургуульд сурдаг. (Баримт 8. БЗД-ийн ХБХЭМБНХ-ын салбар комиссын шийдвэр)
4.	Сурах чадваргүй гэж үзсэн хүүхдийг (О.Б) СЭМҮТ-д сэтгэл зүйн оношилгоо хийлгээд 55 дугаар сургуульд шилжүүлсэн, Эрдэнэ сумын МСҮТ-д автын засварчнаар сургаж байгаа. Сэтгэцийн эмч биш сэтгэл зүйчийн хийсэн оношилгоо байсан. IQ 67%-тай гэж дүгнэсэн. (Баримт 9. СЭМҮТ, Сэтгэл зүйн оношилгоо, 2017) ХБХЭМБНХ-ын салбар комиссын шийдвэргүй.
5.	“Т” нь 2022 онд ирсэн. Эпилепси оноштой. 55 сурч байгаад одоо НТБ-ын төвд явж байна. СЭМҮТ-д сэтгэл зүйн оношилгоо хийлгэсэн. Чингэлтэй дүүргийн ХБХЭМБНХ-ын салбар комиссын шийдвэрээр хөгжлийн бэрхшээлтэй гэж тодорхойлсон. (Баримт 10. ХБХЭМБНХ-ын салбар комиссын шийдвэр)
6.	НТБ-ын төвд сургууль завсардсан хүүхдийг өгдөг. НТБ-ын төвөөс 92-р сургуульд шилжүүлсэн тохиолдол байгаа. БЗД-ийн НТБ төвд 7 хүүхэд 2, 6, 7, 8 ангиудад сурч байна. (Баримт 11.БЗД-ийн НТБТ-д суралцаж байгаа сурагчдын нэрс, 2023)
7.	НТБТ ба 55 дугаар сургуулийн 9 анги төгссөн хүүхдүүд ажил хийх сонирхолтой бол ажилд зуучилдаг. 18 нас хүрээгүй тул байнгын ажлын байр олох хүндрэлтэй.
8.	СХТ байгууллагад 4 хүүхэд байдаг. (Баримт 12. СХТБ-д байгаа сурагчдын нэрс, 2023)

Дүгнэлт 3. Гэр бүлд эргэн нэгтгэх үйл ажиллагаа доголдсоор байна.

- ✓ Гэр бүлд эргэж нэгтгэсэн 8 хүүхэд байна. Гэр бүлд эргэж нэгтгэхэд хүүхэд бэлэн болсон байхад гэр бүлийн нөхцөл сайжраагүй, зарим тохиолдолд дордсон байдаг. Зарим тохиолдолд эцэг эх буцаан авахыг хүсдэггүй. Тус төвд байх хугацаандаа бүтэн өнчин болдог тохиолдол гардаг.
- ✓ Засаг даргын захирамжууд хугацаагүй гардаг. Хүүхдийг гэр бүлд эргэн нэгтгэх төлөвлөгөөтэй ажиллах, Хамтарсан багаас гэр бүлийн үйлчилгээ нэхэхэд хэрэгтэй байдаг.
- ✓ Дүүргийн ГБХЗХ-ийн хэлтэс үйлчилгээ үзүүлэх хүний нөөцгүй, нийгмийн ажилтнууд цалин нь бага, байнга солигддог, тогтворгүй байгаа нь үйлчилгээний чанарт нөлөөлж байна.

Дүгнэлт 4. Хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд тасалдал, хийдэл байсаар байна.

- ✓ Урт болон богино хугацаанд гар бүлд дасгах үйлчилгээ, эргэн нэгтгэх үйлчилгээний хүрээнд эцэг эхтэй хариуцлагын гэрээ байгуулах, хүүхэдтэй нь тогтмол уулзуулдаг байх, ирж уулзахгүй 3 сар болбол утасдаж эцэг эхийг дуудах, удаан хугацаагаар ирэхгүй байвал хүүхэдтэй нь утсаар яриулах, хүүхдийг гэр бүлд авч очиж уулзуулах, эцэг эхийн өдөрлөг зохион байгуулах зэрэг үйлчилгээг төвийн ажилтнууд зохион байгуулдаг. Гэр бүлд нэгтгээд хамтарсан багт хүлээлгэн өгдөг, хяналт тавьдаг. (Баримт 13. ХЗСХТЦ-ын хүүхдүүдтэй гаднын хүмүүс болон эцэг эх асран хамгаалагчдаас хийх уулзалтад тавигдах шаардлага, 2022)
- ✓ Эцэг эх, төрийн байгууллага ч тэр Асрах төвд хүүхдээ хүлээлгэж өгөөд, бүх асуудлаа шийдвэрлэсэн мэт орхидог алдаа байна.
- ✓ Хүүхдийн асуудлыг шийдэж байгаа Хамтарсан баг шийдвэр гаргахдаа төвийг оролцуулахгүй (өгөх, болон эргэн нэгтгэхдээ) байна. Тухайлбал, Хүүхэд эргэн нэгтгэх хүсэлт тавихад ээж ажилтай боловч хүүхэд харах хүнгүй гээд эргэн нэгтгээгүй кейс гарсан.
- ✓ Эцэг эхийн боловсрол, хандлага тааруу, өөрсдөө хүүхдийн өмнө хариуцлага хүлээх ёстой гэдгээ мэддэггүй, ажилтнуудыг загнах зэргээр харилцдаг.

Дүгнэлт 5.Хүүхдийн хөгжилд онцгойлон анхаарч, урлаг, спортоор хөгжүүлэх чиглэлээр орон нутгийн болон нийслэлийн байгууллагуудтай хамтарч байна.

- ✓ Сэтгэл зүйн алба 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа. SEL хөтөлбөрийг багш нар сурсан, сургалт орж байгаа болон Мэргэжлийн чиг баримжаа олгох 3 үе шаттай Ротари клубтэй хамтарсан хөтөлбөрт 14-өөс дээш насны 22 хүүхэд хамруулсан. Хувь хүний

хөгжлийн сургалтууд, MCS, Оюутолгой компаниудтай танилцуулах, менторшип хөтөлбөрүүд хэрэгжүүлдэг.

- ✓ Хүүхдийн хоолонд өөрчлөлт хийх чиглэлээр чихрийн, өөх тос, амтлагч давсны хэрэглээг эрс багасгаж, эрүүл зөв хооллолтод анхаарч байна. 7 хоногт 1 удаа цагаан хоол өгч, овьёос зэрэг шинэ бүтээгдэхүүн хүнсний бүрэлдэхүүнд оруулж байгаа. Төвдөө 3х3 сагсан бөмбөгийн талбай тохижуулж, спортын заал нээлттэй байлгадаг.
- ✓ 2022 оноос төвөөс гадагшаа гаргаж нийгэмшүүлэх, нийгмийн амьдралд бэлтгэхэд анхаарч 43 хүүхдийг хамруулж байна. (Баримт 14. Гадагшаа дугуйлан секцэд хамрагдаж байгаа хүүхдүүдийн судалгаа, 2023)
- ✓ Чимэглэх урлалын дугуйланг арт терапитай хослуулах зэргээр шинэчилж байна.
- ✓ Гадагшаа дугуйлан секцэд хамруулах, хөгжүүлэхэд тухайн хүүхдийн хамрагдах үнэ төлбөрийг даах төсөв байдаггүй. Тухайлбал, хүүхдэд усанд сэлэлтийн хувцас, шил, тэмцээнд оруулах төлбөр зардал хэрэгтэй байхад төсөвт тусгагдаагүй байдаг.

Дүгнэлт 6. Асрамж халамжийн салбарын орон тооны норм норматив бодит байдалд нийцдэггүй, боловсон хүчний хомсдол нүүрлээд байна.

- ✓ 9 бүлэг (ахлах, дунд, бага) зохион байгуулагдсан. ХЭҮК-оос камер хэрхэн байрлуулах зөвлөмж авсан.
- ✓ Хүүхдэд учрах эрсдэлийг бодохоор байнга хонох хүний ээлжийг зохицуулахад нэмэлт 15 нийгмийн ажилтан хэрэгтэй болж байна. Тус төв 24 цагийн ажилладаг тул 8-10 хүүхдэд 1 нийгмийн ажилтан байна гэвэл ээлжид гарах зохицуулалтаар шууд 3-аар үржсэн хүний нөөц шаардлагатай болдог.
- ✓ Хүнд хүүхэдтэй ажиллахаас залуучууд шантарч, сургууль дээр асуудал гаргавал дуудагдахаас залхаж ажлаас гардаг. Сүүлийн 1 жилд олон залуу нийгмийн ажилтан ажлаас гарч байна.
- ✓ Стандарт дээр 40 хүүхдэд 1 сэтгэл зүйч гэдэг нь нийцэхгүй, асрахад байгаа зан үйлийн өөрчлөлттэй, донтолттой хүүхэдтэй буюу онцлог эрэлт хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах сэтгэл зүйч бол өндөр ачаалалтай байдаг.
- ✓ Сэтгэлзүйн үйлчилгээний стандарт байхгүй.
- ✓ Дан нийгмийн ажилтан ажиллуулдаг, гэвч гэрийн даалгавар хийлгэхэд туслах гол хичээлийн багшийн орон тоо шаардлагатай байна.
- ✓ Хүүхдэд бие махбодын шийтгэл үзүүлэхтэй эрс тэмцэж байгаа, шууд ажлаас халж, ширүүн тэмцэл хийсэн. Эргээд хүний нөөцийн асуудал үүсдэг. (Баримт 15. Хүүхэд-залуучуудын СХТЦ-ын хүүхдийн төвийн дотоод журам, 2022 он)
- ✓ Хүүхдийн кейстэй ажиллахад доголдол үүсэж байна, хүүхдийн мэдээллийн нууцлал алдагдах байдал гарсаар байна. Хуулийн байгууллага хэвлэл мэдээлэлд мэдэгддэг. Хүүхдүүд асуудалд ороход эргэх холбоо байдаггүй.

Дүгнэлт 7. Санхүү төсвийн хүндрэлтэй асуудал шийдэгдэхгүй ужгирсаар байна.

- ✓ ХНХ-ын Сайдын 2021 оны 11 сарын 29-ны Дугаар А/188 тоот Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний зардлын норматив шинэчлэн батлах тухай тушаалд хүүхдийн дотуур хувцас 780 төгрөг, хоол хүнсний зардал 1 өдрийн 7400 төгрөг байгаа нь зах зээлийн үнэ, инфляцын өсөлттэй огт нийцээгүй байна. Тооцоолж үзвэл 24 цагаар амьдардаг хүүхдэд 15000 төгрөг байвал хүрэхээр байна. Охидын ариун цэврийн хэрэгслийн төсөв жилд 6 удаа х3550 төгрөг, куртка, гутал 2 жилд 1 удаа гэж төсөвлөдөг нь амьдралд нийцээгүй төсөвлөлт байна. Эмийн төсөв хүрдэггүй, өвлийн цагт олноор ханиад хүрдэг.
- ✓ Хүүхдийн гэр бүлийн орчинд ойртуулах, эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх зорилгоо хэрэгжүүлэхэд засвар хийх, хөрөнгө худалдан авах шаардлага байнга үүсэж байхад төсвийн хэмнэлт хийхийг шаардаж байна.
- ✓ Төсөв маш багаар тавигдсан байхад тендер зарлах болдог, худалдан авалтыг өндөр үнээр хийж байна, төсөвтөө тааруулах бол бөөний үнээр худалдан авах хэрэгтэй байдаг.
- ✓ Хүүхдэд уншуулах ном, төгсөлтийн гэрчилгээний зардал тусдаггүй.
- ✓ Автобусны карт цэнэглэхэд хүндрэлтэй боллоо.

Дүгнэлт 8. Залуусын төвийн үйл ажиллагааг шинээр харах хэрэгтэй байна.

- ✓ 18 хүрээд хүсэлтээр нийслэлийн бүх халамж асрамжийн төвөөс (Өнөр бүлээс) 18-23 залуучууд төвд ирдэг. Бие даан амьдрахад бэлэн ч байх газаргүй, харгалзан дэмжигчгүй бол төвд ирдэг. 25 залуус хамрагдаж байна. (Баримт 16. ХЗСХТЦ-ын Залуучуудын төвийн залуусын нэгдсэн судалгаа, 2023 оны 4 сар)
- ✓ 4 залуу дээд сургуульд, 2 МСҮТ-д (охин), 1 Коллежид сурч байна.
- ✓ 5 хөгжлийн бэрхшээлтэй (группт), 1 залуу тэтгэлэгт хамрагдаж, гадагшаа (БНХАУ) явж сурч байгаа. 1 Турк улсад уран нугаралтаар ажиллаж, 2 охин ажил эрхэлж байна. Зарим залуус ЭЕШ-т бэлтгэж байна. (Баримт 17. ХЗСХТЦ-ын Залуучуудын төвийн ИДС-д суралцаж байгаа болон шинээр боловсролын байгууллагад суралцах залуусын судалгаа, 2023 оны 4 сар)
- ✓ 4 нийгмийн ажилтан, 1 сэтгэл зүйчтэй. Өнгөрсөн жилд 1 залууг хашаа байшинтай болгосон. Амьдрах гэрээг 6 сараар гэх мэт хугацаатай байгуулж, нийгэмтэй харилцах, ажил хөдөлмөр эрхэлж бие даан амьдрахад шилжүүлэх бодлого барьж байна. Залуусыг тогтвортой ажлын байранд зуучлахад хүндрэлтэй байна.
- ✓ Насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй залуус очих газаргүй тул төвд амьдарч байна.
- ✓ Төв аймгийн Борнуурт Од зуслан байдаг. МХЕГ-ын ашиглалтыг хугацаа дууссан гэсэн дүгнэлт гарсан. 1972 онд байгуулагдсан, хөрөнгө оруулалт хийсэн, их засвар хийгээгүй модон барилгуудтай. 2016 онд 100 сая төгрөгийн өртөгтэй зураг төсөл хийгдсэн батлагдсан 4 тэрбум төгрөгийн өртөгтэй ч төсөвт тусаагүй.
- ✓ Залуусын төвийн барилга шинээр баригдсан ч чанаргүй баригдсан тул нөхцөл муутай.
- ✓ Амьдарч буй хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох зорилгоор хэрэглээний мөнгө олгодоггүй нь Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 7.3.5 дахь заалтыг;
- ✓ Хүүхдийг асрамж халамжийн үйлчилгээнээс гарсан тохиолдолд орон нутгийн засаг захиргааны байгууллагад хүлээлгэн өгч, 1 жил хүртэлх хугацаанд хамтран ажилладаггүй нь Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын 7.3.6 дахь заалтыг тус тус зөрчиж байна.
- ✓ Хүүхэд рүү чиглэсэн хөгжлийн төлөвлөгөөг жилд нэг удаа гаргасан боловч үйл ажиллагаа болгон дээр, улирал тус бүрээр үнэлж дүгнээгүй тайлагнаагүй байсан нь хангалтгүй байна.
- ✓ ХЗСХТЦ-ын хүүхдийн төвийн оёдол, чимэглэлийн дугуйланд сургалт явуулах материалаа худалдан авах төсөвгүй, олон улсын тэмцээнд оролцох 2 хүүхэд зардалгүй шалтгаанаар явж чадаагүй байна.
- ✓ Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор, Хүүхэд залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолбор- Залуучуудын төвийн холбогдох албан тушаалтнуудад хүний нөөц бүрдүүлэхэд тавигдах шаардлагыг биелүүлэх, холбогдох баримт бичгийг нөхөн бүрдүүлэх, хүүхдийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө, үйлчилгээг хүүхэд бүрийн онцлогт нийцүүлэн боловсруулж хүргэх, гэр бүлд нь эргэн нэгтгэх үйл ажиллагааг холбогдох журам, стандартын дагуу зохион байгуулах, эргэн хяналтыг сайжруулах;
- ✓ Хүүхдийн төвөөс насанд хүрэн гарч байгаа хүүхдүүдэд зориулсан амьдралд бэлдэх, бие даан амьдрах хөтөлбөрүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх шаардлагатай байна. Эдгээр ажилдаа Засаг дарга нарыг оролцуулж ажиллах хэрэгтэй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Асрамжийн төвийн ерөнхий боловсролын сургууль төгсөж, элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан хүүхдийг сургалтын төлбөрийн хөнгөлөлт болон тэтгэлэгт хамруулах талаар дэмжлэг, туслалцаа үзүүлэх. Тухайлбал 2021-2022 оны хичээлийн жилд Хүүхэд, залуучуудын сургалт хүмүүжлийн тусгай цогцолборын 2 хүүхэд элсэлтийн ерөнхий шалгалтад 800 оноо авсан ч ямар нэгэн урамшуулал, санхүүгийн дэмжлэг аваагүй байна.
- Асрамж, халамжийн төвийн багш нарыг ерөнхий боловсролын багш нартай адил 1, 5, 10 жилийн мэргэшүүлэх сургалтад хамруулах.
- Асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүдэд хамран сургах тойрог тогтоож, сургууль цэцэрлэгт хамрагдах боломж олгох.

- Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны 159/А/146 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдийн хоногт хэрэглэх хоолны норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж норматив” нь Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны А/166, А/559, 222 дугаар тушаалаар баталсан “Цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн хоногийн хоолны илчлэгийн хуваарилалт”, “Цэцэрлэгийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ, “Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ”-ээс зөрүүтэй байгааг судалж, нэгтгэн шийдвэрлэх.
- Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2021 оны 159/А/146 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хувцас, ариун цэврийн болон хичээлийн хэрэглэлийн зардлын дундаж норматив, эдэлгээний хугацаа” нь өнөөгийн зах зээлийн үнэ ханшнаас зөрүүтэй байгаа тул судалж, шинэчлэн боловсруулах.
- Тус төвийн дүрэм, журмыг сүүлд батлагдсан хуулиуд, стандарт, журмуудтай нийцүүлэх шаардлагатай.
- Хүүхэд нэг бүрийг СЭМҮТ-ээр оношлуулдгийг таслан зогсоох, Хүүхдүүдийг сургууль завсардуулахгүй, хөгжлийн бэрхшээлтэй ч байсан аль болох ердийн сургуульд хамруулах хэрэгтэй.
- Тус төвийн хүүхдүүдийг олноор хамруулж байгаа Амгалан цогцолбор сургуулийн төсвийн талаар БЕГ-тай хамтран ажиллаж, нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл хүүхэдтэй холбоотой гарч байгаа зардлыг тусгуулах
- Хүүхэд асрах төвийн орон тооны норм нормативыг эргэн харах, ялангуяа онцгой нөхцөлтэй төвийн нормативыг тусад нь батлах, үндсэн хичээлийн багш ажилд авч гэрийн даалгаварт болон сурлагын хоцрогдол нөхөхөд анхаарах
- Тус төвд хүүхдийг асрахаар шилжүүлэх процедурыг нарийвчлах, гэр бүлд эргэн нэгтгэх үйл явцыг нарийвчлах, хүүхдийг асрах төвд авчрахаас өөр үйлчилгээний хувилбаруудыг гаргах
- Гэр бүлд үзүүлэх үйлчилгээг бүрэн болгох, төвд хүүхдээ өгсөн эцэг эхийн хүлээх үүрэг хариуцлагыг нарийвчлан журамлах
- Тус төвийн төсөв санхүүгийн норм нормативыг үнийн өсөлт, инфляцтай уялдуулан жил тутам өөрчлөх шинэчилж байх
- Тус төвд амьдарч байгаа хүүхдүүдийг тухайн орчноос гаргаж нийгэмшүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагааг бодлого, төсвөөр дэмжих,
- Тус төвийн зуслангийн байрыг төсөвт тусган шинэчлэх, хүүхдүүдийг зуны улиралд агаар салхинд гаргах, идэвхтэй өнгөрөөх, амьдрах ухаанд суралцах боломжийг бүрдүүлэх
- Өнөр бүл төв болон тус төвд охид, хөвгүүдийг тусдаа барилгад байрлуулах шийдэл хийх
- Залуусын төвийн үйл ажиллагааг цогцоор шинэчилж, өөр байдлаар зохион байгуулах.

3.3. Хүүхдийн төв сувилал

Нөхцөл байдал:

1967 онд “өнчин нялхсын ясли”, 1967 онд ихэр, өнчин нялхсын ясли, 1979 онд ЭМЯ-ны хүүхдийн сувилал, 1985 онд нялхсын сувилал, 2006 онд нялхсын клиник сувилал, 2012 онд хүүхдийн төв сувиллын бүтцээр ажиллаж байгаа эрүүл мэндийн байгууллага. Батлагдсан бүтцээр 122 орон тоотой боловч 98 орон тоотой ажиллаж байна.

Тус төв нь “Сувиллын бүтэц, үйл ажиллагаа MNS5232:2019” стандартын дагуу үйл ажиллагаа явуулдаг. 2018 онд магадлан итгэмжлэл орсон 110/2018 тоот гэрчилгээтэй. 05 сард дараагийн магадлан итгэмжлэлд хамрагдана.

96 ортойгоос 80 орыг ашиглаж байна. 17 ор нь олдмол, хөгжлийн /хүнд/ бэрхшээлтэй, байнгын хэвтрийн асаргаатай хүүхдүүдэд зориулж байна.

0-3 настай хүүхдийн дутуу, гүйцэт нярай, шарлалттай нялхсыг сувилах чиг үүрэгтэй, асран хамгаалах чиг үүрэг байхгүй боловч хаягдсан, хавсарсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг авахаас өөр арга байхгүй, түрүүчийн хүүхэд насанд биед хүрч байгаа боловч байнгын хэвтрийн асаргаа шаардлагатай тул нөхөн сэргээх үйлчилгээний төв болон асрамж халамжийн газрууд хүлээн авдаггүй, сэтгэцийн өвчтэйг нь СЭМҮТ авдаггүй. Эдгээр хүүхдийн

асрамж, халамжийн зардал гэж байдаггүй, ЭМЯ-наас баталсан төсвөөр үйл ажиллагаа явуулдаг.

ЗГХА-Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Хүүхдийн төв сувилалд хүүхэд хамгааллын үйлчилгээнд зориулж 2018 онд 114.254.042 төгрөг, 2021 онд 5.700.000 төгрөг, 2022 онд Хүүхдийн төв сувиллын хүүхдийн хөгжлийн өрөө тохижуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхөн сэргээх үйлчилгээнд 23,328,000 төгрөгийн санхүүжилт олгосон байна.

ДУГНЭЛТ:

Хүүхдийн төв сувилал байгууллагын чиг үүрэгт байхгүй боловч хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах үйл ажиллагаа явуулж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн, засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага /MNS6419:2021/ стандартын хүрээнд сэргээн засах тусламж үйлчилгээг батлагдсан стандарт, журам, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу багаар үзүүлэх буюу сэргээн засах, оношилгоо, эмчилгээ, сувилахуйн тусламж, эрүүл мэнд, сэтгэлзүй, эмнэлгийн дэмжих үйлчилгээ болон хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг дагнан хэрэгжүүлдэг чиг үүрэгтэй байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан А/23, 27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баталсан байдаг. Уг тушаалын 2 дугаар хавсралтаар шуурхай тусламж, үйлчилгээний зардлын норматив, гэр бүлийн орчинд хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний норматив, хүүхдийг түр гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний норматив, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний нормативыг баталж өгсөн боловч эдгээрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асрах, хамгаалах зардал тусгагдаагүй тул хүүхдийн төв сувилалд ямар нэгэн санхүүжилт хийгддэггүй, хуваарилагддаггүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн, засалт, хөгжлийн төв буюу төрөлжсөн мэргэжлийн байгууллага улсын хэмжээнд 1 байгаа боловч яг зорилтот хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн, байнгын асаргаатай хүүхдүүдийг харьяалуулан авахгүй, асрамж, халамжийн үйлчилгээг үзүүлэхгүй, эрүүл мэндийн буюу сувиллын байгууллагад байрлуулж байна. Эрүүл мэндийн байгууллагад эдгээр хүүхдүүдийн асрамж халамжийн төсөв гэж байхгүй улсын төсвөөс санхүүждэг, холбогдох агентлаг, дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс хүүхдийн мөнгийг шалгахаас бусдаар ямар нэгэн халамж, асрамжийн санхүүжилт хийгддэггүй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн, засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлагын дагуу бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь бусад төрлийн бэрхшээлтэй нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд оролцох чадвар нь хязгаарлагдсан 18 нас хүртэлх хүнд сэргээн засах тусламж үйлчилгээг батлагдсан стандарт, журам, эмнэлзүйн заавар, удирдамжийн дагуу багаар үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

- Хүүхдийн төв сувиллыг өөрийн үндсэн чиг үүргээр нь ажиллуулах
- Төрийн бус өмчийн асрамж, халамжийн төвүүд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн, засалт, хөгжлийн төвд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг авах орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай тохиолдолд хүүхдийн төв сувиллаас эмч, ажилчдыг гэрээгээр ажиллуулах нөхцөлийг бий болгох асуудлыг чиг үүргийн яамдаас шийдвэрлэн, эрх зүйн орчныг бүрдүүлж, үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалт, хэв шинжид нь өөрчлөлт оруулах
- Амьжиргааны түвшин, ядуурал, ажилгүйдэлтэй холбоотой бүтэн өнчин, асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоогдоогүй иргэн, хүүхэд рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулах асрамж халамжийн нэгдсэн төвийг улсын хэмжээнд байгуулах,

3.4. Вербист хүүхдийн асрамжийн төв

Нөхцөл байдал:

“Вербист” хүүхдийн асрамжийн төв нь Си Ай Си Эм олон улсын төрийн бус байгууллагын харьяа, гадаадын байгууллагын санхүүжилттэй, хагас болон бүтэн өнчин, нэн ядуу амьдралтай орон гэргүй хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдийг асран халамжилдаг. Үндсэн 14 ажилтантай, 4 давхар өөрийн байртай, эзэмшил газартай төрийн бус байгууллага юм. Тус төв нь цэцэрлэгийн насны 3, ерөнхий боловсролын сургуулийн насны 40, дээд сургууль, коллежид 6 нийт 49 хүүхдэд асрамж халамжийн үйлчилгээг үзүүлж байна.

ДҮГНЭЛТ:

2022 оны стандартын хяналт шалгалтын зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажилласан, дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах байдал сайжирсан байсан бөгөөд хүүхэд бүрд Хүүхдийн хөгжлийн төлөвлөгөө, болон нэгдсэн төлөвлөгөөг гарган улирлаар дүгнэн ажиллаж байна.

Тус төвийн одоогийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байр нь өөрийн эзэмшлийн боловч хүүхдийн ая тухай амьдрах орчныг бүрдүүлсэн байдал хангалтгүй бөгөөд стандартын хэрэгжилт дундаж гэж дүгнэж болохоор нөхцөл байдал ажиглагдаж байна.

ЗӨВЛӨМЖ:

Стандартын хүрээнд хүүхдийн орчны гэрэл, болон ор, өрөөний зохион байгуулалтыг өөрчлөх

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль зэрэг хууль тогтоомжийн хүрээнд хүүхдийн тусламжийн утас 108, хүүхэдтэй ажилладаг мэргэжилтнүүд, ЦЕГ-ын хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тусгай нэгж, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн дэргэд Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, 720 хамтарсан баг, 40 хүүхдийн эрхийн улсын байцаагч, 32 хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, 34 Түр хамгаалах байр, НЦҮТ зэрэг хүүхдийн эрхийн зөрчлийг илрүүлэх, хүүхдийг хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх бүтэц үндэсний хэмжээнд бий болж, хууль эрх зүйн орчин хангалттай бүрдсэн байна.

Гэвч цаашид зайлшгүй анхаарч сайжруулах шаардлагатай доорх асуудлууд байна. Үүнд:

1. Сум, багуудад гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны орон тоог тусгайлан бий болгох;
2. Салбар хоорондын уялдаа холбоо хангалтгүй, салангид тус тусдаа ажилладаг, нэгдсэн зохицуулалтгүй;
3. Хамгаалах байр, хамтарсан багууд тогтвортой санхүүжилтгүй, байгаа санхүүжилт нь хүрэлцээгүй учир үйлчилгээ нь тасалдах, үйл ажиллагаа зогсох, хүний нөөцөө алдахад хүрч байна;
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээ гэр бүл төвтэй биш, цогц биш, хүүхдийн эрхэд суурилагагүй, хөгжлийн бэрхшээлтэй болон бусад бүлэгт хүртээмжгүй, үр дүнгүй, гал унтраах төдийгөөр хязгаарлагдаж байна;
5. Урьдчилан сэргийлэх нэгдсэн стратегигүйгээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа үр дүн муутай, гарсан кейсийн араас л зардал гаргаж ажилладаг;
6. Мэдээллийн тогтолцоо салангид, шийдвэр гаргагчдыг бодитой, найдвартай мэдээллээр шуурхай хангаж чаддаггүй;

7. Ажил үүргийн хуваарилалт, зохион байгуулалт, хамтын ажиллагаа сул, нэг нь нөгөөгөө дэмждэггүй (гэр бүл, хүүхэд, залуучууд гээд салангид ажилладаг);
8. Хүүхэд хамгааллын салбар мэргэжлийн боловсон хүчний хомсдолд орсныг анхаарч, шийдвэрлэх;
9. Мэргэжилтнүүдийг сургах, чадавхжуулах нэгдсэн тогтолцоо байхгүй;
10. Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын ажил үүргийн хуваарилалт тэгш бус, албан тушаалын тодорхойлолтод тусгагдаагүй олон ажлыг гүйцэтгэдэг нь хариуцсан ажлын үр дүнд сөрөг нөлөө үзүүлдэг;
11. Анхан шатны мэргэжилтнүүдийн ажлын ачаалал өндөр, цалин бага;
12. Үйлчилгээний үр дүнд хийх хяналт, үнэлгээ байхгүй.
13. Хамтарсан багийн гишүүд, түүний удирдах албан тушаалтантай байгуулах үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод Гэр бүлийн тухай хуулиар хүлээсэн чиг үүргийг тодорхой тусган батлах;

ЗӨВЛӨМЖ:

1. Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийг бодит судалгаанд үндэслэн төсөвлөж, оновчтой хуваарилах;
2. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 18.1.2-т “Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх” чиг үүргийг аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд үүрэгжүүлэн хуульчилсан. Хуулийн хэрэгжилтийг сайжруулах; зардлыг яаралтай шийдвэрлэх;
3. Бүх шатны Засаг дарга нарт тус хуулийн 19.1.5-д “хохилогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах”-ыг үүрэгжүүлэн хуульчилсан боловч өнөөдрийг хүртэл уг асуудлыг шийдвэрлээгүй, хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Хамтарсан багуудын үйл ажиллагаа явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх;
4. ТХБ, НЦҮТ-үүдийг төрөлжүүлэх, үйлчилгээний санхүүжилтийг улсын төсвөөс магадлан итгэмжлэгдсэн байгууллагад нь шууд хуваарилж, гүйцэтгэлд нь хяналт тавих зохицуулалтыг бий болгох;
5. Хүүхэд хамгааллын салбарын гэр бүл төвтэй, цогц, мэргэшсэн, хүртээмжтэй, тогтвортой ажиллах нөхцөлийг хангах;
6. Хүүхдийн эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эцэг эх, олон нийтийн хандлагад нөлөөлөх, салбаруудын оролцоог хангах, уялдуулах, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалт, нөлөөллийн нэгдсэн бодлого баталж, хэрэгжүүлэх;
7. Мэдээллийн нэгдсэн санг бий болгож хөгжүүлэх;
8. Мэргэжлийн боловсон хүчний тогтвортой ажиллах бүхий л нөхцөл боломжийг бүрдүүлэх, хүний нөөцийг бий болгох;
9. Хүүхэд хамгааллын үйлчилгээг төрөлжүүлж, хөгжлийн бэрхшээлтэй бүлэгт хүртээмжтэй болгон хөгжүүлэх;
10. Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын ажил үүргийн хуваарилалтыг оновчтой болгох, албан тушаалын тодорхойлолтод тусгагдсан ажлыг хийж гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;
11. Үйлчилгээ тогтвортой, шуурхай, үр дүнтэй байх нөхцөлийг бүрдүүлэх, хүнд сурталгүй, чирэгдэлгүй байлгах;
12. Хүүхэд хамгааллын үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах.
13. Хамтарсан багийн түвшинд хөтөлж буй судалгааг нэг мөр болгож, мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоонд оруулан цаашид бодлого тодорхойлоход ашигладаг болох;
14. ГБХ, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагуудыг орон нутагт хүрч ажиллахад нь дэмжлэг үзүүлэх;
15. Нийгмийн ажилтнуудын 108 утасны дуудлагын хариу үйлчилгээний чанарыг сайжруулах;

16. Хүүхдийн эрх хамгааллын мэргэжилтэн, Хүүхдийн эрхийн улсын байцаагч 108 утасны дуудлагын хариу үйлчилгээнд тавих хяналт тавих ажлыг сайжруулах;
17. Үе тэнгийн дарамт, хүчирхийлэл, гэмт хэрэг, зөрчлийг бууруулахад нөлөөллийн арга хэмжээг тогтмол зохион байгуулах “Нөлөөлөл арга хэмжээг зохион байгуулах Цахим орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулж, хүүхдийг эерэг аргаар хүмүүжүүлэхэд эцэг эх, багш, ажилтнуудыг оролцоог хангаж, сургалт нөлөөллийн ажлыг тогтмол хийж, хандлагыг өөрчлөхөд анхаарч ажиллах.

ЗУРГАА. ХҮҮХДИЙН ЭРХ, ХҮҮХЭД ХАМГААЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЖИЖ БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨР

Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын талаарх холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэд үндэсний хэмжээнд нээлттэй хяналт шалгалт хийх ажлын хүрээнд Хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээний үр дүнд дараах чиглэлээр мэдээлэл цуглуулж ажиллав.

Үүнд:

1. Хүүхдийн хөгжил хамгааллын зардлын зарцуулалт

Хүүхэд хамгааллын тухай хууль 2016 оноос хэрэгжсэний дүнд Монгол улсын Засгийн газраас хүүхэд хамгаалалд зарцуулах төсөв, санхүүг нэмэгдүүлсэн. Хүүхдийн хөгжил, хамгааллын үйлчилгээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдэхэд УИХ, Засгийн газраас онцгойлон анхаарч ажиллаж байна.

Тодруулбал:

- 2017 онд 1.2 тэрбум төгрөг;
- 2018 онд 6.4 тэрбум төгрөг;
- 2019 онд 7.6 тэрбум төгрөг;
- 2020 онд 8.0 тэрбум төгрөг;
- 2021 онд 8.0 тэрбум төгрөг;
- 2022 онд 8.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт тусган баталсан.

2021 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам”, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны “Аргачлал, зардлын норматив батлах тухай” А/23, 27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг батлан мөрдүүлж байна.

Монгол Улсын Их хурлаас 2021, 2022 оны төсвийн тухай хуулийг батлахад Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээнд 8,0 тэрбум төгрөгийг тус тус баталсан. Батлагдсан төсвийг Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тус тус зарцуулж байна.

Засгийн газрын 2022 оны 97 дугаар тогтоолоор Хүүхэд харах үйлчилгээнд санхүүгийн дэмжлэг олгох журам”-ыг батлуулж, “Хүүхэд харах үйлчилгээний шалгуур, болзол, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, хүүхэд харах үйлчилгээг зохион байгуулах, хяналт тавих журам”-ыг ХНХС-ын 2022 оны А/180 дугаар тушаалаар баталж мөрдүүлэн ажиллаж байна.

НҮБ-ын Хүүхдийн сан, Засгийн газрын захиалгаар хийсэн “Монгол Улсын Хүүхэд хамгааллын үйлчилгээний өртөг ба төсвийн дүн шинжилгээ” судалгаанд дурдсанаар хуулийн хэрэгжилтийг хангахад 11.5 тэрбум төгрөг шаардлагатай гэж үзсэн байдаг.

Монгол Улсын төсвөөс 2023 оны төсвийн жилд хүүхэд харах үйлчилгээний зардалд 1,510,475,100 төгрөгийг зарцуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад батлуулсан. Орон нутгийн хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт ноцтой хэмжээнд дутагдалтай хэвээр байгаа, үүний улмаас хуульд заагдсан хүүхэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд саад бэрхшээл ихээхэн тулгарч байгаа тухай үнэлгээний дүн илтгэлээ.

Хүүхдийн хөгжил хамгааллын 2021, 2022 оны төлөвлөгөө, гүйцэтгэл

Хүүхдийн хөгжил, хамгааллын зардлыг 2021, 2022 онд дараах байдлаар аймаг, нийслэл, дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, хэлтэс, харьяа байгууллагад хуваарилсан.

1. *Аймаг, нийслэл, дүүргийн ГБХЗХГ, хэлтсүүдийн хүүхдийн хөгжил хамгааллын зардалд:*
 - 2021 онд **3,870.0** сая төгрөг буюу нийт санхүүжилтийн **48,4** хувийг,
 - 2022 онд **5,279.2** сая төгрөг буюу нийт санхүүжилтийн **66.0** хувийг,
- / хавсралт- 1, 2/*
2. *ГБХЗХГ-ын харьяа байгууллага болох Өнөр бүл хүүхдийн төв, Олон Улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, түр хамгаалах байр, Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд:*
 - 2021 онд **1235.3** сая төгрөг буюу **15.4** хувийг,
 - 2022 онд **444.8** сая төгрөг буюу нийт санхүүжилтийн **5.6** хувийг,
3. *Агентлагийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад:*
 - 2021 онд **2627.8** сая төгрөг буюу **29.5** хувийг,
 - 2022 онд **1906.0** сая төгрөг буюу **23.8** хувийг
4. *ХНХЯамны бодлогын үйл ажиллагаанд*
 - 2021 онд 266.9 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 3.3 хувийг,
 - 2022 онд 370.0 сая төгрөг буюу нийт санхүүжилтийн 4.6 хувийг тус тус хуваарилсан байна.

2021, 2022 оны Хүүхдийн хөгжил, хамгааллын зардлыг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл:

Хүснэгт 86 төсвийн зарцуулалт /сая төгрөгөөр/

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	2021 ОН			2022 ОН		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Гүйцэтгэл хувь
1	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	2,881.1	2,041.2	70.8	1,917.0	1,893.6	98.8
2	Хамтарсан баг /8 төрлийн үйлчилгээ авсан хүүхдийн тоо/	352.5	352.5	100.0	481.8	454.1	94.2
3	Салбар дундын хамтын ажиллагаа	367.7	337.4	91.8	375.2	434.3	115.8
4	Хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил	721.6	1,144.60	158.6	1,004.6	994.8	99.0
5	Сургалт, судалгааны ажил	403.3	242.6	60.2	483.8	475.4	98.2
6	Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	1,460.4	2,185.9	149.7	2,495.1	2,286.7	91.6
7	Төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	886.1	723.5	81.6	693.0	656.6	94.8
8	ХШҮ, мэдээллийн сан	173	38	22.0	181.0	165.8	91.6
9	Гамшиг, онцгой нөхцөл байдлын үе дэх хүүхэд хамгаалал	487.4	454.9	93.3	181.0	171.4	94.7
10	Хууль тогтоомж боловсруулах	266.9	220.7	82.7	187.5	179.7	95.8
Нийт дүн		8,000.0	7,741.3	96.8	8,000.0	7,712.3	96.4

График №2 / сая төгрөгөөр/




График №3 / сая төгрөгөөр/



Хүүхдийн хөгжил хамгааллын 2023 оны төлөвлөгөө

2023 онд Хүүхэд хамгааллын зардлыг 7,949.9 сая төгрөгөөр баталсан байна.

График 3.



Хүүхдийн хөгжил хамгааллын үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлийн 2018-2022 оны байдлаар:

Хүснэгт 9. Төсвийн зарцуулалт

№	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	2018 ОН			2019 ОН			2020 ОН			2021 ОН			2022 ОН		
		Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Гүйцэт гэл хувь	Төлөвл өгөө	Гүйцэтг эл	Гүйцэт гэл хувь	Төлөвлө гөө	Гүйцэт гэл	Гүйцэт гэл хувь	Төлөв лөгөө	Гүйцэт гэл	Гүйцэт гэл хувь	Төлөвлө гөө	Гүйцэт гэл	Гүйцэт гэл хувь
1	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ	1,488.8	1,505.7	101.1	1,598.0	1,483.6	92.8	2,119.2	1,959.9	92.5	2,881.1	2,041. 2	70.8	1,917.0	1,893. 6	98.8
2	Хамтарсан баг /8 төрлийн үйлчилгээ авсан хүүхдийн тоо/	585	597.1	102.1	364.9	338.5	92.8	278.8	249.9	89.6	352.5	352.5	100.0	481.8	454.1	94.2
3	Салбар дундын хамтын ажиллагаа	408.5	414.5	101.5	903.7	1008.2	111.6	183.4	165.1	90.0	367.7	337.4	91.8	375.2	434.3	115.8
4	Хууль сурталчлах, урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх нөлөөллийн ажил	1,137.5 0	1,103.4 0	97.0	909.20	896.2	98.6	1,491.7	1,400.0	93.9	721.6	1,144. 6	158.6	1,004.60	994.8	99
5	Сургалт, судалгааны ажил	388.5	389.9	100.4	627	631.6	100.7	680.2	560.7	82.4	403.3	242.6	60.2	483.8	475.4	98.2
6	Хүүхдийн хөгжил, оролцоог дэмжих, эрсдэлээс урьдчилан сэргийлэх	1,200.4	1,200.1	100.0	1,638.3	1,597.6	97.5	1,217.8	875.2	71.9	1,460.4	2,185. 9	149.7	2,495.1	2,286. 7	91.6
7	Төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	632	632	100.0	1572	1650.7	105.0	1,498.9	759.6	50.7	886.1	723.5	81.6	693	656.6	94.8
8	ХШҮ, мэдээллийн сан	20	18	90.0	60	54.9	91.5	30	20.1	67.0	173	38	22.0	181	165.8	91.6
9	Гамшиг, онцгой нөхцөл байдлын үе дэх хүүхэд хамгаалал										487.4	454.9	93.3	181	171.4	94.7
10	Хууль тогтоомж боловсруулах				500	499.3	99.9	500	267	53.4	266.9	220.7	82.7	187.5	179.7	95.8
Нийт дүн		5,860.70	5,860.70	100.0	8,173.10	8,160.60	99.8	8,000.00	6,257.50	78.2	8,000.0 0	7,741.3 0	96.8	8,000.00	7,712.3 0	96.4

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ 2023 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ГҮЙЦЭТГЭЛ

Хүснэгт 10. / төгрөгөөр/

№	Аймаг/Нийслэл	Нөхцөл байдлын үнэлгээ хийх зардал /80236/		Хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээний зардал /80237/		Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал /80238/		1-Р УЛИРЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	1-Р УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл			
1	ЗГХА ГБХЗХГ	-		341,334,600.0	75,178,484.0	112,753,800.0	10,164,400.0	454,088,400.0	237,942,321.6	52.4
2	Хүүхдийн тусламжийн 108 үйлчилгээний төв	6,054,000.0	6,043,352.7	10,500,000.0	8,899,361.0	-		16,554,000.0	14,942,713.7	90.3
3	Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ түр хамгаалах байр			18,750,000.0	13,340,577.0	-		18,750,000.0	13,340,577.0	71.1
4	Өнөр бүл хүүхдийн төв							-	-	
5	ОУ-ын Найрамдал цогцолбор							-	-	
Харъяа байгууллага		6,054,000.0	6,043,352.7	370,584,600.0	97,418,422.0	112,753,800.0	10,164,400.0	489,392,400.0	266,225,612.3	54.4
7	Архангай	353,500.0	58,980.0	16,129,800.0	1,577,457.1	11,138,800.0	2,891,090.0	27,622,100.0	4,527,527.1	16.4
8	Баян-Өлгий	1,990,000.0	899,100.0	16,828,800.0	7,564,710.0	8,977,500.0	8,361,650.0	27,796,300.0	16,825,460.0	60.5
9	Баянхонгор	882,300.0		72,175,200.0	65,533,000.0	12,575,100.0	11,138,284.0	85,632,600.0	76,671,284.0	89.5
10	Булган	1,065,900.0		20,557,800.0	5,782,800.0	8,250,000.0	4,116,790.0	29,873,700.0	9,899,590.0	33.1
11	Говь-Алтай	1,623,300.0	67,250.0	17,526,000.0	803,250.0	8,176,500.0	8,176,499.0	27,325,800.0	9,046,999.0	33.1
12	Говьсүмбэр	204,900.0		14,192,700.0	14,163,470.6	3,151,200.0	3,045,000.0	17,548,800.0	17,208,470.6	98.1
13	Дархан-Уул	2,272,750.0		25,000,000.0	24,647,140.1	11,717,975.0	4,685,950.0	38,990,725.0	29,333,090.1	75.2
14	Дорноговь	748,200.0	176,400.0	21,534,300.0	863,204.0	7,229,700.0	4,096,951.6	29,512,200.0	5,136,555.6	17.4
15	Дорнод	599,700.0		19,758,000.0	4,167,808.0	8,693,700.0	8,478,000.0	29,051,400.0	12,645,808.0	43.5
16	Дундговь	310,500.0	-	15,183,900.0	3,544,540.0	8,292,900.0	8,270,570.0	23,787,300.0	11,815,110.0	49.7
17	Завхан	889,500.0		28,158,600.0	5,719,152.8	10,542,600.0	2,067,500.0	39,590,700.0	7,786,652.8	19.7
18	Орхон	945,900.0		28,518,600.0	12,829,628.0	11,199,300.0	6,367,500.0	40,663,800.0	19,197,128.0	47.2
19	Өвөрхангай	4,927,100.0	246,500.0	41,683,200.0	32,926,688.0	12,655,200.0	4,218,400.0	59,265,500.0	37,391,588.0	63.1
20	Өмнөговь	1,560,000.0		44,145,900.0	31,366,810.0	12,692,700.0	7,442,200.0	58,398,600.0	38,809,010.0	66.5
21	Сүхбаатар	1,500,000.0	-	32,628,600.0	10,481,867.7	17,700,000.0	7,425,281.0	51,828,600.0	17,907,148.7	34.6
22	Сэлэнгэ	1,136,400.0		34,522,800.0	14,312,650.0	12,750,600.0	7,609,700.0	48,409,800.0	21,922,350.0	45.3

23	Төв	846,900.0		25,656,000.0	5,864,075.0	11,196,000.0	4,114,850.0	37,698,900.0	9,978,925.0	26.5
24	Увс	1,383,300.0	121,550.0	27,975,300.0	2,079,530.4	10,815,900.0	6,544,452.0	40,174,500.0	8,745,532.4	21.8
25	Ховд	1,270,500.0		37,581,300.0	19,052,995.9	10,797,300.0	3,960,000.0	49,649,100.0	23,012,995.9	46.4
26	Хөвсгөл	8,637,400.0	1,193,300.0	48,129,300.0	14,617,540.0	12,607,800.0	5,949,100.0	69,374,500.0	21,759,940.0	31.4
27	Хэнтий	451,800.0		49,866,900.0	38,941,469.0	15,035,100.0	14,264,000.0	65,353,800.0	53,205,469.0	81.4
Орон нутаг		33,599,850.0	2,763,080.0	637,753,000.0	316,839,786.6	226,195,875.0	133,223,767.6	897,548,725.0	452,826,634.2	50.5
28	Нийслэл	6,809,800.00	29,732,412.00	242,906,500.00	278,394,280.00	54,200,000.00	72,828,800.00	303,916,300.00	380,955,492.00	125.3
29	Баянгол	4,800,000.00	500,000.00	41,000,000.00	40,501,200.00	9,000,000.00	6,739,000.00	54,800,000.00	47,740,200.00	87.1
30	Баянзүрх	6,000,000.00	3,610,500.00	24,000,000.00	23,290,000.00	16,000,000.00	11,190,100.00	46,000,000.00	38,090,600.00	82.8
31	Багануур	3,750,000.00		6,000,000.00	3,969,000.00	3,900,000.00	3,814,100.00	13,650,000.00	7,783,100.00	57.0
32	Багахангай	3,750,000.00		3,000,000.00	3,000,000.00	3,900,000.00	3,900,000.00	10,650,000.00	6,900,000.00	64.8
33	Налайх	4,800,000.00	2,153,500.00	25,500,000.00	15,779,000.00	9,000,000.00	2,551,000.00	39,300,000.00	20,483,500.00	52.1
34	Чингэлтэй	4,800,000.00	4,800,000.00	24,000,000.00	24,000,000.00	9,000,000.00	7,500,000.00	37,800,000.00	36,300,000.00	96.0
35	Сонгинохайрхан	6,710,400.00	4,000,000.00	42,000,000.00	21,643,100.00	12,000,000.00	12,000,000.00	60,710,400.00	37,643,100.00	62.0
36	Сүхбаатар	5,489,000.00	1,305,000.00	22,300,000.00	20,878,100.00	9,000,000.00	7,135,200.00	36,789,000.00	29,318,300.00	79.7
37	Хан-Уул	4,800,000.00		32,000,000.00	27,000,000.00	9,000,000.00	6,000,000.00	45,800,000.00	33,000,000.00	72.1
Нийслэл, дүүрэг		51,709,200.0	46,101,412.0	462,706,500.0	458,454,680.0	135,000,000.0	133,658,200.0	649,415,700.0	638,214,292.0	98.3
Нийт		91,363,050.0	54,907,844.7	1,471,044,100.0	872,712,888.6	473,949,675.0	277,046,367.6	2,036,356,825.0	1,357,266,538.5	

ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5.3.24 заалтаар “Хүүхдийн төлөө сан”-г байгуулсан. Засгийн газрын 2021 оны “Журам батлах тухай” 172 дугаар тогтоолын хавсралтаар “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах түүнд хяналт тавих журам”-ыг баталсан.

Сангийн удирдлагыг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэрэгжүүлнэ. Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь энэ журмын 3.1.1-д заасан сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн, сонгон шалгаруулж дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг байгуулж ажиллуулна.

Тус журмыг үндэслэн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/128 дугаар тушаалыг хүчингүй болгож, 2022 оны А/12 тушаалаар Хүүхдийн төлөө сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг сонгон шалгаруулах, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг холбогдох яам, агентлагийн алба тушаалтнууд, иргэний нийгмийн байгууллага, хүүхдийн төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсан.

Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийн эх үүсвэр

- Хүүхдийн төлөө сангийн эх үүсвэр
- Улсын төсөв
- Хандив тусламж
- Авто тээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого
- Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжсэн соёл, урлаг, спортын тоглолтын хандив, тусламжаас бүрддэг.

Нэг. Орлого төвлөрүүлэлтийн байдлыг харуулбал:

Хүснэгт 11.

№	Эх үүсвэр	Орлого төвлөрүүлэлт		
		2021 он	2022 он	2023 он
1	Улсын төсвийн хөрөнгө	-	-	-
2	Хандив, тусламж	12,146,886.51	5,000,000.00	-
3	Автотээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлого	3,451,297,100.00	4,390,076,113.39	1,158,626,787.0
4	Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг дэмжсэн соёл, урлаг, спортын тоглолтын орлого	-	-	-
5	Бусад /"Хүүхдийн төлөө фонд" ТББ/	2,077,169,604.35	-	-
	Нийт дүн	5,540,613,590.86	4,395,076,113.39	1,158,626,787.00
		Нийт : 11,094,316,491.25		

Хоёр. Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийн зарцуулалт

Журмын 3.1.Сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21².3-т заасан дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна:

3.1.1.хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих;

3.1.2.олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах;

3.1.3.олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх;

Хүснэгт 12.

№	Зардлын зүйл	2021	2022	2023
3.1.1.	Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих;			
3.1.2.	Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах;	25,000,000.00	81,700,000.00	
3.1.3.	Олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх			
	Сангийн нийт зарлага	106,700,000		
	Сангийн үлдэгдэл	10,987,616,491.25 /2023оны 04 сарын байдлаар/		

2022 онд хүүхдэд олгохоор гарсан шийдвэр ба зарцуулалт

1. ХНХС-ын 2022 оны А/28, А/99, А/175,Агентлагийн даргын 2022 оны А/38, А/134 дугаар тушаалаар 30 хүүхдэд 81.7 сая төгрөгийн урамшуулал олгосон.

2. ХНХС-ын А/175, Агентлагийн даргын А/189 тушаалаар 22 хүүхдэд 31.5 сая төгрөгийн урамшууллыг шийдвэрлэсэн. Олгогдоогүй.

3. ХНХС-ын А/198, Агентлагийн даргын А/223 тушаалаар 21 хүүхдэд 46.1 сая төгрөгийн урамшууллыг шийдвэрлэсэн. Олгогдоогүй

4. ХНХС-ын А/206, 2022/12/02 01/894 тоот албан бичгээр 13 хүүхдийн 44.4 сая төгрөгийн хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлсэн. Олгогдоогүй

5. ХНХС-ын А/207, 2022/11/25 01/864 тоот албан бичгээр 35 хүүхдийн 69.0 сая төгрөгийн хүсэлт хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Нийт: 2022 онд 121 хүүхдийн 272.7 сая төгрөг

ҮҮНЭЭС:

- Хүүхдийн гар дээр олгогдсон: 30 хүүхдийн 81.7 сая төгрөг
- Шийдвэр нь гарсан хүлээгдэж буй 91 хүүхдийн 191.0 сая төгрөг /өглөг/

Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 21².3-т хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих, олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийг шагнаж

урамшуулах, олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд зарцуулах заасанчлан **Хүүхдийн төлөө сангийн 100900039503 тоот Төрийн сангийн дансанд** 10,9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 2023 онд Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор **“Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.1.1, 3.1.2, 3.1.3 рт** заасны дагуу 1,5 тэр бум төгрөгийг зарцуулахаар хүсэлтийг ХНХЯ, Сангийн яаманд хүргүүлсэн.

Гурав. 2023 онд “Хүүхдийн төлөө сан”-ийн хөрөнгийг зарцуулах төсөв

Хүснэгт 13.

№	Зардлын зүйл	2023 оны төсөв /сая.төг/
3.1.1.	хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих;	443,4
3.1.2.	олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдийг шагнаж урамшуулах;	656,6
3.1.3.	олон улс, тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан тэмцээн, наадамд оролцох бэлтгэл хангаж байгаа болон оролцох болзол хангасан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд дэмжлэг үзүүлэх	400,0
	Нийт	1,5 тэр бум

Дөрөв. Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтыг санхүүжилтээр дэмжих төсөл сонгон шалгаруулах чиглэлээр

2022 онд: Засгийн газрын 2021 оны 172 дугаар тогтоолоор “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ы 4.1-д заасны дагуу Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх “Хүүхдэд зориулсан бүтээн байгуулалтын төсөл”-ийг 2022 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зарлан, төслийг хүлээн авсан.

9 аймаг, 3 дүүргийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Цагдаагийн ерөнхий газар, Тээврийн цагдаагийн алба, Стандарт хэмжил зүйн хэлтэс зэрэг 27 төрийн байгууллагаас 13.7 тэрбум төгрөгийн төсөвтэй 37 төсөл, 6 иргэний 675.0 сая төгрөгийн төсөвтэй 6 төсөл, 1 аж ахуйн нэгж байгууллагаас 45.1 сая төгрөгийн төсөвтэй 1 төсөл, 21 төрийн бус байгууллагаас 8.3 тэрбум төгрөгийн төсөвтэй 29 төсөл, нийт 56 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэнээс 73 төсөл, арга хэмжээнд нийт 21.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг хүссэн төслийн саналууд ирсэн. Үүнээс:

- Тээврийн цагдаагийн албанаас ирүүлсэн Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд байгуулах 443,4 сая төгрөгийн “Хүүхдийн авто замын танин мэдэхүйн байгууламж” байгуулах төсөл;
- Баянхонгор Эрдэнэцогт сумын Өвгөн жаргалант хүүхдийн зуслангийн 566,4 сая төгрөгийн “Спорт цогцолбор шинээр барих” төсөл;
- Завхан аймгийн Тэлмэн сумын Ерөнхий боловсролын сургуулиас ирүүлсэн 180,5 сая төгрөгийн “Биеийн тамирын талбай байгуулах” төсөл;
- Дархан-Уул аймгийн 16-р сургуулийн 308,8 сая төгрөгийн “Хөл бөмбөгийн талбай хиймэл зүлэгжүүлэх” төсөл;
- Баянхонгор Эрдэнэцогт сумын Өвгөн жаргалант хүүхдийн зуслангийн 805,6 сая төгрөгийн Урлаг заал шинээр барих төсөл;
- “Цэгц хөгжил” ХХК-аас ирүүлсэн 45,1 сая төгрөгийн “Дархан-Уул аймаг, Багануур дүүрэгт гарц, гэрлэн дохио шинээр хийх” зэрэг нийт 2,3 тэрбум төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг нэг бүрчлэн хэлэлцэн, санал хураахад Тээврийн цагдаагийн албанаас ирүүлсэн

Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд байгуулах 443,4 сая төгрөгийн “Хүүхдийн авто замын танин мэдэхүйн байгууламж” байгуулах төслийг Хүүхдийн төлөө сангаас санхүүжүүлэхийг олонхын саналаар дэмжсэн санал, дүгнэлтийг гаргаж, Сангийн удирдлагад танилцуулан шийдвэрлүүлсэн.

2023 онд: “Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 4.1-д заасны дагуу Хүүхдийн төлөө сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх “Хүүхдэд зориулсан шинээр барьж байгуулах бүтээн байгуулалтын төсөл”-ийг 2023 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд зарлан, төслийг хүлээн авсан.

Ажлын хэсэг нь 2023 он 03 сарын 31-ний өдөр хуралдаж

- Багануур дүүргийн харьяат МУ-ын Зөвлөх багш Ч.Уртнасангийн санаачилсан “Нэг ертөнц-Одод” хүүхдийн зуслангийн төсөл,
- Хүүхдийн төв номын сангийн “Хүүхдэд ээлтэй орчин”, “Тохилог орчин амжилтын үндэс”, “Номын гэрэлт гудамж” зэрэг тохижилтын төсөл,
- Баянхонгор аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар”-ын Өвгөнжаргалант зуслангийн “Урлаг спортын цогцолбор” шинээр барих зэрэг төслүүдийг хэлэлцэн ирүүлсэн төслүүдийг шаардлага хангаагүй, 2023 онд Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах төсөв батлагдаагүй үндэслэлээр олонхын саналаар дэмжээгүй санал, дүгнэлт гаргасныг Агентлагийн даргын 2023/04/20-ны 01/278 тоот албан бичгээр ХНХСайд бөгөөд Сангийн удирдлагат хүргүүлээд байна.

Мөн Сангийн яамны 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн СХШХ-07 дугаартай удирдамжийн дагуу “Хүүхдийн төлөө сан”-гийн 2021 он, 2022 оны III улирлын санхүүгийн үйл ажиллагаанд **Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газраас хяналт шалгалтыг хийж, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг ирүүлсэн.**

Хяналт шалгалтын зөвлөмжийн хүрээнд “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газар, “Хүүхдийн төлөө сан” хоорондоо авто тээврийн хэрэгслийн сонирхол татахуйц улсын бүртгэлийн дугаар борлуулсны орлогын тооцоог жилийн эцэст нийлж баталгаажуулж, тус сан авлагаар бүртгээгүй зөрчил илэрсэн тул 2022 оны жилийн эцсийн байдлаар орлогын тооцоог нийлж, акт үйлдэн зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

**Хүүхэд хамгааллын үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар гэрээлэн
гүйцэтгүүлсэн ажлын талаарх танилцуулга 2018-2021**

Хүснэгт 14.

№	ТББ	Санхүүжилт			2021	Үйлчилгээ	Хэрэгжилт	
		2018	2019	2020			2018	2019
1	Ээлтэй ертөнц ТББ	6,300,000	2,700,000	-		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлд нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх	2018 оны 10 дугаар сарын 08-аас 2019 оны 04 дүгээр сарын 30-ны хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй 36 хүүхэд, 42 гэр бүлд нийгэм сэтгэл зүйн үйлчилгээг 14 мэргэжилтэн зүүлсэн байна.	
2	Орхон аймгийн Хүүхэд хамгааллын сайн үйлс төв ТББ	9,100,000	1,900,000	-		Бие махбод болон үйл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	Хөдөлмөр эрхэлж буй 18 гэр бүлийн 21 хүүхдэд хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр нөлөөллийн ажил хийсэн байна.	
3	Хөөрхөн зүрхнүүдийн аян ТББ	12,565,000	88,321,000	-		Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд 12 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	2019 оны 08 дугаар сарын 23-аас 2020 оны 02 дугаар сарын 20-ны хугацаанд Нийслэлийн 9 дүүрэгт ЕБС-ийн 4530 сурагч, эцэг эх 4350, СӨБ-ын 8093 хүүхэд, 37 хамтарсан багт зөвлөх үйлчилгээг үзүүлэх замаар хүүхэд хамгааллын эрсдэлийг бууруулах, хүүхэд бүхий л орчинд хамгаалагдах таатай орчин бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэхэд хувь оруулах зорилготой Олон нийтийг мэдлэгжүүлэх, Үүрэг хүлээсэн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдийг илрүүлэх, Эрсдэлт орчныг илрүүлэх “Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ”-г 8-н хүний бүрэлдэхүүнтэй баг үзүүлсэн байна.
4	Гэр бүлийн хөгжил боловсролыг дэмжих сан ТББ	16,086,000	-	-		Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд сэтгэлзүйн зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх, эцэг эх асран хамгаалагчдад нь гэр бүлийн боловсрол олгох, бэрхшээлийг давах туулахад нь туслан, чадавхжуулах	Төсөлд 30 хүүхэд хамруулахаар гэрээлэн 51 хүүхдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	
5	Дорнод аймгийн ХБХЭЭХолбоо ТББ	10,081,750	4,320,750	-		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	2018 оны 10 дугаар сарын 05-аас 2019 оны 04 дүгээр сарын 30-ны хугацаанд Дорнод аймгийн хөгжлийн бэрхшээлтэй (100 хувийн саажилттай, оюун ухааны бэрхшээлтэй, дауны өөрчлөлттэй) 3-15 насны 15 хүүхдэд өдрийн үйлчилгээ үзүүлсэн байна. Байгууллагын дэргэдэх Хүүхэд харах үйлчилгээнд 6 хүүхэд, Тусгай ангид 2 хүүхэд, Өдрийн үйлчилгээнд 6 хүүхэд 7 хоногт 3 удаа, Гэрээр айлчлах хөтөлбөрөөр 3 хүүхдэд 8 хүний бүрэлдэхүүнтэй баг үйлчилгээ үзүүлсэн байна.	

6	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ	22,694,000	46,446,000	-		Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх	2018 оны 10 сарын 05-аас 2019 оны 04 сарын 30-ны хугацаанд 3-н өмгөөлөгч, 4-н нэр бүхий байгууллагуудтай хамтран Улаанбаатар хотын 6 дүүрэг, Өмнөговь, Орхон, Дорноговь, Дундговь аймгийн Сайнцагаан, Дэрэн сумын бэлгийн хүчирхийллийн хохирогч 20-н хүүхдэд хүүхэд хамгааллын мэргэжлийн цогц үйлчилгээ үзүүлсэн байна.
7	Хөгжлийн хэлхээ ТББ	12,271,623	3,459,267	-		Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, гэр бүлтэй ажиллах	2018 оны 10 дугаар сарын 15-аас 2019 оны 04 дүгээр сарын 30-ны хугацаанд 25-н гэр бүлийн хөдөлмөр эрхэлдэг 48 хүүхдэд 5-н мэргэжилтний бүрэлдэхүүнтэйгээр хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн байна.
8	Сайн үйлсийн ирээдүй ТББ	9,181,900		-		Гуйлга гуйж байгаа хүүхдийг илрүүлж, нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх	Гуйлга гуйдаг хүүхэд, тэдний гэр бүлтэй нь ажиллах төслийг хэрэгжүүлэн 31 хүүхдийг хамруулсан байна. Мөн 3-н удаагийн сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж 33 хүүхэд, 140 эцэг эх, асран хамгаалагч иргэдийг хамруулсан байна.
9	Монголын хүүхдийн эрхийн төв ТББ	12,705,000	-	-		Гэр бүлийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг урлагаар дамжуулан хөгжүүлэх	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, гэр бүлтэй ажиллаж өөрийн байгууллагын дэргэдэх Шинэлэг төвөөр дамжуулан өдөр өнжүүлэх үйлчилгээнд 30 хүүхэд хамруулсан байна. Үйлчилгээ авч байгаа 30 хүүхдийн ар гэр 28 гэр бүлийг хүмүүжлийн эерэг арга сургалтад хамруулсан. Нийт 3 удаагийн нөлөөллийн ажилд 689 хүүхэд хамрагдсан байна.
10	Хүүхэд залуучуудын хөгжил хамгааллын төв	13,629,700	5,841,300	-		Тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй хүүхдийг хөдөлмөрөөс хөндийрүүлж, нийгэмшүүлэх	2018 оны 05 сарын 05-аас 2019 оны 05 сарын 05-ны хугацаанд томоохон зах, худалдааны төв, гудамж талбайд хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн судалгаа хийж, 104 хүүхэд илрүүлээд байна. Мөн сургалтад 68 хүүхэд гэр бүл хамрагдсан байна. Хөдөлмөр эрхлэгч хүүхдийг урлагаар дамжуулан нийгэмшүүлэх, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах зорилгоор бүжгийн багш, сэтгэл зүйчтэй гэрээ байгуулан ажиллаж, 28 хүүхдэд төслийн үйлчилгээг үзүүлж байна. Гэрээр айлчлах ажлын хүрээнд 10 эцэг эхэд зөвлөгөө өгч 4-н мэргэжилтэн үзүүлсэн байна.

11	Энэрэлийн түүчээ ТББ	15,595,000	-	-		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	Байнгын асаргаа, дэмжлэг шаардлагатай хөгжлийн болон нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа, өрх толгойлсон эцэг эхтэй хүүхэд тэдний гэр бүлд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд 60 гэр бүлийн 30 хүүхдийн гэрээр айлчлан хөгжлийн үйлчилгээ, эрүүл мэндийн үзлэг зөвлөгөөнд тогтмол хамруулсан байна.	
12	Хүүхдийн эрхийн үндэсний төв ТББ	13,496,350	5,784,150	-		Мансууруулах, донтох, сэтгэцэд нөлөөлөх эм болон бодисын хамааралтай болсон хүүхдүүдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх	Төслийн хүрээнд хараа хяналт сул 49 хүүхэдтэй ажилласан байна.	
13	Монгол өрх сэтгэл судлалын хүрээлэн ТББ	15,582,000	-	27,300,000		Эрсдэлт нөхцөлд байгаа зорилтот бүлгийн хүүхдэд сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх	Эрсдэлт нөхцөлд байгаа зорилтот бүлгийн хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд 60 хүүхэд, 152 эцэг эхэд үйлчилгээ үзүүлж ажилласан байна.	2018 оны 10 сарын 05-аас 2019 оны 04 сарын 30-ны хугацаанд 9-н дүүргийн ЕБС-ийн 4530 сурагч, эцэг эх 4350, СӨБ-ын 8093 хүүхэд, 37 хамтарсан багт зөвлөх "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, эрх зүйч, жолооч гэсэн 4 хүний бүрэлдэхүүнтэй нийслэлийн 5 дүүргийн 69 цэгт хүрч, нийт 47871 хүнд хүрч нөлөөлж ажилласан байна. Гэрээний хугацаа болоогүй байсан ч Ковид-19 цар тахлын улмаас өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан гэрээг 2020 оны 11-р сарын 20-ны өдрөөс дуусгавар болгож дүгнэсэн.
14	Үлэмж гэр бүлийн хөгжлийн төв ТББ	10,048,500	4,306,500	9,430,000		Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх	2018 оны 10 дугаар сарын 05-аас 2019 оны 04 дүгээр сарын 30-ны хугацаанд Улаанбаатар хотын Баянгол, Сонгинохайрхан дүүрэг, Хэнтий аймгийн Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдүүдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх" төслийг хэрэгжүүлэн 5 хүүхэд үйлчилгээнд хамрагдаж байна. 5 хүүхдийн хувийн хэргийн бүрдэл хангалттай, нэмэлт баяжилтуудыг хийхийг зөвлөсөн. 5 хэрэг мөрдөн байцаалтын шатанд байгаа, 2 өмгөөлөгч, 2 хууль ёсны төлөөлөгч томилуулан, ажиллаж байна. Явцын нөхцөл байдлын үнэлгээ хийгдээгүй, санхүүгийн бүрдэл, баримтжуулалт хангалтгүй тул зөвлөгөө өглөө. Хамтран ажиллаж байгаа хорооны нийгмийн ажилтнуудыг чадавхжуулах чиглэлээр сард 1 удаа уулзалт зохион байгуулж байна.	

15	Хүүхдийн эрхийн сургалт судалгааны хүрээлэн ТББ	17,699,500	6,223,490	9,950,000	Хууль зөрчсөн хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, улмаар хууль зөрчсөн хүүхдэд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний жишиг загвар, аргачлалыг тодорхойлох	2018 оны 10 сарын 30-аас 2019 оны 05 сарын 05-ны хугацаанд 8-н мэргэжилтэн хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээ дэмжих нийслэл, сонгосон орон нутагт хүүхэд хамгааллын үйлчилгээнд 69 хүүхэд хамрагдсанаас 45 хүүхэд үйлчилгээ авсан байна. Тухайн 45-н хүүхдийн ар гэр асран хамгаалагчид зөвлөгөө мэдээлэл өгч хамтран ажилласан байна.
16	Хүний хөгжил иргэдийн оролцоо ТББ	15,505,000	6,645,000	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, гэр бүлд нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх	2018 оны 10 дугаар сарын 05-с 2019 оны 04 дугаар сарын 30-ны хугацаанд Чингэлтэй дүүрэг дэх оюуны хөгжлийн бэрхшээлтэй 30-н хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагч нарт сургалт, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ, эрүүл мэнд, боловсролын үйлчилгээ болон портеж хөтөлбөрийг 2 мэргэжилтэн үзүүлсэн байна.
17	Өсвөр үеийн хөгжлийн төв ТББ	13,128,500	5,626,500	9,890,000	Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдэд нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх	2018 оны 10 сарын 15-аас 2019 оны 04 сарын 15-ны хооронд 6 сарын хугацаанд Сүхбаатар, Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянзүрх дүүргийн захын хороодод амьдардаг эмзэг бүлгийн хүний наймаа, бэлгийн мөлжлөг, гэр бүлийн хүчирхийллээс хамгаалагдах шаардлагатай 25-н өсвөр насны охидод бүх төрлийн хүчирхийллээс ангид байх зан үйлийг өөрчлөх, засах сэтгэлзүйн зөвлөгөө, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухааны ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулсан байна. Мөн бэлгийн мөлжлөгт өртсөн өсвөр насныханд зориулсан сэтгэл зүйн гарын авлага боловсруулсан байна. Эдгээр хүүхдүүдэд оёдол, зүймэл урлал, хэрээсэн хатгамал, бүжгийн хичээл, байгаль дэлхийтэй танилцах сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулж, сэтгэл зүйн үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлж, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг шуурхай үзүүлэн, нийгэмшихүйн үйлчилгээг хөгжүүлэх тал дээр санаачилгатай ажиллаж байна.
18	Нанзан данзан сан ТББ	10,574,200	-	-	Хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийг илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлж, гэр бүлтэй ажиллах, мэдээллийн сан үүсгэх	Зорилтот бүлгийн хүүхэд, тэдний гэр бүлд хүрч үйлчлэх талаар ямар нэгэн ажил, үйлчилгээ зохион байгуулаагүй.
19	Амин хүүхэд ТББ			9,950,000	Эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх	
20	Хүүхдийн эрх хамгаалах төвийн дэргэдэх Үжин төв		45,360,000	-	Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдэд урт хугацааны нийгэм сэтгэлзүйн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх	2019 оны 10 дугаар сарын 03-аас 2019 оны 12 дугаар сарын 25-ны хооронд буюу 3 сарын хугацаанд 5-17 насны 39 хүүхэд, 43 насны нэг эмэгтэй гээд нийт 40-н үйлчлүүлэгчид Сэтгэл зүйн, Хууль эрх зүйн, Эрүүл мэнд, Боловсролын, Амьдрах ухаанд сургах зөв дадал хэвшилтэй болгох үйлчлүүлэгчийг тайвшруулах, хэвийн байдалдаа эргэн ороход нь туслах нөхөн сэргээх нийгмийн ажлын цогц үйлчилгээг 6 мэргэжилтэн үзүүлсэн байна.
		236,244,023	226,933,957	66,520,000		

2. Үндэсний аудитын газраас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санхүүгийн тайланд хийсэн Үндэсний аудитын дүгнэлтэд хийсэн дүн шинжилгээ

Үндэсний аудитын газраас Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 2018-2021 онд “Хязгаарлалттай санал дүгнэлт”-ийг удаа дараа авч байжээ.

Хүснэгт 15.

№	Тайлант он	Аудитын дүгнэлт	Тайлбар
1	2018 он	Хязгаарлалттай санал дүгнэлт	<p>Нийт зарлагын дүн: 7,500,053.400 төгрөг Нийт зөрчлийн дүн: 596,806.400 төгрөгийн 10 зөрчил Албан шаардлага өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> Тайлант онд 18 төрийн бус болон аж, ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгүүлсэн ажлын нийт 208,009.700 төгрөгийн санхүүжилтийг анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн, Кино хийхэд 132,400.000 төгрөгөөр жүжиг хийлгэсэн Хүүхдүүдэд үзүүлэхэд зориулж 22,095.000 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалтыг зөрчсөн, Удирдах ажилтны зөвлөгөөнд 16,856.800 төгрөг, Системийн спортын арга хэмжээнд 8,532.500 төгрөг, Ахмадын баярын өдөрт 3,500.000 төгрөг, Брэйнсторм ХХК-аар байгууллагын брендбүүк 20,000.0 сая төгрөгөөр хийлгэхэд, Сургалтын зардлаас магистр, докторын сургалтын төлбөрт 11,000.0 сая төгрөг, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолборын 40 жилийн ойн арга хэмжээнд хүүхэд хамгааллын зардлаас 125,000.000 сая төгрөгийг тус тус төсвийн зориулалт зөрчин зарцуулсан, Эм Эс Си Ай ХХК-тай “Салбарын болон байгууллагын үйл ажиллагаанд судалгаа шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт өгөх” 50,000.000 сая төгрөгийн ажлыг 2018 оны 3 дугаар сарын 22-ноос 2018 оны 6 дугаар сарын 29-нийг хүртэлх хугацаанд гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, урьдчилгаа төлбөрт 40,000.000 сая төгрөг төлсөн боловч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, хүлээн аваагүй, гэрээг сунгаагүй, хариуцлагын талаар зүйл, заалт оруулаагүй, эргэж буцааж төлүүлсэн эсэх нь тодорхойгүй.
2	2019 он	Хязгаарлалттай санал дүгнэлт	<p>Нийт зарлагын дүн: 6,389,677.000 мянган төгрөг Нийт зөрчлийн дүн: 513,365.100 мянган төгрөгийн 7 зөрчил Албан шаардлага өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> Төсвийн зориулалтыг өөрчлөн урсгал зардлаас 119,500.000 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, <p>Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хоёр ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны цалинг төсвөөс 17,552.000 мянган төгрөг нөхөн олгосон боловч буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ огт аваагүй. Өмнөх оны санхүүгийн тайланд өглөгийн үлдэгдлээр тусгагдаагүй 2018 онд 3 иргэн, 16 төрийн бус байгууллагатай байгуулсан гэрээт ажлын үлдэгдэл төлбөр 120,134.100 мянган төгрөгийг төлж, санхүүгийн үр дүнгийн тайланд тайлант жилийн зардлаар хүлээн зөвшөөрч тайлагнасан зөрчилтэй.
3	2020 он	Хязгаарлалттай санал дүгнэлт	<p>Нийт зарлагын дүн: 2,995,588.800 мянган төгрөг Нийт зөрчлийн дүн: 136,221.6 мянган төгрөгийн 9 зөрчил</p>

			<p>Төлбөрийн акт тогтоосон:</p> <ul style="list-style-type: none"> Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан нь Шүүхийн шийдвэрээр тогтоогдсон хоёр ажилтанд ажлаас чөлөөлөгдсөн хугацааны нийт 17,552.0 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосон боловч буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авах тухай зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, <p>Албан шаардлага өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн 3 дахь шатны шинэчлэлийг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээний 102/2020 дугаартай гэрээг 145,000.000 мянган төгрөгөөр "Бид солюшн" ХХК-тай байгуулан 72,500.000 мянган төгрөгийн урьдчилгаа шилжүүлсэн байна. Зөвлөх үйлчилгээний гэрээнд заасан үр дүнг тооцох, хугацааг баримтлаагүй, Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих 442 мэдээллээс 27 мэдээллийг хугацаа хоцроож, нэг мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй,
4	2021 он	Хязгаарлалттай санал дүгнэлт	<p>Нийт зарлагын дүн: 3,956,567.700 мянган төгрөг Нийт зөрчлийн дүн: 454,864.700 мянган төгрөгийн 8 зөрчил</p> <p>Албан шаардлага өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> Тайлант онд нэмэлт санхүүжилтийн 3 гүйлгээ болох 20,316.700 мянган төгрөгийн зардлын гүйлгээг шилэн дансны нэгдсэн цахим системд мэдээллийг оруулаагүй байна. <p>Зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн:</p> <ul style="list-style-type: none"> Нэмэлт санхүүжилтийн орлогоос хүүхэд хамгаалах сайн дурын ажил, журам сурталчлах хүүхдийн эрх гэх мэт зардлуудад зарцуулсан 52,420.000 мянган төгрөг өгийн гэрээ дүгнэсэн акт, ажлын тайлан анхан шатны дэмжих баримтын бүрдэл хангалтгүй, Хүүхэд хамгаалал, хүн амын бүлэгт чиглэсэн хөтөлбөр 87 арга хэмжээний 2,510,689,000 мянган төгрөгийн зарцуулалтыг шалгахад 73 зардлын гүйлгээний 153,177.400 мянган төгрөгийн зарцуулалтад мөнгөн урьдчилгааны тайлан бэлтгээгүй байна.

Дүгнэлт:

ГБХЗХГ нь хүүхэд хамгааллын үндэсний хэмжээний төсвийн бодлого, санхүүжилт, зарцуулалтыг хариуцдаг байгууллага. Улсын хэмжээнд хүүхэд хамгааллын төсөв, санхүүжилтийн зардлын нарийвчилсан дүн, мэдээллийн олдоц, ил тод байдал хангалтгүй зарим мэдээллийг гаргаж өгөөгүй хэдий ч Үндэсний аудитын хийсэн дүгнэлтээс харахад ГБХЗХГ нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйл 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;” заалтыг удаа дараа зөрчсөн, Шилэн дансны тухай хуулийн дагуу тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллийг хугацаа хоцроодог, зарим мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулдаггүй, хэт ерөнхий, санхүүжилт гаргах тухай тушаалын хавсралтууд дутуу зэргээс хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зориулж буй төсвийн зарцуулалтыг нарийвчлан тооцох боломжгүй байна. ГБХЗХГ-ын нийт зардлын дүн Хүүхэд хамгааллын зардлын дүнгээс зөрүүтэй (бага) байна. Орон нутагт шилжүүлсэн Хүүхэд хамгааллын зардалд тавьсан хяналт сул, нэгдсэн мэдээлэл байхгүй байна. 2018-2021 он хүртэл жил бүр санхүүгийн сахилга бат, зөрчил, алдаа дутагдал удаа дараа гаргаж байхад хариуцлага тооцсон талаар мэдээлэл огт байхгүй байна.

Зөвлөмж:

- Хүүхэд хамгааллын төсвийн зарцуулалтыг системийн хувьд сайжруулах олон асуудал урган гарч ирж байна. Тухайлбал, мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна. Тэр дундаа хүүхэд хамгааллын зардал, эх үүсвэрүүд, зориулалт, зарцуулалтын нарийн дата,

санхүүжилтийн үр дүнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл тун хомс, олдоц муутай мөн ил тод биш үр дүнд суурилсан тайлан байхгүй байгааг сайжруулах шаардлагатай байна.

- Хүүхдийн хөгжил хамгаалалд зориулж өгсөн хандив, тусламжийн мэдээлэл, зарцуулалтын ил тод байдал хангалтгүй нэн ялангуяа ОУБ, Төрийн болон ТББ, иргэдийн санаачилсан асрамж, халамжийн төвүүд, Түр хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвд өгсөн тусламжийн дүн мэдээг шилэн дансанд заавал байршуулах
- Хүүхэд хамгааллын зардалд жил бүр 8 тэрбум төгрөг төсөвлөгддөг боловч төсвийн зарцуулах зориулалт, ангилал тодорхойгүй, санхүүжүүлэх үүрэг, чиглэл нь холбогдох хууль, журамд тусгагдаагүй 2022 он хүртэл явж санхүүгийн сахилга бат, хяналт сул байснаас хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ авах ёстой хүүхдүүддээ хүрэхгүй үр дүнгүй зүйлд зарцуулагдсан байгаад анхаарах цаг нэгэнт болжээ. Иймээс 2022 оны 01 дүгээр сарын 31-нд Сангийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын хамтарсан тушаалаар А/23,27 тоот тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баталсан ч энэ нормативаар шуурхай тусламж үйлчилгээ, гэр бүлийн орчинд хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх, хүүхдийг түр гэр бүлээс нь тусдаа орчинд хамгаалах, нөхөн сэргээх, хүүхэд асрах хувилбарт үйлчилгээний норматив, урьдчилан сэргийлэх үйлчилгээний зардлыг санхүүжүүлэх жишиг нормативыг баталсан ч журмын хэрэгжилт Нийслэл, дүүрэг, аймгийн ГХБХЗХГ-ын анхан шат “Хамтарсан баг”-т олгосон талаарх мэдээлэл хангалтгүй байгаад анхаарах, санхүүжилтийг олгох ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.
- Хүүхэд хамгааллын зардал нь халамжийн үйлчилгээ болон бусад салбарын зардалтай давхцах, зориулалтын бусаар ашиглах, төсвийн зарцуулалт бодитой бус, үр ашиг, үр дүн багатай зарцуулагдах эрсдэлтэй байгаад анхаарах
- Хүүхэд хамгаалалд зориулсан төсөв бүх түвшинд хангалтгүй ялангуяа анхан шатанд хариу үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий Хамтарсан багт тогтсон төсөв байхгүй, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ дэх төсвийн болон төсвийн бус зарцуулалт орон нутагт харилцан адилгүй байгаад анхаарах
- Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн магадлан итгэмжлэлийн журмын дагуу ТББ-уудыг магадлан итгэмжилсэн боловч Хүүхэд хамгааллын зардлаас санхүүжүүлдэггүй. Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх тендер зарладаг боловч ТББ-ууд нь оролцдоггүй учир нь тендер сонгон шалгаруулалт зарлахдаа оны эхнээс биш 9,10 сард зарлаж богино хугацааны багахан мөнгөөр гэрээлэн гүйцэтгэж үр дүнгүй чанаргүй ажил хийж байгаад анхаарах
- Хүүхдийн хөгжил хамгааллын чиглэлээр гэрээ байгуулсан ТББ-уудын шалгаруулалт, гэрээний хэрэгжилт, үр дүнд 2018-2023 оныг хамруулан дүн шинжилгээ хийх ёстой боловч ГХБХЗГ-аас 2018-2019 оны мэдээлэл, гэрээний мөнгөн дүнгийн задаргааг өгч 2020-2023 онд хийгдсэн гэрээ бусад мэдээллийг өгөөгүй тул дахиж тусгайлсан хяналт шалгалтыг явуулах шаардлагатай.
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон хүчирхийлэл, гэмт хэргийн хохирогч, хамгаалал шаардлагатай хүүхдэд хариу үйлчилгээ үзүүлэн ажилладаг ТББ-уудын чадавхыг бэхжүүлэх, Төрөөс дэмжих бодлого байхгүй байгаад анхаарах
- Монгол улсын Засгийн газраас зарим төрлийн үйлчилгээг ТББ-аар гэрээлэн гүйцэтгэх замаар Төрийн данхайсан зарим бүтцийг бууруулах замаар үр дүн, чанарт суурилсан нийгмийн ажил үйлчилгээг бий болгох
- Хүүхдийн хөгжил, хамгааллын үйл ажиллагааны төлөвлөлтийг статистик мэдээлэл, судалгаа, нотолгоонд суурилсан орон нутаг тус бүрийн онцлог гэмт хэрэг, хүчирхийллийн гаралт, давтамж, эрсдэлд үндэслэсэн хийж, үр дүнг нь тооцох, сайн туршлагыг нутагшуулах, шинэ үйлчилгээг бий болгож хөгжүүлэх, хүүхдийн асуудлаар салбар дундын зохицуулалтыг хийх үйл ажиллагааг сайжруулах

- Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, олон сая долларын санхүүжилтийн үр ашгийг нэмэгдүүлэх, бодлогын нэгдсэн удирдлагаар хангах, үр дүнг тооцох, хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Гурав: Сангийн Яамны төсөл арга хэмжээний жагсаалтаас хүүхдийн эрх хамгаалалтай холбоотой төслийн мэдээллээс түүвэрлэсэн байдал

Сангийн яамны төсөл арга хэмжээний жагсаалтыг ажлын хэсгээс ирүүлсэн бөгөөд тус мэдээлэлд нийт 256 төсөл хөтөлбөрийн талаарх товч мэдээлэл байв. Уг жагсаалтад төсөл, хөтөлбөрийн талаарх хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарим төсөл, хөтөлбөрийн төрөл, хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжүүлэх байгууллага, салбарын талаарх тодорхой мэдээлэл байхгүй байсан тул хүүхдийн эрх, хүүхэд хамгаалалтай холбоотой төслүүдийг түүвэрлэн жагсаалтыг гаргаж ажиллалаа.

Хүснэгт 16.

№	Санхүүжүүлэгч байгууллага	Нэр	Төрөл	ХУГАЦАА		Төлөв	Төслийн зорилго
				Эхлэх	Дуусах		
Боловсрол, шинжлэх ухааны яам							
1	Азийн хөгжлийн банк	Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл	Буцалтгүй тусламжийн төсөл	2021-01-01	2024-02-29	Хэрэгж иж байгаа	Тэгш хамран сургах боловсрол: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилготой; Сургуулийн үдийн хоол; Хосолсон сургалт: Сурагчийн сурлагын амжилтыг сайжруулах зорилгоор хосолсон сургалтын загварыг бий болгох
2	Азийн хөгжлийн банк	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл	Зээлийн төсөл	2018-04-30	2024-06-30	Хэрэгж иж байгаа	Ерөнхий боловсролын 2 сургууль, 3 цэцэрлэг шинээр барьж, 5 сургууль, 13 цэцэрлэгийн барилгыг өргөтгөж, шаардлагатай тавилга, тоног төхөөрөмжөөр хангана. Сургуулийн суудлын тоог 3400, цэцэрлэгийн орны тоог 2600 орчмоор нэмэгдүүлнэ. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн болон үнэлгээний шинэчлэлийг эцэслэнэ. Шинэчилсэн сургалтын хөтөлбөртэй нийцсэн сургалтын хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж хангана. Сайжруулсан хөтөлбөр ба үнэлгээний чиглэлээр багш, удирдах ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлнэ. Боловсролын үйлчилгээний төлөвлөлт, удирдлагын тогтолцоог бэхжүүлнэ.
3	Америкийн Нэгдсэн Улс	АНУ-ын хоёр цэцэрлэг	Хүмүүнлэгийн төсөл	2020-01-01	2022-12-31	Хэрэгж иж байгаа	Увс аймгийн Улаангом, Хэнтий аймгийн Дадал сумдад цэцэрлэг барих
4	Америкийн Нэгдсэн Улс	50 ортой 3 цэцэрлэг барих төсөл	Хүмүүнлэгийн төсөл	2019-09-18	2021-12-31	Хэрэгж иж байгаа	50 хүүхдийн ортой гурван цэцэрлэг барих

5	Бүгд Найрамдах Солонгос Улс	ШУТИС-н Мэдээлэл Холбооны Технологийн Сургуулийн чадвахыг бэхжүүлэх төсөл	Буцалтгүй тусламжийн төсөл	2019-01-15	2023-01-15	Хэрэгж иж байгаа	Монгол улсын Шинжлэх Ухаан Технологийн Сургуулийн Мэдээлэл, Холбооны Технологийн сургуулийн чадавхыг бэхжүүлэх замаар Монгол улсын ахисан шатны боловсролын салбарын мэдээллийн технологийн аж үйлдвэрийн салбарын үр нөлөөг нэмэгдүүлж улсын хөгжилд хувь нэмэр оруулах
6	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Ерөнхий боловсролын 7 сургууль, 1 цэцэрлэг барих төсөл	Буцалтгүй тусламжийн төсөл	2016-05-05	2021-12-31	Хэрэгж иж байгаа	Сонгинохайрхан, Хан-Уул болон Баянзүрх дүүрэгт нийт 5,680 суудалтай 7 сургууль, Архангай аймагт 100 хүүхдийн 1 цэцэрлэг баригдана
7	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага	"ЕБС-ийн үдийн хоол үйлдвэрлэлийг дэмжих төсөл"	Хүмүүнлэгийн төсөл	2021-10-01	2025-09-01	Хэрэгж иж байгаа	Монгол улсын ерөнхий боловсролын бүх сургуулиудад шим тэжээлийн тэнцвэртэй байдлыг хангасан, аюулгүй үдийн хоолоор ханган нийлүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулна.
8	Мэдээлэл байхгүй	Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр	Буцалтгүй тусламжийн төсөл	2022-08-18	2027-10-31	Хэрэгж иж байгаа	Мэдээлэл байхгүй
9	Мэдээлэл байхгүй	Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэх нь" (MONGWBL) төсөл"	Буцалтгүй тусламжийн төсөл	2021-05-03	2023-01-31	Хэрэгж иж байгаа	Ажлын байранд суурилсан сургалтыг нэвтрүүлэх
10	Дэлхийн банк	Боловсролын чанарын шинэчлэл төсөл	Зээлийн төсөл	2015-08-17	2022-12-31	Хэрэгж иж байгаа	Бага боловсролын эх хэл, байгалийн ухаан ба математикийн сургалтын чанар, үр дүнг сайжруулж, сургуулийн түвшинд төлөвлөлтийг бэхжүүлэх замаар бага боловсролын чанарыг сайжруулах, Ковид-19 цар тахлын үед "Хүүхдийн мөнгөн тэтгэмж"-д дэмжлэг үзүүлэхэд оршино.

11	Европын Холбоо	Хүрээлэн буй орчны инженерчлэлийн хөтөлбөрийг шинэчлэх замаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нь ТАСМЕЕ	Техник туслалцааны төсөл	2021-01-17	2024-01-16	Хэрэгж иж байгаа	"Хүрээлэн буй орчны инженерчлэлийн хөтөлбөрийг шинэчлэх замаар уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх нь" – ТАСМЕЕ нь Европын Холбооны "Эрасмус+"-аас санхүүжүүлж буй хамтарсан төсөл бөгөөд хүрээлэн буй орчны судалгааг боловсронгуй болгохоос гадна Монгол улсын хүрээлэн буй орчны бохирдолт, түүнийг шийдвэрлэх арга, технологид анхаарлаа хандуулна.
Эрүүл Мэндийн Яам							
12	Кувейт Улс	Түлэнхийн төв барих төсөл	Буцалтгүй тусламжийн төсөл	2017-07-25	2022-05-30	Хэрэгж иж байгаа	Түлэнхийн төвийн барилгыг барих
13	Люксембургийн Их Гүнт Улс	Монгол Улсын зүрх судасны үндэсний төв ба зүрх судасны тусламж үйлчилгээг уялдуулан сайжруулах төсөл	Буцалтгүй тусламжийн төсөл	2017-06-01	2022-09-30	Хэрэгж иж байгаа	Хүрэх Үр дүн 1: Алсын зайн анагаах ухааны үндэсний сүлжээг бэхжүүлэх; Хүрэх Үр дүн 2: ЗСТ-ийн мэс заслын чадавхыг тогтворжуулан цаашид сайжруулах; Хүрэх Үр дүн 3: Бүх шатлалд зүрх судасны тусламж үйлчилгээг уялдуулан бэхжүүлэх; Хүрэх Үр дүн 4: ЗСТ-ийг чадавхжуулж, институтчилах.
14	НҮБ-ын Хүүхдийн сан	Эх, хүүхдийн эрүүл мэнд	Хүмүүнлэгийн төсөл	2017-01-01	2022-12-31	Хэрэгж иж байгаа	Эх хүүхдийн эрүүл мэнд хамгаалах зорилт ханган ажиллах
15	Азийн хөгжлийн банк	Ази номхон далайн гамшгийн эсрэг хариу арга хэмжээ авах сангийн буцалтгүй тусламж	Буцалтгүй тусламжийн төсөл	2020-12-17	2020-12-17	Хэрэгж иж байгаа	Мэдээлэл байхгүй
16	Азийн хөгжлийн банк	Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5 төсөл: Яаралтай үеийн тусламжийн нэмэлт санхүүжилт	Зээлийн төсөл	2020-07-07	2022-04-30	Хэрэгж иж байгаа	Анхны төсөлд хамрагдаагүй 7 аймгуудын нэгдсэн эмнэлгийн төвлөрсөн ариутгалын тасгийг шинэчлэх; КОВИД-19 болон амьсгалын замын хүнд, хурц хэлбэрийн халдвартай өвчтөнийг оношилж, эмчлэх лавлагаа шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгүүдийн эрчимт эмчилгээ болон түргэн тусламжийн үйлчилгээний чадавхыг сайжруулах; Халдварт Өвчин Судлалын Үндэсний төв болон халдвар зөөвөрлөх өндөр эрсдэл бүхий улсуудтай хил залгаа аймгуудын эмнэлэгт КОВИД-19 болон амьсгалын замын хүнд, хурц хэлбэрийн халдварыг оношлох чадавхыг сайжруулах; Улаанбаатар хотод онцгой байдлын үед хэрэглэх эм, эмнэлгийн

							хэрэгслийн нөөцийн төвлөрсөн агуулахын байгууламжийг барьж, тоноглох зэрэг болно
17	Дэлхийн банк, НҮБ-ын Хүүхдийн сан	Монгол Улсад КОВИД-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төсөл	Зээлийн төсөл	2020-04-09	2023-03-31	Хэрэгж иж байгаа	Монгол Улсад COVID-19 халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, нийгмийн эрүүл мэндийн бэлэн байдлын үндэсний тогтолцоог бэхжүүлэх
18	НҮБ-ын Хүүхдийн сан	Ковид-19-ийн хариу арга хэмжээг хурдасгах бэлтгэн нийлүүлэлтийн болон санхүүгийн хөтөлбөр	Хүмүүнлэгийн болон бусад тусламжийн төсөл	2021-05-17	2021-12-31	Хэрэгж иж байгаа	Ковид-19 цар тахлын үед улс орнуудын авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг сайжруулах, хурдасгах
19	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага	Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 37, 50 дугаар сургуульд шүдний үзлэг хийх тогтолцоог нэвтрүүлэх төсөл	Техник тусалцааны төсөл	2022-12-31	2025-12-31	Хэрэгж иж байгаа	Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 37, 50 дугаар сургуульд шүдний үзлэг хийх тогтолцоог нэвтрүүлэх төсөл
20	Мэдээлэл байхгүй	Коронавирусын халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламж	Хүмүүнлэгийн болон бусад тусламжийн төсөл	2021-08-19	2021-12-31	Хэрэгж иж байгаа	КОВИД-19 халдварын эсрэг эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг нэмэгдүүлэх.
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам							
20	Азийн хөгжлийн банк	Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл 2	Зээлийн төсөл	2021-06-07	2023-12-31	Хэрэгж иж байгаа	Цар тахлын үед нийгмийн эмзэг бүлэгт ирэх дарамтыг бууруулах, иргэдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх
21	Азийн хөгжлийн банк	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл	Зээл, тусламжийн төсөл	2018-04-04	2024-10-30	Хэрэгж иж байгаа	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийн хүртээмжийг нэмэгдүүлэх
22	Азийн хөгжлийн банк	Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл	Зээлийн төсөл	2015-04-08	2021-08-31	Хэрэгж иж байгаа	Төслийн зорилтот 3 салбар болох хөдөө аж ахуй, барилга, зам тээврийн салбарт МБС-ын байгууллагыг төгсөгчдийн хөдөлмөр эрхлэх чадварыг сайжруулах

23	Бүгд Найрамдах Солонгос Улс	Монгол улсын төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний мэдээллийн систем хөгжүүлэх төсөл-2020	Буцалтгүй тусламжийн төсөл	2019-08-22	2021-06-10	Хэрэгж иж байгаа	Монгол улсын нөхцөл байдалтай уялдуулан төрийн хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний системийн чанар болон үр ашгийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.
24	Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг	Түншлэлд суурилсан техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт	Техник тусламжааны төсөл	2019-03-01	2023-12-31	Хэрэгж иж байгаа	Монгол улсын мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоонд Чадамжийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх, уг чадамжийн төвийн санхүүжилтийн тал дээр бодлогын зөвлөгөө өгөх, мөн түүнчлэн мэргэжлийн боловсрол, сургалтын багш бэлтгэх, хөгжүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ
25	Дэлхийн банк	Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл	Зээлийн төсөл	2020-11-18	2023-12-31	Хэрэгж иж байгаа	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл нь ажил хайгч, бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлын үед шаардлага хангасан ажиллагчдад нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх
26	Дэлхийн банк	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл	Зээлийн төсөл	2017-07-05	2022-12-31	Хэрэгж иж байгаа	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл нь ажил хайгч, бичил бизнес эрхлэгчдэд хөдөлмөрийн зах зээл дэх боломжийг хүртээмжтэй хүргэх, КОВИД-19 цар тахлын үед шаардлага хангасан албан бус салбарт ажиллагчдад нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт үзүүлэх.
27	Мэдээлэл байхгүй	Жендерт суурилсан хүчирхийлэлттэй тэмцэх төсөл	Мэдээлэл байхгүй	-	2022-12-31	Хэрэгж иж байгаа	Мэдээлэл байхгүй
Хууль зүй, дотоод хэргийн яам							

28	Азийн хөгжлийн банк	Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл	Буцалтгүй тусламжийн төсөл	2019-02-01	2023-12-31	Хэрэгж иж байгаа	Үр дүн 1: ГБХ-ийг даван туулагчдад хамтарсан багийн үйлчилгээ болон амьжиргааны дэмжлэг үзүүлэх үйлчилгээ хүрсэн байх. Үр дүн 2: ГБХ-ийг даван туулагчдыг хамгаалалд авах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх үүрэг хүлээсэн гол албан тушаалтан болон ажилтнуудын чадавх бэхэжсэн байх. Үр дүн 3: ГБХ-ээс урьдчилан сэргийлэх, мэдээлэх болон хохирогч, даван туулагчдыг хамгаалах гол оролцогч талуудын зан үйл өөрчлөгдөж, сайжирсан байх.
29	Мэдээлэл байхгүй	Иргэдийн оролцоо төсөл	Буцалтгүй тусламжийн төсөл	2022-01-01	2022-12-31	Хэрэгж иж байгаа	Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, залуучууд болон эмзэг бүлгийн иргэдийн төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох оролцоог нэмэгдүүлж, төрийн зүгээс тэдний хэрэгцээ, шаардлагад нийцсэн шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх;

Сангийн Яамны холбогдох мэргэжилтнээс мэдээлэл, тайлан ирээгүй тул дүн шинжилгээ хийж, гарсан үр дүнг тооцох боломжгүй байна.

Дөрөв.Монгол Улсад 2018-2023 онд ОУБ-аас хүүхдийн хөгжил хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, хандив тусламжийн нэгдсэн бүртгэл, зарцуулалт, хүрсэн үр дүнгийн талаарх мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх

Хүүхдийн хөгжил оролцоо, эрх хамгаалал чиглэлээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг 85 олон улсын байгууллагын мэдээллийг Гадаадын иргэн, харьяатын газрын цахим мэдээллээс түүвэрлэн авсан. Эдгээр байгууллагуудын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилт нь хэрэв төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр бол Сангийн яам, холбогдох чиг үүргийн яамдаар дамжин хэрэгждэг. Сангийн яамнаас төсөл, хөтөлбөрийн талаарх хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарим төсөл, хөтөлбөрийн төрөл, хэрэгжүүлэх хугацаа, хэрэгжүүлэх байгууллага, салбарын талаарх тодорхой мэдээлэл байхгүй байсан тул холбогдох яамдаас цахимаар ирүүлсэн мэдээллүүдийг оруулав.

Эрүүл мэндийн яам

1. “Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн техник технологийг шинэчлэх, хүний нөөцийг бэхжүүлэх-II” төсөл нь Бүгд Найрамдах Австри улсын Засгийн газрын хооронд байгуулагдсан Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд хийгдсэн ба 2018.10.11-2022.06.30-ны хугацаанд хэрэгжих 7000 евро буюу 25683140 төгрөгийн санхүүжилттэй, хөнгөлөлттэй зээл бөгөөд төслийн хүрээнд ЭХЭМҮТөвд 35 нэр төрлийн 422 тоног төхөөрөмж үе шаттайгаар нийлүүлэгдэж, угсралт суурилуулалтын ажил хийгдэж ашиглалтад оруулсан. MRI аппаратны хэвийн ажиллагааг хангах, цахилгааны хэлбэлзэл болон тасалдлаас сэргийлэх тог баригчийг нэмэлтээр нийлүүлэгдэх бөгөөд тээвэрлэлт хийгдэж байна. MRI өрөө, симуляц сургалтын өрөө, Хагалгааны өрөө болон эмзүйн тасгуудад иж бүрэн барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. ЭХЭМҮТ-ийн 21 эмч мэргэжилтэн Австри улсын Венийн их сургуульд 3-4 долоо хоногийн хугацаатай нярай, эх барих эмэгтэйчүүд, оношилгоо, лабораторийн чиглэлээр сургалтад хамрагдах бөгөөд Австрийн эмнэлэг КОВИД-19-с шалтгаалан суралцагч эмч хүлээх авахгүй байсан тул 2023 онд хийгдэхээр төлөвлөсөн эмч нарын /11/ сургалт ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 2023 оны 1 улиралд хамрагдахаар явж байна. Мөн эмнэлгийн удирдлагын багийн 12 гишүүн Австри улсад 7 хоногийн менежментийн сургалтад хамрагдсан. Төслийн хэрэгжилт 97%-тай.

2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг сургуулийн орчинд эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээ” буцалтгүй тусламжийн төсөл нь (СБД) /ГССҮТ/ 2020-2022.05 сар буюу 2.5 жилийн хугацаанд хэрэгжих бөгөөд 49380.0 төгрөгийн санхүүжилтээр хэрэгжиж дууссан.

ДЭМБ-ын техникийн дэмжлэгээр 2020-2021 онд Нийслэлийн 9 дүүргийн төрийн өмчит бүх сургуулиудын 13964 багш, нийгмийн ажилтан, эмч, бусад ажилтнуудад хүүхдийн эсрэг хүчирхийллийн сургуулийн орчинд илрүүлэх, мэдээлэх, урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах талаар сургалт явуулж, чирэгдэлгүй түргэн шуурхай эрүүл мэндийн болон бусад шаардлагатай үйлчилгээг авч хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

3. Канадын Олон Улсын Судалгааны Хөгжлийн Төвийн санхүүжилтээр 2020-2022 онд 120.000,0 төгрөгийн санхүүжилтээр “Хүүхдэд чиглэсэн эрүүл бус хүнсний телевизийн зар сурталчилгааны өнөөгийн байдлыг Азийн есөн оронд харьцуулан судлах” сэдэвт олон улсын судалгаа /НЭМҮТ/ хийгдсэн ба судалгааны түүврийн шинжилгээгээр хүүхдийн телевизийн сувгуудад хоол хүнсний зар сурталчилгааны зөвшөөрөгдөөгүй өртөлт зонхилсон, зөвшөөрөгдсөн хүнсний сурталчилгааны түвшин бага элсэн чихэртэй ундаа, тав тухтай эсвэл бэлэн хоол (жишээ нь, түргэн хоол), чихэр, амтат гурилан бүтээгдэхүүн, сүмс, амтлагч зэргийг хүүхдийн алдартай телевизийн сувгуудаар байнга сурталчлах зөвшөөрөлгүй хүнсний бүтээгдэхүүнүүд байсныг тогтоосон.

4. НҮБХАС-гийн 2019-2022 онд хэрэгжих 89371,0 төгрөгийн санхүүжилт, буцалтгүй тусламж болох “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нь” сургалтын төслийн хүрээнд 2019 онд 10 аймгийн нэгдсэн эмнэлгийн

эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу эрүүл мэндийн салбарын болон эрүүл мэндийн ажилтны хүлээх үүрэг, хохирогчдыг илрүүлэх, шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулсан.

2022 онд 11 аймгийн (Увс, Ховд, Архангай, Сүхбаатар, Дундговь, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дорноговь, Орхон, Булган, Төв) Нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн хуулиар хүлээх үүрэг болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод хариу арга хэмжээ авах хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл нэмэгдэж, ур чадвар сайжирсан.

5. ДЭМБ, НҮБ-ын Хүүхдийн сан, Хүн амын сангийн санхүүжилттэй 2022-2023 онд хэрэгжүүлэх 954855,48 төгрөгийн санхүүжилттэй “Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх” төсөл, арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй, тавьсан зорилгодоо хүрсэн.

/Тодорхой мэдээлэлгүй./

6. НҮБ-ын Хүн амын сангийн 2022/03-2022/12 онд хэрэгжүүлэх 332949,99 төгрөгийн санхүүжилттэй “Нөхөн үржихүй, өсвөр үеийн эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх” төсөл нь 100 хувийн хэрэгжилттэй, тавьсан зорилгодоо хүрсэн, амжилттай хэрэгжиж дууссан.

/Тодорхой мэдээлэлгүй./

7. НҮБ-ын Хүн амын сангийн 2022.05-09 сард хэрэгжүүлсэн 99665,60 төгрөгийн санхүүжилттэй “Хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчдэд сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх арга техник” сургалтыг зохион байгуулах төсөл /СЭМҮТ/-ийн хүрээнд сумын эмч, мэргэжилтнүүд хүчирхийллийн хохирогч болон үйлдэгчдэд сэтгэл зүйн, сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх арга техникт суралцсан. Сумын эмч, мэргэжилтнүүд хүчирхийллийн хохирогч болон үйлдэгчдэд сэтгэл зүйн, сэтгэл заслын тусламж үйлчилгээг үзүүлэх мэдлэг, ур чадвар сайжирсан. Нийт сургалтад хамрагдсан 10 аймгийн 208 оролцогчдын сургалтын өмнөх ба дараах мэдлэгийн түвшинг үнэлэх дунджаар 26,11 хувиар өссөн үзүүлэлттэй.

8. Азийн хөгжлийн банкны “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” 2019-2022 онд хэрэгжүүлэх 10,333,800,0 төгрөгийн санхүүжилттэй төсөл ХЗДЯ-ны хамтран оролцож байгаа.

ДҮГНЭЛТ:

- Эрүүл мэндийн яамнаас ирүүлсэн төсөл хөтөлбөрийн мэдээлэл нь зөвхөн эмнэлгийн барилга байгууламж, орчин нөхцөлийг сайжруулахаар хийгдсэн хөрөнгө оруулалтын мэдээлэл байна.

- ЭМЯ-ы гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд ч эмнэлгийн орчин нөхцөл, оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмжийг сайжруулах, барилга байшин барих, засвар үйлчилгээ хийлгэх чиглэлээр хөрөнгө оруулалт, төсөв санхүүгийн асуудлыг шийдвэрлүүлж ажилласан талаар тайлагнасан байна.

- “Нөхөн үржихүй, өсвөр үеийн эрүүл мэндэд дэмжлэг үзүүлэх”, “Хүчирхийллийн хохирогч болон хүчирхийлэл үйлдэгчдэд сэтгэл заслын тусламж үйлчилгээ үзүүлэх арга техник” төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн үр дүн хэмжигдэхгүй, үр нөлөө нь тодорхойгүй, хүүхдийн эрх, хүүхэд хамгаалалтай холбоотой, тухайлбал бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, өсвөр насныханд зориулсан нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэл зүйн үйлчилгээ, хүүхдийн эсэн мэнд амьдрах эрхийг хангахтай холбоотой арга хэмжээ хийгдсэн эсэх нь тодорхойгүй.

- “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх нь”, “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг сургуулийн орчинд эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэлт, хариу арга хэмжээ” сургалтын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдсан эмч, багш нарын урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа хангалтгүй. Зөвхөн 1 дүүргээр жишээ авахад СХД 2023 оны 1-р улирлын 108 дугаарт ирүүлсэн 425 дуудлага мэдээллийн 5 буюу 0.1 хувь нь эмчийн дуудлага мэдээлэл байна. Өөрөөр хэлбэл сургууль, цэцэрлэг, хорооны өрхийн эмнэлэг гэх мэт анхан шатны байгууллагуудад урьдчилан сэргийлэх, тандан судлах, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах ажлууд хангалтгүй хийгдэж байгаагаас аливаа хэлбэрийн хүчирхийлэлд өртөх хүүхдийн тоо нэмэгдэж байна.

- “Хүүхдэд чиглэсэн эрүүл бус хүнсний телевизийн зар сурталчилгааны өнөөгийн байдлыг Азийн есөн оронд харьцуулан судлах” сэдэвт олон улсын судалгаа /НЭМҮТ/-ны хүрээнд тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн бодлогын түвшинд ямар үйл ажиллагааг зохион байгуулсан нь тодорхойгүй.

Хууль зүй дотоод хэргийн яам

“Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн гүйцэтгэгч байгууллагаар ХЗДХЯ, хэрэгжүүлэгч байгууллагаар ХНХЯ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар ажиллаж байгаа ба Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы сангийн 4,000,000 ам.долларын санхүүжилтээр 2019-2023 онуудад хэрэгжих ба төслийн хүрээнд шинээр байгуулж буй түр хамгаалах байрны барилгын засвар үйлчилгээ болон тавилга, тоног төхөөрөмжид 1.231.794.219, 12 аймаг, 3 дүүргийн хамтарсан багийн сургалт, ухуулга сурталчилгаа, тоног төхөөрөмжид 159.872.460 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Мөн нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагааны бусад зардлуудад АХБ-ны Монгол дах суурин төлөөлөгчийн газар Ковид-19 хямралын үед гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хариу арга хэмжээ авах механизмыг бэхжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулах техник туслалцааны төслөөс 287.140.000, НҮБХАС-аас 306.378.500, Дэлхийн зөв ОУБ-аас 24.384.849, ГБХЗХГ-аас 15 аймаг 3 дүүрэгт 360.109.334, мөн 5 дүүрэг, 10 аймагт 953.182.292 төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон бол хамтарсан багийн үйлчилгээ, үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 1.200.462.381 төгрөгийн санхүүжилтийг олгосон.

2022 онд нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйлчилгээ, үйл ажиллагааны бусад зардлуудад АХБ-ны “Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-өөс 3 аймаг, 1 дүүргийн барилга засварын ажилд 1.526.071.145,60, тавилга тоног төхөөрөмжид 714.826.836,60, НҮБХАС-аас 172.926.778, ХНХЯ-аас 1.805.849.238, 1 дүүрэг, 16 аймагт үйлчилгээ, үйл ажиллагаа, урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 1.072.226.390 төгрөгийн санхүүжилтийг олгожээ.

2022 онд 33 арга хэмжээг төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган баталсан бөгөөд 4 зорилтын хүрээнд зорилт тус бүрээр хэрэгжилтийн үнэлгээ хийж, 86,5 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үзүүлэлттэй, тухайн онд үнэлэгдэх боломжгүй 3 үйл ажиллагаа байгаа бөгөөд эдгээр нь төсөл хэрэгжүүлэгч байгууллага буюу ХЗДХЯ болон төсөл хэрэгжүүлэх нэгжээс шалтгаалахгүйгээр хугацаа хойшилж, төслийн удирдах хороогоор хэлэлцэгдэн 2023 оны төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдахаар шийдвэрлэсэн байна.

Төслийн хүрээнд Налайх дүүрэг, Увс, Сэлэнгэ, Сүхбаатар аймагт түр хамгаалах байрыг цахилгаан хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр ханган тохижуулан, 50 эмэгтэйд бичил тэтгэлэг олгон, бичил бизнесээ эхлэхэд нь дэмжлэг үзүүлж ажилласнаар хөтөлбөрт хамрагдахаас өмнөх үетэй харьцуулахад 20-300 хувиар орлого нь нэмэгдсэн байна.

Хамгаалалд авах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх үүрэг бүхий гол албан тушаалтан, ажилтнуудын чадавхыг бэхжүүлэх зорилтын хүрээнд 12 төрлийн гарын авлага боловсруулан, 40 сургагч багш бэлтгэн, 25 дэмжих бүлэг байгуулж, сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг эхлүүлсэн.

Зан үйл хандлагад нөлөөлөх мэдээлэл харилцааны үйл ажиллагааны хүрээнд 20 дэмжих бүлгийг байгуулж, 18 сургагч багш бэлтгэн, дэмжих бүлгээр дамжуулан 112 эрэгтэй, 200 өсвөр насны охид хөвгүүдэд гэр бүлийн хүчирхийллийн талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлсэн,

Зан үйлийг өөрчлөх мэдээлэл харилцааны бүтээгдэхүүний төсөл (15 видео зохиомж, 30 сошиал болон хэвлэмэл хэлбэрээр гарах контент, 10 ТикТок бичлэгийн жишээ) боловсруулагдсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Улаанбаатар хотын Дарь-Эх, Дундговь, Дорнод, Завхан аймгийн баривчлах төвүүдийн номын сан, сургалт, эмчилгээ, сэтгэл заслын 11 өрөөг иж бүрэн тохижуулах ажлын хүрээнд уг ажлыг Баянзүрх дүүрэгт шинээр баригдах Түр хамгаалах байрны ажил 2023 оны 4-р улирал болж өөрчлөгдсөнтэй холбогдуулан худалдан авалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн нөхцөлийг боловсруулсан.

Гэр бүлийн тухай хууль, зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, эрүүгийн хууль болон бусад холбогдох хуулийн 4 судалгаа хийгдэж бодлогын зөвлөмж боловсруулагдаж түгээгдсэн байхаас зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан байна.

ДҮГНЭЛТ:

Төслийн хэрэгжилтийн явцыг хянаж, тухайн жилд хэрэгжсэн арга хэмжээнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг тооцон ажилласан байна.

“Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд холбогдох судалгаа, сургалт нөлөөллийн болон хөрөнгө оруулалтын ажлууд хийгдэж байгаа боловч нийгэмд аливаа хэлбэрийн хүчирхийллүүд газар авч байгаад анхаарч, нийгмийн сэтгэл зүйд нөлөөлөх, сэтгэл зүйчдийг нөлөөллийн ажилд татан оруулах чиглэлээр зохион байгуулалтын ажил түлхүү хийх шаардлагатай гэж үзэж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам

1. Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн хүрээнд Хүүхдийн эрхийг хамгаалах, хангах чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагааны явцад

- Орчин, нөхцөлийг сайжруулах хүрээнд 30034,6 төгрөгийн ном сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, тусгай боловсролын сургуулийн орчныг сайжруулахад завсарлагааны гэрлэн дохио, камер суурилуулах

- Үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш хамруулан сургах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 915.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 21 аймагт аймгийн төвийн нэг сургуульд “Хүүхдийн хөгжлийг дэмжих загвар танхим” тохижуулж, тусгай хэрэгцээт боловсролын сургуулийн сурагчдад зориулан сургалтын хэрэглэгдэхүүнээр

- “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-д дэмжлэг үзүүлэх хүрээнд Коронавирусын халдварын цар тахлын үед иргэдийн амьжиргааг хамгаалах, хүүхдүүдээ анхааран халамжлахад 14,240.0 төгрөгийн дэмжлэг нөхөн төлбөрийг ХХҮЕГ-т олгосон.

2. БШУЯ, Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй Тэгш хамруулах боловсролыг дэмжих төсөл Цэцэглэн хөгжсөн, сөрөг нөлөөнд тэсвэртэй Ази, Номхон далайн бүс нутгийг цогцлоох Японы Сангийн санхүүжилтээр 2021.01.01-2024.02.29 онд хэрэгжих бөгөөд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн дэд бүтцийг сайжруулж илүү хүртээмжтэй болгох, Тэгш хамруулах боловсролын үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх, Тэгш хамруулах боловсролыг дэмжих эх үүсвэр, олон нийтийн оролцоо болон бодлогыг бэхжүүлэх 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд хэрэгжиж байгаа бөгөөд тайлант хугацаанд 4 сургууль, 4 цэцэрлэгт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулж налуу зам, ханын бариул, брайль тэмдэглэгээ хийж, ариун цэврийн 30 өрөө зассан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих 8 танхим байгуулж, 527.8 сая төгрөгийн тохируулгат төхөөрөмж, дэмжих хэрэгсэл нийлүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах үйлийг дэмжих 631.6 сая төгрөгийн хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлсэн. Хүүхдэд хүрэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр суралцахуйн түгээмэл загварын арга барил, зарчимд суурилсан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжих, багшид дэмжлэг үзүүлэх арга зүйн зөвлөмж боловсруулж, тэгш хамран сургах боловсролын арга зүйн сургалтаар 437 багш, орчин бүрдүүлэх сургалтаар 46 захирлыг чадавхжуулсан. 6 төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах гарын авлага боловсруулж, 500 багшид түгээсэн. Вакум сургалтаар 21 багш дохионы хэл, брайль бичигтэй болсон. Сургууль, цэцэрлэгээс гадна байгаа 194 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг илрүүлж, 80 хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулсан.

3 аймаг, 1 дүүргийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Боловсролын хэлтсийн салбар комисс, боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл, цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн багийн 96 хүнийг тэгш хамран сургах боловсролын талаар чадавхжуулсан. Хөгжлийн бэрхшээл болон тэгш хамран сургах боловсролын асуудлаар сургалт, нөлөөллийн ажил хийж, 3 аймаг, 1 дүүргийн 2094 хүний мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлсэн. 2023 онд 7 сургууль, 5 цэцэрлэгт 855.2 сая төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурах үйлийг дэмжих хэрэгсэл нийлүүлэхээр ажиллаж байна.

3. Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах” төслийн Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах хүрээнд Боловсролын хүртээмжийг сайжруулах чиглэлд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 2

сургууль, 7 цэцэрлэгийн ашиглалтад оруулахад 24 тэрбум 644 сая төгрөгийг зарцуулаад байна.

Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах” төсөл нь 2018 оны 4 сарын 30-ны өдрөөс 2024 оны 6 дугаар сарын 30-ныг хүртэл хэрэгжинэ. Төслийн хүрээнд 7 сургууль, 14 цэцэрлэгийн барилгыг барих, өргөтгөхөөс 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 2 сургууль 7 цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулж, цэцэрлэгийн хүчин чадлыг 1170 ор, сургуулийн хүчин чадлыг 1060 суудлаар тус тус нэмэгдүүлээд байна. Гүйцэтгэл нь 40-90%-тай баригдаж буй 9 барилга байгаа ба 3 барилгын тендерийг шинээр зарлан үнэлгээ хийгдэж байна. 2024 оны 6 дугаар сар гэхэд ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоог 3400, цэцэрлэгийн орны тоог 2300 аар тус тус нэмэгдүүлэх юм.

Төслийн хүрээнд баригдаж буй дээрх барилгууд эрчим хүчний хэмнэлттэй инженерийн шийдэлтэй, жендэр, нийгмийн тэгш хамруулалтын шаардлагын дагуу тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан налуу зам, хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон стандартад нийцсэн ариун цэврийн тоноглол, шат, бариул, хяналтын камер, гал тогоо, эмчийн өрөө, тусгаарлах өрөөтэйгөөс гадна сургууль, цэцэрлэгт шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангаж байна.

Боловсролын чанарыг сайжруулах чиглэлд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар 11 тэрбум 120 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг дараах 3 чиглэлд оруулжээ. Тухайлбал, сургалтын хөтөлбөр үнэлгээг сайжруулах, сургалтын хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж хангах, сайжруулсан хөтөлбөр ба үнэлгээний чиглэлээр багш, удирдах ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх хүрээнд арга хэмжээг төлөвлөн ажиллалаа. /дэлгэрэнгүй мэдээллийг нийгэм, жендэрийн үйл ажиллагааны тайлангаас харна уу, тайланг хавсаргав./

4. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг /ЖАЙКА/, Солонгосын Олон Улсын Хамтын Ажиллагааны Агентлаг /КОЙКА/, Хүүхдийг ивээх сангийн санхүүжилтээр хэрэгжүүлж буй 3 төслүүдийг нэгтгэн нэгдсэн үр дүнд хүрэх төслийн саналыг боловсруулан GPE-ийн “Үржүүлэгч санхүүжилт/Multiplier Grant” -д хүргүүлсэн. 2022 оны 5 дугаар сард GPE нь Монгол улсын боловсролын салбарт хэрэгжүүлэх “Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих” төслийг баталсан. 2022-2025 онд гурван жилийн хугацаатай хэрэгжих энэхүү төсөл нь боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг дээшлүүлэн боловсролын чанарыг сайжруулах зорилготой бөгөөд боловсролын салбарын тэргүүлэх гурван чиглэл болох “Тэгш хамруулан сургах боловсрол”, “Сургуулийн хоолны үйлдвэрлэл, үйлчилгээ” болон “Хосолсон сургалт”-ыг хөгжүүлэх цогц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

ДҮГНЭЛТ:

Боловсролын салбарт хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллаас илүү хүүхдийн сурч хөгжих эрхийг хангахад түлхүү чиглэсэн, барилга байгууламж, сургалтын орчин, хэрэглэгдэхүүнд түлхүү хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам

3. “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төсөл нь 2 үе шаттай хэрэгжиж байгаа бөгөөд төслийн 1 дүгээр үе шат: Швейцарын хөгжлийн агентлаг 4.3 сая ам.доллар, НҮБ-ын Хүн амын сан 853 мянган ам.доллараар санхүүжүүлж, Монгол Улсын Засгийн газар мөнгөн бус хэлбэрээр 452 мянган ам.долларын хувь нэмэр оруулж, нийт 5.6 сая ам.долларын төсөвтэйгөөр 2017-2020.10.30 хүртэл хэрэгжсэн.

Төслийн II үе шат: Швейцарын хөгжлийн агентлагаас 2.7 сая доллар, Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын ХАС-аас 2.7 сая доллар, нийт 5.4 сая долларын санхүүжилттэй 2020.10.30-2023.07 сар хүртэл хэрэгжих. /Архангай, Баян-Өлгий, Дархан-Уул, Завхан, Ховд аймаг, Баянзүрх дүүрэг/

Төслийн эхний шатанд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрх зүйн орчныг сайжруулах, хүчирхийллийн хохирогчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, статистик мэдээллийг боловсронгуй болгох чиглэлээр амжилттай хэрэгжүүлж дууссан.

Төслийн хоёр дахь шат буюу 2020 оны 10 дугаар сараас 2023 оны 07 дугаар сар хүртэл жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн ойлголт,

хандлагыг дээшлүүлэх, хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлийг өөрчлөх, хохирогчид нийгмийн ажил, үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх үндсэн зорилтуудыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу зохион байгуулж байна.

Дөрөв. Бүх яам, холбогдох чиг үүргийн агентлагууд 2018-2023 онд хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр ОУБ, ТББ, Хэвлэл мэдээллийн байгууллагатай хийсэн гэрээ, хэрэгжилт

Мэдээлэл ирүүлээгүй тул хэрэгжилт, үр дүнд дүн шинжилгээ хийх, жагсаалт гаргах боломжгүй байна.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:

- Зарим чиг үүргийн яамдаас ирүүлсэн төсөл хөтөлбөрийн талаарх товч мэдээллээс харахад барилга байгууламж барих, өргөтгөх, засварлах үйлчилгээ хийх зэргээр орчин нөхцөлийг бүрдүүлэх, техник, тоног төхөөрөмжөөр хангах гэх мэт материаллаг зүйлд их хэмжээний хөрөнгө оруулалтууд хийгдсэн байх тул хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн үр дүн, үр нөлөөг тооцох боломжгүй байна.
- Нээлттэй хяналт шалгалтын ажлын хэсэг дүүргүүдийн ГБХЗХХ-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхэд тухайн дүүрэгт хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүд болон төсөл хөтөлбөрийн хүрээнд хийгдэж буй арга хэмжээний талаарх мэдээлэл хомс, ил тод биш байна.
- Хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллах хүний нөөцийн хомсдол, тогтворгүй байдал хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр үзүүлэх нийгмийн ажил, гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанар хүртээмж, хангалтгүй байгаа тул мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, төрийн үйлчилгээг иргэдэд бүрэн хүргэх чиглэлээр төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааг өргөжүүлэх, зорилтот үр дүнд хүрэхэд анхаарах
- Монгол Улсын хэмжээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй нийт төсөл, хөтөлбөрийн болон эдгээрийн санхүүжилтийн талаарх нэгдсэн бүртгэл мэдээлэл, хяналтыг сайжруулах
- Чиг үүргийн зарим яамдын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн талаарх бүрэн мэдээлэл байхгүй тул нийт төсөв, зарцуулалтыг тооцох боломжгүй, төсөл хөтөлбөр дуусаад цаашид ямар байдлаар үр дүн, үр нөлөө бий болгож байгаа талаар мэдээлэл олох, дүгнэхэд хүндрэлтэй байна.
- Холбогдох төрийн байгууллагаар дамжихгүйгээр шууд хэрэгждэг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээрх хөрөнгө оруулалт, хандив тусламжийн талаарх мэдээлэл, нэгдсэн бүртгэл, зарцуулалт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл МУЗГ-т байхгүй байна. **Жишээлбэл:** Гаднын сүм хийд, хувийн халамж, асрамжийн байгууллагуудаар дамжиж буй тусламж үйлчилгээ гэх мэт.
- Анхан, дунд шатанд хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх ГХУСАЗСЗ, Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, Хамтарсан баг, Хүүхэд хамгааллын баг, Эцэг эхийн зөвлөл ажиллаж байгаа ба хүүхдийн осол, гэмтэл, нохойд хазуулах, живэх, амиа хорлох, гэмт хэрэг, хүчирхийллийн хохирогч болсон кейс удаа дараа гарч байгаа ч хариуцлагагүй ажилласан төрийн албан хаагч, дарга нарт хариуцлага тооцсон талаарх, зөвлөл, хороо, баг, зөвлөлийн нэгдсэн тайлан байхгүй.
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлдэг бөгөөд хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалал, хөгжлийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах ёстой ч үр дүнгүй цаасан төлөвлөгөөнөөс хэтрэхгүй байгаад анхаарах
- Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийллийг бууруулахын тулд гэр бүл рүү чиглэсэн төрийн оновчтой зөв бодлого, хүүхдийг бага наснаас нь зөв хүмүүжүүлэх, эрүүл ахуйн зөв дадал, гэр бүлийн, бэлгийн, санхүүгийн, амьдрах ухааны, харилцааны, хөдөлмөрч,

- үндэсний өв уламжлалаа дээдэлсэн, эрх зүйн мэдлэг боловсрол, мэргэжил сонголт гээд “Зөв ёс зүйтэй Монгол хүүхэд” төлөвшүүлэх цогц бодлого шаардлагатай байна.
- Засгийн газар, чиг үүргийн яам, агентлагууд хүүхдийн хөгжил, хамгаалал, хүмүүжил, төлөвшил, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэдэн ТББ-тай хамтран ажилласан талаарх мэдээлэл нийтэд ил тод болгох
 - Хохирогч болсон хүүхдэд учирсан гэм хорыг бодитойгоор үнэлэх, хүчирхийлэл үйлдэгчид хүлээлгэх хариуцлагыг чангатгах
 - Хүүхдэд чөлөөт цагаа өнгөрүүлэх спорт заал, хөгжлийн ордон төв хүрэлцээгүй, хорт зуршил, цахим тоглоом, дэлгэцийн донтолтод донтох, амиа хорлох, сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд анхаарал хандуулж, хүүхэд, өсвөр үеийнхэн нийгэм- сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ авах боломж нөхцөл, хүртээмж алга байна.
 - Хүчирхийлэлд өртсөн, эцэг эх, асран хамгаалагч нь асран халамжлах боломжгүй, асаргаа, сувилгаа шаардлагатай 0-3 хүртэлх насны хүүхдэд хүүхэд хамгааллын болон эрүүл мэндийн нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх бүтэц, орон тоо хангалтгүй.
 - Аймаг, дүүргийн өсвөр үеийн кабинетуудын үйл ажиллагаа, эмч, боловсон хүчний чадавх сул, хүүхэд, өсвөр үеийнхэнд үйлчилгээ авах боломж, хүртээмжийг сайжруулах
 - Байнгын асаргаа, сувилгаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын асрах төвийн хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Жил бүр хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо 1000, 1000-аар нэмэгдэж, тэдэнд ээлтэй орчин, дэд бүтэц, үйлчилгээ, боловсон хүчний чадавх сул байгаад анхаарах
 - Архи нийгэмд хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдэгдэх, амь насаа алдах, эрүүл мэндээрээ хохирох зэрэгт гол нөлөөлөх гол хүчин зүйл болсоор байна. Хууль эрх зүйн орчныг яаралтай өөрчилж, архи үйлдвэрлэх, худалдан борлуулах чиглэлээр эрх зүйн шинэ зохицуулалт хийх
 - Бүтэн өнчин хүүхэд, асрамж, халамжийн төвөөс гарч байгаа 18 хүрсэн залуусын нийгмийн асуудлыг бүрэн шийдсэн оновчтой бодлогыг бий болгох
 - Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2019 оны 02 дугаар тогтоолоор бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогч хүүхдийн сэтгэл санааны гэм хорыг үнэлэх, тооцох аргачлалыг боловсронгуй болгох, эрүүл мэнд, сэтгэл зүйн нөхөн сэргээх урт хугацааны эмчилгээ, үйлчилгээний хууль тогтоомжийн зохицуулалтыг боловсронгуй болгох ажлыг 2020 оны I-IV улиралд хийх, хэрэгжилтийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Эрүүл мэндийн яам хариуцан ажиллах чиглэл өгсөн боловч удаашралтай байгаад анхаарах
 - Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хууль ёсны эрх ашгийг бүрэн хамгаалах, сэтгэл зүйн зөвлөгөө, туслалцаа, урт хугацааны сэтгэл заслын эмчилгээ, гэмт хэрэг үйлдэгдсэн орчноос нь тусгаарлах, тухайн нөхцөл байдлыг мартахад тус болох өөр орчинд хүүхдийг түр хамгаалан хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хэрэг шийдэгдтэл хүүхдийг түр хамгаалах байр, нөхөн сэргээх төвүүдэд байрлуулан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх, эдийн засгийн, бие махбод, сэтгэл санааны хохирлыг заавал барагдуулдаг механизмыг бий болгох, хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийлэл үйлдсэн этгээдэд оногдуулах ялын бодлогыг оновчтой болгох, гэр бүлийн орчинд болон ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн 16 наснаас доош хохирогч бүх хүүхдийг Хүүхэд хамгааллын тухай хууль Гэрч хохирогчийг хамгаалах хуулиар төр шууд хамгаалалтад авч хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх механизмыг бий болгох
 - Хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийн гэмт хэргийг шалгах цагдаагийн албан хаагчийг томилохдоо эмэгтэй мөрдөн байцаагч томилох, хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогийг харгалзан оновчтой асуулт асуух, олон цагаар, олон дахин байцаалт авахгүй байх, хохирогчийг нөхөн сэргээх, эрүүл мэнд, сэтгэл санааны, эдийн засгийн, хохирлыг заавал тооцох, холбогдох нотлох баримт бүрдүүлэн ажиллах, хэргийг хурдан шийдвэрлүүлэх
 - Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд мөн Монгол улсын Засгийн газрын үндсэн чиглэл болон, эрх барьж байгаа намын мөрийн хөтөлбөрт /2020-2024/ хүчирхийлэлд өртсөн хүүхдэд урт хугацааны нөхөн сэргээх

үйлчилгээ үзүүлэх төвийн байрыг бүс, орон нутагт байгуулан ажиллах тухай тусгагдсан ч бага насны бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн нөхөн сэргээх төв одоо болтол байгуулаагүй байгаад анхаарах

- Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр Төрөөс авч хэрэгжүүлж байгаа ажил төдийлөн хөрсөн дээрээ буухгүй өнгөрсөн борооны араас цув нөмрөхтэй адил хүүхэд хүчирхийлэлд өртсөний дараа хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлдэг буруу жишиг үүрэг хүлээгчдэд байсаар байгааг өөрчлөх

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ:

- Хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийг төслийн үндсэн зорилгод нийцүүлж, хүүхэд хамгааллын бодлогын үр дүн, үр нөлөөг сайжруулах.
- ГБХЗХГ, хэлтэс, сум, баг, хороо, анхан шатны нэгж нь хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн талаарх мэдээ мэдээллээр дутмаг байна. Иймд анхан шатны нэгжүүдийн оролцоог хангах.
- Монгол Улсын хэмжээнд хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж буй нийт төсөл, хөтөлбөр болон Гэр бүл-Хүүхдийн мэдээллийн нэгдсэн сантай болох
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал бодлогын түвшинд хууль, эрх зүйн орчин эрс сайжирч, хангалттай хэмжээний төсөвтэй болгосон ч хэрэгжилтийн шатандаа сүүлийн 3 жилд эрс доройтсон нь Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал хариуцсан байгууллагын дээд болон дунд түвшин буюу улс, аймаг, дүүргийн газар, хэлтсийг мэргэжлийн бус чадваргүй, ёс зүйгүй удирдлагатай шууд холбоотой тул цаашид анхаарах
- Хүүхдийн салбарын төлөвлөлтийг статистик мэдээлэл, судалгаа, нотолгоонд суурилсан орон нутаг тус бүрийн онцлог гэмт хэрэг, хүчирхийллийн гаралт, давтамж, эрсдэлд үндэслэсэн хийж, үр дүнг нь тооцох
- Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, бодлогын нэгдсэн удирдлагаар хангаж, олон сая долларын санхүүжилтийг үр ашигтай байхаар чиглүүлэх чадваргүй удирдлага ГБХЗХГ-ыг удирдсаар байгаад анхаарах цаг болжээ.
- Салбарын хууль, эрх зүйн орчноо сайн мэддэг, туршлагатай, Олон улсын байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдсөн, бодлогын зохицуулалт хийх, хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвартай, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн, багаар ажиллах, хамт олноо удирдан чиглүүлж, зөвлөж, арга зүйгээр хангаж ажиллах мэдлэг, туршлагатай Төрийн албаны тухай хуульд заасан шалгуурыг хангасан мэргэжлийн удирдлагаар Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, Хүүхэд, Залуучуудын хөгжлийн газрын дарга, дэд дарга, аймаг, дүүргийн газар, хэлтсийн дарга нарыг томилох
- Гэр бүлийн тухай хуулийг яаралтай батлуулах, хүүхдийн тэтгэлгийн сан, хүүхдээ тэжээн тэтгэх үүргээ биелүүлдэггүй эцэг эхчүүдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх, сум баг, хороонд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэнтэй болгох
- Нийгмийн ажилтны цалин, орон тоог нэмэгдүүлэх, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн ажил үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах зардал, нийгмийн ажилтныг бэлтгэх, чадавхжуулах, лицензжүүлэх, хүүхэд хамгааллын мэргэжилтнүүдийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр яаралтай анхаарч арга хэмжээ авах

ДОЛОО. ХҮҮХДИЙН ЭРХ БА ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хуулийн үндсэн зарчимд төр, иргэн, хуулийн этгээд үйл ажиллагаа явуулахдаа хүүхдийн язгуур эрхийг эн тэргүүнд хангахыг эрмэлзэж, хүүхэд эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг тэгш хангахаар тусгасан.

Монгол Улсын нийт хүн амын 37.3 хувийг 18 хүртэлх насны хүүхэд эзэлж байна. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас гаргасан статистик мэдээллээр улсын хэмжээнд 15 ордон, 38 зуслан, төвүүд ажиллаж байна. Эдгээр төвүүдэд 2018-2022 онд 2018 онд 38900 хүүхэд, 2019 онд 61034 хүүхэд, 2020 онд 51827 хүүхэд, 2021 онд 12495 хүүхэд, 2022 онд 61050 хүүхэд нийт 225306 хүүхэд хамрагдсан байна.

Нээлттэй хяналт-шалгалтын удирдамжийн дагуу ажиллаж, Монголын хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төв, Баянгол дүүргийн Хүүхэд хөгжлийн ордон болон Хүүхдийн төв сувиллын үйл ажиллагаатай газар дээр нь танилцсан.

7.1. МОНГОЛЫН ХҮҮХДИЙН ОРДНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1958 онд байгуулагдсан цагаасаа эхлэн өнөөдрийг хүртэл 109 багш, ажилчидтайгаар сургалтын үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа бөгөөд үүний 70 хувь нь багш байна. Хүүхдийн ордны дугуйланд жилд 2000 гаруй хүүхэд, 7 дүүрэгт МХО-ны багш нар үнэ төлбөргүй явуулдаг сургалтад 2,400 гаруй хүүхэд хамрагдаж байна.

МХО-ны тулгамдаж буй асуудал нь харьяаллын асуудал байна. Одоогийн байдлаар Нийслэлийн Засаг даргын эрх мэдлийн хүрээнд ажиллаж байгаа. Олон жилийн хугацаанд боловсрол, соёлын байгууллагууд өөрийн харьяалал үйл ажиллагааны чиглэлээр авахыг хүсдэг ч тогтолцооны хувьд хэвтээ, босоо, холимог гэх мэт ойлгомжгүй байдалтай явж ирсэн.

Нэг талдаа сургалтын байгууллага шиг нөгөө талдаа хүүхдийн хөгжлийн байгууллага зэрэг тодорхой бус зүйл байсаар ирсэн бөгөөд 2015 оноос хойш дүрэм журмыг өөрчлөөгүй байгаа нь одоогийн шаардлагатай нийцэхгүй байна.

МХО нь нийслэлийн төрийн санд орлого төвлөрүүлдэг учир 3 заалаа түрээслэх маягаар төлөвлөгөөгөө биелүүлэх бөгөөд барилга байгууламжийн хувьд Нийслэлийн өмчид хамаарагдаж байна. /Гэтэл нийслэлийн хөрөнгөөр баригдаагүй Оросуудын тусламжаар баригдсан байдаг./

МХО дээр Эрдэмтдийн зөвлөл ажилладаг бөгөөд энэ хүмүүсийн тусламжтайгаар үйлчилгээ авдаг хүүхдүүд болон тэдний асран хамгаалагч эцэг эхэд сургалт явуулдаг. Хүүхдүүдийн санал хүсэлтийг авдаг хайрцаг ажилладаг гэх боловч санал хүсэлт гомдол бараг ирдэггүй эцэг эх асран хамгаалагч нь ордны холбогдох хүмүүст асуудлаа тавиад шийдвэрлүүлдэг.

Зуны сургалт багш нар нь амардаг учраас олон сараар явуулах боломжгүй, 6 сарын 05-аас 7 сарын 05-ны хооронд 1 сарын хугацаанд явуулдаг. Хүний нөөцийн хувьд нарийн мэргэжлийн хүмүүс дутагдалтай нэн ялангуяа тайзны инженер техникийн болон зарим багш нар дутагдалтай.

Нийслэлд үйл ажиллагаа явуулдаг томоохон ордны хувьд цаашдын зорилго бол өөрийн эзэмшлийн газрын зай талбайг ашиглаад Спортын цогцолбор барих зорилгоор ТЭЗҮ болон цогцолборынхоо макетыг бэлэн болгосон. Ингэснээрээ хүүхдийн чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх тэднийг эрүүл амьдрах, хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх, цахим орчноос хөндийрөх зэрэг ач холбогдолтой хамгийн гол нь хүүхдэд зориулсан шинэ цогцолбор баригдах юм байна. МУ-ын ерөнхийлөгч дэмжиж байгаа гэв. Хүүхдийн ордны нийт ашигтай талбай 10,500 м². 29 камер байршуулж хүүхдийн аюулгүй орчныг хангаж ажиллаж байна.

7.2. ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВ

Энэхүү төвд ажиллах хүрээнд төвийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, хүний нөөцийн ажилтан нартай уулзаж, нөхцөл байдлын талаар ярилцаж, сургалтын танхим болон заал, үзэсгэлэнгийн байран дээр ажиллаж байгаа багш нартай уулзсан болно. Урлан бүтээх төвийн гол онцлог нь суралцагчид нь үнэ төлбөргүй, хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, сонирхол болон ур чадвараа дээшлүүлэх улмаар амьдралын болон мэргэжлийн чиг баримжаагаа олох зорилгоор гол төлөв амьдралын түвшин доогуур хүүхдүүд суралцдаг.

Зохион байгуулалт бүтцийн хувьд Нийслэлийн Засаг даргын харьяалалд, нийслэлийн төсвөөс санхүүждэг. Өв тээгч байгууллагаар бүртгэгдсэн бөгөөд одоогийн байдлаар 45 хүн ажиллаж байгаагаас 20 багш 18 төрлийн 21 дугуйлан ажиллуулж байна. Тус төвд ЕБС-ын 2-12 дугаар ангийн хүүхдүүд хамрагдах боломжтой. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тэгш боломжоор хангах зорилгоор 20 хүүхэд хамрагдсан. Ажлын 5 өдрийн 1 өдрийг багш нараа өөрийгөө хөгжүүлэх бүтээл туурвих зэрэгт цаг гаргаж өгдөг.

Жилдээ 1800-2100 хүүхэд суралцдаг. 1 хүүхэд 7 хоногт 2 цаг буюу 120 минутаар нийт 4 цагаар, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд дундаа завсарлагатайгаар 130 минутаар хичээллэдэг ялгаатай.

Хичээлийн шинэ жилтэй адилхан хугацаанд хичээллэдэг бөгөөд 1 хүүхэд тууштай бүтэн жилээр явах нь бага хувийг эзэлдэг бөгөөд цөөхөн хүүхдүүд тууштай явснаараа ирээдүйнхээ мэргэжлийн баримжааг олж аваад СУИС, ДУДС, ШУТИС-ын дизайны ангид элсэн суралцдагаас гадна сургуулиа төгсөж ирээд Урлан бүтээх төвдөө багшилдаг.

2015 оноос эхлэн өөрийн сургалтын хөтөлбөрийг одоогийнхоо хэрэгцээ, онцлогт суурилсан байдлаар боловсруулсан. Хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар Нийгмийн ажилтан ажилладаг. Хүүхдийн санал хүсэлтийг янз бүрийн аргаар сонсож зөвлөгөө өгч ажилладаг.

Хүүхэд хамгааллын бодлоготой, Эцэг, эхийн зөвлөл байгуулан ажиллаж байгаа гэх боловч уулзсан хүмүүс 4 сард ажилдаа орсон шинэ хүмүүс учраас өөрсдийнхөө хэмжээнд мэдээлэл солилцож ажилласан болно.

Урлан бүтээх төвийн гол онцлог нь сургалт нь үнэ төлбөргүйгээс гадна эмзэг бүлгийн хүүхдүүд голлох хувийг эзэлдэг байсан учир хүүхдүүдэд үнэ төлбөргүй халуун аарц 2018 он хүртэл өгдөг байсан бөгөөд энэ нь хүүхдүүдийг сургалтдаа туушдаа явах нэг хөшүүрэг болж тэдний эрүүл мэндэд тустай үйлчилгээ байсан юм. Гэтэл Дэд дарга, тогооч, жолооч нарын орон тоог цомхотгосноор хүүхдэд халуун аарц өгдөг үйлчилгээ зогссон байна. Гал тогооны тоног төхөөрөмж бусад зүйл байгаа боловч тогооч санхүүжилт дутагдалтай учир боломжгүй болсон мөн санхүүжилтгүй болсон байна.

7.3. ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН СТАНДАРТЫН ТЕХНИКИЙН ХОРОО БАЙГУУЛАГДАВ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны санаачилгаар Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд хүүхдийн эсэн мэнд амьдрах, хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, олон нийтийн үйлчилгээнд хүүхэд хамгааллын үйлчилгээний хэм хэмжээг бий болгох хэрэгцээ, шаардлагыг үндэслэн Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны А/69 дүгээр тушаалаар анх удаа "Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороо"-г төр, иргэний байгууллага, эрдэмтэн судлаачдын бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Хүүхдийн хөгжил, хамгааллын стандартчиллын техникийн хороо байгуулагдсанаар өмнө орчны аюулгүй байдлын стандарт батлагддаг байсан бол энэхүү зөвлөл байгуулагдсанаар хүүхдийн асуудлыг дангаараа хэлэлцэн баталдаг болсноор давуу талтай.

Стандартчиллын техникийн хороо нь хүүхдийн эрхэд суурилсан, хүүхдэд ээлтэй байх зарчмын хүрээнд хүүхдийн хөгжил, хамгаалалтай холбоотой стандартуудыг хэлэлцүүлж, Стандарт, хэмжил зүйн газраас хянан, баталгаажуулж байна.

Тус хороо 2021 онд Нийгмийн ажил үйлчилгээний нийтлэг стандарт, Гамшиг, онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага стандартыг шинээр боловсруулж, батлан, мөрдөж эхэлсэн.

Техникийн хороо нь хүүхдийн асуудлаар үүрэг хүлээсэн төрийн байгууллагууд болон хүүхдийн эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, эрдэмтэн судлаачид, олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн 17 гишүүнтэйгээр ажиллаж байна. Тус стандартын техникийн хороогоор дараах стандартууд батлагдаад байна. Үүнд:

- Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа, ерөнхий шаардлага” MNS 2019:
- Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчин, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага”,MNS 6781:2019
- Хохирогчийг түр хамгаалан байршуулах, үйлчилгээнд тавих шаардлага MNS:2019
- Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага”
- Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал. Ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948: 2021
- Нийгмийн ажлын үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6949 : 2021

1.”Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 5633:2019”-ийн хэрэгжилт тайлан

Батлагдсан огноо: Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн С/17 тогтоолоор батлагдсан. 2019 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Аймаг, Нийслэлийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газрын байцаагч, Цагдаагийн ерөнхий газар.

Стандартыг хэрэгжүүлэгч байгууллага:Улсын хэмжээнд 2022 оны байдлаар хүүхдийн 38 зуслан үйл ажиллагаа явуулж, нийт 59,378 хүүхдийг хөгжлийн хөтөлбөрт хамруулсан. Дээрх зуслангийн үйл ажиллагаанд Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар зэрэг байгууллагатай хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулж зөвлөмж-18, албан шаардлага-8 хүргүүлж зөрчлийг арилгуулсан байна.

Дээрх стандартын 5.1-д “Зуслангийн газар зүйн байршил, амрагч хүүхдийн хэрэгцээ, үйл ажиллагааны онцлогоос хамааран хүүхдийн зуслан нь Хүүхдийн зуслан, Гэр бүл-хүүхдийн зуслан, Гадаад хэлний зуслан, Спортын зуны зуслан, Скаутын зуслан, Хөдөлмөр зуслан гэсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулж болно” гэж заасан.

Иймд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүүхдийн амралт, зуслангийн үйл ажиллагаанд тавих нийтлэг шаардлага стандартыг хангасан тохиолдолд өмчийн хэлбэр харгалзахгүй хөдөлмөр зуслангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн. Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа стандартад Нүүдлийн соёлын боловсрол олгох зуслангийн үйл ажиллагааны зохицуулалтыг нэмж тусгахаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Уг зохицуулалт батлагдсанаар хүүхдэд амьдрах ухааны болон хэрэглээний боловсрол олгох, төлөвшүүлэх нөхцөл бүрдэнэ.

Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага-MNS 5633:2019 Стандартын хэрэгжилт 85-95%-тай байгаа бөгөөд стандарт хэрэгжиж эхэлсэн хугацаанаас жил бүр тогтмол хяналт шалгалтыг хийж, холбогдох зөрчлийг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байгаа нь нэгдсэн тайлан мэдээнд тусгагдсан байна.

/Ковид-19/ цар тахлын улмаас хүүхдийн зуслангууд 2020, 2021 онуудад хүүхэд хүлээн аваагүй бөгөөд 2022 оноос үйл ажиллагаагаа дахин явуулж эхэлсэн. Стандартын дагуу үйл ажиллагаа явуулахын өмнө хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллагуудаас бүрдсэн баг хяналт шалгалт хийдэг.

Тулгамдаж буй асуудал:

- Хүний нөөцийн хувьд мэргэшсэн, тогтвортой ажиллах нөхцөлийг бий болгох,
- Зуслангийн багшийн мэргэшүүлэх нэгдсэн сургалтыг тогтмолжуулах.

2.Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага-MNS 5852:2017

Батлагдсан огноо: Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор батлагдсан. 2018 оны 01 дугаар сарын 30-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Аймаг, нийслэлийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд хамгааллын мэргэжилтэн, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн улсын байцаагч, Боловсролын улсын байцаагч

Стандартыг хэрэгжүүлэгч байгууллага: Монгол Улсад хүүхдийн халамж, асрамжийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа 21 байгууллагын 30 төв.

Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага MNS 5852:2017 стандартын хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах ажлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас Монгол Улсын хэмжээнд хүүхдийн асрамж, халамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 21 байгууллагын 30 хүүхдийн төвд Цагдаагийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газруудын оролцоотойгоор 2019, 2022 онд зохион байгуулж ажилласан.

- Нийслэл дэх халамж, асрамжийн 17 байгууллагын 27 төв;
- Орон нутаг дахь Дархан-Уул аймаг дахь “СОС” хүүхдийн хотхон болон “Нарны хүүхдүүд” халамж, асрамжийн төвүүд, Орхон аймаг дахь “Энэрэл” хүүхдийн төв, Дорнод аймаг дахь “Анна хоме” хүүхдийн төв, Өвөрхангай аймгийн Хархорин суман дахь Монголын хүүхдийн сангийн “Солонго” салбар;

Хяналт шалгалтаар нийтлэг илэрсэн зөрчил дутагдал:

Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 27 хүүхдийн төвд 60 зөрчил, нэмэлтээр орсон 1 байгууллагад 6 зөрчил, нийтдээ 66 зөрчил илэрснээс газар дээр нь арга хэмжээ авч, 1 байгууллагад албан шаардлага, үүрэг даалгавар өгч, 28 байгууллагад зөвлөмж, арга зүй өгч ажиллалаа. Илэрсэн зөрчил дутагдлыг ангилбал:

- Хүүхдийн хувийн хэргийн бүрдэл хангалтгүй, батлагдсан маягт хөтлөөгүй, нөхцөл байдлын үнэлгээг өөрсдийн дураар өөрчилсөн.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн тухай тэмдэглэлийг хангалттай хөтөлдөггүй, баримтжуулдаггүй.
- Ажилтан, албан хаагчид нь сэтгэцийн хувьд эрүүл гэдгээ тогтоолгосон мэргэжлийн байгууллагын тодорхойлолт авдаггүй.
- Сэтгэл засалч дутмаг байдаг.
- Хяналт шалгалтын явцад 1 байгууллагад буюу “Вербист” төвд багшийн ёс зүйтэй холбоотой зөрчил дутагдал /Хүүхдийн толгой руу цохиж хөнгөн гэмтэл учруулж, зөрчил гаргасан багш Ч-г Монгол Улсын Хөдөлмөрийн хуулийн 131-р зүйлийн 1,2-р заалт, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 8-р зүйлийн 5.2-р заалтуудыг үндэслэн 1 сарын цалин хасах/ илэрсэн байна.
- Монголын Хүүхдийн сангийн 4-р салбарт шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байж болзошгүй мэдээлэл байсан ч нотлох баримт байгаагүй ба нийт төвүүдийн хэмжээнд илтэд шашны үйл ажиллагаа явуулж буй байгууллага байгаагүй.

Нээлттэй хяналт шалгалтын явцад 2023 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр “Вербист” төвийн үйл ажиллагааг дахин шалгасан бөгөөд зөрчил илэрснээс хойш орчин нөхцөл болоод үйл ажиллагаа нь эмх цэгцтэй болж сайжирсан байна.

Санал:

Хууль, эрх зүйн орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр:

- МУ-ын холбогдох хууль, журам, стандартын хэрэгжилтийг хангах ажиллах,

- НҮБ-ын Хүүхдийн эрхийн хорооны 12-р ерөнхий зөвлөмжийн хэрэгжилтийг сайжруулах (гэр бүл, халамжийн хувилбарт үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээ, сургууль, арга хэмжээ, ажлын байр, хүчирхийллийн нөхцөл байдал, онцгой нөхцөл байдалд гэх мэт.)
- Халамж, асрамжийн төвүүдэд хийгдсэн хяналт, шалгалтын дүнг үндэслэн Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох асуудлыг шийдвэрлэх.
- Эцэг, эх болон харьяалал, гэрийн хаяг тодорхойгүй, эцэг, эх нь архины хамааралтай зэргээс шалтгаалан хүүхдийн бичиг баримтын бүрдэл дутуу хийгддэг байдлыг шийдвэрлэх, хамтарсан баг, цагдаа, халамж асрамжийн төвүүдийн ажлын уялдаа холбоог сайжруулах.
- Халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт заасан “18 хүртэлх насны тэжээгч нь нас барсан хагас, бүтэн өнчин хүүхдэд сар бүр олгодог тэтгэвэр”, 13 дугаар зүйлийн 1.5 дахь хэсэгт заасан “Нийгмийн халамжийн сангаас олгогдох хүүхдийн мөнгөн тэтгэмж”, 5.2 дахь хэсэгт заасан “18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэнд 18 нас хүрмэгц нь 1 удаа олгох мөнгөн тэтгэмж”, 5.3 дахь хэсэгт заасан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох мөнгөн тэтгэвэр, тэтгэмж”-ийг олгуулах ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг хангах;
- Халамж, асрамжийн төвд амьдарч байгаа хүүхдийн мөнгөн тэтгэмж эцэг, эхийн дансанд шууд орж, хүүхдэд хуримтлал үүсэхгүй байгаа нөхцөл байдлыг шийдвэрлэх.
- Халамж, асрамжийн төвүүдээс 18 нас хүрч ар гэртээ эргэн нэгтгэгдэж байгаа хүүхдийн нийгмийн баталгаа, хангамжийн асуудал ахуйн хэрэглээ болон хөдөлмөр эрхлэлтийн асуудалд дэмжлэг үзүүлдэг байх.
- Халамж, асрамжийн төвүүдэд амьдарч байгаа хүнд, хөнгөн, хавсарсан, оюуны бэрхшээлтэй 79 хүүхэд амьдарч байгаагаас 18-аас дээш насны 8 хөгжлийн бэрхшээлтэй залуус амьдарч байна. Эдгээр залуус нь цаашид бие даан амьдрах чадвар, асран халамжлах төрөл садан байдаггүйгээс халамж, асрамжийн төвдөө амьдарсаар байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр:

- Нийт ажилтан, албан хаагчдын хувийн хэргийн баяжилтыг стандартын шаардлагад нийцүүлэн хөтөлж хэвших.
- Хүүхдийн хөгжил, хамгааллын мэдлэг арга зүй олгох, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтад нийт ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулах.
- Төвүүдэд мэргэжлийн нийгмийн ажилтан, мэргэжлийн сэтгэл зүйч ажиллуулах, нийгмийн ажлын үйлчилгээг үзүүлэх ур чадварыг нэмэгдүүлэх, практикт суурилсан сургалтуудад хамруулах.
- Албан хаагчдын хариуцлагыг сайжруулж, сургалт нөлөөллийн ажлыг төлөвлөгөөний дагуу хийж, гүйцэтгэл, үр дүнг тооцон ажиллах.
- Харилцан туршлага солилцож, үндэсний онцлог, хэрэгцээ шаардлагатай хослуулан хувилбарт үйлчилгээг хэрэгжүүлэх, сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх.
- Хүүхэд бүрийн хувийн хэргийн баяжилтыг сайжруулж, батлагдсан маягтыг хууль журмын дагуу хөтөлж хэвших. Цаашлаад асрамж, халамжийн төвүүдийн үйл ажиллагаанд тохирсон маягтыг шинээр батлан гаргаж хэрэгжүүлэх.
- Аливаа шашны үзэл баримтлалыг дэмжсэн үйл ажиллагаа явуулахгүй байх.

Хүүхдийн хөгжил, оролцоо, хамгааллын ажиллагааг сайжруулах чиглэлээр:

- Хүүхэд тус бүрд чиглэсэн оновчтой үйлчилгээг нөхцөл байдлын үнэлгээнд тулгуурлан төлөвлөн хэрэгжүүлж, мэргэжлийн нийгмийн ажлын үйлчилгээг хууль журамд нийцүүлэн хүргэх.
- Хүүхэд бүрийн хөгжлийн төлөвлөгөөг гаргаж, үр дүнд чиглэсэн үйлчилгээнүүдийг хүргэх.

- Хүүхэд бүрийн авьяас чадварыг нээн илрүүлж, хөгжүүлэх, дэмжих, оролцоог хангах, бүтээлч үйлсийг хөгжүүлэх.
- Хүүхдүүдэд Монгол ёс заншлыг өвлүүлэн хөгжүүлэх, үндэсний өв соёлыг түгээн дэлгэрүүлэх, монгол хүний эрхэм чанарыг бий болгон төлөвшүүлэх.
- Хүүхдийг аливаа шашны үйл ажиллагаанд татан оролцуулахгүй байх.

3. Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018

Батлагдсан огноо: Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан. 2018 оны 06 дугаар сарын 15-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Аймаг, нийслэлийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд, хамгааллын мэргэжилтэн, Хөдөлмөрийн улсын байцаагч

Хэрэгжүүлэгч байгууллага: Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс

Улсын хэмжээнд 2018 онд 491 уралдаан, 10,453 хүүхэд, 2019 онд 172 уралдаанд 10,435 хүүхэд 2020 онд 439 уралдаанд 13519 хүүхэд, 2021 онд 3 уралдаанд 1620 хүүхэд, 2022 оны 259 уралдаанд 7596 хүүхэд оролцож, уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2018 стандартыг мөрдүүлж ажилласан байна.

Үндэсний морин уралдааны уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS6264:2018 стандарт, 2022 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан Үндэсний их баяр наадмын тухай хуулийн /шинэчилсэн найруулгын/ 10 дугаар бүлгийн 10.2 дахь хэсгийн хэрэгжилтийг хангуулж, хяналтыг холбогдох төрийн байгууллагууд тогтмол хяналт тавин ажиллаж байгаа нь холбогдох тайлан мэдээнүүдээс харагдаж байна. Хурдан морины уралдаанч хүүхдийн эрх, аюулгүй байдлыг ханган ажиллах нь дан ганц төрийн байгууллагын хүлээх үүрэг биш бөгөөд уяач, уяачдын холбоод, эцэг, эхийн хариуцлагын үйл ажиллагаанаас харагдаж байсан.

2022 оны нийт уралдааны явцад 406 уралдаанч хүүхэд мориноос унаж бэртсэн байна. Үүнээс хүнд гэмтэлтэй-22 хүүхэд эмнэлгийн яаралтай тусламж авсан. Даатгалын нөхөн төлбөрт 172,976.841 төгрөгийг гаргуулан ажилласан байна. Стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулж, шаардлага хангаагүй хувцас-9, морины хэрэгсэл-21 хураан авч зөрчлийг арилгуулсан байна. Үндэсний морин уралдааны морь унаач хүүхдийн хамгаалалтын хувцас, морины хэрэгсэлд тавих шаардлага MNS 6264:2018 стандартын хэрэгжилт 98 хувьтай хэрэгжиж байна.

Санал:

- Уяач нь хурдан морины уралдаанч болон “уяачийн туслах” хүүхэд, эцэг, эхтэй нь гурван талт гэрээг заавал байгуулдаг байх.
- Хурдан морины уралдаанч хүүхэд болон “уяачийн туслах” хүүхдийн жишиг цалинг насны ангиллаар ялган тодорхой тогтоох.
- Өвлийн цагт үсэргээ, сунгаа, морины ажлыг хүүхдээр хийлгүүлж байгаа эсэхийг хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох; /Засгийн газрын 57 дугаар захирамж хэрэгжиж байгаа ч тус захирамжийн хэрэгжилтийг хангах асуудал дээр анхаарах шаардлагатай/
- Уралдаанч хүүхдийн хамгаалах хэрэгслийн чанарыг сайжруулах талаар холбогдох стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах, уралдаанч хүүхэд бүрэн хамгаалах хэрэгсэлтэй барианд ирсэн эсэх шалгуурыг Үндэсний их баяр наадмын морин уралдааны болон Монголын хурдан морины уралдааны дүрэмд тусгах;

4.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засалт, хөгжлийн төвийн бүтэц, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага-MNS 6419:2021

Батлагдсан огноо: Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн С/38 дугаар тушаалаар батлагдсан. 2021 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Эрүүл мэндийн улсын байцаагч

Хэрэгжүүлэгч байгууллага: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв

Тус стандартын хэрэгжилтэд одоогоор үнэлгээ хийгдээгүй байгаа бөгөөд Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төвөөс стандартын хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төв нь 2020 оноос үйл ажиллагаагаа тогтмолжуулж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд өдрийн, түр байршуулан сэргээн засах, явуулын үйлчилгээ гэсэн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж, хүүхдийн хөгжлийн бэрхшээлийн эрт илрүүлэлт, хөгжлийг дэмжих хөтөлбөр, техник технологийн эмчилгээ, оношилгоонд хамруулан ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд хүүхдийн асрамж халамжийн төвд амьдарч байгаа байнгын асаргаа шаардлагатай Засаг даргын захирамжтай 67 хүүхэд, залуучууд байна. Үүнээс 31 нь 15-35 насны залуучууд байгаа бөгөөд эдгээрт зориулсан асаргаа, сувилгаатай тусгайлсан төв шаардлагатай.

Санал:

- Эрсдэлт нөхцөлд буй, асрамж, халамжийн төвд байгаа байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд рүү чиглэсэн цогц үйлчилгээг бий болгох.

5.Хүүхдэд тээвэрлэх автобус ба үйлчилгээнд тавих шаардлага MNS 6440:2014

Батлагдсан огноо: Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор батлагдсан. 2014 оны 05 дугаар 20-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Зам тээврийн яам, Нийтийн тээврийн газар

Хэрэгжүүлэгч байгууллага: Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх сургууль цэцэрлэг.

Улсын хэмжээнд 2023 оны байдлаар 80 хүүхдийн автобус хүүхдүүдэд үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд нийслэлийн хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 72 хүүхдийн автобус 69 сургуулийн 208 мянга гаруй хүүхдэд үйлчилж байна.

2023 оноос Дархан хотод 8 хүүхдийн автобус 8 чиглэлд явж, нийт 10 сургуулийн хүүхдүүд хамрагдаж байна.

Нийслэлийн хэмжээнд 2022 оны Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 24 дүгээр тогтоолоор Хүүхдийн автобусанд тавих ерөнхий шаардлага UCS 1604В:2022-ийг баталж, хэрэгжилтийг Нийслэлийн нийтийн тээврийн газар, Нийслэлийн боловсролын газраас хариуцан ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.13. дэх заалт “Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын аюулгүй, найдвартай зорчих “Сургуулийн автобус” төслийг хэрэгжүүлнэ. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.3.7 дахь заалт “Сургуулийн бүсэд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчныг бүрдүүлж, суралцагч гэр сургуулийн хооронд үнэ төлбөргүй зорчих “Сургуулийн автобус” төсөл хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийг нэгдсэн зохион байгуулалтаар техникийн шаардлага хангасан автобусаар тав тухтай, аюулгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлэн нийгмийн хариуцлагын хүрээнд НТҮГ болон зорчигч тээврийн аж ахуйн нэгжүүдтэй хамтран “Сургуулийн автобус” төслийг 4 дэх хичээлийн жилдээ хэрэгжүүлж байна.

2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр “Сургуулийн автобус” төсөл 4 дэх жилдээ хэрэгжиж байгаатай холбогдуулан Автобусны жолооч, Хүүхэд зохицуулагч нарт НБГ, НГБХЗГ, ННТГ, Тээврийн цагдаагийн албаны байгууллагууд хамтран сургалт зохион байгууллаа. Сургалтад 23 сургуулийн 23 жолооч, 23 хүүхэд зохицуулагч нар оролцлоо. 2019-2020, 2020-2021 оны хичээлийн жилд 29 сургуулийг хамруулан 35 чиглэлд 40 автобус өдөрт дунджаар давхардсан тоогоор 5600-6300 хүүхэд тээвэрлэсэн.

2021-2022 оны хичээлийн жилийн эхний хагаст 29 сургуулийг хамруулан 37 чиглэлд 37 автобус 2021 оны 09 дүгээр сарын 06-аас үйлчилгээнд гарч 5/9 зарчмаар хичээллэсэнтэй холбоотойгоор өдөрт давхардсан тоогоор 1680-2100 хүүхэд тээвэрлэсэн.

2022-2023 оны хичээлийн жилд эхний ээлжид 23 сургуулийг хамруулан 23 чиглэлд 23 автобусаар үйлчилж давхардсан тоогоор өдөрт дунджаар 4300-4571 хүүхэд тээвэрлэж байна.

Санал:

- Сургуулийн автобусны тоо хангалтгүй, хүртээмжтэй байж чадахгүй байна.

6.Сургуулийн бүс, техникийн ерөнхий шаардлага MNS 6444:2014

Батлагдсан огноо: Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 12 дугаар тогтоолоор баталсан. 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Боловсролын ерөнхий газар, боловсролын улсын ерөнхий байцаагч, Зам тээврийн яам

Хэрэгжүүлэгч байгууллага: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг.

“Сургуулийн бүс.Техникийн ерөнхий шаардлага” MNS 6444-2014 стандартыг 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөж ирсэн. Уг стандартыг Сургууль, цэцэрлэгийн орчны авто зам, явган зорчигчийн хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах, замын байгууламжийн төлөвлөлтийг сайжруулах, хүүхдэд ээлтэй орчныг өнөөгийн цаг үетэй уялдуулан шинэчлэхээр шийдвэрлэж, “Ай Си Си Рөүд” ХХК сонгон шалгарч гэрээ байгуулан эхлэлийн шатны тайланг боловсруулан ирүүлсэн. Эхлэлийн тайлан Редакц, шүүмжийн ажлын хэсэг томилон ажиллаж байна.

7.Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015

Батлагдсан огноо: Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 36 дугаар тогтоолоор батлагдсан. 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Аймаг, нийслэлийн Хүүхдийн эрхийн улсын байцаагч, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн улсын хяналтын байцаагч

Хэрэгжүүлэгч байгууллага:Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийслэлийн хэмжээнд 70 төвийн 228 хүүхэд харагч

- 2015 онд Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль батлагдаж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 2015 оны 09 сараас 2017 онд хэрэгжилтийг ханган ажилласан.
- 2018 оны 01 дүгээр сараас Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцад шилжиж, Боловсролын яам хэрэгжилтийг 2018-2021 онуудад хариуцсан.
- 2022 оноос Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад буцаж шилжсэн.

2022 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд 130 төвийн 1950 хүүхэд харагч ажиллаж байгаа бөгөөд нийт 2022 хүүхдэд үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.

Хүүхэд харах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6540:2015 стандартын дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас жил бүр стандартын хэрэгжилтийг үнэлэн ажилладаг бөгөөд 2022 онд улсын хэмжээнд стандартын хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулсан. Стандартын хэрэгжилт 85 хувьтай. Одоо уг үйлчилгээ нь нэг талаасаа бизнесийн зорилготой болсон. Анхны үйлчилгээний зорилгоос хазайсан.

Санал:

- Боловсрол, шинжлэх ухааны яамнаас цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлсэнтэй холбоотойгоор уг үйлчилгээг нарийн мэргэжлийн үйлчилгээ шаардлагатай хүүхдүүд рүү чиглэсэн хувилбарт үйлчилгээ болгох шаардлагатай. Жишээ нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд өдрийн үйлчилгээ үзүүлэх зарчмаар.

8.ЕБС-ын сурагчдын дотуур байрны орчин, үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага-MNS 6781:2019

Батлагдсан огноо:Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар батлагдсан. 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Боловсролын ерөнхий газар, боловсролын улсын ерөнхий байцаагч,

Хэрэгжүүлэгч байгууллага: Ерөнхий боловсролын 89 сургуулийн дотуур байр

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчин, үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS6781:2019 стандарт, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх, арга зүйн дэмжлэг үзүүлэх, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах хүрээнд Ерөнхий боловсролын 89 сургуулийн дотуур байранд хяналт шалгалтыг зохион байгуулж нийт 9 дотуур байрны орчин, үйлчилгээ, ерөнхий шаардлага хангахгүй холбогдох зөвлөмжийг өгч ажилласан. Стандартын хэрэгжилт 60 хувьтай үнэлэгдсэн. Цэцэрлэг, сургууль, дотуур байрыг төвлөрсөн болон бие даасан ариун цэврийн байгууламжтай болгох хүрээнд 1, 2 дугаар ээлжийн нийт 26 багц 16 аймгийн 92 сумын 307 объектын барилга угсралтын ажил хийгдэж байна.

Үүнээс 9 аймгийн 30 сумын 38 сургууль, 19 цэцэрлэг, 30 дотуур байрыг ариун цэврийн байгууламжтай болгож байнгын ашиглалтад оруулсан. Үлдсэн 62 сумын 220 объектын барилга угсралтын ажлын явц 1, 2 дугаар ээлж нь 30-90 хувийн гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгох” зорилтыг хэрэгжүүлэх, Улсын Их Хурлын 2020 оны 39 дүгээр тогтоолоор “Эрдэнэт” ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд 100.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Сургууль цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжаар солих төслийн 1, 2-р ээлжийг хэрэгжүүлэх ажлын тендер 2021 онд зохион байгуулагдаж 16 аймгийн 92 суманд 307 сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих ажлын нийт 43,365.2 сая төгрөгийн дүнтэй гэрээг 26 аж ахуйн нэгжтэй байгуулан Барилгын хөгжлийн төвөөр Захиалагчийн өдөр тутмын хяналтыг гүйцэтгүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд нийт 1,2-р ээлжийн барилга угсралтын ажлын 12 аймгийн 55 сумын 130 объектыг хүлээж авах комисс ажиллаж байнгын ашиглалтад оруулж, 17 сумын 70 объектод улсын комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Төслийн 3 дугаар ээлжид 15 аймгийн 113 суманд 280 сургууль, цэцэрлэг, дотуур байрын зураг төсөл боловсруулах ажлын нийт 1,765.2 сая төгрөгийн дүнтэй гэрээг байгуулан зураг төслийн ажлыг эхлүүлсэн бөгөөд 2023 оны 1 дүгээр улиралд багтаан зураг төслийн ажлыг дуусгуулж, барилга угсралтын ажлын гүйцэтгэгч шалгаруулах худалдан авах ажиллагааг зарлана. Боловсрол, шинжлэх ухааны яамны Хөрөнгө оруулалтын хэлтсээс 4 дүгээр ээлжид хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 17 аймгийн 88 сумын 200 объектын жагсаалтыг холбогдох аймгийг Засаг дарга нартай зөвшилцөн, давхардсан болон орхигдсон объект байгаа эсэх судалгааг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан гаргаж, жагсаалтын дагуу зураг төслийн ажлын гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулахаар төлөвлөсөн. Ариун цэврийн байгууламжийн барилга, угсралтын ажилд хийсэн техник хяналт, бодит гүйцэтгэлийн баталгаажуулалтад үндэслэн 2022 оны эцсийн байдлаар 28.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Санал:

- Шаардлага хангахгүй ЕБС-ийн дотуур байрын жагсаалтыг гаргаж, үе шаттай стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх төлөвлөгөө гарган хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;
- Дотуур байрын гадна болон дотор орчны аюулгүй байдал, хоол хүнс, цэвэр усны хэрэглээнд тогтмол хяналт тавих үндэсний механизмыг бий болгох;
- Дотуур байр дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг заавал тусгадаг болох;
- Дотуур байрын багш, туслах, эмч, сэтгэл зүйч, жижүүр, үйлчилгээний ажилтны орон тоог дотуур байрын хүчин чадал, суралцагчдын тоотой уялдуулан баталж, цалин

хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгаагаар хангах арга хэмжээг төсөвт тусган хэрэгжүүлэх;

- Дотуур байрын багш болон ажилчдыг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох хамтын ажиллагааг сайжруулах, хүний эрхийн боловсрол олгох, орон нутгийн холбогдох эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлэн хүүхэд хамгааллын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх.

9.ЕБС-ын орчны аюулгүй байдалд тавих ерөнхий шаардлага MNS 6782:2019

Батлагдсан огноо: Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар батлагдсан. 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Хяналт тавих: Боловсролын ерөнхий газар, боловсролын улсын ерөнхий байцаагч

Хэрэгжүүлэгч байгууллага: 2022-2023 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 859 сургуульд 746,405 хүүхэд өдрөөр суралцаж байгаагийн 683,708 нь төрийн өмчийн сургуульд, 62,697 нь хувийн өмчийн сургуульд суралцаж байна.

Сургуулийн орчны аюулгүй байдлын стандартын хэрэгжилтийг 2022 оны 6 дугаар сард үнэллээ. Үнэлгээнд 21 аймаг, 9 дүүргийн төрийн өмчийн 650 сургууль хамрагдаж, сургуулийнхаа гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг стандартын шаардлагад нийцэж буй эсэхийг үнэлсэн.

Үнэлгээнд хамрагдсан нийт сургуулийн гадаад, дотоод орчны эрсдэлийн түвшин нь “дундаж эрсдэлтэй” гэж үнэлэгдсэн. 17 аймгийн сургууль орчмын гэрэлтүүлэг муу, 9 аймаг өндөр эрсдэлтэй гэж дүгнэгдсэн. Мөн цахилгааны монтаж болон аюулгүй байдал хөдөө орон нутагт харьцангуй дундаж, Улаанбаатар хотод өндөр эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна. Цаашид дээрх эрсдэлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авахаас гадна сургууль орчмын зорчих хэсгийн цардмал замын хэсгийг нэмэгдүүлэх, биеийн тамирын талбайн аюулгүй байдлыг хангах, сургууль орчмын авто замын явган зорчигч зорчих хэсгийн тэмдэг тэмдэглэгээг тодруулах, шинээр хийх, сургалтын орчны камерын тоог нэмэгдүүлэх, камержуулах, хүүхэд хөгжлийн өрөөгүй 192 сургуулийг нэн тэргүүнд өрөөтэй болгох шаардлагатай байна гэж дүгнэсэн.

Ахлах ангиуд бага болон дунд ангиас илүүтэйгээр 2 ээлжээр, 40-өөс дээш хүүхдийн бүлэг дүүргэлттэйгээр хичээллэж байна. Хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 3 ээлжээр хичээллэж болзошгүй ерөнхий боловсролын сургуулийн суудлын тоог нэмэгдүүлэх, түрээсийн байранд хичээллэх, өргөтгөлийн барилгын явцыг хурдасгах, санхүүжилтийг шийдвэрлэх зэрэг арга хэмжээ авлаа.

2022-2023 оны хичээлийн жилд Нийслэлд түрээсийн байранд нийт 18 сургууль 20 байранд үйл ажиллагаа явуулж нийт 278 бүлгийн 11310 хүүхэд хичээллэж байна. Нийт 20 байрыг сард 426,2 сая төгрөгөөр түрээсэлж байна. Сардаа нэг хүүхдэд 37,683 төгрөгийг түрээсийн байранд зарцуулж байна.

Сургуулийн барилга байгууламж, дэд бүтцийн хувьд 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 61580 хүүхдийн хүчин чадалтай, 649.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 125 төсөл арга хэмжээ, өмнөх оноос шилжин хэрэгжих 382.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 42498 хүүхдийн хүчин чадалтай, 87 төсөл арга хэмжээ, шинээр 267,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 19082 хүүхдийн хүчин чадалтай 38 төсөл, арга хэмжээ хэрэгжиж, жилийн эцсийн байдлаар 7308 хүүхдийн хүчин чадалтай 21, гадаадын тусламжаар 2, нийт 23 сургууль /нийслэлд 9, орон нутагт 14/-ийг шинээр ашиглалтад орууллаа.

Одоогоор барилга угсралтын ажил нь үргэлжилж байгаа 100 сургуулийн барилга байна.

Гадаад эх үүсвэр буюу “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмж сайжруулах төсөл”-ийн хүрээнд дараах 6 сургуулийн өргөтгөлийн барилга угсралтын ажил үргэлжилж байна.

Санал:

- Улсын хэмжээнд сургууль орчмын гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх.
- Сургууль орчмын зорчих хэсгийн цардмал замын хэсгийг нэмэгдүүлэх.
- Биеийн тамирын талбайн аюулгүй байдлыг хангах.
- Цахилгаан, ил монтаж зэрэг нь эрсдэлтэй сургууль их байгаа тул засаж, сайжруулах.

- Сургууль орчмын авто замын явган зорчигч зорчих хэсгийн тэмдэг тэмдэглэгээг тодруулах, шинээр хийх шаардлагатай.
- Сургалтын орчны камерын тоог нэмэгдүүлэх, камержуулах.
- Хүүхэд хөгжлийн өрөөгүй байгаа 192 сургуулийг нэн тэргүүнд өрөөтэй болгох шаардлагатай байна.

10. Гамшиг, онцгой байдлын үеийн хүүхэд хамгаалал, ерөнхий зарчим, салбар дундын хамтын ажиллагааны нийтлэг шаардлага MNS 6948:2021

Батлагдсан огноо: Стандарт, хэмжил, зүйн газрын даргын 2021 оны 12 дугаар 22-ны өдрийн С/66 дугаар тушаалаар батлагдсан. 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс дагаж мөрдсөн.
Хяналт тавих: Гамшиг онцгой байдлын үед үүрэг хүлээсэн байгууллагууд гамшиг онцгой байдлын үед үйлчилгээ шаардлагатай нийт хүүхдэд энэхүү стандартаар үйлчилнэ.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны ТНБД-ын тушаалаар 2022 оны А/35 дугаар “Гамшигийн үеийн хүүхэд хамгаалал, үйлчилгээний стандартыг танилцуулах сургалт”-ыг зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гишүүд, нийгмийн ажилтнууд, онцгой байдлын газрын ажилтнууд, асрамж халамжийн төв, нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны ажилтнууд, нийт 200 хүнд хамруулсан сургалт зохион байгуулж стандартыг хэрэглэх, үнэлэх арга зүйн мэдлэгтэй болгосон. Мөн уг стандартын хэрэгжилтийг хангах заавар бүхий 16 постер гарын авлагыг бэлтгэн 21 аймаг, 9 дүүргийн хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн гишүүдэд түгээсэн.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын дэд сайдаар ахлуулсан Хүүхэд хамгааллын салбар дундын бүлгийн ажлын хэсэг мэргэжлийн ангийн гишүүд гамшигийн үед авах арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг стандартын дагуу хэрэгжүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх арга зүйн сургалтын хүрээнд төлөвлөгөө гарган орон нутагтаа хэрэгжүүлж, болзошгүй эрсдэл болон өвөлжилтийн бэлэн байдлын төлөвлөгөөний дагуу мөн хамтран ажиллаж байна.

Санал байхгүй. Стандарт харьцангуй шинэ тул сурталчлан таниулах, хэрэгжүүлэх шатанд явж байгаа.

11. Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021

Батлагдсан огноо: Стандарт, хэмжил, зүйн газрын даргын 2021 оны 12 дугаар 22-ны өдрийн С/66 дугаар тушаалаар батлагдсан. 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс дагаж мөрдсөн.

Хяналт тавих: Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам

Хэрэгжүүлэгч: ХНХЯ, ЭМЯ, БШУЯ, ГБХЗХГ, ХХҮЕГ, ШШГЕГ, сум, хорооны нийгмийн ажилтан

2022 оны жилийн эцсийн байдлаар Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх газар 60, Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Ерөнхий газар 721, Монгол Улсын Эрүүл мэндийн яамны харьяа 300, Боловсрол, шинжлэх ухааны яам 872, Гэр Бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар 861 нийгмийн ажилтан буюу нийт 2634 ажиллаж байна. Сум хорооны түвшинд Хамтарсан багийн нарийн бичиг буюу нийгмийн ажилтнаар Улсын хэмжээнд сум, хорооны 764 нийгмийн ажилтан ажиллаж байгаагаас хамтарсан багт 699 нийгмийн ажилтан ажиллаж байна.

Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/41 дүгээр тушаалаар “Бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхэд, тэдний гэр бүлийн гишүүдэд нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх ажлыг боловсронгуй болгох, хэлэлцүүлэг” үндэсний хэмжээнд зохион байгуулж 21 аймаг 9 дүүргийн нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр хариуцсан мэргэжилтнүүдэд нийгмийн ажлын үйлчилгээний стандарт, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Мөн Өвөрхангай аймагт “Нийгмийн ажилтны зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, 100 гаруй нийгмийн ажилтныг журам, стандарт, нийгмийн ажлын үйлчилгээний сургалтад хамруулсан.

2022 оны 11 сард 21 аймаг 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга нар болон 100 нийгмийн ажилтанд Нийгмийн ажлын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны 2022 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор “Монголын нийгмийн ажилтны ёс зүйн үндэсний хорооны дүрэм”-ийг батлуулсан.

Стандартын хэрэгжилтийг бүрэн хангуулах ажлын хүрээнд 2023 оны 05 дугаар сарын 15-нд Нийгмийн ажлын салбар хорооны гишүүд /21 аймаг, нийслэл, 9 дүүрэг/-д сургалт зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Санал:

- Салбар бүрд “Нийгмийн ажлын үйлчилгээний нийтлэг шаардлага MNS 6949:2021” стандартыг таниулан сурталчлах, мөрдүүлэх ажлыг зохион байгуулах.

Батлагдсан огноо: Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн С/07 дугаар тушаалаар батлагдсан. 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Хяналт тавих: Аймаг, дүүргийн хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд хамгааллын мэргэжилтэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөл

Хэрэгжүүлэгч байгууллага: Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 17 түр хамгаалах, 17 нэг цэгийн үйлчилгээний төвд 2022 жилийн эцсийн байдлаар нийт 4795 иргэн түр хамгаалан байрлуулах үйлчилгээ үзүүлснээс 1569 насанд хүрэгч, 3226 хүүхдэд аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ үзүүлсэн. 3226 хүүхдүүдийг хүйсээр нь авч үзвэл эмэгтэй 1795 /55,6%/ эрэгтэй 1430 /44,3%/ байна.

Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартыг хүчин төгөлдөр болохоос өмнө Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийн хамтарсан хяналт шалгалтыг 2019 онд, батлагдаад хэрэгжсэний дараа 2021 оны 12 сард тус тус 2 удаа зохион байгуулсан байна. Мөн жил бүр Хүүхдийн эрхийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллага, хүүхдийн эрхийн улсын байцаагч нар нь төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд стандартын хэрэгжилтийн хяналт шалгалт хийж, холбогдох зөвлөмжийг тухай бүр өгч ажилласан нь цугларсан тайлан мэдээнээс харагдаж байна. Тус хяналт шалгалтыг Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллагын харьяа 17 нэг цэгийн үйлчилгээний төв, 17 түр хамгаалах байрны үйл ажиллагаа, үйлчилгээнд хяналт, дүн шинжилгээ хийсэн.

Хяналт шалгалтын үр дүнд дараах арга хэмжээг авах шаардлагатай зөвлөмжүүд гарсан байна:

- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн сэтгэл зүйчдийг нарийн мэргэшүүлэх хэрэгцээ шаардлагатай, ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогчтой ажиллах арга зүйд суралцах нэн шаардлагатай.
- Хохирогчдод үзүүлэх үйлчилгээнд зориулсан нэг бүрийн төсвийг нэмэгдүүлэх, хохирогчдод үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ, эрх зүйн туслалцаа, хохирогчийн бичиг баримтыг нөхөн гаргуулах, сэтгэцийн дүгнэлт гаргуулах зэрэг хувьсах зардлын тооцоог Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны “Журам батлах тухай” А/150 дугаар тушаалаар баталсан “Түр хамгаалан байрлуулах үйлчилгээний нэг хүнд ногдох хувьсах зардал тооцох журам”-д оруулах.
- Хамтарсан багийн гишүүн, мэргэжлийн сэтгэл зүйч, нийгмийн ажилтан нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор цалин, урамшууллыг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн нөхцөл байдлыг харгалзан төрийн албан хаагчийн дундаж цалинтай дүйцүүлэх.
- Хохирогчтой ажилласан кейс материалыг архивлах журмыг шинээр боловсруулж батлуулах, мөрдүүлэх.
- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудыг жишиг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд туршлага судлуулах.
- Орон нутгийн сонгуулийн дараа аймаг, сумдын удирдлага, холбогдох ажилтан, албан хаагчдын дийлэнх нь солигдсон тул Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулах арга зүйн болон мэргэжил, ур чадварын ажлуудыг эрчимжүүлэх.

- Хамтарсан багийн ажлын байрны тодорхойлолтод гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиг үүргийг тусгах.
- Түр хамгаалах байранд үндсэн орон тоон дээр нэмээд тогооч, манаач, хамгаалалтын ажилтан, жолоочийн орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Хувьсах зардлын төрлийг нэмэгдүүлэх. Тухайлбал, харшилтай үйлчлүүлэгч ирэхэд тохиолдолд хоол хүнсний зардал болон нэмэлт зардал шаардлагатай болдог гэжээ.

Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6040:2019 стандартын хэрэгжилт 70-80%

Тулгамдаж буй асуудал:

- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг ч үйлчилгээний зардлын дийлэнх хувийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас эсвэл олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн дэмжлэгээр үзүүлж байна.
- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн орон тоо болон цалингийн санг зарим орон нутаг баталж өгөөгүй.
- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудын дунд хохирогчид үзүүлсэн тусламж, үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан болох e-tuslamj болон eGBV программд мэдээлэл оруулах мэдлэг муу байна.
- Орон нутагт и-баримт гаргаж өгөх боломж бүрэн бүрдээгүй, хүчирхийлэлд өртсөн хохирогчид үйлчилгээ үзүүлэхэд эмчилгээний зардал, дотуур үзлэг, баримтжуулалт хийхэд зураг угаалгах зэрэг төлбөрийн асуудал үүсдэг ба эдгээрийн санхүүгийн тайлан бүрдүүлэлтийг хангахад хүндрэлтэй.
- Түр хамгаалах байрны стандарт, төрийн бус байгууллагыг магадлан итгэмжлэх журам нь Улаанбаатар хотод нийцсэн боловч орон нутагт хэрэгжүүлэхэд шаардлага хэтэрхий өндөр байгаа нь хүндрэл болж байна.
- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудын дунд гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн кейс файлын хөтлөлт янз бүр, бүрдүүлэлт сул байна.
- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнууд ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, урамшуулал хөшүүрэг тодорхойгүй мэргэшсэн мэргэжилтнүүд бүгд цалин өндөртэй газрыг сонгон ажиллаж байгаа нь хүний нөөцийн хувьд хүндрэл болж байна.
- Түр хамгаалах байрны хувьд холбогдох хууль, журамд заасан нууцлалын шаардлага хангагдаагүй.

12.Хүүхдийн тоглоомын талбайд тавих ерөнхий шаардлага MNS 6751:2019

Батлагдсан огноо. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн С/07 дугаар тушаалаар батлагдсан. 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Хяналт тавих: Аймаг, дүүргийн Орчны эрүүл ахуйн асуудал хариуцсан улсын байцаагч, Хүүхдийн эрхийн улсын байцаагч, хүүхэд хамгааллын мэргэжилтэн, Цагдаагийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан, Эрүүл мэндийн яамны

Хэрэгжүүлэгч байгууллага: Хүүхдийн бүх тоглоомын талбай

Нөхцөл байдал: Хүүхдийн тоглоомын талбайд тавих ерөнхий шаардлага MNS 6751:2019 стандартын хяналт шалгалтыг жил бүр Мэргэжлийн хяналтын Ерөнхий газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Цагдаагийн байгууллага, орон нутгийн холбогдох байгууллагуудтай хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг явуулж хяналт тавьдаг. 2022 онд Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.1.4, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Засгийн газрын 2018 оны “Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангах тухай” 01 дүгээр албан даалгавар, Хүүхдийн тоглоомын талбайд тавигдах ерөнхий шаардлага MNS6751:2019 стандартын хэрэгжилтийг хангаж, хүүхдийн тоглоомын талбайд үзлэг шалгалт хийж, хүүхдийг болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, эрсдэлийн түвшнийг тодорхойлох, арилгах арга хэмжээг Нийтийн аж ахуй үйлчилгээний газартай хамтран, нийтийн эзэмшлийн гудамж, талбай нь 99 байрлалд 500 гаруй тоглоом,

хэрэглэлд хяналт шалгалт хийж ажиллаж, 150 гаруй тоглоом хэрэглэл нь ямар нэгэн эвдрэл гэмтэлтэй, хүүхдийн биед гэмтэл учруулж болзошгүй байна. Шалгалтын явцад тоглоом, хэрэглэлүүд хагархай, цуурсан, тоглоомуудын эрэг, боолт, бэхэлгээ суларсан, хаалт хашлага ганхсан, гагнаас салсан, торон хашаа шаардлага хангахгүй, тоглоомын талбай нь стандартын шаардлага хангаагүй хүүхдийн хөдөлгөөнд саад учруулсан, хог хаягдалд дарагдсан зэрэг нийтлэг зөрчил илрүүлж ажилласан. Зөрчлийг арилгуулахаар 17 албан, шаардлага, зөвлөмжийг хүргүүлж ажиллалаа.

Нийслэлийн хэмжээнд Орон сууц, гэр хорооллын дунд байрлах 973 тоглоомын талбайн стандартын хяналт шалгалт хийснээс шаардлага хангасан 431, шаардлага хангаагүй 385, солих, сайжруулах шаардлагатай 157 тоглоомын талбай байна.

Түлгамдаж буй асуудал:

- Хүүхдийн тоглоомын талбайн тоглоомууд эвдрэл ихтэй, зориулалтын зөөлөн дэвсгэргүй, хашаа хайс нь эвдэрсэн, эсвэл машин замаас тусгаарлаагүй, хурд сааруулагч, тэмдэг тэмдэглэгээ хийгдээгүй, талбайн хувьд бага, ашиглалтаас гарсан хуучин эвдэрхий тоглоомоо хураан аваагүй, цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал хийгддэггүй;
- СӨХ-гүй байрнууд нь гадна орчны цэвэрлэгээ үйлчилгээ хангалтгүй, хог ихтэй;
- Хүүхдийн тоглоомын талбай хогийн цэгтэй ойрхон, машин замаас тусгаарлагдаагүй, орчны бохирдол ихтэй. Саравчинд согтуу, тэнэмэл иргэд цугларч оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулдаг;
- Гэрэлтүүлэг муу, камер хангалтгүй;
- Нийтийн эзэмшлийн зам талбай, хүүхдийн тоглоомын талбайн орчимд тэжээвэр амьтан (нохой)-ны ялгадас их буюу орчныг бохирдуулдаг;
- Тоглоомын талбайн 20-оос багагүй хувьд ногоон байгууламж байхгүй;
- Хүүхдийн тоглоомын талбайн гадаргуу нь зориулалтын бус буюу хөвсгөр, резин, элс, голын хайрга, хиймэл зүлэг зэргийг талбайн гадаргууд хэрэглээгүй;
- Хариуцах, хяналт тавих байгууллага тодорхой бус /ялангуяа гэр хорооллын дунд байрладаг тоглоомын талбайд/ Хүүхдийн тоглоомын талбайд мэдээлэх тэмдэг байхгүй зэрэг нь Монгол Улсын Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий стандарт MNS 6751:2019 шаардлага хангаагүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрч байна.

Иймд хүүхдийн тоглоомын талбайг эзэмшигч, хариуцагч нарт зохих шатны байгууллагуудад хүүхдийн тоглоомын талбайн /MNS6751:2019/ стандартын хэрэгжилтийг хангуулах, хүүхдийн тоглоомын талбайн ашиглалт, хяналт хамгаалал, сайжруулалт, хүүхдийн эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, илэрсэн зөрчлийг арилгуулах чиглэлээр хүүхдийн эрхийн улсын байцаагчийн зөвлөмж, шаардлагыг хүргүүлэн ажиллалаа.

Санал: Стандартын хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах.

13.Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 6890:2020

Хяналт тавих: Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн С/62 дугаар тушаалаар батлагдсан. 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон. Мэдээлэл байхгүй.

14.Сургалт хүмүүжлийн орчны эрүүл ахуйн шаардлага-MNS 6799:2019

Батлагдсан огноо. Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн С/58 дугаар тушаалаар батлагдсан. 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон.

Эрүүл мэндийн яам мэдээлэл байхгүй.

ДҮГНЭЛТ

Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн судалгааны (2020) дүнгээс үзвэл хүүхдийн эрх зөрчигдөх байдлыг хүүхдүүд тодорхойлохдоо эсэн мэнд амьдрах эрх гэж 24

хувь, хөгжих эрх гэж 29 хувь, хамгаалуулах эрх гэж 42 хувь, оролцох эрх гэж 5 хувь тус тус үзсэн байна. Хөгжих эрхийн хувьд сургуульд сурах, амарч тоглох, сувилалд явах зэрэгтэй холбоотой эрхүүд нэрлэгдсэн байна. Нийслэлийн хэмжээнд Хүүхдийн хөгжлийн чиглэлээр үйлчилгээ үзүүлэх ажлыг Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсүүд, Хүүхдийн урлан бүтээх төв, Нийслэлийн биеийн тамир спортын газар, Нийслэлийн боловсролын газар, Улаанбаатар хотын номын сан, Монголын хүүхдийн ордон зэрэг газрууд дангаар болон хамтран зохион байгуулж байгаа бөгөөд мөн Ерөнхий боловсролын сургууль бүр өөрийн орчинд хүүхдийн хөгжлийн чиглэлээр тодорхой ажлуудыг тогтмол хийж гүйцэтгэж байна.

2023 оны 01 дүгээр улирлын байдлаар нийт хөгжлийн үйлчилгээнд 43,958 хүүхэд хамрагдсанаас 25 төрлийн дугуйланд 2770 хүүхэд, спортын 25 төрлийн секцэд 2440 хүүхэд, 4 төрлийн хүүхдийн хөгжлийн үйлчилгээнд 560 хүүхэд, Ерөнхий боловсролын сургуулийн урлагийн наадамд 36,448 хүүхэд, “Би Монгол хүүхэд” ёс заншлын наадамд 1740 хүүхэд хамрагдсан. Гэвч энэ нь нийслэлийн хэмжээнд байгаа 5-17 насны нийт 359,301 хүүхэдтэй харьцуулахад 12,2 хувийг эзэлж байгаа бөгөөд хөгжлийн үйлчилгээ хүртээмжгүй байгааг илэрхийлж байна.

БШУЯ-аас авсан мэдээллээр 2022-2023 оны хичээлийн жилд улсын хэмжээнд сургууль дээрх урлаг, спорт болон бусад чиглэлээр нийт 688 секц дугуйлан ажиллаж байгаагийн 178 нийслэлд, 510 нь орон нутагт нийт 425252 хүүхэд хамруулан хичээллэж байгаа нь нийт 746405 ЕБС-ийн сурагчдын 57 хувь нь ямар нэгэн байдлаар сургууль дээрээ хөгжүүлэх дугуйланд хамрагдаж байгааг харуулж байна. Энэ нь орон нутагт хүүхэд хөгжүүлэх үйл ажиллагаа нь сургууль дээр төвлөрч сургуулиас гадуурх хөгжлийн үйлчилгээ хомс байгааг харуулж байна. Эсрэгээрээ нийслэлд сургууль дээрх хүүхэд хөгжлийн дугуйлангаас илүү хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж байгаа ч энэ нь нийт хүүхдийн дөнгөж 12 хувийг эзэлж байгаа нь хүүхэд хөгжлийн үйлчилгээний хүртээмж бага, төлбөртэй сургалтын төлбөр нь өндөр байгааг харуулж байна.

Тиймээс хүүхэд хөгжлийн үйлчилгээнд алслагдсан сум, дүүрэг хороодын хүүхэд ч хөгжих эрхээ эдлэн хамрагдах нөхцөл боломжоор хангах бодлогын зохицуулалт шаардлагатай байна.

Түүнчлэн, 2022-2023 оны хичээлийн жилд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ерөнхий боловсролын 859 сургуулиас сургууль дотроо спорт заалгүй 201 сургууль, сургууль дотроо урлагийн заалгүй 446 сургууль, гаднаа спортын талбай, тоглоомын талбайтай 73 сургууль байгаа нь сургуулийн орчинд хүүхэд бие махбод болон оюун санааны хувьд хөгжих эрхээ эдлэх боломж хангалтгүй байгааг харуулж байна.

“Хүүхэд хамгааллын тогтолцоо” 2021-д дурдсанаар бага насны хүүхдэд үзүүлэх хөгжлийн үйлчилгээний хүртээмж бага. Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд 3-5 хүртэл насны хүүхдийн 68 хувь нь нийслэлд, 57 хувь нь хөдөө орон нутагт хамрагдаж байгаа нөхцөл байдал одоо ч дээрдээгүй байгааг анхаарах шаардлагатай.

Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээр батлан хэрэгжиж буй стандартын хэрэгжилтэд хяналт тавих ажил хангалтгүй байгаа нь мэдээлэл цуглуулах явцад ажиглагдав. Нөгөөтээгүүр 2020, 2021 онд батлагдсан стандартын талаарх мэдлэг ойлголт хэрэгжүүлэгч болон хяналт тавигч талд хангалтгүй, стандартыг сурталчлан таниулах шатанд явж байна. Хүрээлэн буй орчны эрүүл аюулгүй байдлын хүрээнд анхаарал татсан стандартын хэрэгжилт нь Хүүхдийн тоглоомын талбайд тавих стандартын хэрэгжилт байлаа. Нийслэлийн хэмжээнд байгаа 973 тоглоомын талбайн талаас илүү буюу 56 хувь шаардлага хангахгүй болон солих шаардлагатай байгаа нь хүүхдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, хөгжих эрхийн хэрэгжилт хангалтгүй, хүүхдийн бие махбодод гэмтэл учруулж болзошгүй нөхцөл үүссэн байгааг харуулж байна. Түүнчлэн Хүүхдийн төв сувиллын чиг үүрэг нь зөвхөн Эрүүл мэндийн яамны харьяа эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх байтал байнгын асаргаатай, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд асрамж, халамжийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдал нь салбар хоорондын нарийн зохицуулалт шаардлагатай онцгой объектодгу байгааг анхаарч, тохирох зохицуулалтыг хийх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ:

- Сургалт, хөгжлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын багш, албан хаагчдыг мэргэжил, арга зүйн мэргэшүүлэх сургалтад тогтмол хамруулах;
- Асрамж, халамжийн төвүүдийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт шалгалтыг тогтмолжуулах,
- Уяач нь хурдан морь унаач болон “уяачийн туслах” хүүхэд, эцэг, эхтэй нь гурван талт гэрээг заавал байгуулдаг байх;
- Хурдан морь унаач хүүхэд болон “уяачийн туслах” хүүхдийн жишиг цалинг насны ангиллаар ялган тодорхой тогтоох,
- Өвлийн цагт үсэргээ, сунгаа, морины ажлыг хүүхдээр хийлгүүлж байгаа эсэхийг хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох; /Засгийн газрын 57 дугаар захирамж хэрэгжиж байгаа тус захирамжийн хэрэгжилтийг хангах асуудал дээр анхаарах шаардлагатай/
- Унаач хүүхдийн хамгаалах хэрэгслийн чанарыг сайжруулах талаар холбогдох стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах, унаач хүүхэд бүрэн хамгаалах хэрэгсэлтэй барианд ирсэн эсэх шалгуурыг Үндэсний их баяр наадмын морин уралдааны болон Монголын хурдан морины уралдааны дүрэмд тусгах;
- Эрсдэлт нөхцөлд буй, асрамж халамжийн төвд байгаа байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд рүү чиглэсэн цогц үйлчилгээг бий болгох.
- Хүүхдийн төв сувиллын чиг үүргийг тодорхой болгох, Эрүүл мэндийн яам болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай уялдуулан зохицуулах,
- Хүүхэд харах үйлчилгээг нарийн мэргэжлийн үйлчилгээ шаардлагатай хүүхдүүд рүү чиглэсэн хувилбарт үйлчилгээ болгох,
- Шаардлага хангахгүй ЕБС-ийн дотуур байрын жагсаалтыг гаргаж үе шаттай стандартын шаардлагад нийцүүлэн шинэчлэх төлөвлөгөө гарган хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх;
- Дотуур байрын гадна болон дотор орчны аюулгүй байдал, хоол хүнс, цэвэр усны хэрэглээнд тогтмол хяналт тавих үндэсний механизмыг бий болгох;
- Дотуур байр дахь хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсөв, хөрөнгийг заавал тусгадаг болох;
- Дотуур байрын багш, туслах, эмч, сэтгэл зүйч, жижүүр, үйлчилгээний ажилтны орон тоог дотуур байрын хүчин чадал, суралцагчдын тоотой уялдуулан баталж, цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгаагаар хангах арга хэмжээг төсөвт тусган хэрэгжүүлэх;
- Дотуур байрын багш болон ажилчдыг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох хамтын ажиллагааг сайжруулах, хүний эрхийн боловсрол олгох, орон нутгийн холбогдох эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог нэмэгдүүлэн хүүхэд хамгааллын бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх,
- Сургуулийн автобусны хүртээмжийг нэмэгдүүлэх, тавих хяналтыг сайжруулах,
- Улсын хэмжээнд сургууль орчмын гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх
- Сургууль орчмын зорчих хэсгийн цардмал замын хэсгийг нэмэгдүүлэх
- Биеийн тамирын талбайн аюулгүй байдлыг хангах
- Цахилгаан, ил монтаж зэрэг нь эрсдэлтэй сургууль их байгаа тул засаж, сайжруулах
- Сургууль орчмын авто замын явган зорчигч зорчих хэсгийн тэмдэг тэмдэглэгээг тодруулах, шинээр хийх шаардлагатай
- Сургалтын орчны камерын тоог нэмэгдүүлэх, камержуулах
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиар бий болгосон хохирогч хамгааллын бүтэц, тогтолцооны зураглалыг харилцан уялдаатай гаргаж, байгууллагуудын чиг үүргийн давхцалыг арилгаж, уялдаа холбоог хангах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх;
- Хамтарсан багийг чадавхжуулах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих, үүргийг хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хариуцуулах, сум, багуудад гэр бүл, хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтны орон тоог тусгайлан бий болгох, эсхүл нийгмийн ажилтны орон

тоог хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлэх;

- Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх, сайн дурын хөтөлбөрийг үр дүнтэй эхлүүлэх, төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх;
- Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйл ажиллагааны стандартыг батлан гаргах, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийг хуулиар тогтоосон тус бүрийн чиг үүргийн дагуу ажиллуулах;
- Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнууд ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, урамшуулал хөшүүргийг бий болгох,
- Түр хамгаалах байрыг холбогдох хууль, журамд заасан нууцлалын шаардлага хангагдаагүй байгаад анхаарах
- Хүүхдийн тоглоомын талбайн ашиглалт, эдэлгээнд тогтмол хяналт тавих
- Хариуцах, хяналт тавих байгууллагыг тодорхой болгох,
- Бүх стандартад тавих хяналтын дагуу тайлан мэдээг тогтмол хүлээн авч, нэгтгэж, мэдээлэл солилцох салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах.
- Нийслэлийн хэмжээнд хүүхдийн хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуул байгаа 2 ордон ажиллаж байгаа боловч энэ нь нийт хүүхдийн хөгжих хэрэгцээний хүртээмжийг хангаж чадахгүй байгаа учир дээрх 2 байгууллагаар дамжуулан буюу цогц удирдгийн системийг бий болгон дүүрэг бүрд салбар хөгжлийн ордуудыг бий болгох,
- Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг түшиглэсэн хөгжлийн орчин бий болгох.

---oO---

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсад төвтэй төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрууд ¹

	Улс	Салбар төлөөлөгчийн газар	Салбар төлөөлөгчийн газрын зорилго	Салбар төлөөлөгчийн газрын хаяг	Салбар төлөөлөгчийн газрын холбогдох утас
	2	3	4	5	6
1	Олон Улсын байгууллага	НҮБ-ын дэргэдэх НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF)	Монгол Улс дахь НҮБ нь ардчилсан засаглал, хүний эрх, нийгэм, эдийн засгийн хөгжил, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, улмаар дасан зохицох, байгаль орчныг хамгаалах зэрэг олон салбарыг хамарсан хөгжилд хувь нэмэр оруулдаг. НҮБ-ын Хүүхдийн Сан нь дэлхийн 190 орон тэдгээрийн дотор Монголд хүүхдийн эрхийг хангах, хамгаалах үйлсэд тэргүүлэгч дэлхий хэмжээний байгууллага юм.	Монгол дахь Нэгдсэн Үндэстний Байгууллага Нэгдсэн Үндэстний гудамж-14, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар 14201	Утас: (+976) 11-312217, (+976) 11-312185 ulaanbaatar@unicef.org unrcomongolia@un.org
2	Олон Улсын байгууллага	НҮБ-ын дэргэдэх НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP)			
3	Олон Улсын байгууллага	НҮБ-ын дэргэдэх НҮБ-ын Хүн Амын Сан (UNFPA)			
4	Олон Улсын байгууллага	НҮБ-ын дэргэдэх Дэлхийн Хүнсний Байгууллага (WFP)			
5	Олон Улсын байгууллага	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага	Хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ явуулдаг.	ЭМЯ, Засгийн газрын VIII байр, Олимпын гудамж-2, Улаанбаатар хот	Утас: +976 11 327870 +976 11 322430
6	Олон Улсын байгууллага	Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)	ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар нь 53 дахь төлөөлөгчийн газар бөгөөд 1997 онд байгуулагдсан. Төлөөлөгчийн газар нь тухайн орны газар нутагт байрлан ажилладгийн хувьд тухайн орны нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлон, засгийн газар болон холбогдох байгууллагуудтай харилцан санал солилцсоны эцэст тодорхой хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулах хэлбэрээр ажилладаг. Үүнээс гадна төслийн үр дүн болон ач холбогдлыг дээшлүүлэх үүднээс тухайн орны засгийн газар, бусад олон улсын байгууллагууд болон ижил	ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар Бодь Цамхаг 7-р давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар Төв шуудан 682, Улаанбаатар 211213, МОНГОЛ	+976-11-325939

			төрлийн үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудтай хамтран ажиллах чиглэлийг баримталдаг		
Эх сурвалж: https://immigration.gov.mn/mn/trijn-bus/#					
7	Олон Улсын Байгууллага	"Дэлхийн зөн" World Vision	"Дэлхийн Зөн" ОУБ нь хөгжил, нөлөөлөл, гамшгийн менежментийн чиглэлээр төсөл, хөтөлбөрөөрөө дамжуулан нийгмийн эрсдэлт нөхцөлд амьдарч буй хүүхэд, гэр бүлийн сайн сайхан байдлыг хангахын төлөө ажилладаг олон улсын хүмүүнлэгийн байгууллага.	Улаанбаатар хот, БЗД, 15-р хороо, 13-р хороолол, Энхтайвны өргөн чөлөө-49, Соманг плаза, 4-р давхарт Орон нутаг салбарын Факс: 70155322	Утас :94031340, 70155323 mongolia@wvi.org
8	Олон Улсын Байгууллага	Олон улсын Адвентист Хөгжил ба Туслалцааны Байгууллага "АДРА"	"АДРА" ОУБ нь 1994 оноос хойш Монгол Улсад тасралтгүй үйл ажиллагаа явуулж, үндсэн дөрвөн чиглэл болох хүнсний аюулгүй байдал, эрүүл мэнд, боловсрол болон гамшгийн менежментийн хүрээнд Эдийн засгийн тогтвортой хөгжилд туслах, эрүүл мэнд, боловсролын салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, нийгмийн хөгжилд зориулсан төрөл бүрийн төсөл хэрэгжүүлэх, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур иргэдэд буцалтгүй тусламж үзүүлэх ажил зохион байгуулж ажиллах.	Улаанбаатар хот, БЗД, 1-р хороо, Токиогийн гудамж, Палаzzo цамхаг, 8-401 тоот	Утас: 11-450732, 11-450734, 88007338 bona@adra.org.mn
9	Олон Улсын Байгууллага	Швейцарын хөгжлийн агентлаг	2018-2021 онуудад Монгол Улсад хэрэгжүүлэх Швейцарын Хамтын ажиллагааны стратеги нь - Хөдөө аж ахуй, хүнсний аюулгүй байдал, - Мэргэжлийн боловсрол сургалт болон - Засаглал гэсэн гурван үндсэн чиглэлд үйл ажиллагаагаа чиглүүлсэн.	Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Аризона төв, 4 давхар	Утас: 11-329365 Mongolia.secretary@savechildren.org
Төрийн бус байгууллагууд					
	Америкийн Нэгдсэн Улс	Денан төсөл	Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.		
10	Америкийн Нэгдсэн Улс	Дээрэт олон улсын энэрлийн байгууллага	Хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагад тусламж дэмжлэг үзүүлэх, салбарт үзүүлэх тусламжийн хүрээнд боловсрол, эрүүл мэнд, скаутын хөдөлгөөн, барилга хот байгуулалт, төлөвлөлт, банк, бизнесийн салбарт төсөл хэрэгжүүлдэг.	Улаанбаатар хот, БЗД, 7-р хороо, Токиогийн гудамж, 6-р барилга, Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм	Утас: 99110247, 99113246 463001, Факс: 463019 PurevjargalDo@churchofjesuschrist.org
11	Холбооны Бүгд	"Хэлп Интернэйшнл" Help International	"ХЕЛП Интернэйшнл" нь Монгол Улсад 1994 оноос хойш олон нийтийн хүмүүнлэгийн тусламжийн	Улаанбаатар хот, БЗД, 2-р хороо, 1А	Утас: 11-455463, 88153888 info@helpmongolia.org

	Найрамдах Герман Улс		үйлчилгээ үзүүлж, архинд донтсон болон донтолтод өртөж болзошгүй хүмүүс, нийгмийн эмзэг бүлгийн орон гэргүй хүмүүс, хараа хяналтгүй хүүхдүүдэд муу зуршлаас нь салгах, эргэн нийгэмшихэд нь туслан нийтийн халамж үйлчилгээ үзүүлж, нийгэмд сайнаар нөлөөлж, үлгэр дуурайл үзүүлэх зорилготой.	хэсэг, цэргийн хотхон аос-11 тоот	
12	Америкийн Нэгдсэн Улс	"Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн"	"Бүгд Найрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн" (БНОУХ) нь Монгол Улсад 1992 оноос үйл ажиллагаа хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд Монгол Улсад парламентын тогтолцоог хөгжүүлэх, улс төрийн намуудыг чадавхжуулах мөн сонгуулийн тогтолцоог сайжруулах, иргэдийг шийдвэр гаргагчдад дуу хоолойгоо ажил хэрэгч байдлаар хүргэх, улс төрийн үйл явц дахь оролцоогоо нэмэгдүүлэх, хараат бус чанартай мэдээ, мэдээллийг авахад нь дэмжлэг үзүүлэхийн тулд дотоодын мэргэшсэн иргэний нийгмийн байгууллагуудыг дэмжин ажиллах.	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Амбассадор оффис 15/а5 тоот	Утас: 77015161, 99059276
13	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	Гонконг хотод төвтэй "Мандах Нар"	Боловсрол, эрүүл мэндийн салбарт сайн санааны тусламж үзүүлэх, тусгай боловсролын сургалт зохион байгуулах	Улаанбаатар хот, БГД, 19 хороо, Мандах наран төв, 210 тоот	Утас: 98126376, 91917388, 11366376
14	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	"Конрад-Аденауэр-Сан"	ХБНГУ-д төвтэй "Конрад-Аденауэр-Сан" нь Монгол Улсад 1993 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна. Хөгжлийн тусламж үзүүлэх замаар олон улсын хамтын ажиллагааг дэмжих, иргэдэд нийгэм, улс төрийн боловсрол олгох, судалгаа явуулах, оюутнуудад тэтгэлэг олгох зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Жамьяан гүний гудамж, Меру тауер 8 давхар 14210 тоот	Утас: 11-319135, 11-319136 99084485 nfo.mongolia@kas.de
15	Австралийн Холбооны Улс	"Сайн Хөрш нийгэмлэг" Good Neighbor Society	Монгол Улсад 1993 оноос хойш тасралтгүй үйл ажиллагаа явуулж. Олон нийтэд хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, хүмүүнлэгийн тусламж хэрэгжүүлэх зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байгаа Австрали Улсын Х.А.Д.А олон улсын байгууллагын салбар төлөөлөгчийн газар юм.	Улаанбаатар хот, ЧД, 16-р хороо, Согоотын 63-р гудамж, 851 тоот	Г.Алтантуяа 88229611
16	Бүгд Найрамдах Солонгос Улс	"FHI MONGOLIA"	1993 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба Төв байгууллагын зорилго чиг үүргийг Монгол Улсын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулж иргэдийн амьдралын түвшинг сайжруулах, эмзэг бүлгийн хүүхэд залуус, гэр бүлүүд	Улаанбаатар хот. БЗД, 4 хороо, Доржийн гудамж Цэргийн хотхон 64-4 тоот	Утас 88577357, 89867901 fhim949@gmail.com

			цаашид өөрсдийн хүч, бололцоогоор хөгжихөд сургах, амьдралд хөлөө олоход дэмжих зорилготой.		
17	Швейцарын Хаант Улс	Клайм "CLAIM"	Төсвийн хүрээнд хамтран ажилладаг байгууллагуудын тусламжтайгаар хөгжлийн бэрхшээлтэй иргэд, зорилгод бүлгийн иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, сургууль завсардсан зэрэг зайлшгүй тусламж хэрэгтэй хүмүүст хүмүүнлэгийн тусламж үзүүлэх.	Улаанбаатар хот, БЗД, 1-р хороо, 23-37 тоот	Утас: 11-463693, 99112547 claimngo16@gmail.com
18	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	"Альфа коммюнитиз"	1994 онд Монгол Улсын үйл ажиллагаа тасралтгүй явуулж. Хүүхдийг үл хайхрах, хүчирхийлэх, мөлжих явдлаас сэргийлж халамж, хамгаалал нэн шаардлагатай, өөрийн гэр бүлд өсөж хүмүүжих боломжгүй болсон хүүхдэд гэр бүл түүнтэй дүйцэхүйц орчин бий болгож хүүхдийн эрхийг хангаж ажиллах.	Улаанбаатар хот, ХУД, 1-р хороо, Эрэлийн 36-р байр, 1-4 тоот	Утас: 99663689 www.alphacommunities.org
19	Америкийн Нэгдсэн Улс	"Жей Си Эс" /JCS/	Монгол Улсад 1993 оноос хойш үйл ажиллагаа явуулж. Төв, орон нутгийн эдийн засгийн хөгжил, түүний дотор хөдөө аж ахуйн хөгжлийг хурдасгах, байгаль орчны бохирдлыг багасгах, хүн амын боловсрол, эрүүл мэндийг хамгаалах, тэр дундаа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст халамж үзүүлэх, гамшигт нэрвэгдсэн иргэдэд тусламж үзүүлэх чиглэлээр төсөл хэрэгжүүлэх, мэргэжлийн сайн дурынхныг ажиллуулах	Улаанбаатар хот, БЗД, 3-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 50 дугаар байр 3 давхарт	Утас: 11-452465, 80119218 journeywithjcs@jvsintl.org
20	Норвегийн Хаант Улс	"НЛМ" Норвегийн тусламжийн байгууллага	Норвегийн Хаант Улсад төвтэй "НЛМ" ТББ нь 1994 онд Монгол Улсад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч. Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран иргэдийн амьдралын түвшинг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, хүүхдийн эрх болон хүүхэд хамгааллын чиглэлээр нийгмийн салбарт хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Скай плаза төв, 4 давхарт	Утас: 70002300, 99096751
21	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Азийн соёл хөгжлийн институт"	Монгол Улсын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах, Хоёр улсын хооронд харилцан ашигтай ажиллах, боловсрол, ШУ-ны салбарт тодорхой төсөл хэрэгжүүлэх, дүрмийн зорилгодоо нийцсэн аж ахуйн үйл ажиллагаа явуулах.	Улаанбаатар хот, ХУД, 20-р хороо, Шаравын гудамж, 20 дугаар байр, 1 давхарт	Утас: 76001040, 99254650
22	Америкийн Нэгдсэн Улс	"Азийн Сан"	1993 онд Монгол Улсад үйл ажиллагаа тасралтгүй явуулж, засаглалыг дэмжих, байгаль орчныг хамгаалах, төрийн үйлчилгээг сайжруулах, эмэгтэйчүүдийг чадавхжуулах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх,	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Ориент Плаза, 3 давхарт	Утас: 11-330524, 11-311497 www.asiafoundation.org

			боловсролыг дэмжих чиглэлээр төв болон орон нутгийн засаг захиргаа, академи, иргэний нийгмийн байгууллага, иргэд болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах.		
23	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс	“Кристина Нобелийн хүүхдийн сан”	1997 оноос тасралтгүй үйл ажиллагаа явуулж, Эрх нь зөрчигдсөн хүүхдүүдэд нийгэм сэтгэлзүй болон эрүүл мэндийн тусламж үзүүлэхээс гадна, хүүхдийн сурч боловсрох, хөгжих хэрэгцээг тасралтгүй ханган ажиллах замаар хүүхдийг ирээдүйдээ итгэлтэй, сэтгэлзүйн тогтвортой, бие даасан хүн болгон төлөвшүүлэх. Зорилтод бүлгийн хүүхэд, залуучуудыг дэмжих, хөгжүүлэх, хамгаалах, бие даасан хувь хүн бий болгоход дэмжлэг үзүүлэх зорилготой хүмүүнлэгийн байгууллага.	Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Жигжиджавын гудамж, КНХС, 1 давхарт.	Утас: 11-315611, 89081228
24	Швейцарийн Холбооны Улс	Олон Улсын “Дэлхийн байгаль хамгаалах сан”	Дэлхийн байгаль хамгаалах сангаас Монгол Улсад хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байгаль хамгаалах, байгаль орчны талаар хүмүүст боловсрол, сургалт, сурталчилгааны төслүүдийг хэрэгжүүлэх, тэдгээрийг дэмжиж, зохион байгуулах, санхүүжүүлэх эх үүсвэр хайж олох	Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, Амарын гудамж, Интер байр 4 давхарт	Утас 318447, 98892362
25	Америкийн Нэгдсэн Улс	“Англи хэлний институт” /English Language institute/	Ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш нарыг бэлтгэх, зуны сургалт явуулах чиглэлээр дэмжлэг тусалцаа үзүүлэх.	Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Матрикс төв, 311 тоот	Утас: 310662, 99150011
26	Бүгд Найрамдах Итали Улс	“Раул Фолеругийн анд нөхдийн холбоо” /АИФО/	Монгол Улсад 1996 оноос хойш Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэм, хамт олонд тулгуурлан сэргээн засах төслийн хүрээнд сургалт, эмчилгээ, протез ортопедийн үйлдвэрлэл болон бусад жижиг төслүүдийг санхүүгээр дэмжих	Улаанбаатар хот, БЗД, 4-р хороо, Американ дэнж, 44-6- 141 тоот	Утас: 70153058, 99095302, 99027408 mongoliacr@mongol.net
27	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	“Ханнс Зайделийн сан”	1993 оноос эхлэн Монгол Улсад өөрийн суурин төлөөлөгчөө томилон ажиллуулж буй ХБНГУ-ын улс төрийн сан юм. Ардчилсан төрийн болон нийгмийн байгууллыг хөгжүүлэх, шилжилтийн үйл явцыг нийгмийн баримжаат зах зээлийн эдийн засгийн тогтолцоо хүртэл даган ажиглах, тусалж дэмжих.	Улаанбаатар хот, СБД, 6-р хороо, Сүхбаатарын гудамж, 11/1 тоот	Утас: 321294, 327350
28	Бүгд Найрамдах	"Ивээлт Гараг"	Иргэдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, тэдгээрийг зах зээлийн харилцаанд суралцах, мэргэжлийн боловсрол олгох, хүнсний ногоо тарихад нь бодит тусалцаа	Багануур дүүрэг, 3-р хороо, Нацагдоржийн	Утас: 91143577, 0121-21997

	Солонгос Улс		үзүүлэх болон нэн ядуу иргэдэд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх	гудамж 53-р байр 2-р давхарт	
29	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	“Фридрих эбэртийн сан”	Нийгэм, эдийн засаг, улс төрийн холбогдолтой судалгааны ажил, судалгааг дэмжих, Монгол Улсын гадаад харилцаа, улс төр мэдээллийн солилцоог дэмжих, насанд хүрэгчдийг боловсролоор хангах, бусад олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах.	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Ланд марк тауэр, 901 тоот	Утас:11-312892, 11-312889, 94110833 info@fes-mongolia.org
30	Ватикан Улсад	“Ватиканы католик шашны байгууллага”	Хүмүүнлэгийн тусламж үзүүлэх хүрээнд: байгалийн болон гэнэтийн гамшгийн үед туслалцаа үзүүлэх, хүүхэд, залуучууд, өндөр настны, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн халамжийн төв, оюутны байр, боловсролын хөтөлбөрийн хүрээнд, цэцэрлэг, бага, дунд, ахлах сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулах, оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, номын сан ажиллуулах, эрүүл мэндийн хүрээнд: эмнэлгийн анхан шатны үзлэг, үйлчилгээ үзүүлэх, хөдөө аж ахуйн хөтөлбөрийн хүрээнд газар тариаланг дэмжих	Улаанбаатар хот, БЗД, 18-р хороо, Ватиканы төлөөлөгчийн газар, POBox 694 UB ccmvatican@magicnet.mn	Утас:11-458825, 11-452575
31	Америкийн Нэгдсэн Улс	“Холт” Интернэшнл	Хүнд нөхцөлд байгаа өнчин, хөгжлийн бэрхшээлтэй, хараа хяналтгүй хүүхдүүдийн эрх ашгийг хамгаалах, улсын асрамжийн газар, улс хооронд хүүхэд үрчлэх асуудлаар төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах.	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, “Монгол ТВ” цамхаг 9 давхарт 905 тоот	Утас: 96061051, 99061051, 96031051
32	Швейцарын Холбооны Улс	“Олон Улсын тахь групп”	Тахийг эх нутагт нь чөлөөт бэлчээрт зэрлэгшүүлэн өсгөхөөс гадна байгаль экологийн судалгаа явуулж зэрлэг амьтадын амьдрах орчныг иж бүрнээр хангах	Улаанбаатар хот, ЧД, Нет капитал оффис, 3 давхар	Утас: 77112031 99889762 www.takhi.org
33	Бүгд Найрамдах Финланд Улс	“Флом”	"Флом" СТГ нь 2001 оноос Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бөгөөд Финланд Улсын Засгийн газрын болон олон улсын бусад байгууллага, хувь хүмүүсийн өгсөн хандив, санхүүгийн дэмжлэгтэйгээр Монгол Улсын хөгжилд иргэний нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний чадавхыг бэхжүүлэх, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн бусад салбарт төсөл, хөтөлбөрөөр дамжуулан хөгжлийн болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа явуулах.	Улаанбаатар хот, СБД, Бага тойруу, НҮБ гудамж 21/1, 38-р байр, 1 тоот	Утас:11-326101, 98806101

34	Америкийн Нэгдсэн Улс	“Монголиан Азия Рийч”	Эмч сувилагч, эмнэлгийн бусад ажилтныг анагаах ухааны ба нөхөн үржихүйн сургалтын хөтөлбөрт хамруулж, эмнэлгийн үйлчилгээг гадаад улсад үзүүлэх ажлыг зохион байгуулах, анагаах ухааны чиглэлээр суралцагсдад төлбөрийн туслалцаа үзүүлэх тахир дутуугийн байдлаас болоод сургууль завсардсан хүүхдүүдийг анхан шатны болон мэргэжлийн сургалтад хамруулах, асрамжийн төв ажиллуулах зорилготой.	Улаанбаатар хот, БЗД, 22-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, 120 тоот	Утас: 11-461673, 70172008, 99283370
35	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Жи си эс” /Global Civic Sharing/	Монгол Улсад 2002 оноос эхлэн хөдөө, орон нутагт нийгэм эдийн засгийн байдлыг сайжруулах, жижиг аж ахуйг хөгжүүлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, зээл олгох, бусад сургалтад хамруулах, ижил төстэй байгууллагуудтай хамтрах ажиллах.	Улаанбаатар, СХД, 21-р хороо, Жаргалант тосгон, Рашаант өртөө, Ухны ам 1-1 тоот	Утас: 90116046 gcsmongol@gcs.or.kr
36	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Өрнө Дорнын Соёл хөгжлийн харилцааны зөвлөл”	Соёл, анагаах ухааны харилцаа, боловсролыг дэмжих, хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх, хамтын үйл ажиллагааны хүрээнд улс хоорондын солилцооны хөтөлбөрүүдэд өвчтөн, эмч, эмнэлгийн ажилтан, багш, оюутан, бусад мэргэжилтнүүдийг хамруулах, өнчин болон тахир дутуу хүмүүст тусламж үзүүлэх	Улаанбаатар хот, БЗД, 7-р хороо, 15-р хороолол Их тойруу Дэнжийн 8	Утас: 94074077, 88337947 eccmongol@gmail.com
37	Америкийн Нэгдсэн Улс	“Байгаль, зэрлэг амьтныг хамгаалах нийгэмлэг”	Монгол Улсад байгалийн унаган төрх, зэрлэг амьтад болон бэлчээрийг хадгалан хамгаалах замаар Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болох зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах, байгаль орчны судалгаа шинжилгээ хийх чиглэлээр Монгол Улсын Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллагууд хөгжлийн агентлагууд, ШУА, их дээд сургуулиуд болон орон нутаг болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, Бага тойруу, Сан бизнес центр, 2 давхарт, 201 тоот	Утас: 70009089, 96461016
38	Нидерландын Хаант Улс	“Монголын хүүхдийн сан”	Орон гэргүй, гудамжны хүүхдүүдийг орон байраар хангах, тэдний оюун ухаан болон бие махбодын хэрэгцээг хангаж, анхаарал халамж тавих, эмзэг бүлгийн айл өрхийн хүүхдүүдийг цаашид гудамжны амьдралд оруулахгүйн тулд туслалцаа үзүүлэх, адил зорилго бүхий байгууллагуудтай хамтран ажиллах зорилготой.	БЗД, 4-р хороо, Американ дэнж 44/2-р байр, 6 тоот	Утас: 70004494, 89026442
39	Америкийн Нэгдсэн	“Америк Монгол судлалын төв”	Монгол-Америкийн эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд,	Улаанбаатар хот, СБД, 2-р хороо	Утас: 99170042, 70110486, 77100486

	Улс		эрдэмтдийг дэмжсэн хөтөлбөр хэрэгжүүлэх, уг хөтөлбөрийн хүрээнд эрдэмтэд судлаачдыг практик зохицуулалтаар хангах, мэдээллээр зуучлах, хурал, чуулган, уулзалт зохион байгуулах, номын сангаар үйлчлэх.	Нацагдоржийн номын сан зүүн хаалга.	info@mongoliacenter.org
40	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Дэлхийн сайн санаат хүмүүс” (Good people Mongolia)	Соёл, боловсрол, шинжлэх ухаан, эрүүл мэндийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, эмзэг бүлгийн хүүхэд залуучуудад боловсрол, мэргэжил олгох, дадлагажуулах, мэргэжилтэн бэлтгэх, асрамжийн газар байгуулах.	Улаанбаатар хот, БЗД, 26-р хороо 830-р байр 2 тоот	Утас: 89897631
41	Бүгд Найрамдах Хятад Ард Улс Тайвань	"Тайваний хүүхэд гэр бүлийг дэмжих сан"	Амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой өрхийн эдийн засгийн чадавхыг сайжруулах, тэдгээр өрхийн хүүхдүүдийн эсэн мэнд амьдрах эрхийг хамгаалах, сургууль завсардахгүй суралцуулах зорилготой.	Улаанбаатар хот, БЗД, 42-р хороо, Аман хуур 2 хотхон, 40-202 тоот	Утас: 11-330776 Info@tfcf.org.mn
42	Бүгд Найрамдах Франц Улс	“AVSF-CICDA” Хил хязгааргүй малын эмч нар ба агрономчид	Малчдын хоршооллыг бий болгож, тэдний амьжиргааны баталгааг хангах, мал аж ахуйн салбарт ажиллаж буй малын эмч, мэргэжилтнүүдийн мэргэшлийг дээшлүүлэх зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 3-р хороо, 5-р хороолол Сөүлийн гудамж 7/1-тоот “MGG” properties 402, 403 тоот	Утас: 330043, 96047877 G.brunet@avsf.org t.luvsandorj@avsf.org 88022056 Эрдэнэсүрэн Баянхонгор, Баянхонгор сум
43	Бүгд Найрамдах Хятад Ард Улс Тайвань	“Ариун сэтгэлт гэгээн Марийн бүлгэм” /Си Ай Си Эм/	Англи хэл заах, сургалтын тэтгэлэг олгох, хүүхдүүдийн ирээдүйн боловсролын төлөө хүүхдийн цэцэрлэг, боловсролын бусад байгууллагад тусламж үзүүлэх, судалгааны төвөөрөө дамжуулан Монголын түүх соёлыг дэмжих, хараа хяналтгүй хүүхдүүдэд зориулсан төв ажиллуулах, сургалт зохион байгуулах, орон нутгийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 6-р хороо, Их Сургуулийн гудамж, 11-р байр /Урлан бүтээх төвийн зүүн талд 4-р дэлгүүрийн хойд талд/	Утас: 11-354461, 11-354462, 11-354464 cicmmongolia@yahoo.com
44	Америкийн Нэгдсэн Улс	“Дэлхийн евангелийн эвслийн сайн мэдээнүүд” /WEGO/	Хүүхдийн эрх ашгийг хангах үүднээс асрамжийн газрын хүүхдүүдэд ерөнхий боловсролын сургууль, сувилал, амралтын газар ажиллуулах тэдний боловсрол, эрүүл мэндэд тусламж үзүүлэх, сувилал, амралтын газар байгуулахад нь туслах, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд зориулан тэдний эрх ашгийг хамгаалах үүднээс түр байрлах байрыг бий болгох, тусгай хөтөлбөр зохион байгуулах, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх зорилготой.	Улаанбаатар хот, БЗД, 20-р хороо, Гачуурт Бага Хуандай, Могойт дэнж 36 А тоот	Утас: 88007511, 98994832 shinenaidvar2017@yahoo.com

45	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Сайн Хөрш" "Good neighbors"	Улаанбаатар хот, орон нутагийн хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол, эрүүл мэнд, ундны ус, орлого нэмэгдүүлэх, сүлжээ хамтын ажиллагаа болон хүүхдийн эрх хамгаалал хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах, НҮБ-д зөвлөх эрхтэй, хөгжлийн төлөөх хүмүүнлэгийн байгууллага.	Улаанбаатар хот, БГД, 6-р хороо, Кёкшү цамхаг, 769 тоот	Утас: 70144155, 70144133
46	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Ногоон Ази сүлжээ" "Green Asia Network"	Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, хүлэмжийн хий, цөлжилт, шар шороон шуургыг буруулах төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.	Улаанбаатар хот, СБД, 16-р хороо, 14061 Дамбадаржаа гудамж, 112/1 тоот	Утас: 70167770, 70111433 greenasimn@gmail.com
47	Бүгд Найрамдах Чех Улс	"Каритас Чех"	Монгол Улсын боловсрол, нийгэм, эрүүл мэндийн салбар болон хөдөө орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.	Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Дельта төв, 503 тоот	Утас: 70135899, 70135999 ccr.mongolia
48	Бүгд Найрамдах Итали Улс	"I Fiori Semplici Onlus"	Хараа хяналтгүй болон сургуулиас завсардсан хүүхдүүдийг орон байраар хангах, сурах боломж олгох, тэдэнд мэргэжил эзэмшүүлэх, улс хооронд хүүхэд үрчлэх чиглэлээр ажиллах	Улаанбаатар хот, ЧД, 6-р хороолол, 11/3 ifioridimongolia@gmail.com	Утас: 317564
49	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Солонгос-Монголын харилцааг дэмжих нийгэмлэг" "Komex Mongolia"	Агаарын бохирдол, цөлжилтийн эсрэг, газар, тариалангийн чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх. Хоёр орны харилцаа, холбоо, соёл боловсролын салбарыг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, бусад ТББ-уудтай хамтран ажиллах зорилготой.	Улаанбаатар хот, СХД, 33-р хороо, Тахилтын ам мод үржүүлгийн талбай.	Утас: 91951666, 70140103, 89119119
50	Америкийн Нэгдсэн Улс	"Samaritan's Purse"	Монгол Улс дахь эмнэлэг, эрүүл мэндийн салбарын байгууллагуудад тоног төхөөрөмжийн туслалцаа үзүүлэх, хүүхдийн зүрх төсөл хэрэгжүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн эцэг, эх, эмнэлгийн ажилтан албан хаагчдад анагаах болон нөхөн сэргээх сургалт явуулж, зөвлөгөө өгөх, ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах	Улаанбаатар хот, БЗД, 15-р хороо, 13-р хороолол, "Соманг плаза" төв 5 давхар 505 тоот	Утас:70151600, 453018
51	Америкийн Нэгдсэн Улс	"Дэ Нэйче Консерванси" /The Nature Conservancy/	Монгол Улс дахь амьд биетийн олон янз байдлын төлөөлөл болох байгаль, амьтан, ургамлын бүлгэмдлийг тэдгээрийг оршин тогтноход чухал ач холбогдол бүхий эх газар, усан орчныг хамгаалах, Монгол Улсын Засгийн газар болон эрх ашиг нь хөндөгдөж болох	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, DHL оффис, 2 давхарт, 201 тоот	Утас: 70118525, 70118526 nature.org
52	Бүгд Найрамдах Итали Улс	"Амичи Ди Дон Боско"	Эмзэг бүлгийн иргэд, хүүхэд хамгаалал, хүмүүнлэгийн чиглэлээр хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх, улс хооронд	Улаанбаатар хот, ЧД, 3-р хороо, Peace tower, 1408 тоот	Утас: 70117800

			хүүхэд үрчлэх асуудлаар төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллах зорилготой.		
53	Америкийн Нэгдсэн Улс	“Ворлд лернинг” /World Learning/	Соёл судлалын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд туслалцаа дэмжлэг үзүүлэх, Монгол хэл, Монголын түүх соёлын талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, хөтөлбөрт оролцогчдод Монгол орны түүх, соёлын дурсгалт газруудаар аялах, тэдгээрийг судлах боломжоор хангах, Монгол Улсын түүх, соёл, ахуй амьдрал, орчин экологи судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хувь хүн, албан газар, байгууллагатай хамтран ажиллах.	Улаанбаатар хот, БЗД, 16-р хороо, Дандар баатрын гудамж, ЭМЯ, 16 В-3	Утас: 11-452138
54	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Сэлвэшн арми” The Salvation army	Нийгмийн халамжийн чиглэлээр өндөр настан болон хүүхдийн асрамжийн төв, өдөр өнжүүлэх ажиллуулах, хоол хүнс, тусламжийн бараа түгээх, ДОХ-оос урьдчилан сэргийлэх, ийм өвчтэй хүмүүст туслах, боловсрол, соёлын чиглэлээр сургалт семинар зохион байгуулах, газар тариалан эрхлэхэд иргэдэд дэмжлэг үзүүлэх зорилготой.	Улаанбаатар хот, БЗД, 22-р хороо, Цайз техникийн зах өгсөх замд, замын баруун талд	Утас:96653685, 96647261,91997268 salvation2020mgl@gmail.com
55	Япон Улс	“Хүүхдийг ивээх сан”	Хүүхдийг Ивээх Сан /ХИС/ нь 1994 оноос Монгол Улсад үйл ажиллагаа явуулж, боловсрол, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал болон хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх чиглэлээр ажиллах.	Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Аризона төв, 4 давхар	Утас:11-329365, 11-329371
56	Канад Улс	“Дүфрэнэ Готьерын Сан”	Боловсрол, эрүүл мэнд болон олон нийтийг хөгжүүлэх хөтөлбөр, төслийг дэмжих замаар амьдралын баталгаат түвшнээс доогуур хүүхэд, гэр бүлд туслах	Улаанбаатар хот, СБД, Залуучуудын өргөн чөлөө, Дүфрэнэ Готьерын Сан 27/1, 403 тоот	Утас:11-324679, 99091966 fdgmon@magicnet.mn
57	Канад Улс	“Амийн мод сэргэлт”	Газрын даацыг зохистой хуваарилах, газрыг үр өгөөжтэй ашиглах, цөлжилтөөс хамгаалах зорилгоор Монголын залуучуудыг газар тариалангийн аж ахуйг хөгжүүлэх арга ухаанд сургаж зохих үр чадварыг эзэмшүүлэх	Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, Бор гүвээ, 5-р баг, 1 хэсэг, 104 тоот	Утас: 88072667
58	Америкийн Нэгдсэн Улс	“Файр”	Үндэсний болон олон улсын хэмжээнд хувь хүн, олон нийтэд амьжиргаагаа сайжруулах санаачилгууд гаргаж ажиллах боломжийг бүрдүүлэх, эрүүл мэнд, боловсрол, ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.	Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Matrix centre,4 давхарт, 407 тоот	Утас:70101810, 99172583 program@fireprojects.org

59	Бүгд Найрамдах Чех Улс	“Пипл ин нийд” /People In Need/	БНЧУ-ын санхүүжилттэй тусламжийн төсөл хэрэгжүүлэх /ЗГ/ Монгол Улсад 2009 оноос хойш үйл ажиллагаа явуулж ирсэн. Орон нутгийн иргэдийг чадавхжуулах, гамшиг, онцгой байдлын үеийн тусламж үзүүлэхээс гадна орон нутгийн удирдлагууд, иргэний нийгмийн байгууллагууд, хоршоод бүлгүүдийн чадавхыг бэхжүүлж, тогтвортой амьжиргааг дэмжих, дээд боловсролыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах болон агаарын бохирдлыг буруулахад хувь нэмрээ оруулж, мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Парк вийв residence 8-р байрны 01тоот, Моннис /Төв номын сан/	Д.Золзаяа Систем үйл ажиллагаа хариуцсан захирагч Утас:99025531 70111501
60	Бүгд Найрамдах Франц Улс	“ЖЭРЭС” JERES	Эрчим хүч, хөгжлийн чиглэлээр мэргэшсэн ТББ, Монгол Улсад эмзэг бүлгийн иргэдийн амьдрах нөхцөлийг сайжруулах, уур амьсгалын өөрчлөлт болон түүний нөлөөтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Делта төв 403 тоот	Утас:75052000
61	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	“ӨМӨЗО-ны олон улсын худалдааг дэмжих холбоо ба Эрээн хотын олон улсын худалдааг дэмжих холбооны төлөөлөгчийн газар”	Хөрөнгө оруулахад дэмжлэг үзүүлэх, бизнесийн орчин, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх. Хоёр орны бизнес эрхлэгчдийн уулзалт, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах, хил худалдаанд тохиолдож буй саад бэрхшээлийг арилгах, хөнгөвчлөхөд чиглэгдсэн үнэлэлт дүгнэлт гаргах, хамтран хэрэгжүүлэх.	Улаанбаатар хот, Худалдаа аж үйлдвэрийн танхим	Утас: 91999795, 11-330393
62	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	“Сэргээн босголт зээлийн банк”	ХБНГУ-ын засгийн газрын даалгавраар хөгжлийн хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад зээл тусламж, санхүүгийн хамтын ажиллагааны төсөл хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.	Улаанбаатар хот, СБД, Сөүлийн гудамж, Найман Зовхис байр, 6 давхар, 601 тоот	Утас: 99108953
63	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Копия Монгол төв"	Хөдөө аж ахуйн салбарт техникийн хамтын ажиллагааны төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр шинжилгээ судалгаа хийх, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд мэдлэг түгээх үйлчилгээг зохион байгуулах	Улаанбаатар хот, ХУД Зайсан 11-р хороо МААЭШХ-н байр 4 давхарт 423 тоот	Утас: 70121021
64	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Сүрьеэгийн үндэсний нийгэмлэг”	Халдварт өвчин судлалын үндэсний төв (ХӨСҮТ)-тэй хамтран сүрьеэ өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	Улаанбаатар хот, БЗД, 26-р дугаар хороо	Утас: 91811523

				Смарт оффис 801 тоот	
65	Швейцарын Холбооны Улс	“FXB Mongolia”	Ядуурал, ХДХВ болон бусад өвчнүүд, байгалийн гамшгийн үр нөлөөтэй тэмцэж, эмзэг бүлгийнхэнд үндсэн эрхээ эдлэх, үр хүүхдээ өсгөх, өнчин хүүхдүүдийг зохих ёсоор өсгөн хүмүүжүүлэхийн тулд эдийн засгийн тогтвортой өөрөө удирдах эрхтэй болоход нь дэмжлэг үзүүлэх.	Дорноговь аймаг, Сайншанд сум, 1 баг, ноён хутагтын 33-6А тоот	Утас: 99161637
66	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Ворлд шэйр” “World share” /хүмүүнлэг/	Хилийн чанд дахь тусламжийн ажил болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа, бүлгийн үйл ажиллагаа, хүүхэд ивээн тэтгэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, цэвэр усаар хангах, яаралтай тусламж дэмжлэг үзүүлэх.	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Автозамчдын гудамж 34, "Жэй" тауэр, 7 давхарт 703 тоот	Утас: 88019664
67	Бүгд Найрамдах Франц Улс	“Аксион Монголи”	Хүмүүнлэг, соёл, нийгэм, эдийн засгийн болон боловсролын салбарт дэмжлэг үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	Улаанбаатар хот, БЗД, 26-р хороо, Олимп Виллаж, 201-158 тоот	Утас: 11-330607, 424129
68	Канад Улс	“Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага /CESO/”	Канадын өндөр туршлагатай сайн дурын зөвлөхүүдийн тусламжтайгаар Канад болон дэлхийн эдийн засаг, нийгмийн өсөлтийг хурдасгах, бэхжүүлэх.	Улаанбаатар хот, ЧД, 1 хороо, Бага тойруу, НТН цамхаг, 3 давхарт	Утас:7610500
69	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Рафаэл интернэйшнл”	Монгол Улсын эрүүл мэндийн салбарын ажилтан, эмч мэргэжилтнүүдийг сургаж, чадваржуулах замаар эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг үзүүлэх, хүүхдийн зүрхний мэс засал хийх боломж, орчин нөхцөлийг бий болгох, алслагдсан хороолол, орон нутгийн иргэдэд монгол эмч нараас бүрдсэн сайн дурын үзлэгийн баг үзлэг эмчилгээ хийх ажлын өргөжүүлэх зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, оюутны гудамж, Unity 401 тоот	Утас:88021255
70	Канад Улс	“Вэлүү сан” Veloo Foundation	Монгол Улсад нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажиллагаа явуулах, эмзэг бүлгийн хүүхдүүдэд тусламж үзүүлэх зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, нарны зам, Мандал даатгал байр 1001 тоот, НСКБ 87 байр	Утас:70000474, 95011351

71	Бүгд Найрамдах Итали Улс	“Азиа Монголиан” /Хөдөө аж ахуй/	Азийн буурай хөгжилтэй үндэстний цөөнх, эдийн засаг, нийгэм, эрүүл мэнд болоод соёлын хөгжлийг дэмжих зорилготой.	Улаанбаатар хот, БГД, 16-р хороо, Орхоны 1-23 тоот, Оюу төв	Утас:88105483
72	Япон Улс	“Өндөр Түвшний Технологийн Боловсролын Хүрээлэн”	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй япон маягийн коосэн технологийн дээд сургуулиудын үйл ажиллагааг дэмжих зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, ШУТИС-н 8 дугаар байр 303 тоот	Утас:99086310
73	Австралийн Холбооны Улс	“Эй Ви Ай” AVI	Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжих, ялангуяа нийгмийн эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, боловсрол, байгаль орчны менежмент болон уул уурхайн салбарын хүний чадавхжуулахад Австрали Улсаас мэргэжлийн боловсон хүчнийг авчирч ажиллуулах. Мөн хоёр улсын байгууллага хоорондын болон мэргэжилтнүүдийн хамтын ажиллагааг өргөжүүлэн, мэдлэг, ур чадвар, туршлага солилцох, харилцан суралцах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, 2 орны соёлын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах.	Улаанбаатар хот, СБД, Бага тойруу 1200, 8-р хороо Сити Тауэр 1203-1 тоот	Утас:99090735
74	Америкийн Нэгдсэн Улс	“Ла Миссион дэ Жуа”	Хүүхэд хөгжлийн төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, өөрсдийгөө илэрхийлэх бүрэн боломжоо нээхэд туслах чадвар, чадварыг зааж сургах.	Налайх дүүргийн, 1-р хороо, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн 4 давхар 409 тоот	Утас 98127145
75	Швейцарын Холбооны Улс	“Бизнес Профешиналс Нетворк сан” БПН	Хөгжиж буй улс оронд ажлын байр шинээр бий болгох, эдийн засагт хувь нэмэр оруулах, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжих, зөвлөгөө өгөх, бизнесийн удирдлагын сургалт семинар явуулах, бизнес эрхлэгчдийн хоорондын харилцаа холбоог тогтоох үндсэн зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, Оюутны 33, Танан төвийн буудал, 404 тоот.	Утас 91915155
76	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	ӨМӨЗО-ны Баяннуур хотын худалдааг дэмжих хороо	Нэг зам, нэг бүс санаачилгатай холбогдуулан Хятад, Монгол, Орос гурван улсын эдийн засгийн коридорын бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлэх, БНХАУ, Монгол Улсын худалдаа, бизнес, хил дамнасан тээвэрлэлт, соёлын солилцооны урсгалыг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах	Улаанбаатар хот, Хүннүгийн гудамж, Их Монгол оффис, 2-6 тоот 1730918407@qq.com	Утас: 99104889

77	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	“Шпаркассэ банкны олон улсын хамтын ажиллагааны сан”	Монгол Улсын банкны салбарыг бэхжүүлэх, банкны ажилтнуудыг олон улсад тавигддаг суурь шаардлага хангах хэмжээнд чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэхэд Монгол банк болон бусад банкны холбоонд туслалцаа үзүүлэх.	Улаанбаатар хот, ХУД, 15-р хороо, Галакси Тауэр 1003	Утас: 94099457
78	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс	“Тогтвортой ноос, ноолуурын эвсэл”	Нийгмийн сайн сайхны тусын тулд малчин өрх болон малчны бүлэг нөхөрлөлүүдийг дэмжих, тэдний шаардлага, эрэлт хэрэгцээнд тулгуурласан сургалт, судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулах, байгаль орчныг хамгаалах мөн нөхөн сэргээх чиглэлээр малчдад боловсрол олгох, ядуурлыг бууруулах ба эдийн засгийн тогтвортой хөгжил, нөхөн сэргээлтийн арга аргачлалыг дэмжих зорилготой.	Улаанбаатар хот,СХД, 3-р хороо, Twin tower 5030 тоот	Утас:70115559
79	Америкийн Нэгдсэн Улс	“Уанскай” "Onesky"	Эрсдэлийн бүлгийн хүүхдүүдэд санхүүгийн дэмжлэг, боловсролын болон бусад зүйлийн туслалцаа үзүүлэх, сургалт, зөвлөмж өгөх, хувь хүмүүс, олон нийтийн байгууллага, төрийн байгууллагуудад бага насны хүүхдүүдийг асран хамгаалах, сурган хүмүүжүүлэх тухай сургалт, боловсролын хөтөлбөр бэлдэхэд дэмжлэг туслалцаа үзүүлэх, дунд насны хүүхдүүдэд бие даан суралцах боломж бүрдүүлэх, гэр бүлийн гишүүд болон асран хамгаалагчдад хүүхэд хөгжүүлэх арга барилд суралцах зорилготой	Улаанбаатар хот, СБД 1-р хороо Шангри-Ла оффис төв 9 давхар 908 тоот БЗД, 21-р хороо Бага Дарь-Эхийн 8	Утас 99065304
80	Америкийн Нэгдсэн Улс	”Прожект Орбис Интернэйшнл”	Нүд судлалын мэс заслын болон эмчилгээний арга зүйг түгээн дэлгэрүүлэх, туршлага солилцох, сургалт явуулах чиглэлээр дэлхий дахинд үйл ажиллагаа явуулах, зохион байгуулах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх, эмч болон ажилтнуудад сургалт зохион байгуулах зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 3-р хороо, 5-р хороолол, Төгөлдөр оффис, 4 давхарт	Утас 99186985
81	Оросын Холбооны Улс	“Бид Самбогийнхон” /эрүүл мэнд/	Самбо бөхийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх чиглэлд үйл ажиллагаа явуулж буй холбооны гишүүдийг дэмжих, холбооны гишүүдийн эрх, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, тэдэнд аливаа маргаан, зөрчлийг шийдвэрлэхэд бүх талаар туслах, мөн хууль эрх зүйн болон бусад туслалцаа үзүүлэх, холбооны гишүүд хооронд болон холбооны гишүүд гуравдагч этгээд хоорондын харилцаанд аливаа зөрчил тэмцэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, эдгээр харилцааг зохицуулах	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Ланд марк оффис, 8-р давхарт	Утас: 91113438

82	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Олон улсын хөдөө аж ахуйн хамтын ажиллагааны сүлжээ” /Хөдөө аж ахуй/	Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлж, гадаад улс орнуудад Солонгосын хөдөө аж ахуйн их сургууль байгуулан, хөдөө аж ахуй газар тариалангийн салбарт олон улсын солилцоо болон хамтын ажиллагааг хөгжүүлж, орон нутгийн өөрөө удирдах байгууллагын хооронд хамтын ажиллагааны сүлжээ байгуулах болон ажиллах хүч солилцох замаар хөдөө аж ахуй газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өргөжүүлэх, улс орны хөгжилд хувь нэмэр оруулах, хүн төрөлхтний найрсаг харилцаа, хамтын эрх ашгийн төлөө ажиллах	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Union оффис, 15 давхарт, 1507 тоот	Утас: 99270033
83	Бүгд Найрамдах Солонгос Улс	"Банд фор гүүд Band for good"	2016 онд БНСУ-ын Гуанжү хотод анх байгуулагдсан, Нийгэмд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ болон соёл урлаг, боловсрол, байгаль орчин зэрэг салбарт бусадтай хамтран ажиллах.		
84	Бүгд Найрамдах Солонгос Улс	“Байгаль орчны мониторингийн үндэсний төв”	Ус хамгаалах бүсийн бохирын хамгаалалт зэрэг хянан шалгах үйл ажиллагаа, Агаарын бохирдол илрэх, хаягдал хог ялгаруулалт зэрэг байгаль орчны хянан шалгах ажиллагаа, Хүний биед хорт бодис ялгаруулах байгууллагыг хянан шалгах, илрүүлэн илчлэх.		
85	Бүгд Найрамдах Солонгос Улс	“ВИТ” “With”	ВИТ (Эрүүл мэндээр дамжуулан бүх нийтийн ашиг сонирхол) нь олон нийтийн хөгжлийн төсөл, хоолны дэглэм ба хоол тэжээлийн интервенцийн төсөл, боловсрол, судалгаа чиглэлээр үйл ажиллагаа явуулах зорилготой.	Улаанбаатар хот, СБД, 8-р хороо, ШУТИС-ийн төв байр, 337 тоот	Утас:99153660 monwith2022@gmail.com

ТАЙЛАН ТАНИЛЦСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА:
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ХҮНИЙ ЭРХИЙГ ХАНГАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА:

Б.БОЛОРСАЙХАН

ТАЙЛАН ХЯНАСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН ДЭД ДАРГА:
ХНХЯ-НЫ ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН ДАРГА

Н.БАЯРМАА

АЖЛЫН ХЭСГИЙН ДЭД ДАРГА:
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИРГАА,
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН АХЛАХ РЕФЕРЕНТ

Э.МӨНХЗУЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХНХЯ-НЫ ГЭР БҮЛИЙН БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ
ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН:

Ж.АЗЖАРГАЛ